



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХҮҮЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖЛЭГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ЭНЭ ДУГААРТ:

- Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын агуулга, чиг үүрэг
- Өнөөгийн нийгэм ба ял шийтгэл
- Баривчлах ба хорих ялын харилцан хамаарал, эрх зүйн орчин
- Франчайзийн гэрээ, түүний онцлог
- Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл
- Монгол Улс дахь харьцуулсан эрх зүйн судалгаа
- Ажил гүйцэтгэх гэрээ, түүний үндсэн нөхцөл
- Монгол Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах зарим асуудал
- Эрх зүйт ёс ба хуульчийн ёс зүй
- Иргэний хуулийн тайлбар (цуврал)
- Нотариатчийн ёс зүйн асуудалд
- Латин нэр томъёо (цуврал)

ЭНЭ ДУГААРТ:

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын агуулга, чиг үүрэг (ХЗУТ-ийн ТБХТ-ийн секторын эрхлэгч С.Гэрэлмаа)	3-4
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн баталгаажилт (ХЗДХЯ-ны мэргэжилтэн Ш.Үнэнтөгс)	5-12



Шүүх эрх мэдэл

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл (Улсын дээд шүүхийн шүүгч Л.Бямбаа)	13-16
Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, харьцуулалт (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Д.Дэлгэрбат)	17-18



Криминологи

Өнөөгийн нийгэм ба ял шийтгэл "Ганц худаг" буюу цагдан хорих төвийн эрт, эдүгээгийн асуудал (ШШГЕГ-ын харьяа Хорих 407 дугаар ангийн дарга, хурандаа, гавьяат хуульч Р.Оюунбадам)	19-25
Компьютерийн гэмт хэрэг (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш докторант Ц.Хүрэл-Очир)	26-31



Прокурорын хяналт

Баривчлах ба хорих ялын харилцан хамаарал, эрх зүйн орчин (Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, докторант Ц.Мөнхбат)	32-33
---	-------



Иргэний хууль тогтоомж

Франчайзийн гэрээ, түүний онцлог (ШУА-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Г.Мөнхболд)	34-43
Шилжилтийн үеийн нийгмийн хангамжийн эрх зүй (ХЗУТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Отгонтэнгэр их сургуулийн багш Д.Эрдэнэчимэг)	44-47
Иргэний хуулийн тайлбар (Цуврал)	48-55



Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

Монгол Улс дахь харьцуулсан эрх зүйн судалгаа (ШУА-ийн ФСЭХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн захирал, Олон улсын эрх зүй, эрх зүйн харьцуулсан судалгааны төвийн захирал, ХЗУТ-ийн захирал, Академич Ж.Амарсанаа)	56-60
Газар өмчлөх эрх ба газрын хэвлийн баялгийг ашиглах эрх: Германы эрх зүй дэх ашиг сонирхлын зөрчил (Доктор, профессор Л.Л.Чантурия)	61-63

Ажил гүйцэтгэх гэрээ, түүний үндсэн нөхцөл (ХЗУТ-ийн ажилтан, хууль зүйн магистр М.Доржханда)	64-72
--	-------

Гүтгэлэг тойрсон маргаантай асуудлууд (БНЗУ-ын Дэлгэцийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрант П.Өнөрмаа)	73
---	----

Монгол Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах зарим асуудал (ХЗУТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гүнбилэг)	74-75
Legal system of Mongolia (by Gunbileg Boldbaatar, researcher National Legal Center of Mongolia)	76-80



"Эврика - 2006"

Эрх зүйт ёс ба хуульчийн ёс зүй (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант М.Батсуурь)	81-85
Торгох ялын биелэлт, түүний үр нөлөөг дээшлүүлэх нь (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Р.Мөнхзүл)	86-90
Захиргааны хэргийн шүүхээс Засгийн газрын шийдвэрийг хянах нь (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Д.Энхчимэг)	91-95
Эрх зүйт ёс (эрх зүйг бүтээх ажиллагаа) (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант О.Мөнхсайхан)	96-100



Цагдаагийн байгууллагын 85 жилийн ойд

Цагдаагийн байгууллагын түүхэн замналаас (ЦЕГ-ын ажилтан, дэд хурандаа З.Батсүх)	101-105
---	---------



Эрх зүйн үйлчилгээ

Нотариатчийн ёс зүйн асуудал (Баянгол дүүргийн нотариатч, хууль зүйн магистр Ч.Баянжаргал)	106-108
---	---------



Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол

Эрчим хүчний тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	109-110
Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	110-112
Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	113-114



Нэр томъёо

Латин нэр томъёо (Цуврал)	115-117
------------------------------------	---------



Мэдээ, мэдээлэл

Газрын эрх зүйн зохицуулалт эрдэмтдийн анхаарлыг татав	118
--	-----

Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүн:

Ц.Бат-Орших Сэтгүүлийн зөвлөлийн ерөнхий эрхлэгч

Гишүүд:

Л.Бямбаа	- Улсын дээд шүүхийн шүүгч
Н.Дагва	- Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга
М.Дангаасүрэн	- Улсын дээд шүүхийн судалгааны төвийн захирал
А.Доржготов	- Улсын дээд шүүхийн шүүгч
Л.Заяа	- ГТХАН-ийн ХСДСТ-ийн удирдагч
Д.Мөнхгэрэл	- ХЗДХЯ-ны газрын дарга
Э.Лхагвасүрэн	- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
Д.Наранчимэг	- Отгонтэнгэр их сургуулийн захирал
А.Оюунчимэг	- Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч
Т.Уранцэцэг	- Сонгинохайрхан дүүргийн шүүгч
Ш.Үнэнтөгс	- ХЗДХЯ-ны мэргэжилтэн
Б.Пүрэвням	- Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч
Роберт Ла Монт	- АНУ-ын ОУХА-ийн ШЭМШХ-ийн удирдагч
Ж.Сайнжаргал	- Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга
Б.Цэрэнбалтав	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Б.Чимид	- ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор
А.Энхжав	- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга

Дугаарыг эрхэлсэн: Б.Дашдулам

Сэтгүүлийн хариуцлагатай
нарийн бичгийн дарга

Ц.Ариунжаргал

Сэтгүүлийн ажилтан

Эрхлэн гаргагч: Хууль зүйн үндэсний төв

Редакцын хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7

Утас: 315736 Факс: 315736

Вэб сайт: www.legalcenter.mn

И-мэйл: magazine_info@legalcenter.mn

Улсын бүртгэлийн дугаар: 279

ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧМЫН АГУУЛГА, ЧИГ ҮҮРЭГ



ХЗҮТ-ийн Төрийн
байгуулалтын хууль
тогтоомжийн секторын
эрхлэгч С. Гэрэлмаа

Үндсэн хуулиар ямар зарчим тогтоосон вэ? Тэдгээр нь ямар чиг үүрэг гүйцэтгэх учиртай вэ? Зарчим нь субъектив ухагдахуун. Эдгээрийг хууль тогтоогч өөрийн орны эрх зүйн тогтолцоо, эрх зүйн ухамсар, соёл болон хууль тогтоомжийн хүрсэн төвшинд үндэслэн томъёолдог. Нөгөөтэйгүүр зарчим нь төрийн удирдлагын хүрээнд үүссэн харилцаа холбоог бодитойгоор тусгадаг. Зарчим нь Үндсэн хуульд тогтоосон төрийн байгууллаас шууд хамааралтай томъёологддог. Тухайлбал, тоталитар дэглэмийн үед 1960 оны Үндсэн хуулийн тавдугаар зүйлд "Төрийн бүх байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим бол төвлөн удирдах ардчилсан ёс мөн." гэжээ. Үүний дагуу МАХН нийгмийг удирдан чиглүүлэгч хүчний үүргийг гүйцэтгэж байжээ. Харин 1992 оны Үндсэн хуульд:

1. Ардчилсан ёс;
2. Шударга ёс;
3. Хүний эрх, эрх чөлөөг хангах;
4. Тэгш байдал;
5. Үндэсний эв нэгдлийг хангах;

6. Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж тодорхойлжээ.

Үндсэн хуулийн зарчим нь *Нэгдүгээрт*, төрийн байгууллага болон бусад субъектээс үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, удирдлага болговол зохих үзэл баримтлалын цогц юм. Зарчим нь олон тооны эрх зүйн хэм хэмжээг цэгцлэх, харилцан үйлчлэх явдлыг хангахад чиглэгдэнэ.

Хоёрдугээрт, эрх зүйн хэм хэмжээний агуулгыг тайлах, хууль тогтоох, хэрэгжүүлэх, хэрэглэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Гуравдугаарт, шүүн таслах ажиллагааг зохистой явуулах нөхцөлийг бүрдүүлдэг. Иргэн, эрүү, захиргааны хэргийн шүүх нь нэг талаас Үндсэн хуулиар хуульчлагдсан процессын эрх зүйн нийтлэг зарчим, нөгөө талаас тус тусын онцлог шинжийг агуулсан тусгай зарчмыг үйл ажиллагаандаа баримталдаг.

Иймд зарчмын тухай мэдлэг нь иргэдэд хуулийн заалтыг зөв ойлгож, өөрийн эрхийг хамгаалахад тус дөхөм болох учир энэ өгүүлэлдээ зарчмын агуулга, чиг үүргийг тайлбарлахыг зорив.

1. Ардчилсан ёсны зарчим

Ардчилсан ёсны зарчим нь маш өргөн утгатай ч энд явцуу утгаар нь тайлбарлахыг зорив. Ардчиллыг онолын агуулгаар тайлбарлах юм бол төрийн эрх мэдэл ганц эрх баригчаас биш ард түмнээс үүдэлтэй байх ёстой гэсэн философийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэхийг хэлнэ. Засгийн эрхийг ард түмэн өөрөө шууд буюу төлөөлөх байгууллагаараа дамжуулан барих нөхцөлд ардчилсан ёсны зарчим хэрэгжинэ.

Эртний Грек, Римд тухайн улсын бүх чөлөөт иргэд /боолчуудаас бусад/ төв тайлбай дээрээ

цугларч санал хураалт явуулах замаар улс орныхоо амин чухал асуудлыг шийдэж, засгийн эрхийг шууд барих хэлбэрийг хэрэглэж байсан бол одоо ихэнх улс орны ард түмэн төлөөлөгчийн байгууллагаараа дамжуулан төрийн эрхийг барих хэлбэрт шилжээд байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын иргэд дөрвөн жил тутам Улсын Их Хурлыг сонгох эрхээ хэрэгжүүлэх замаар төр барих эрхээ эдэлж байна. Нөгөөтэйгүүр ард нийтийн санал асуулгаар олонхийн санал авсан асуудал шийдвэрлэгдсэнд тооцдог учир энэ нь төрийн эрх барихад шууд оролцох нэг хэлбэр болж байгаа юм.

2. Шударга ёсны зарчим

Яавал шударга ёсны зарчмыг хангах вэ?

Шударга ёсны зарчмын эхний төлөв нь тэгш байдал /равенства/ болон зохицсон байдал /пропорциональность/ или соразмерность/ гэсэн хоёр утгаар илэрхийлэгддэг. Тэгш байдлын шударга ёсны дагуу нийгмийн баялгийг хүн тус бүрийн оруулсан хувь нэмрийг хүл харгалзан тэгш хуваарилдаг. Зохицсон байдлын шударга ёсны дагуу хүн бүрийн оруулсан хувь нэмрийг харгалзан нийгмийн баялгийг хуваарилдаг.

Тэгш байдлын шударга ёсыг хэрэглэхэд илүү хялбар байдаг бол зохицсон байдлын шударга ёсыг хэрэглэхэд оновчтой шалгуур тогтоох шаардлага зэрэгцэн үүсдэг учир илүү төвөгтэй болдог.

Шударга ёсны хоёр дахь төлөв нь хуулийн дагуу төрийн үйл ажиллагаа явагдахад оршино. Хууль нь төрөөс иргэдтэй харилцах харилцааг зохицуулсан байдаг. Иймд ихэнх иргэд төрийн байгууллага, албан тушаалтнаас хуулийн дагуу гаргасан шийдвэрийг шударга хэмээн хүлээн зөвшөөрдөг.

3. Хүний эрх, эрх чөлөөг хангах зарчим

Хүний эрх, эрх чөлөөг хангах нь төрийн удирдлагын эрхэм зорилт юм. Хүний эрх, эрх чөлөө нь андлаггүйн халдлагаас ангид байх ёстой орон зайг төрөөс хамгаалах үүднээс тодорхой үйлдлээс түдгэлзэх /хэнийг ч дур мэдэн баривчлахгүй байх, хэвлэл нийтлэлд хяналт тогтоохгүй байх г.м/ Эсхүл эсрэгээр тодорхой эрх, эрх чөлөөг эдлүүлэхийн тулд идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг /сурч боловсрох эрхийг хангахын тулд сургууль барих, эрүүл байх эрхийг хангах үүднээс эмнэлэг барих г.м/ шаарддаг.

Хүний эрх, эрх чөлөөг бусад иргэн эсхүл төр, аливаа хуулийн этгээдээс зөрчдөг. Гэхдээ бусад иргэний хувьд хүний эрхийг зөрчих орон зай нь хязгаарлагдмал байдаг бол төрийн хувьд энэ орон зай маш өргөн байдаг бөгөөд төр нь хэт их эрх мэдэлтэй байдагаараа иргэдээс ялгаатай. Нэн ялангуяа захиргааны байгууллага өөрийн хууль ёсны захирамжаа үйл ажиллагаагаараа иргэдэд газар өмчлүүлэх, тусгай зөвшөөрөл олгох гэх мэт хүний эрхийг хангадаг эсхүл хууль ёсны үйл ажиллагаа явуулахгүй байснаараа болон хууль бус шийдвэр гаргаснаараа хүний эрхийг зөрчдөг. Ийм ч учраас хүний эрх, эрх чөлөөг хангах үүргээс ангид төрийн эрх мэдлийн болон захиргааны байгууллага, албан тушаалтан байдаггүй. Тэдгээрийн үйл ажиллагаа нь нэг зоосны хоёр тал юм. Нэг тал нь гэрэлтэй нөгөө тал нь сүүдэртэй. Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаараа хүний эрхийг хангана. Хуулийг зөрчиж, дур зоргоор авирласнаараа хүний эрхийг зөрчинө.

4. Тэгш байдлын зарчим

Тэгш байдал буюу ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан

тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэж тусгажээ. Ялгаварлан гадуурхахгүй байх гэдэг нь нийгэм, биологийн болон бусад аль нэг шинжээр хэнийг ч онцлох, чухалчлах, эрхэмлэх, эсхүл дорд үзэхгүй байхыг хэлнэ.

Үүнийг нэг талаас хүний үндсэн эрх, нөгөө талаас төрийн үйл ажиллагааны зарчим болгон тунхагласан байна. Өөрөөр хэлбэл, хүний үндсэн эрхийг тунхагласан энэхүү зарчим нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд бүгдэд нь хамааралтай бөгөөд түүнийг дагаж мөрдөх нь тэдгээрийн үүрэг юм.

Гэхдээ хүний зарим эрх, эрх чөлөөг үндэсний аюулгүй байдал, нийтийн хэм журам сахиулах гэсэн цөөн үндэслэлээр хязгаарлаж болдог байна. Тухайлбал, гадаадын иргэдэд газар өмчлүүлэхгүй байх нь үндэсний аюулгүй байдлын үүднээс зөвтөгж болох талтай.

5. Үндэсний эв нэгдлийг хангах зарчим

Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь "үндэстэн" гэдэг нь "хэсэг бүлэг хүмүүсийн хэл, газар нутаг, эдийн засаг, сэтгэл санааны агуулга чанараар нэгийн улмаас түүхийн ёсоор бий болсон батжилтай нэгдэл, нийлэл"-ийг хэлнэ гэжээ¹. Мөн толь "эв" нь "хүн амьтны хоорондын найр нийлэмж"-ийг хэлнэ гэжээ². Өөрөөр хэлбэл, үндэстний найр, нийлэмжтэй байх явдлыг хангахад энэ зарчмын мөн чанар оршино.

Энэ зарчим өмнөх тэгш байдлын зарчимтай холбоотой хэрэгжинэ. Аливаа шашны, угсаатны бүлэг болон үндэстний цөөнх зэрэг бүлэг хүмүүсийг үүсэл гарлаар нь эсхүл аливаа өөр шинжээр нь онцлох, дорд үзэж ялгаварлахгүй байснаар үндэсний эв нэгдлийг хангана.

6. Хууль дээдлэх зарчим

Нэгдүгээрт, хууль дээдлэх тогтолцоонд хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг өөр өөр

субъектүүд хэрэгжүүлдэг бөгөөд харилцан нэг нэгэндээ хяналт тавьдаг учраас аль нэг төрийн албан тушаалтан болон бүлэг этгээд давуу эрх эдэлдэггүй зөвхөн хуулийг дээдэлдэг.

Хоёрдугаарт, энэ зарчмын нэрнээс ч үзсэн хууль тогтоох байгууллагаас баталсан хэм хэмжээ гүйцэтгэх байгууллагын хэм хэмжээнээс давуутай байна гэсэн санаа илэрхий байна. Хууль тогтоох байгууллагаас эрх олгоогүй нөхцөлд гүйцэтгэх байгууллага сайн дураараа, дүрэм, журам батлах ёсгүй.

Хууль дээдлэх зарчим нь янз бүрийн төвшингийн хэм хэмжээний харилцаагаар илэрдэг. Тухайлбал, УИХ-аас баталсан бусад хууль Үндсэн хуультай зөрчилдвөл Үндсэн хуулийн заалтыг мөрдлөг болгоно. Засгийн газрын тогтоол УИХ-аас баталсан хуультай зөрчилдвөл хуулийн заалтыг мөрдөнө.

Харин нэг төвшингийн хуулиуд хоорондоо зөрчилтэй байвал үндсэн асуудлыг зохицуулж байгаа акт нь үйлчлэх нь зохистой. Тухайлбал, аль нэг хуульд орсон хөдөлмөрийн харилцаанд холбогдох заалт нь Хөдөлмөрийн хуультай зөрчилдвөл хөдөлмөрийн харилцааны тухай Хөдөлмөрийн хуулийг мөрдлөг болгох нь зохистой.

Захиргааны байгууллагын тогтоосон хэм хэмжээ нь хуулийн хэм хэмжээнээс доогуур төвшинд байх учраас зөрчилдсөн үед хууль тогтоомжийг баримтлах ёстой. Мөн захиргааны байгууллагад асуудлыг "үзэмжээрээ" шийдвэрлэх эрх олгогдсон үед үзэмжийн хүрээ нь хуулийн хүрээнээс халих ёсгүй.

Хууль дээдлэх зарчим мөн шүүхийн шатанд хамааралтай. Шүүх нь Үндсэн хуультай зөрчилдсөн болон албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх ёсгүй бөгөөд асуудлыг үзэмжээрээ шийдвэрлэх эрх олгогдсон ч гэсэн шийдвэрээ хуулийн хязгаарт багтаан гаргана.

Эдгээр зарчим нь өөр хоорондоо харилцан уялдаатай хэрэгждэг.



¹ Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь", 622 дахь тал.

² Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь", 865 дахь тал.

ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭРХ ЗҮЙН БАТАЛГААЖИЛТ

/Мэдээллийн бүрдүүлбэрийн эрхийн
хүрээнд бичсэн цуврал/

Нэгдүгээр өгүүлэл

Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө нь хүний эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох нь

Монгол Улсын шинэ Үндсэн хууль нь хүний эрхийг анх удаа өргөн дэлгэрээр томьёолж, зөвхөн иргэний эрхийг төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суух гадаадын иргэн, харьяалаггүй хүмүүсийг хамруулсан "Хүний эрх, эрх чөлөө" гэдэг томъёоллоор тунхагласнаар өмнөх Үндсэн хуулиудаас зарчмын хувьд өөр шинэ төвшинд баталгаажуулсан юм. Энэхүү Үндсэн хуулиар хүний итгэл үнэмшилтэй байх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хуульчлан баталгаажуулсан нь нэн шинэлэг хандлага болсон юм.

Хүн төрөлхөөс насан хутаг орштол итгэл үнэмшилтэй байх, түүнээ чөлөөтэй илэрхийлэх зэрэг заяамал эрхтэй байх ба тэрхүү заяамал эрхээ хэрэгжүүлэх хэлбэр нь мэдээлэл хайх, хэвлэн нийтлэх, түгээх замаар тэрхүү мэдээллийг хүлээн авснаар илрэн гардаг байна.

Өөрөөр хэлбэл, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл түгээх эрх буюу хэвлэл, мэдээллийн эрх чөлөө нь хүний аливаа үзэгдэл, үзэл санаа, онол, улс төрийн урсгалд итгэх, шүтэн бишрэх, түүнийгээ өөрчлөх зэрэг итгэл үнэмшилд суурилдаг. Итгэл үнэмшил нь хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний эх суурь, тулах цэг болдог бөгөөд уг эрхийн үндсэн дээр хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрхийн хэлбэрээр илрэн гардаг бие биенээ



ХЗДХЯ-ны мэргэжилтэн
Ш.Үнэнтөгс

дамжин илэрч, сэлбэж байдаг хам шинжтэй эрх юм.

Энэ талаар доктор Б.Чимид: "Угтаа бол хүн аливаад өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй баймааж түүнийгээ саад тотгоргүй гадагшуулснаар сая үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж буй хэрэг. Сүсэглэхээс өргөн агуулгатай хүний хувийн энэхүү салшгүй эрх нь үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх зэрэг Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө гэх бүлэгт багтах, нийгэм, улс төр, хувийн бусад эрх, эрх чөлөөний тулах цэг суурь дэвсгэр нь хэмээн үзэж болох байх аа!". гэсэн нь итгэл үнэмшлийн эрх бол хэвлэл мэдээллийн эрх чөлөөний нэгэн салшгүй хэсэг бөгөөд бусад эрхээ тодорхойлогч хүчин зүйл болохыг нотолсон гэлтэй.

Хүмүүс хүрээлж буй нийгмийн орчинд өөр өөрийн ертөнцийг үзэх үзэл, хандлагаар үнэлэлт дүгнэлт өгч, байр сууриа илэрхийлэхэд энэхүү эрх чиглэдэг. Үүний тулд бас үг хэлэх, хэвлэн нийтлэх зэрэг бусад эрх чөлөөг зайлшгүй эдлэх ёстой.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг илэрхийлэх эрхийн агуулгыг дараах төрөлд хуваан авч үзэж болно. Энэ нь:

- Хүний итгэл үнэмшилтэй байх эрх;
- Хүний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх;
- Хэвлэн нийтлэх эрх;
- Мэдээлэл хайх, түгээх, хүлээн авах эрх гэж хэвлэл, мэдээллийн эрхийн бүрдүүлбэр болгон авч үзье.

Итгэл үнэмшилтэй байх эрхийн тухайд нэгэнт дээр өгүүлсэн бөгөөд энэ нь хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний эрхийн бүрдүүлбэрийг нөхцөлдүүлэн тодорхойлогч, хам шинжтэй тулах цэг гэдэг үүднээсээ л уг эрхтэй нөхцөлдөж буй тул дэлгэрэнгүй гаргахаа түгдгэлзье.

Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн үндэс

Монгол Улсын иргэний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхтэй ..." Монгол Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 18 дугаар зүйлийн 1-д "Хүн бүр чөлөөтэй бодож, сэтгэх ... эрхтэй", 18.2-т "Өөрийн ... үзэл бодолтой байх, сонгож авах гэсэн хэний ч эрх чөлөөг хязгаарлан хавчиж болохгүй", 19 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр,

1 Б.Чимид "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөө". УБ., 2001 он. 10 дахь талд.

эхсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрх хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг багтаана" гэж заан баталгаажуулсан ба энэ нь иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх зэрэг улс төрийн эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлэх боломж олгоход оршино.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн нь үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй" гэж тусгагдан баталгаажсан ба Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Энэ хуулийн зорилт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино", 2 дугаар зүйлд "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хяргаарласан хууль батлан гаргахыг хориглоно", 3 дугаар зүйлийн 1-д "...төрөөс олон нийтийн мэдээллийн агуулганд хяналт/цензур/ тогтоохгүй", 4 дүгээр зүйлд "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно" гэж заасан заалт болон Иргэний хууль, Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Улсын их хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүгийн хууль, Засгийн газрын тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Аюулгүй байдлыг хангах тухай хууль, Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гадаад худалдааны арбитрын тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль зэрэг 30 шахам салбар хуулиудаар зарим төрлийн харилцааг зохицуулсан байна.

Энэ өөрийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөвхөн хуулийн хүрээнд бөгөөд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хязгаарлаж болно. Харин энэ эрхээ эдлэхдээ бусдыг гүтгэсэн, доромжилсон, худал мэдээ тараасан этгээд хуульд заасан хариуцлага хүлээх учиртай ба энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр эрх, эрх чөлөөг эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 18 дугаар зүйлийн 3-т "...үзэл бодолтой байх эрх чөлөө зөвхөн хуулиар заасан бөгөөд нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун мөн бусад хүний үндсэн эрх, эрх чөлөөг нэгэн адил хамгаалах ашиг сонирхлын үүднээс тогтоосон хязгаарлалттай байна", 18.3-т "Энэ зүйлийн 2-т дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлагыг ногдуулна. Энэ нь гагцхүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэдгээр нь: а/ бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх; б/үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна", 20.1-т "Дайныг аливаа хэлбэрээр сурталчлахыг хориглоно" гэж заасан.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19.2-т "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно", 19.3-т "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохиргоо, нийгмийн хэв журыг гажуудуулж болохгүй" гэж зааж өгснөөр болон тус хуулийн 25.2, 33.1.12-д улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг

нь арилгах, хүн ам нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд эрх бүхий байгууллага, албан тушаалтан онц байдал зарлаж болох тухай заасан нь Хүний эрхийн олон улсын Билль, конвенциудын үзэл санаатай нийцэж байна.

Түүнчлэн хуульд заагдсан зарим хязгаарлалттай холбогдуулан өөрийн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжоо зохих хэмжээнд холбогдох хуулиар хязгаарлуулсан байна. Үүнд: Иргэний хуулийн 7, 392 дугаар зүйл буюу Иргэн өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээг мэдээг тараасан этгээд түүний үнэн зөв болохыг нотолж чадахгүй бол учирсан гэм хорыг арилгуулахыг шаардах эрхтэй бөгөөд гутаасан мэдээг тараасан этгээд түүний үнэн зөв болохыг нотолж чадахгүй бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй болохыг заасан ба энэ зүйлээр шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг 1991 онд 66 байсан бол 1996 онд 110, 1997 онд 137, 1998 онд 121, 1999 онд 140 хэрэг болж жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай болж байна. Энэ төрлийн хохирлын хэмжээг шүүх тогтоох болсноор шүүх, шүүгч бүр олон янзаар шийдвэрлэж байсан байна. Жишээлбэл, нэр төрийн хохиролд Баянгол дүүргийн шүүх 180000, Чингэлтэй дүүргийн шүүх 1 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн шүүх 500000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэж байсан байх юм. Түүнчлэн нийслэлийн 6 дүүрэгт 1995-1997 оны хооронд нэр төр гутаагдсан гэх нэхэмжлэл 69-ийг хүлээн авсны 20 хэргийн зохигчид эвлэрч, 49 хэргийн нэхэмжлэлийг хангах, хэрэгсэхгүй болгох зэргээр шийдвэрлэсэн байна. Эдгээрээс 16 хэрэгт бүгд 142.8 сая төгрөг нэхэмжилсний 8.6 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Нэхэмжлэгч нар өөрийн нэр төр, алдар хүндийг доод тал нь 250.000 төгрөг, дээд тал нь 83 сая төгрөгөөр үнэлж байжээ.

Эрүүгийн хуулийн 67 /дайн сурталчлах/, 70 /үндэсний эв нэгдлийг бусниулах/, 71 /төрийн нууц задруулах/, 117 /гутгэх/, 143 /шүүмжилсэн иргэнийг мөрдөн хавчих/, 153-157 /мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг/ дугаар зүйл нь үзэл бодлоо

илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалан зохицуулсан, зохих хүрээнд хязгаарласан байна. Тухайлбал, шүүхээр шийдвэрлүүлсэн нийм хэрэг 1966 онд 66, 1997 онд 137 байна.

Нөгөөтэйгүүр Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Аюулгүй байдлыг хангах тухай хууль, Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гадаад худалдааны арбитрын тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн холбогдох заалтаар нууцад хамаарах объект, тодорхой үйл ажиллагаа, мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцдаг, эсхүл ажил албаны үүргийн дагуу мэдсэн этгээд болон албан үүргийн хувьд төрийн нууцыг мэдэх ёсгүй этгээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг олж авах зорилгоор хайсан, тэдгээрийн нууцыг бусдад задруулсан бол зохих хариуцлага хүлээлгэхээр, Улсын их хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд УИХ-ын гишүүний хувьд үзэл бодлоо илэрхийлэхдээ асуудалд нотолгоотой, хариуцлагатай хандахыг үүрэг болгосон, Улсын Их хурлын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн нэр дэвшигчийг гүтгэх, дооржлох, нэр төрийн нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглосон бөгөөд зарим сурталчилгаа явуулахыг хязгаарласан болон төрийн зохих ажил албан тушаал эрхлэж буйтай холбогдуулан зарим хуулиар хязгаарлалт тогтоожээ.

Түүнээс гадна Соёлын тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Захиргааны хариуцлагын тухай, Зохиогчийн эрхийн тухай зэрэг хуульд үзэл бодлоо илэрхийлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан байна. Эдгээр хуульд

үг хэлж үзэл бодлоо илэрхийлэх боломж, арга замыг тодорхойлсноос гадна нийгмийн эрүүл саруул ёс суртахууныг дэмжих, хүний бусад эрхийг хамгаалахад чиглэгдсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.5-д Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно гэж заасан нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхэд зүй ёсны хязгаарлалт юм.

Дээрх хууль тогтоомжид буй хязгаарласан зарим эх сурвалж уг эрхийн хэрэгжилтийг бүдгэрүүлж, эргэлзээ төрүүлж байна. Энд үндэсний хууль тогтоомж болон олон улсын хэм хэмжээгээр хязгаарлагдсан зүй ёсны хоригийн тухай яриагүй. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19-д зааснаар хүний эрхийн хязгаарлалтыг а/бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх; б/үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байвал зөвхөн хуулиар хязгаарлаж болох тухай шалгуурын тухай асуудал юм.

Гэтэл Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 28.2-д "Сонгуулийн сурталчилгааг санал хураах өдрөөс 24 цагийн өмнө зогсооно. Энэ үеэс эхлэн сонгууль явагдаж дуустал ямар нэг хэлбэрээр ухуулга, сурталчилгаа хийх, санал хураах өдөр хүртэл 7 хоногийн хугацаанд олон нийтийн санал асуулга явуулах, санал асуулгын дүн мэдээг нийтлэхийг хориглоно" гэсэн нь олон түмэн сонгуулийн талаарх өөрийн санал бодлоо илэрхийлэх эрхийг /тодорхой хугацаанд/ хязгаарласан.

Мөн уг хуулийн 28.5-д "Нэр дэвшигч, түүний шадар туслагч, ухуулгагч, талархан дэмжигч этгээд, нам, хамтарсан намууд ... биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, урлагийн тоглолт зохиох, ... явуулахыг хориглоно...", 28.3-д Монголын үндэсний радио, телевизээр Сонгуулийн ерөнхий хорооны баталсан хуваарьт зааснаас өөр төлбөртэй ба төлбөргүй нэвтрүүлэг явуулж үл болно" гэсэн нь Иргэний

болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрхтэй гэснийг зөрчиж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг шууд хязгаарласан нь Үндсэн хууль, олон улсын Пактаар хүлээсэн эрхийн байдлыг зөрчсөн.

Түүнчлэн Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 21.5-д "Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн алд ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн нь мөн адил хүний итгэл үнэмшил, үзэл бодлоо ямар нэг арга хэрэгслээр чөлөөтэй илэрхийлэх эрхийг улс төрийн аргаар боомилон зөрчсөн гэх үндэстэй байна.

Мөн Шүүхийн тухай хуулийн 62.2, Прокурорын байгууллагын тухай хуулийн 29.3, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 21.2, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 36.2-т тус тус Шүүгч, Прокурор, Хүний эрхийн комиссын гишүүн, цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана" гэж заасан нь тухайн хүнийг эрхэлж буй албан тушаалтай нь холбогдуулж итгэл үнэмшилтэй байж, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан мэт ойлгогдох их бүрхэг заалт бөгөөд Үндсэн хууль болон хүний эрхийн Билльд тусгагдсан хүнийг үндэс угсаа... эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадурраж үл болно гэсэн зарчмыг зөрчсөн гэж болох үндэстэй. Засгийн газрын тухай хуулийн 24.1.4-д "Засгийн газрын гишүүн шийдвэр, мэдэгдэл гаргах, аливаа хэлбэрээр албан ёсны байр сууриа илэрхийлэхдээ Ерөнхий сайдын бодлогыг баримтална. Хэрэв эрхэлсэн

асуудлынхаа хүрээнд Ерөнхий сайдын бодлогыг зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай гэж үзвэл энэ тухай зохих шийдвэрийн төсөл бэлтгэж Ерөнхий сайдад уламжлан шийдвэрлүүлнэ” гэж заасан нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийг шууд хязгаарласан байна.

Төр, засгийн байгууллагуудаас Төрийн нууц, Байгууллагын нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын нууцын эрхлэгч, түүнийг хөтлөх, мөрдөх заавар болон дэгээр хуульд нийцүүлэн гаргасан байгууллагын нууцын жагсаалт, журмаар алба хаагчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зохих хүрээнд хязгаарласан байдаг байна. Энэ нь тийм ч түгээмэл биш бөгөөд хууль зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Харин 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, 2000 онд Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль батлагдсан нь үзэл бодлоо хангах хууль зүйн баталгааг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон юм. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн дагуу байгуулагдсан Комиссыг “Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүүлэн дэмжих байгууллага” гэж тодорхойлоод хүн өөрийнх нь эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзвэл Комисст гаргал хэрхэх эрхийг баталгаажуулсан нь нааштай алхам болсон юм.

Түүнчлэн манай Үндсэн хуульд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасанчлан “хэвлэл мэдээллээр болон хил хязгаар үл хамааран” хангах тухай хамгийн чухал заалт орхигдсон боловч Үндсэн хуулийн Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударга сахин биелүүлнэ болон Монгол Улсын нэгдэн орсон гэрээ нь соёрхон батлагдмагц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэсэн заалтаар нөхөгдөх боломжтой.

Мөн бусдын нэр төр, алдар хүндийг гутааснаас шалтгаалсан хэрэг өсөх хандлагатай байгаа болон түүнийг шүүх, шүүгчээс үнэлэх үнэлэмж янз бүр байгааг зохицуулах зорилгоор Улсын дээд шүүхийн иргэний танхимаас 2000 онд “Иргэний хуулийн 7, 392 дугаар зүйлийг хэрэглэх тухай” зөвлөмж, аргачлалыг гаргасан нь ихээхэн ач холбогдолтой болжээ.

Товчдоо хэлэхэд МЧАС-ийн ерөнхийлөгч Ц.Дашдондов нэгэнтээ “...*Чи Хүний эрх зөрчөөд, хүн рүү дайраад байвал амин газар чинь буудчихна шүү! Буу олдono шүү...*” хэмээн мэргэжил нэгт нөхөддөө тоглоомоор хэлсэн нь үнэхээр бодит заналхийлэл юм. Учир нь хэвлэл мэдээлэл хэт туйлшран нийгэмд оволозоно, төдий чинээ нийгэм өөрөө, хууль бүтээгдэх замаар эрх чөлөөг нь хязгаарлах зүйл хангалттай хийж чадна. Нөгөө талаас хууль болгоны үг, таслал бүр хэрэглэж чадвал буу биш, их буугаар буудсангай адил хүчин чадал агуулдагийг илэрхийлсэн үг юм.

Үндсэн хуулиар тунхагласан хүн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь дээрх харьцуулсан судалгаа, хууль тогтоомжид тусгагдсан байдлыг үндэслэн дүгнэхэд дээрх улс төрийн эрхийн хязгаарлалтыг эс тооцвол харьцангуй чөлөөтэй хэрэгжиж байна гэх үндэстэй бөгөөд энэ эрх хэрэгжих нөхцөл бололцооны хувьд өргөн агуулгыг хамарч байна.

Ер нь үзэл бодлоо илэрхийлэх нь хүн хүрээлэн байгаа орчинтойгоо өөрийн байр сууриас харьцах түүний төрөлх чанараас үүдэлтэй. Гадаад ертөнцтэй субъектив байдлаар, өөрийн үзэл бодлоор харьцах нь тухайн хүний аж төрөх ёсны салшгүй хэсэг, бие хүн үл давтагдах шинж юм. Гэхдээ үзэл бодлоо илэрхийлэх нь гадаад учир шалтгаанаас нэг их хамаарахгүй, тухайн хүний ертөнцийг танин мэдсэн түвшин, үзэл хандлагаас хамаарч байдаг бол үг хэлэх нь улс төр, улс төрийн дэглэмээс нэлээд хамааралтай байдаг. Энэхүү бодит хэрэгцээгээ хэрэгжүүлэхийн тулд үг хэлэх эрх чөлөөг эдэлдэг. Энэ нь амаар, бичгээр, улс төр, философиин үзэл баримтлалаар, уран сайхны дүрээр

гэх зэрэг ямар ч арга, хэлбэрээр илэрч болдог.

Үг хэлэх нь ардчилсан дэглэмийн чухал шинж бөгөөд ийм дэглэмийн үед төр, нийгмийг удирдах үйл хэрэгт оролцон гаргахад нийгмийн бүх гишүүн адил тэгш оролцох боломж бүрддэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол үг хэлэх эрхгүйгээр хүн хэвийн амьдарч чадахгүй, нийгэм эрүүл саруул оршин тогтнох, үйл ажиллагаагаа явуулж чадахгүй тийм орчин юм. Энэ бүхнээс үзвэл чөлөөтэй бодож сэтгэх, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хоорондоо нягт холбоотой гэдэг нь харагдаж байна.

Нийгэмд байгаа бодит хүчин зүйлийн хүрээнд өнөөдөр хүн өөрийн үзэл бодлоо, дээрх хуулиар тогтоосон зохих хязгаарлалттай хүрээнд ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг амаар, бичгээр, хэвлэл мэдээллийн, уран сайхны болон бусад хэлбэрээр улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой аргаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх боломжтой болж гэх бүрэн үндэслэлтэй байна. Тухайлбал, өнөөдөр Монгол Улсад 2000 оны байдлаар 1024 сонин, 240 сэтгүүл, 107 мэдээллийн хэрэгсэл /радио/, телевиз, мэдээллийн агентлаг/ үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд одоогоор Монгол Улсад албан бус тоогоор 8500 компьютер интернетэд холбогдсон, 1770 төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдсэн зэрэг нь хүн өөрийн үзэл бодлоо ямар нэг хил хязгаараас үл хамааран түгээх, илэрхийлэх боломжтой байгааг харуулж байна.

Хэвлэл мэдээлэх, мэдээлэл түгээх, ашиглах эрхийн үндэс

Монгол Улсын иргэний хэвлэл мэдээлэх эрх нь НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой арга замаар ... түгээн дэлгэрүүлэх эрх багтана” болон Иргэний болон улс төрийн эрхийн

тухай олон улсын Пактын 18 дугаар зүйлийн 1-д "Хүн бүр чөлөөтэй бодож, сэтгэх... үзэл бодолтой байх, чөлөөтэй сонгох... болон үзэл санаагаа ... заан түүгээ замаар илэрхийлэх эрх чөлөөтэй", 19 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй ... түүгээр эрх чөлөөг багтаана" гэж заан баталгаажуулсан ба энэ нь иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх зэрэг улс төрийн эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлэх боломж олгоход хэр нээлттэй байгаагаар илэрнэ.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн нь хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй" гэж тусгагдан баталгаажсан ба Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар уг харилцааг бүхэлд нь зохицуулж байна.

Түүнчлэн Эрүү, Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Хэрэгжүүлэх эрхийг хамгаалах тухай хууль, Улсын их хурлын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Захиргааны хармуцлагын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль зэрэг салбар хуулиудаар зарим төрлийн харилцааг зохицуулсан байна.

Энэхүү үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ илэрхийлэх гол арга замын нэг хэвлэн нийтлэх эрх чөлөөг зөвхөн хуулийн хүрээнд бөгөөд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс

хязгаарлаж болно. Харин энэ эрхээ эдлэхдээ бусдыг гүтгэсэн, доромжилсон, худал мэдээ тараасан этгээд хуульд заасан хариуцлага хүлээх учиртай ба энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр эрх, эрх чөлөөг эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана" болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 18 дугаар зүйлийн 3-т "... үзэл бодолтой байх эрх чөлөөг зөвхөн хуулиар заасан бөгөөд нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун мөн бусад хүний үндсэн эрх, эрх чөлөөг нэгэн адил хамгаалах ашиг сонирхлын үүднээс тогтоосон хязгаарлалттай байна", 18.3-т "Энэ зүйлийн 2-т дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлагыг ногдуулна. Энэ нь гагцхүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэдгээр нь: а/ бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх; б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна", 20.1 "Дайныг аливаа хэлбэрээр сурталчлахыг хориглоно" гэж заасан.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19.2-т "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно", 19.3-т "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журыг гажуудуулж болохгүй" гэж зааж өгснөөр болон тус хуулийн 25.2, 33.1, 12-д улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд эрх бүхий байгууллага, албан тушаалтан онц байдал зарлаж болох тухай заасан нь Хүний эрхийн олон улсын Билль, конвенциудын үзэл санаатай нийцж байна.

Хуульд заагдсан эдгээр зарчимтай холбогдуулан хэвлэн нийтлэх эрхийн асуудлыг а/эрхийн хамгаалалт, хууль зүйн орчин, б/хязгаарлалт, в/хуулиар хүлээлгэсэн үүрэг гэж ерөнхийд нь тоймлон авч үзье.

А/ Эрхийн хамгаалалт
Баталгааны хувьд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн байдлын тайлбарт дурдсан Үндсэн хууль, Хүний эрхийн олон улсын Билльд тусгагдан баталгаажсан эрхийн бүрдүүлбэртэй адил байгаагаас гадна Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бүхэлдээ буюу түүний 1 дүгээр зүйлд "Энэ хуулийн зорилт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, **хэвлэн нийтлэх** эрх чөлөөг баталгаажуулахад оршино", 2 дугаар зүйлд "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно", 3 дугаар зүйлийн 1-д "Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт/цензур/ тогтоохгүй", 3 дугаар зүйлийн 2-т "Төрөөс хэвлэлд мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй", 4 дүгээр зүйлд "... Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно" гэж заасан нь эрхийн чухал баталгаа болсон юм.

Үүнийг 2000 онд Женевт хуралдсан НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны 68 дугаар чуулганаар Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын дөрөвдүгээр ээлжит үндэсний илтгэлийг хэлэлцээд Хүний эрхийн хорооноос гаргасан CCPR /179/ Add.120 дүгнэлтэд Монгол Улс Хэвлэлтийн эрх чөлөөний тухай хуулийг гаргасанд тус Хороо сайшааж тэмдэглэсэн байдаг.

Түүнчлэн Улсын их хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4-д Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд хэвлэл, мэдээллийн хэрэгслийн асуудал, 13.6-д Хууль зүйн байнгын хорооны бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд Хэвлэл

мэдээллийн эрх чөлөө, түүний баталгааг бүрдүүлэх явдал гэж заасан, мөн Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3-д: "Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улсын бүртгэлийн... хүрээний бодлогын асуудлыг эрхлэнэ" гэж зааж тусгасан нь хэвлэл нийтлэл буюу хэвлэл, мэдээллийн асуудал төрийн хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллын аль ч функцний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх, эрхийн баталгааг бүрдүүлэх чиг үүргийг заасан нь хэвлэл мэдээллийн асуудлыг төрийн бодлогын хүрээнд өндөр төвшинд авч үзэх ёстой байдгийг илэрхийлж буй бөгөөд хамгаалалт баталгааны хувьд хангалттай орчин бүрдэлдэн гэж үзэх үндэс бүхий байна. Гэвч байдал ийм хэмжээнд байгаа эсэх нь ихээхэн эргэлзээтэй.

Б/Хязгаарлалтын хувьд дээр дурдсан Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй адил Хүний эрхийн Билль, Үндсэн хууль, салбар хууль тогтоомжоор хязгаарлагдсан ба нөгөөтэйгүүр олон улсын конвенциор Монгол Улсын хүлээсэн үүрэг, Үндсэн хуулиар тунхаглагдсан эрх, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажсан эрх чөлөөг илт зөрчсөн байдал байсаар байгааг тэмдэглэж байна.

Энд үндэсний хууль тогтоомж болон олон улсын хэм хэмжээгээр хязгаарлагдсан зүй ёсны хоригын тухай яриагүй зөвхөн тус улсын гүйцэтгэн захирамжлах байгууллагаас гаргасан эрх зүйн акт, түүгээр тогтоосон хэм хэмжээний асуудлын тухай юм.

Монгол Улсын Засгийн газраас 1991 онд 267 тоот тогтоолоор батлан гаргаж, хүчин төгөлдөр үйлчилж буй "Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг бүртгэх журам"-ын дагуу хэвлэл, мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх зүйн зохицуулалт журамлагдсан байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэж авах, хяналт тавих процессын ажиллагаа нь Засгийн газрын дээрх тогтоолыг хэрэгжүүлэх

зорилгоор Монгол Улсын Хууль зүйн сайдын 1991 оны А/352 тоот тушаалаар баталсан "Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг бүртгэх, хяналт тавих заавар"-ын дагуу зохицуулж байна. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2000 оны 50 тоот тушаалаар улсын бүртгэлийн гэрчилгээний загварыг баталсан бөгөөд уг тушаалаар улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Удирдлагын зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэн, Сайдын гарын үсэг зурснаар баталгаажуулан гэрчилгээ олгодог байна. Эдгээр журам, заавраар тогтоосон эрх хэмжээний хүрээнд дүн шинжилгээ хийж үзэхэд:

1. Тус журам, заавраар Үндсэн хуулийн үзэл санаад тохирсон, бусад хэм хэмжээгээр тогтоосон зүй ёсны хоригийг зөрчөөгүй аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах эсэхийг бие даан шийдвэрлэх эрхийг зөвхөн төрийн бүх шатны байгууллага, нам эвсэл, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжид олгосон байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах эрхийг хувь хүн, сайн дураар эвлэлдэн нэгдсэн хэсэг бүлэг хүмүүст бус зөвхөн хуулийн этгээдэд олгож байгаа нь Хүний эрхийн Билль, Үндсэн хуулиар тунхаглагдсан Хүн бүр эрх зүйн этгээд байна болон нийгэм, өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ...байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй гэснийг илт зөрчиж байна. Нөгөө талаас дээрх эрх зүйн баталгааны хэм хэмжээгээр томъёолгдсон хүний итгэл үнэмшилгүй байх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэл нийтлэх эрх буюу товчдоо хэвлэл мэдээллийн эрх чөлөөний баталгааны чухал илрэл болох мэдээллийн хараат бус чөлөөт байх эрх нь туйлын хүндээр зөрчигдөж байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрхлэх зөвшөөрлийг гагцхүү хуулийн этгээдэд олгож байгаа нь төр болон бусад сонирхол илэрхийлэгч бүлэглэлээс хэвлэл мэдээллийг хараат байдалтай болгох нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, одоогоор Хууль зүй,

дотоод хэргийн яам энэхүү зөвшөөрлийг зөвхөн аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллага, нам эвсэл зэрэг хуулийн этгээдэд олгож байгаа нь мэдээллийг аль нэг улс төрийн хүчин, бүлэглэл ашиг сонирхолдоо нийцүүлэн түгээх, мэдээллийн агуулгад оролцох боломжийг үгүйсгэхгүй байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхээр байна. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг нь өөрөө тусдаа бие даасан хуулийн этгээд мөн бөгөөд түүнийг хэн нэгэн, хэсэг бүлэг хүн үүсгэн байгуулах эрхтэй бөгөөд хуулийн этгээд шинээр байгуулах зөвшөөрлийг заавал хуулийн этгээдэд олгоно гэдэг нь угтаа хууль зүйн хувьд логикийн том алдаатай бодлого юм.

Мөн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглосон заалтыг зөрчиж байгаа ба энэ хууль батлагдан гарсаар 3 жил болсон ч тус журам, заавраа хуульд нийцүүлэн өөрчлөөгүй байна.

2. Тус журмын 1-д өгүүлсэн зүй ёсны хоригийн биелэлтэд хяналт тавих зорилгоор тогтмол хэвлэлийн нэг хувийг хэвлэгдсэн даруй Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр заасан, бүртгүүлсний хураамж төлөхөөр заасан нь нэг талаас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар хориглогдсон төрөөс мэдээллийн агуулгад цензур тогтоохгүй гэснийг зөрчиж байгаа боловч Үндсэн хууль, конвенциор хязгаарласан зүй ёсны хоригийн биелэлтэд зарим талаар төрөөс зохицуулалт хийж болохыг үгүйсгэхгүй. Мөн Тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулахад төлөх хураамжийн хэмжээг заасан тул бүртгэлийн хураамж авч буй нь хууль зөрчөөгүй байна.

3. Тус журам, зааварт улсын бүртгэлд бүртгүүлэх материал нь бүрдэл болоогүй, эсвэл нийтлэлийн бодлого, зориулалт, үйл ажиллагааны чиглэл нь Монгол Улсын хууль тогтоомжид харшилж байвал зохих үндэслэлийг тодорхойлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгээс татгалзана. Үүсгэн байгуулагч үг шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл шүүхэд

гомдлоо гаргаж болно гэж заасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасан төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавихгүй гэснийг зөрчиж байгаа ч, Үндсэн хууль, хүний эрхийн Билльд туссан улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, садар самуун, хүчирхийлэлийг сурталчилахаас сэргийлэх, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах, ашиг сонирхлын үүднээс хязгаарлалт тавьж болно гэснийг үндэслэн бүртгэхээс татгалзаж болох үндэстэй байна. Гэхдээ энэ нь зүй бус хяналтын үйл ажиллагааг сайшааж буй хэрэг бус юм.

4. Мөн тус журамд улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ аваагүй, түүнчлэн холбогдох хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг Хууль зүйн яам дүрэмдээ заасны дагуу зогсоох хүртэл арга хэмжээ авна гэж заасан, Хууль зүйн сайдын тушаалаар баталсан зааварт: хэвлэл мэдээллийн хэрэгслийн зорилго чиглэл, нийтлэлийн чиглэлийг үүсгэн байгуулагчаар батлуулж, түүнд нь тус яам хяналт тавина гэсэн нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй гэснийг зөрчиж байгаа ба "холбогдох хууль тогтоомж" гэж чухам ямар хууль тогтоомжийг заасан нь бүрхэж байна. Энэ тодорхой бус байдлаас шалтгаалан энэ үгийг хэн нэгэн өөрт ашигтайгаар тайлбарлан, эрхийг хязгаарлаж болзошгүй байна.

Нөгөөтэйгүүр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн 3-т хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтлэл, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэж зааснаар зөвтгөн тайлбарлаж болох ч хэвлэлийн эрх чөлөө болон хариуцлага хоёр салшгүй хамт байдаг, хамт яригддаг зүйл гэдгийг томьёолсон зарчмын ач холбогдолтой хууль болжээ.

Эцэст нь дүгнэн хэлэхэд Олон улсын хүний эрхийн Билль-д

зааснаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөвхөн хуулиар хязгаарлаж болно, өөрөөр байж болохгүй. Мөн Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчимд нийцэхгүй байгаа бөгөөд дээрх олон улсын Пактад тус улс нэгдэн орж, тодорхой үүрэг хүлээсэн атлаа Монгол Улс иймэрхүү хязгаарлалтыг хуулийн доорхи буюу дэд актаар, өөрөөр хэлбэл, хууль тогтоох бус гүйцэтгэх байгууллагын шийдвэрээр тогтоосон нь учир дутагдалтай юм. Тэгээд ч энэ журам, заавар 1991 онд буюу шинэ Үндсэн хууль батлагдан гарахаас өмнө гарсан, 1998 онд хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль УИХ-аар батлагдан гарч төрийн мэдэлд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл байхыг хориглосон, энэхүү хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээг тус ондоо /1988/ багтаан шийдвэрлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороондоо даалгасан 111 тоот тогтоол УИХ-аас гаргасан ч одоо хүртэл хэрэгжээгүй зэрэг учир дутагдалтай байгааг тэмдэглэн даруй Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээг УИХ, Засгийн газрын холбогдох эрх хэмжээний байгууллагууд авч ажиллах нь зүйтэй байна, Өөрөөр хэлбэл, дээрх журам, зааврыг хүчингүй болгож, хуульд нийцүүлэн шинээр бүрдүүлэх нь чухлыг тэмдэглэж байна.

Энэ нь Монголын радио, телевиз, Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл засаг төрийн харьяанд хэвээр байгаа бөгөөд төрийн өмчлөл хэвээр байгаа учраас тэдэнд нөлөөлөх нөлөөлөл хүчтэй байгааг тэмдэглэж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас 1991 онд 27 тоот тогтоолоор баталсан Радио, Телевизийн Хэрэг Эрхлэх газрын дүрмийн 1 дүгээр зүйлд "Монгол Улсын засгийн газрын дэргэдэх Радио, Телевиз нь /цаашид Монгол Улсын радио, телевиз гэх/ мэдээлэл, сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлгийн нэгдсэн бодлогыг төр, засгийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх захираганы төв байгууллага мөн" гэж заасан ба энэ дүрэм одоо ч хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ нь Засгийн

газрын 1995 оны 206 тоот тогтоолоор РТХЭГ-ын бүтэц орон тоог шинэчлэн тогтоосон, 1993 оны 59 тоот тогтоолоор Радио, телевизийн нэвтрүүлгийн чанарыг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай гэх мэт удирдлага зохион байгуулалт болон мэдээллийн агуулгад оролцсон шийдвэр гаргасар байна.

Мөн Засгийн газрын тухай хуулийн 20.1.1-д Үндэсний радио, телевизийн асуудал, 20.1.3-д гадаад, дотоод мэдээлэл буюу МОНЦАМЭ агентлаг Ерөнхий сайдын эрхлэх ажлын шууд хүрээнд хамаарсан байна. Тэгээд ч энэ бүрэн эрхийн хүрээнд тэдгээр агентлагийн удирдлагыг томилж, чөлөөлдөг эрхтэй.

Тухайлбал, тун "ойрын бодитой жишээ гэвэл, сүүлийн жилүүдэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл худал хуурмаг, аллага, хүчирхийлэл, хулгай дээрэм, архидалт, садар самуунд уриалах, хүний нэр төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хувийн амьдралд хөндлөнгөөс оролцсон мэдээ, нийтлэл гарч буйг холбогдуулан иргэдээс ирүүлсэн гомдлыг үндэслэн 1996 онд Хууль зүйн яамнаас Ж.Амарсанаа сайдын үед хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд шалгалт хийж, Халуун хөнжил, Амт+Плейбой, Таашаал, Тодорхой нууц зэрэг сонинг улсын бүртгэлээс хасч, бүртгүүлснээсээ хойш нэг ч дугаар гаргаагүй, хаяг, редакци эрхлэн гаргагч нь тодорхой бус, эдийн засгийн боломжгүй 171. сонин, 27 сэтгүүлийг улсын бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авсан. Мөн 1998 онд С.Батчулуун сайдын үед нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудыг шалгаж, сайн дураараа улсын бүртгэлээр хасуулах хүсэлтээ гаргасан 51 сонин, сэтгүүлийг улсын бүртгэлээс хассан. 2000 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн тушаалаар тус яам, Үндэсний татварын ерөнхий газар, Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран хэвлэл, мэдээллийн зарим байгууллагад шалгалт хийсэн байна. Энэ шалгалтаар зөрчил дутагдал гаргасан 21 сонин болон нэг телевизийг 1.950.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авч, удаа дараа

хууль зөрчсөн Чоно, Дуулиант хэрэг, Жигшүүрт хэрэг сонины үйл ажиллагааг зогсоож, улсын бүртгэлээс хассан байна.¹

Ер нь хязгаарлалт ганц энэ биш, нутаг ч эргэж няглант Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх ажлыг дорвитой хийх /энэ чиг үүргийг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах/ нь зүйтэй бөгөөд ихэнхдээ тойруу дам хэлбэрээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан өөр бусад хуулийн заалт ч ажиглагдаж байгаа ба хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль батлагдан гарснаас хойш ч энэ эрхийг хязгаарласан хуулийн заалт гарсан байна. Тухайлбал, энэ нь дам хэлбэрээр хэвлэл мэдээллийн байгууллагад үүрэг хүлээлгэх байдлаар илэрч байна.

в/ хуулиар хүлээлгэсэн үүргийн хувьд Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориолосон нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжсэн хэрэг, улмаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг бие даан хөгжих баталгаа болж өгөх ёстой ч зарим талаар төр зарим хуулиар үүрэг тулган хүлээлгэх хандлага гарч байгаа нь харамсалтай.

Энэхүү хуулиар хүлээлгэсэн үүрэгдэлтийг хэвлэл мэдээллийнхэнд оногдуулсан, бусад байгууллага албан тушаалтанд оногдуулсан гэж хуваан үзэж ч болох талтай байна. Үүнд:

а. бусад байгууллага албан тушаалтанд оногдуулсан нь: Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хуулийн 12-д "...иргэнийг ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан таслан шийдвэрлэх арга хэмжээ болж цагдан хорьсон, эсхүл захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ авсан тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа дурдсан ажиллагаа хууль зөрчсөн болох нь

нотлогдвол шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллага хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан 10 хоногийн дотор мэдээлэл хийж залруулах үүрэгтэй". Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6.4-д хэрэглээнд гарсан бүтээгдэхүүн хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулж болох нь нотлогдвол энэ тухай үйлдвэрлэгч, худалдагч, орон нутгийн захиргаа, улсын хяналтын байгууллага хэвлэл, мэдээллийн болон бусад хэрэгслээр олон нийтэд хүргэх үүрэгтэй. Ерөнхийлөгч, Улсын их хурал, Аймаг, нийслэлийн сонгуулийн хуульд сонгуулийн ерөнхий хороо сонгууль дууссан өдрөөс хойш 3 сарын дотор дүнг төрийн төв хэвлэлд нийтэлнэ. Улсын их хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9.3, 10-д, Засгийн газрын тухай хуулийн 31-д, Олон улсын гэрээний тухай хуулийн 25-д тус тус зааснаар зарлиг, тогтоол шийдвэр, олон улсын гэрээг Төрийн мэдээлэл эмхтгэлд албан ёсоор нийтлэх ба түүнийг эхийг бусад сонин хэвлэл баримтлана гэж заасан хэрэг үүрэгдэлт байна

б. Хэвлэл мэдээллийн байгууллагад хүлээлгэсэн үүрэгдэлт нь: Цагдаагийн байгууллагын тухай, Онц байдлын тухай зэрэг хуульд зааснаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг дайчлан ашиглах, мэдээллээ шуурхай хэвлэн нийтлэх, нэвтрүүлэх, зарим талаар үнэ төлбөргүй ашиглах үүргийг хүлээлгэсэн ба Ард нийтийн санал асуулгын хуулиар санал асуулгыг шуурхай, үнэн бодитой мэдээлэх үүрэгтэй, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар гэмт хэргээс сэргэлжүүлэхээр нийтлэх, нэвтрүүлэх явуулах, хойшлуулшгүй мэдээллийг яаралтай нийтлэх үүрэгтэй, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд энэ талын мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй мэдээлнэ гэж заасан байна.

Түүгээр ч зогсохгүй хувийн болсон чөлөөт хэвлэл мэдээллийн байгууллагуудад өөрийн харьяаны юм шиг үүрэг ногдуулдаг төдийгүй,

түүнийгээ биелүүлэхгүй бол хууль зүйн хариуцлага хүлээлгэх тухай заадаг зуршил хууль тогтоох төвшинд байсаар байна. Тухайлбал, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд 2001 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр хэвлэл мэдээллийн байгууллага нь сонгууль бэлтгэн явуулах ажлын явц, сонгуулийн дүнг олон нийтэд шуурхай мэдээлж байх үүрэгтэй" гээд хэрэв нийтлэгдсэн мэдээ худал ташаа байвал иргэнийг 24000-25000 төгрөгөөр, хэвлэл мэдээллийн байгууллагыг 200,000 төгрөгөөр торгохоор заажээ. Энэ нь мөн Улсын их хурлын сонгуулийн хуулийн 4.2, 4.3, 21.3, 21.4, 21.5, 6.8-д тусгагдсан бөгөөд утга адил заалт юм.

Иймд үүрэгдсний цаана ямар үр дагавар байгааг хууль зүйн үүднээс танин мэдэх түүнийг судлан илрүүлж, арилгах зайлшгүй шаардлагатай байгааг тэмдэглэж байна.

Хэдийгээр хэвлэл нийтлэх эрх буюу хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь дээрх хууль зүйн хүрээнд зохих хязгаарлалт, доголдол байгаа ч практик амьдрал дээр түлхүү хангагдсан гэж дүгнэх үндэстэй байна. Тухайлбал, 20 жилийн өмнө манай оронд 75 нэрийн сонин, сэтгүүл нэг удаа 1.5 сая орчим хувиар хэвлэгдэн гарч, нэг айл өрхөд дунджаар 4.5 тогтмол хэвлэл ногдож, жил бүр 600 шахам нэрийн номыг 5 сая гаруй хувиар хэвлэж, 5 өрхийн 4 нь радио сонсож, 7 хүний нэг нь телевизийн нэвтрүүлэг үзэж байсан бол одоо 1024 сонин, 240 сэтгүүл, бие даасан суваг 4 телевиз, кабельт сүлжээний 16, теле студи 50, өргөн долгионы АМ радио 8, богино долгионы FM радио 14, радиогийн 6 студи, 11 мэдээллийн агентлаг, 1 баримтат киноны үйлдвэр, 6 интернетийн мэдээллийн online сүлжээ үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 220 нэрийн сонин, сэтгүүл тогтмол хугацаанд нэг удаа 1.2 сая хувиар хэвлэгдэж нэг айл өрхөд дунджаар 5-7 тогтмол хэвлэл ногдож байна.

/үргэлжлэл дараагийн дугаарт/

¹ Ш.Үнэнтөгс "Монголын хэвлэл мэдээлэл". УБ., 2000 он. 96 дэх талд

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл



Улсын дээд шүүхийн
шүүгч, докторант
Л.Бямба

Монгол Улсын Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хуваарилсан нь эрх зүйт төрийн нийтлэг зарчмууд эрх зүйн тогтолцооны шинэтгэлийн гол чиг шугам болж, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёсд төрийн эрх мэдлийн бүх салаа, түүний үйл ажиллагаа захирагдмал байх эрх зүйн шинэ дэг журмыг төлөвшүүлэх үйл явц өдгөө үргэлжилж байна. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын төлөвшил, хөгжил түүний эрх зүйн орчноос шууд хамаарна. Эрх зүйн орчин бүрэлдээгүй нөхцөлд шүүх эрх мэдлийн байгууллага хараат бусаар гагцхүү хуульд захирагдан ажиллах бололцоогүй бөгөөд улмаар эрх зүйт төрийн бусад суурь зарчмуудын хэрэгжилтэд ч сөргөөр нөлөөлдөг.

Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Үндсэн хууль болон бусад хуулиар байгуулсан шүүх бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх Үндсэн хуулийн шинэ зарчим хэрэгжиж эхэлсэн нь түүнийг тал бүрээс судалж, өөрчлөлт, хөгжилтийг байнга ажиглаж, ололтыг бататгаж, алдаа эндэгдлийг цаг алдахгүй

засаж залруулж, эрх зүйн зохицуулалтыг ямагт боловсронгуй болгож байх шаардлага зүй ёсоор бий болсон билээ. Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын төлөвшилтөөс ардчилсан нийгмийн суурь зарчмуудын хувь заяа шууд хамаарч байдаг тухай онолын дүгнэлт монголын нийгмийн өнөөгийн байдалд тод томруун харагдлаа. Шүүх эрх мэдлийн хараат бус байдал бүрэлдэх үйл явц бусад эрх мэдэлтэй харьцуулахад улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгмийн зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг, хамгийн нарийн төвөгтэй, их хүч чармайлт, цаг хугацаа шаарддагийг бусад улсын болон манай өнөөгийн туршлага харуулж байна.

1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн хууль төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд харилцан тэнцвэртэй, хяналттай, бие даасан байх зарчмын дагуу хуваарилснаар Монгол Улсын түүхэнд анх удаа шүүх эрх мэдэл нь Үндсэн хуулийн дагуу бие дааж бусад эрх мэдлээс хараат бус байх төдийгүй тэдгээрийг хуулийн хүрээнд хянах, эрх мэдлийн хувьд тэнцвэртэй, аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх бүхий эрх мэдлийн зохион байгуулалт, тогтолцоо болсон юм.

Монгол Улсын Үндсэн хуульд хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал, гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар, шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэхээр тусгасан нь төрийн эрх мэдлийг хуваарилах түгээмэл онолын үзэл баримтлалтай нийцэж байгаа юм.

Шүүх эрх мэдэл төрийн бусад салаа мөчрийн алинд ч байдаггүй бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хүний эрх, эрх чөлөө хасах, язгаарлах, тухайлбал, хүнийг цаазаар авах тогтоол гаргах, хувь хүн болон хуулийн этгээдийн хөрөнгийг хураах, шилжүүлэх, төлбөр гаргуулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг хаах, улс

төрийн намыг тараах, төрийн байгууллагыг шийдвэрээ өөрчлөх, бусад учруулсан хохирлыг барагдуулахыг шаардах, эцэг, эх байх эрхийг хасах зэрэг "аугаа" их эрх хэмжээг хэрэгжүүлдэг.

Нөгөө талаас бас харьцангуй сул эрх мэдэл мөн. Хууль тогтоох эрх мэдэл шиг иргэд-сонгогчдын шууд дэмжлэгт тулгуурладаггүй, гүйцэтгэх эрх мэдэл шиг хүчтэй механизм шүүхэд байдаггүй. Харин ч шүүхээр хэргээ шийдүүлсэн талуудын нэг болох шүүгчдэгч, иргэн, хуулийн этгээд нь ихэвчлэн шүүх, шүүгчид гомдож, шүүмжилж, өөсэв эрж байдаг. Гэвч шүүх эрх мэдлийн нэр хүнд, хүч чадал нь шүүхийн шийдвэрийн цэцэн мэргэн, хөдөлбөргүй байдал, хэлбэрэлтгүй хэрэгждэгт оршдог.

Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл үйл ажиллагааныхаа үрдүг ард түмэнд болон түүний төлөөлөгчдийн байгууллагад тайлагнадаг бол шүүх эрх мэдэл шударга ёсны үнэт зүйл, өндөр стандартад тулгуурлан хариуцлагаа өөрөө хэлээдэг онцлогтой.

Шүүхийн бие даасан байдлын үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын эрх зүйн баримт бичиг, үндсэн хуулийн эрх зүйн онол, зарчим, судлаачдын санал дүгнэлтэд тулгуурлан **нэгдүгээрт**, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй харилцан хяналт тэнцвэртэй, **хоёрдугаарт**, чиг үүрэг нь халдашгүй дархан, **гуравдугаарт**, бие даасан удирдлага, зохион байгуулалттай байхыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалж, баталгаажуулсныг багтаан үздэг.

Төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг монголын төр шинэ Үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрч, төрийн тогтолцооны үндсэн тулгуур болгосноор тус хуулийн 47 дугаар зүйлийн 1-д "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн үндсэн зарчим бий болсон юм.

Үндсэн хуулийн энэ заалтад нэгдүгээрт, шүүх бол бусад эрх мэдлээс хараат бус, бие даасан эрх мэдэл, хоёрдугаарт, шүүх эрх мэдлийн чиг үүргийн халдашгүй байдал, "хөдөлмөрийн хуваарь"-ийг Үндсэн хуулийн төвшинд тогтоосноос гадна өмнө нь шүүхийн хяналтад байгаагүй хэрэг маргааныг шүүх шийдэх Үндсэн хуулийн эрхийг нээж өгсөн юм. Монгол Улсын Үндсэн хууль шүүх эрх мэдлийг шүүхээс өөр ямар ч субъект эрхлэх ёсгүй гэдгийг тогтоосноор шүүх хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс бүрэн тусгаар гэдгийг заасны зэрэгцээ ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглож, шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулахаар заасан нь шүүх эрх мэдэл, шүүхийн бие даасан байдлын амин сүнс мөн. Шүүх эрх мэдэл хараат бус байхын эрх зүйн баталгаа нь тэрээр бие даасан, шүүгч хараат бус байх нөхцөл бүрэлдсэн байх явдал мөн. Энэ хоёр ойлголт хоорондоо салшгүй холбоотой боловч бас нарийн зааг ялгаатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг дотор нь (1) шүүгчийн хараат бус, (2) шүүхийн бие даасан байдал гэсэн хоёр хэсэгт салган авч үзсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3-д "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн Ерөнхий Зөвлөл ажиллана" гэжээ. Энэ нь шүүх хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хараат бусаар бие даан ажиллах нөхцөлийг хамтын удирдлагатай, тусгай байгууллага байгуулж, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоож, тэрхүү байгууллага нь шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр хүний нөөц, төсөв санхүү зэрэг шүүхийн байгууллагын бие даан, тогтвортой, хараат бус ажиллах нөхцөлийг хангаж ажиллахаар хуульчилсан нь шүүх эрх мэдлийн бие даасан байдлын зохион байгуулалтын нэг үндэс мөн.

"Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана" гэж Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 3-д заасан нь шүүх

бие даасан, шүүх эрх мэдэл эдийн засгийн хувьд хараат бус байхын Үндсэн хуулийн эрх зүйн баталгаа болсон юм. Монгол Улсын Үндсэн хуульд "шүүгч хараат бус байх", "шүүх, шүүгч зөвхөн хуульд захирагдах" гэсэн харилцан хамааралтай зарчмыг хуульчилж, тэдгээрийн хэрэгжих, биелүүлэх зохион байгуулалт, эрх зүйн хийгээд улс төр, эдийн засгийн баталгаа, механизмын үндсийг тогтоож өгсөн байна.

Шүүгчдийг томилох журам улс орнуудад харилцан адилгүй өөр өөр байдаг боловч хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас шүүгчийг томилох буюу сонгох журмаас татгалзах шаардлага нь шүүгчийн хараат бус байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлдэг. Хэрэв дээрх шаардлагыг зөрчсөн тохиолдолд шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх улс төрийн болон эрх зүйн боломж бүрдэх учраас төрийн эрх мэдлийг хуваарилах онолын хийгээд олон улсын дагаж мөрдөөл зохих шүүх эрх мэдлийн хараат бус байдлын үндсэн зарчмуудын дагуу шүүгчийг томилох асуудлыг тухайн орны Үндсэн хуулийн зохицуулалтын хэмжээнд авч үздэг.

"Шүүх эрх мэдлийн хараат бус байдал" нь төрийн эрх мэдлийн тогтолцоонд шүүх бие даан оршиж, шүүх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлэх эрх зүйн байдлын бүтцийн болон бүрэлдэхүүний байдал, чанарыг илэрхийлсэн ойлголт мөн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг "шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал" гэсэн хоёр зарчмын нийлбэр гэх үзлээр Үндсэн хуульд томъёолсон байна.

Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй харилцан хяналт тэнцвэртэй, чиг үүрэг нь халдашгүй дархан, бие даасан удирдлага, зохион байгуулалттай болохыг үзэл баримтлалын төвшинд тодорхойлсны зэрэгцээ "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", "шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно", "шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хариуцна", "шүүх бие даасан шүүгч хараат бус байна", "хэн боловч шүүгчээс шүүн

таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэж заасан нь Монгол Улсад шүүх эрх мэдлийн хараат бус байдлын Үндсэн хуулийн эрх зүйн үндэс бүрэлдсэн гэж үзэх үндэслэл мөн.

"Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус" гэдэг ойлголтууд нь хоорондоо нягт холбоотой нэгдмэл нэг ойлголт хэдий ч түүний бүрэлдэхүүн бүрдэл хэсгийг дотор нь задлан судалж үзвэл ялгаа заагтай өөр өөр утга ухагдахууны нэгдэл байдаг. Энэ талаарх үзэл баримтлалыг Үндсэн хуульд зөв тусгаж чадвал шүүх эрх мэдлийн бие дааж оршин тогтнох эрх зүйн үндэс бүрэлдэнэ. Зарим тохиолдолд шүүх эрх мэдлийн хараат бус байдлын ерөнхий ойлголтыг тухайн орны Үндсэн хуулийн илэрхийллээр хязгаарлахгүй, олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцүүлэх шаардлага гарч болох юм. Жишээ нь: 2002 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд "Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол эхлэлбэрээр мэдүүлэх эрхтэй." гэж заажээ. Энэ заалтаас үзэхэд шүүх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа олон улсын гэрээг баримталж болох эрх зүйн боломжийг нээж өгсөн байна. Гагцхүү энэ шаардлагыг хангахад Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн орсон байхыг тухайн хуулиар шаарджээ. Харин Үндсэн хуульд шүүх эрх мэдлийн хараат бус байдлын талаар тусгагдсан үзэл баримтлалаас гадна энэ талаарх түгээмэл онолын үндсэн зарчим, олон улсын гэрээ, конвенц, баримт бичгүүд зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүдийн заалтыг шүүх эрх мэдлийн байгууллага үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, 1985 онд болсон НҮБ-ын 7 дугаар үйл хурлаар Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын үндсэн зарчмуудыг баталсан бөгөөд үүнийг хожим нь Ерөнхий ассамблей санал нэгтгэжээр баталжээ. Шүүх эрх мэдлийн хараат бус байх үндсэн зарчмуудад шүүх эрх мэдлийн

хараат бус байдал, мэргэшил, сонгон шалгаруулалт, сургалт, шүүгчээр ажиллах нөхцөл, хугацаа, ажил мэргэжлийн халдашгүй байдал, хариуцлага хүлээлгэх, түдгэлзүүлэх, опруулах үндэслэл зэрэг тусгагджээ /Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 40/32 болон мөн оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 40/146 дугаар шийдвэрүүдээс харна уу/. Дээрх зарчмууд манай Үндсэн хуульд зохих ёсоор тусгалаа олсон юм.

Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2-д "Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно." гэж шүүгчийг томилон ажиллуулах дэг журмыг Үндсэн хуулиар тогтоож өгсөн нь шүүгчийн хараат бус байдлын чухал баталгаа болсон юм.

Шүүхийн бие даасан шинжийн нэг чухал үзүүлэлт болох шүүх өөрийн удирдлага, зохион байгуулалттай байх асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль мөн хуульчилж өгсөн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1-д Монгол Улсын шүүхийн нэгдсэн тогтолцоог тогтоож, "...шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд шүүхийн хяналтаас гадруур байх үл болно" гэж заасан нь шүүх, шүүгчийн ажлыг хэн ч удирдахгүй, хэний ч өмнө ажлаа хариуцаж тайлагнахгүй, зөвхөн хуульд үйлчилж, дээд шатны шүүхтэй мэргэжлийн хяналтын тогтолцоотой байхыг заажээ. Энэ бол өмнөх өө шиг Дээд шүүх тус улсын шүүхийн байгууллагын бүх ажлыг удирдаж, Ардын Их Хурал, түүний Тэргүүлэгчдэд ажлаа хариуцан тайлагнадаг байсан шиг бус зөвхөн мэргэжлийн хяналтын тогтолцоотой байх шүүхийн хараат бус байдлыг хамгаалсан заалт болсон юм.

Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн

3-д "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн Ерөнхий Зөвлөл ажиллана" гэжээ. Энэ нь шүүх хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хараат бусаар бие даан ажиллах нөхцөлийг хамтын удирдлагатай, тусгай байгууллага байгуулж, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоож, тэрхүү байгууллага нь шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр хүний нөөц, төсөв санхүү зэрэг шүүхийн байгууллагын бие даан, тогтвортой, хараат бус ажиллах нөхцөлийг хангаж ажиллахаар хуульчилсан нь шүүх эрх мэдлийн бие даасан байдлын зохион байгуулалтын нэг үндэс мөн.

"Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана" гэж Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 3-д заасан нь шүүх бие даасан, шүүх эрх мэдэл эдийн засгийн хувьд хараат бус байхын Үндсэн хуулийн эрх зүйн баталгаа болсон юм. Тиймээс Шүүх бие даасан улмаар шүүх эрх мэдэл эдийн засгийн хувьд хараат бус байх тухай Үндсэн хуулийн энэ заалт "шүүхийн ажлын нөхцөл, шүүн таслах ажиллагааны зардал, шүүгчийн цалин хангамж зэрэг нэг нэгнээсээ харилцан хамааралтай олон салбар асуудлыг багтаасан ойлголт бөгөөд аль нэг нь дутуу дулимаг, хүрэлцээ муутай бол шүүх хараат бус ажиллаж чадахгүй" хэмээн шүүхийн эдийн засгийн баталгааг иж бүрэн авч үзэх ёстой.¹ гэж үзэж байгаатай санал нэг байна.

Монгол Улсын Үндсэн хуульд "шүүгч хараат бус байх", "шүүх, шүүгч зөвхөн хуульд захирагдах" гэсэн харилцан хамааралтай зарчмыг хуульчилж, тэдгээрийн хэрэгжих, биелүүлэх зохион байгуулалт, эрх зүйн хийгээд үлс төр, эдийн засгийн баталгаа, механизмын үндсийг тогтоож өгсөн

байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1-д "Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана", 64 дүгээр зүйлийн 2-т "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна" гэж заасан нь шүүх эрх мэдлийн мөн чанар, гол онцлог, шударга ёс, шүүгчийн статусын амин сүнснийг илэрхийлсэн Үндсэн хуулийн зарчим бөгөөд шинэ үзэл баримтлалын цөм нь мөн.² Үндсэн хуулийн энэ цөм асуудлын хамрах хүрээ, мөн чанар, шинэлэг талыг зарим судлаач 1960 оны Үндсэн хуулийн холбогдох заалттай харьцуулан судлах замаар тодорхойлсон байна. Тэрээр бичихдээ: "Уг зарчим Үндсэн хуулийн томъёоллын хувьд ч агуулгын хувьд ч манайдаа шинэлэг зүйл мөн. Үүнийг өмнөх үеийн бодит байдалтай харьцуулан үзсэнээр илүү тод ойлгож болно. 1960 оны Үндсэн хуульд: "Шүүгч нар хэргийг шүүн таслахдаа хэний ч нөлөөнд орохгүй, гагцхүү хуулинд захирагдана" гэж заасан байв. Энэхүү томъёоллоотой шүүгч хараат бус байх шинэ Үндсэн хуулийн заалтыг яг адилтган үзэж "андуурах"³ явдал ч үзэгдсээр байна. Ийм хандлагатай эвлэрэх боломжгүй. "Шүүгч хэргийг таслахдаа хэний ч нөлөөнд орохгүй, гагцхүү хуульд захирагдана" гэсэн өмнөх Үндсэн хуулийн заалт хараат бус байх гэдгээс явцуу (өрөөсгөл) бөгөөд шүүгч иргэний маргааныг таслахдаа хуулиас гадна Намын Төв Хороо Засгийн газрын хавсарсан тогтоол, яам, хороодын зааврыг хүртэл баримтлан шийдвэрлэдэг байснаараа уул зарчим ёс төдий байсан юм" гэж шүүгчийн хараат бус байдал алдагдах гол үндсийг хуулиас гажих явдал гэдгийг түүхийн баримтад тулгуурлан сануулсан нь хуульд захирагдах нь шүүгчийн хараат бус байдлын цөм гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

¹ Ц.Нямдорж <<Шүүхийн хараат бус байдлын эдийн засаг, зохион байгуулалтын баталгаа "Шүүх эрх мэдэл-Шинэ зуун" олон улсын онол-практикийн бага хурал>>. УБ., 2001, 110 дахь тал

² Б.Чимид <<Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд. "Шүүх эрх мэдэл-Шинэ зуун" олон улсын онол-практикийн бага хурал>>. УБ., 2001, 53 дахь тал

³ Наад захын баримт бол шүүгчийн хараат бус байх тухай шинэ Үндсэн хуулийн зарчмыг 10 жилийн дараа 2002 оны 7 дугаар сарын 4-нд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуульд "Шүүгч гагцхүү хуульд захирагдана" гэсэн тодорхойлолт (гарчиг)-ын дотор оруулж, өөр нэг зарчмын тодотгол мэт болгожээ (Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл". УБ., 2004, 141 дэх тал)

⁴ Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл". УБ., 2004, 141-142 дахь тал

Монгол Улсын Үндсэн хуулийн "шүүгч хараат бус байх" гэсэн энэ томъёоллын цаана ямар агуулга, багтаамж, бүрдэл хэсэг, элемент байгааг нэг мөр тайлбарлаж, задаргаа хийгээгүй байна. Тийм ч учраас зарим эрдэмтэд "юунаас, юугаараа хараат бус байх гэдэг бол судалж тодруулуштай язгуур асуудал юм"¹ гэжээ.

Профессор Б.Чимид шүүгчийн хараат бус байдал албан ажил, мэргэжил, хувийн шинж чанарын талтайг тэмдэглээд шүүгч гагцхүү хуульд захирагдахгүй бол хараат бус байдлаа дараах хөндлөнгийн нөлөөнд алдана гэсэн утгаар хамгийн их магадлал бүхий ойрын нөлөөллийн хүрээнуудийг тодорхойлжээ. Үүнд "хууль тогтоох байгууллагын нөлөөнөөс, засгийн газар, түүний яам, агентлаг зэрэг захиргааны байгууллагын нөлөөнөөс, улс төрийн нам, төрийн бус бусад байгууллага, хучнуудийн нөлөөнөөс, нутгийн удирдах байгууллагын нөлөөнөөс, улс төр, засаг төрийн эрх мэдэл бүхий дээд, өндөр албан тушаалтны шахалт дарамтаас, төр, орон нутаг, хувийн болон иргэний нийгмийн зэрэг сонирхлын их, бага элдэв бүлэг хүмүүсийн оролдлого нөлөөнөөс, эцэст нь шүүхийн удирдлага, дээд шатны шүүхийн захиргаадаах нөлөөнөөс ангид байж үйл ажиллагаагаа явуулах учиртай" гэж шүүгчийн хараат бус байддал нөлөөлдөг зарим элементийг тодруулсан байна.

Профессор С.Жанцан шүүгчийн хараат бус байх хүрээг "нэгд, албан тушаал, ёс суртахуун, эд хөрөнгийн гэх мэтээр бусдын нөлөөнд үл автагдах, хоёрт, гагцхүү хуульд хатуу захирагдах, гуравд, бие дааж хуульд нийцсэн шийдвэр гаргах эрх мэдэлтэй нийлбэр юм"² гэж тодорхойлжээ. Монгол Улсын Үндсэн хуульд "шүүгч гагцхүү хуульд захирагдана" гэсэн зарчмыг томъёолсон нь нэгдүгээрт, шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчийн

хувьд хэрэг, маргаан шийдвэрлэхдээ хуулийг ягштал баримталж ажиллахыг, хоёрдугаарт, бусад эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны болон шүүгчдэд нөлөөлж болзошгүй бүх субъектын хүсэл зориг, албадлага, шаардлага, нөлөөнөөс шүүгчийг хамгаалсан, болзошгүй хууль бус үйлдлийг сонсохыг, дагахгүй, биелүүлэхгүй байхын хууль зүйн баталгаа, шүүгч хараат бус байх үндэс мөн. Тийм учраас ХБНГУ-ын судлаач К.А.Беттерманн шүүгч хараат бус байх, гагцхүү хуульд захирагдах тухай үндсэн хуульд ёсны баримтлалын харилцан хамаарлыг "үнэн хэрэгтээ шүүгч хараат бус байх гэдэг нь зөвхөн хуульд захирагдах зарчим дээр үндэслэсэн байдаг билээ. Шүүгчид хуульд захирагдсанаараа хараат бус байх, гагцхүү хуульд захирагдах тодорхой зорилт, зөвлөмж, санал бодол дээр бус харин бичигдсэн болон бичигдээгүй эрх зүйн нормуудын нэгтгэл болсон "хууль" дээр үндэслэн өөрсдийн шийдвэрээ гаргах ёстой. Шийдвэр гаргах ганц хэмжүүр нь хууль юм. Үүнийг баталгаажуулах, мөн шүүгчийн шийдвэрт нөлөөлж болохгүй хүчин зүйлд автагдахгүй байх явдалд шүүгчийн хараат бус байдлын утга учир, зорилго оршино"³ гэж хараат бус байдлыг хамгаалах хэрэгсэл, арга нь хуулийг баримтлах явдал гэж үзжээ. Үүний улмаас шинэ Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 2-д "Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэж хориглосон зохицуулалтыг оруулсан байна. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн эдгээр заалт бол шүүгч үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгийн аливаа хууль бус нөлөөнөөс шүүгчийг Үндсэн хуулиар "хуулиас өөр юунд ч захирагдахгүй гэж хэнд, хэзээ ч нүүр бардам хэлэх"

эрх зүйн баталгаа юм. Харин монголын шүүгчид тэгж хэлж чадаж байгаа эсэх нь өөр асуудал юм. Тийм учраас "шүүгч гагцхүү хуульд захирагдана" гэдэг бол эрх зүйт төрийн зарчмыг шүүх эрх мэдлийн хүрээнд шүүгч баримтлан хэрэгжүүлэх үндсэн зарчим учраас тухайн шүүгчийн субъектив эрх бус, Үндсэн хуулийн объектив зарчим юм. Энэ зарчмыг хэрэгжүүлж байдаг хувьд нь шүүгчийн хувийн хараат бус байдлыг мөн төрөөс Үндсэн хуулиар хамгаалдаг.

Шүүгчийн хувийн хараат бус байдлын зарим элементийг Монгол Улсын шинэ Үндсэн хууль хамгаалж өгчээ. Шүүгчийг төв, орон нутгийн хууль тогтоох болон хурлын байгууллагаас тэдгээрийн бүрэн эрхийн хугацаанд сонгодог байсан. Харин шинэ Үндсэн хуулиар шүүгчийг "бүх насаар" нь (хуулиар тогтоосон алба хаших насны дээд хязгаар хүртэл) томилодог болсон нь хэрэв шүүгч өөрөө хүсвэл тодорхой хугацаа бодолгүйгээр насан туршдаа тухайн ажил мэргэшлийг "өмчлөх" болсон нь түүний хувийн хараат бус байдлын чухал баталгаа болсон юм. Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 4-д Үндсэн хууль болон бусад хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр болон шүүгчийн өөрийн хүсэлтээс гадуур бүх шатны шүүгчийг огцруулахыг хориглосон нь шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга байх, аливаа нөлөөнд автахгүй байснаараа хувийн хохирол үзэхгүй байхыг шинэ Үндсэн хууль баталгаажуулсан гэж үзэж байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл, Монгол Улсын шинэ Үндсэн хууль шүүх эрх мэдэл хараат бус байх (шүүх бие даасан, шүүгч хараат бус байх) Үндсэн хуулийн эрх зүйн үндсийг бүрэн бүрдүүлсэн байна.



¹ Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл". УБ., 2004, 142 дахь тал

² Мөн гэнд. 142-143 дахь тал

³ С.Жанцан "Монгол улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын тогтолцоо". УБ., 2003, 3 дахь тал

⁴ Беттерманн К.А. "Шүүгчийн хараат бус байдлын утга агуулга ба хязгаарууд". Эргэцүүлэл. УБ., 2000, 121 дэх тал

Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, харьцуулалт

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
оюутан Д.Дэлгэрбат

Монгол Улс **дэлхий нийтийн чиг хандлагаас хоцролгүй** 1990 оноос ардчилсан эрх зүйт төрийг байгуулах үйлсэд эргэлт буцалтгүй орж, 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталсан. Дэлхий нийтийн чиг хандлагаас хоцролгүй хэмээн тодотгон авч үзсэний учир нь Үндсэн хууль баталсан үйл явц нь Монгол Улсад шинэлэг үзэгдэл биш боловч харин уг Үндсэн хууль нь үзэл баримтлалын хувьд шинэлэг бөгөөд хүний эрх, иргэний нийгэм, ардчилсан ёсны баталгаа болсон төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг бэхжүүлж чадсан оршино. Товчоор хэлбэл, уг зарчмын агуулга нь төрийн эрхлэдэг ажил үүргийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилан, тэдгээр нь эрх хэмжээнийхээ хүрээнд чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ ямар нэг хэмжээгээр бие биедээ хяналт тавих бололцоотой байх явдлаар тодорхойлогдоно. Үүний доторх шүүх эрх мэдэл нь нэгд/ эрүү, иргэний төдийгүй эрх зүйн бусад маргааныг эцэслэн шийдвэрлэх, хоёрт/ хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор хяналт тавих чиг үүрэгтэй байдаг.¹

Нөгөө талаас хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй гүйцэтгэх эрх мэдлийн буюу захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь тасралтгүй, байнгын явагдаж байдаг. Иймээс энд төр ба иргэний эрх, үүрэг болон ашиг сонирхол ямагт оролцдог². Харин энэ

харилцаанд захиргаа туйлын давуу эрх эдэлж, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол үргэлж хөндөгдөж байдаг. Учир нь хувь хүмүүс хоорондын харилцаанд нөгөө тал нь зөвшөөрсөн тохиолдолд харилцан үүрэг хүлээдэг бол төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх харилцаанд төрийн бүрэн эрхийг (нийтийн ашиг сонирхлыг) хэрэгжүүлэх үүднээс нэг талын хүсэл зоригийн дагуу үүрэг хүлээлгэхийг тодорхой тохиолдолд хуулиар зөвшөөрдөг. Иймээс л захиргаа болон иргэн хоорондын харилцаанд хөндлөнгийн буюу шүүхийн хяналт зайлшгүй чухал юм.

Ийм учраас Монгол Улсын Их хурал Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийг³ үндэслэн 2002 оны 12 дугаар сарын 26-нд “Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай” гэсэн хоёр хуулийг баталж 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөн захиргааны хэргийн шүүхийг байгуулан ажиллаж эхэлсэн. Харин уг захиргааны хэргийн шүүхийн гол үүрэг нь бол нийтийн захиргаатай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явдал юм.⁴

Хууль зүйн шинжлэх ухаанд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй нь материаллаг бус формаль шинжтэй буюу тухайн шийдвэрийн агуулгыг шууд тодорхойлохгүй, харин шийдвэрт хүрэх арга замыг тодорхойлдог гэж үздэг. Энэ нь иргэд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хөндлөнгийн гуравдагч эсгэрхээр маргаанаа эцэслэн

шийдвэрлүүлэх замаар хамгаалах бололцоотой байх тухай асуудал юм.

Хууль зүйн утгаараа захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулдаг тул эрх зүйн бусад салбаруудтай (эрүүгийн, иргэний процессын эрх зүй г.м) ижилхэн нийтлэг шинжүүдтэй байдаг. Үүнд:

1. ухамсарлагдсан, зорилго чиглэлтэй үйл ажиллагаа;
2. нийтийн засгийн субъектүүдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдон илэрч гардаг;
3. хууль зүйн ач холбогдолтой аливаа ажил хэргийг шийдвэрлэх эрх зүйн тодорхой үр дагаварт хүрэхэд чиглэдэг;
4. үйл явцын үе шат, түүний эцсийн үр дүнг албан ёсоор баримтжуулдаг зэрэг орно.⁵

Ийнхүү эрх зүйн салбаруудын хувьд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа нь нийтлэг үндэс суурьтай байдаг тул захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны олон асуудлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмын дагуу шийдвэрлэхээр хуульд заасан байна.⁶

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээр дурдсан ерөнхий шинжийн зэрэгцээгээр салбар эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын арга болон субъектүүдийн эрх зүйн байдал зэрэгээ шалтгаалан өөрийн

¹ Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал”. УБ., 2002 он, 116 дэх тал

² Хууль дээдлэх ёс (цэтгүүл) №2, Н.Отгончимэг “ЗХУШ Ажиллагаа”. УБ., 2003 он, 14 дэх тал

³ Үндсэн хуулийн 48-1-д “...эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”

⁴ Захиргааны хэргийн шүүх нь уг үүргээ биелүүлснээр захиргааны хууль бус үйлдэл, эс үйлдлээс иргэн, хуулийн этгээдийг хамгаалах, ардчилсан нийгэмд хэвшсэн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг арилгуулах явдлыг хангана.

⁵ Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал”. УБ., 2002 он, 227 дэх тал

⁶ Тодруулбал Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13, 21.2, 22.5, 25.1, 26.4, 30.1, 40.2, 47.4, 69.1, 82.1, 91.1, 92.1, 93.1 дэх хэсэг.

гэсэн онцлогууд байдаг. Тэдгээр зарим нэг гол онцлогуудыг цухас дурдвал:

❖ Шүүх өөрийн санаачлагаар хэрэг үүсгэхгүй. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь захиргааны актын улмаас зөрчигдсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, нэхэмжлэлийн үндсэн дээр хэрэг үүсгэдэг. Ер нь хууль зүйн шинжлэх ухаанд шүүх өөрийн санаачлагаар хэрэг үүсгэх үндэслэл нь нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн байх явдал байдаг бөгөөд нэгэнт энэ хувийн ашиг сонирхол зөрчигдсөн тухай асуудал яригдаж байгаа тул шүүх өөрийн санаачлагаар хэрэг үүсгэдэггүй байна.

❖ Нэхэмжлэл гаргагч иргэн, хармуцагч болох захиргааны байгууллага, албан тушаалтан хоёр нь хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо аль ч талаараа эрх тэгш байж чаддаггүй. Захиргаанд нотлох баримтыг цуглуулах хийгээд өөрийгөө өмгөөлөх чадвар болон материаллаг хүч боломж (хөрөнгө, мөнгө) өргөн хүрээгээр хангагдсан байдаг бол иргэний хувьд ийм боломж бололцоо байдаггүй. Нөгөө талаас дээр дурдсанаар иргэний гомдол, нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх хэргийг үүсгэх эсэхээ шийддэг. Иймд шүүх зөвхөн захиргаа иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нэг талыг л, тодруулбал, захиргааг шүүдэг гэсэн үг. Иймээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд инквизицийн буюу "хянан шалгах" зарчим үйлчилдэг. Энэ зарчим ёсоор захиргааны байгууллагын шийдвэрийг олох, нөхцөлийг тодорхойлох гэх мэт нотлох баримт цуглуулах үйл

ажиллагааг бие даасан хараат бус хөндлөнгийн шүүх гүйцэтгэнэ.

❖ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны болон шүүхийн журмаар хэрэгждэгээрээ эрүүгийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас онцлог юм. Захиргааны шүүхэд захиргааны акт нь нэхэмжлэлийн дагуу шалгагдахын өмнө захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа (ЗХУША) хийгдсэн байх ёстой.¹

Энэ зарчмын эрх зүйн үндэслэл нь "төрийн эрх мэдэл хуваарилах" зарчмаас үүсэлтэй. Өмнө авч үзсэнчлэн төрийн эрх мэдлийн салаа бүр нь эрх хэмжээнийхээ хүрээнд чиг үүргээ бие даан хэрэгжүүлдэг бөгөөд үүнээс гүйцэтгэх эрх мэдлийн буюу захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгийн их зөрчдөг. Иймд захиргааны байгууллагын үйл ажиллагааг шүүхийн хяналтад оруулах нь зайлшгүй гэж үздэгч энэ хөндлөнгийн хяналт нь **төрийн эрх мэдлийн салааны бие даасан тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр явагдах ёстой.**

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь хуулийн хэрэгжилтийг хангах, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах² зэрэг өөрийн чиг үүргийг **шатлан захирах** удирдлагын хэлбэрээр хуулийн хүрээнд **бие даан** гүйцэтгэх Үндсэн хуулийн үзэл баримтлалтай.

Шатлан захирах удирдлагын зарчим ёсоор олон тооны захиргааны актыг өдөр тутам гаргаж байдаг Засаг дарга, агентлаг, газар зэрэг Засгийн газрын байгууллагууд нь дээд шатны байгууллага, албан тушаалтнаас хараат байж, бие даасан харьяалагдан захирагдах статустай ажилладаг. Ийм учраас захиргааны дотоод хяналтыг хэрэгжүүлэгч ЗХУША

зайлшгүй байх шаардлага урган гардаг байна. Ийм хяналтгүйгээр захиргааны акт болгоныг захиргааны шүүхээр хянахад хүрвэл захиргааны байгууллага өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болно. Нөгөө талаас ЗХУША нь ЗХШХША-аас богино хугацаанд зардал багатайгаар явагддаг тул иргэнд, шүүхийн ачааллыг багасгадаг тул шүүхийн хувьд ч ашигтай байдаг.

Энэхүү ЗХУША нь хянан шийдвэрлэх ажиллагаа болохынхоо хувьд хэрэг явдлын учрыг олох, иргэний тайлбарыг сонсох, түүнтэй зөвлөх зэрэг нь анхан шатны захиргааны шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааныхтай адил байдаг ч захиргааны байгууллагын хүрээнд явагддаг хийгээд өөр өөр чиг үүргийг хэрэгжүүлдгийн хувьд ялгаатай зохицуулалтуудыг мөн агуулдаг. Үүнд:

1. ЗХШХША нь захиргааны **актын** хууль зүйн үндэслэлийг хянадаг бол ЗХУША нь уг актын хууль зүйн үндэслэлээс гадна зорилгодоо нийцсэн эсэхийг хянадаг.³ Өөрөөр хэлбэл, захиргааны актыг хууль зүйн үндэслэлээс гадна үр дүн, эдийн засгийн үр ашгийг хийгээд уг актын зорилго, дээд шатны захиргааны байгууллагын төсөөлөлд нийцсэн эсэх зэргийг давхар шалгана гэсэн үг.

2. Хэдийгээр захиргааны шүүхийн хяналт нь ЗХУША-ны хяналтаас явцуу хүрээтэй байдаг ч хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектуудын эрх зүйн байдал хийгээд чиг үүргийн хувьд давуу байдаг.⁴ Нийтийн захиргааны байгууллагын албан тушаалтан хуульд захирагдахын зэрэгцээ дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны заавар шийдвэрийг биелүүлдэг бол шүүгч гагцхүү хуульд захирагдан эцсийн шийдвэрийг гаргадаг.

Энэхүү урьдчилсан болон шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хоорондын харьцуулалтыг олон шалгуураар (гарч буй шийдвэрээр нь, үргэлжлэх байдлаар нь г.м) үргэлжлүүлж болох ч дээр дурдсан зүйлс бол зарчмын шинжтэй асуудлууд юм. Эцэст нь хэлэхэд ЗХУША нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь заавал шүүхээр засуулж байж хууль ёсны болох бус угаас хууль ёсны байх ёстой гэсэн зарчмыг хэрэгжүүлэгч гол механизм юм.

¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт энэ асуудлыг зохицуулсан байна.

² Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

³ Захиргааны эргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. УБ., 2001 он, 177 дахь тал

⁴ Захиргааны эргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. УБ., 2001 он, 189 дэх тал

ӨНӨӨГИЙН НИЙГЭМ БА ЯЛ ШИЙТГЭЛ

Өнөөгийн нийгэм бол "Хүний нийгэм", "Хүн төвтэй нийгэм" хэмээн ярьж бичсээр 15-16 жилийн нүүрийг үзлээ. Гэвч нийгэм хөгжихийн хэрээр гэмт хэрэг жилээр биш өдрөөр өсөж, гэмт халдлагын улмаас хүний амь бие, эрүүл мэндэд аюул занал учирч буйг цагдаагийн байгууллагын судалгаа бидэнд бэлхнээ харуулж байна. Нөгөөтэйгүүр цаг үе өөрчлөгдөхийн сацуу хүмүүсийн харилцаа өөрчлөгдөж байна. Ядуурал, хоосрол, ажилгүйдэл, гэр бүлийн тогтворгүй байдал, үр хүүхдээ алах, хаях, хүнд худалдах, албан тушаалтнуудын хүнд суртал, авилгал, хээл хахууль гээд энэ бүхэн хүмүүсийн хоорондын харилцааг итгэл үнэмшилгүй, хоосон хөндий болгож байгаа билээ. Урьд хожид дуулдаж сонсогдоогүй, олныг цочирдуулсан гэмт хэрэг олноор үйлдэгдэх боллоо. Үүнтэй холбоотойгоор олон жилийн хорих ялаар шийтгүүлэх явдал шүүхийн практикт олонтаа тохиолддог болжээ.

Эрдэмтэн судлаачдын бүтээлд ядуу амьдрал, оюуны хоосрол, шунахай цэвдэг сэтгэл, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл, эдийн засгийн хямрал гэхчилэн гэмт хэргийн шалтгаан талаас авч үзэж, нийгмийн шалтгааныг онцолсон байдаг.¹

Хүнийг зодох, санаатай алах, хүнд гэмтэл учруулах, гүтгэх, доромжлох, булаах, дээрэмдэх гэх мэт гэмт хэргийн цаана заавал архидалт байгаа нь нэгийг бодогдуулж байна.

Нийгмийн сэтгэл зүйд ялын боллогын талаар янз бүрийн ташаа ойлголт байна. Юуны улмаас хүн хорих ял эдэлж байна вэ гэдгийг сонирхдог. Их мэдээлэл цуглуулахыг хүсдэг. Тэгэхдээ



ШШГЕГ-ын харьяа Хорих 407 дугаар ангийн дарга, хурандаа, гавьяат хуульч Р. Оюунбадам

голчлон рецидив гэмт хэрэгтнүүд хорих ялаар шийтгүүлдэг байх гэсэн ойлголттой байдаг. Тэгвэл өнөөдөр гэмт хэрэг үйлдсэний улмаас насанд хүрэгсэд төдийгүй насанд хүрээгүй хүмүүс хорих ялаар шийтгүүлж байна.

Хорих ялын ойлголт, хэрэглэж буй хүрээ хязгаар, үр нөлөөний талаар олон нийтээс авсан санал асуулгад нийт 214 хүн оролцсоноос 31.7 хувь нь эрэгтэй, 69.2 хувь нь эмэгтэй, үүнээс бага боловсролтой 1.8 хувь, дунд ба бүрэн дунд боловсролтой 61.6 хувь, тусгай дунд боловсролтой 6.07 хувь, дээд боловсролтой 23.3 хувь хүмүүс байлаа.

√ Таны бодлоор хэрэгтнүүдийн үйлдсэн гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл нь тохирсон гэж үздэг үү гэсэн асуултад:

- Тийм - 15.8 хувь
- Зарим тохиолдолд - 82.2 хувь
- Үгүй - 1.8 хувь нь хариулсан байдлаас үзэхэд ял шийтгэлийн тухай нэлээд ерөнхий ойлголттой байна.

Сүүлийн жилүүдэд ахуйн шинжтэй, эдийн засгийн хохиролтойгоор үйлдэгдэн гарч буй гэмт хэргийн дийлэнх хувийг залилан мэхлэх, хулгай дээрэм, булаалтын хэргүүд эзэлж байгаа бөгөөд гэмт халдлагад өртөөгүй айл өрх, иргэд цөөхөн байна гэвэл хэтрүүлэг болохгүй байх.

Гэмт хэргийн улмаас жилд 20-оод тэрбум төгрөгийн хохирол учирдаг. Хохирол жилээс жилд өсч байгаа бөгөөд түүний дөнгөж 16-хан хувийг нөхөн төлүүлж байгаа гэж үзэхэд гэмт хэргийн улмаас нийгэм болоод иргэд ямар их хохирдог болох нь тодорхой байна.

Зарим тоо баримтаас авч үзвэл "3-4 жилийн өмнө 5800 ялтын хоол хүнсний зардлыг төрөөс авч байсан бол одоо 10000-12000 ялтын хоол хүнсний зардлыг төрөөс төлөх боллоо" гэжээ. Үүнээс эмэгтэй ялтын тоо 61.8 хувиар өсчихөөд байна.

Монгол Улсад жилд дунджаар бүртгэгддэг бүх гэмт хэргийн 10.8-аас 12 хувь, хорих ял эдлэгчдийн 6 орчим хувийг эзэлж байгаа зэрэг статистик тоо мэдсэн дээр түшиглэж хийсэн судалгаа бодитой жин дарна гэж бодож байна.²

Яагаад гэвэл өнөөдөр ялан эмэгтэйчүүдээс бусдад учруулсан гэм хорын төлбөр 2 миллиард 278 сая 633 мянган төгрөг, 199083 ам.доллар буюу 218991300 төгрөг, бүгд 2 миллиард 497 сая 624 мянган төгрөгийн гэм хорын төлбөрийн шүүхийн гүйцэтгэх хуудас бий.

Хулгай, залилан мэхлэх, өмч ашиглах, булаалт, дээрэм зэрэг хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд нийт ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 70 шахам хувийг эзэлж байгаа нь дээрх тоо баримтыг бататгаж байна. Иймд ялтын бусдад учруулсан хохирлын зарим хэсгээг дурдахад илүү ойлгомжтой болох байх.

¹ Н.Жанцан, "Криминологи", УБ., 2000

² "Бүрийн сонин", 2006 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр №089, 090

Ялтан /эм/ "Ц" 2003 оноос эхлэн төрийн бус байгууллага байгуулан бусадтай гэрээ байгуулж, /эм/ "Н", /эр/ "З" нартай бүлэглэн гадаадад ажиллах хүч гаргах эрхтэй гэдгээ бусдад итгүүлж, энэ хэрэгтээ хүч оруулах зорилгоор төрийн яамны тусгай зөвшөөрлийг ч гаргуулаад амжсан байх юм.

130 гаруй эзэн холбогдогчтой энэхүү хэргийн улмаас 384 628 793 төгрөг, 286 022 ам.долларын зөрчил илэрснээс 5 сая 4 мянган төгрөг, 259273 ам.долларын хохирол учирсан байна. Дээрх төлбөрийг ялтан "Ц" 8 жил хорих ял эдлэх хугацаандаа төлж барагдуулж чадахгүй гэдэг нь хэнд ч ойлгомжтой учраас хохирогчийн гомдол хэвээр үлдэнэ.

Шунахайн сэдэлт агуулсан залилан мэхлэх гэмт хэрэг зөвхөн эдийн засгийн хохирол учруулаад зогсохгүй, улс орны үндэсний аюулгүй байдалд ноцтойгоор хохирол учруулах хандлагатай болжээ. Үүнд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэрэг яахын аргагүй багтана.

1900-гаад оны үед Европод "Цагаан боол"-ын худалдаа гэж нэрлэгдсэн далд хэлбэрийн үзэгдлийг өнөөдөр монгол эмэгтэйчүүд гэмт хэрэг болтол нь хөгжүүлж байгаа нь нэн харамсалтай.

Хүнийг хил давуулан худалдах, худалдан авах гэмт хэрэгт эмэгтэйчүүдийг татан оролцуулж, тэр дундаа насанд хүрээгүй охидыг хамруулсан бусадтай бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн "Д" гэгч эмэгтэй чанга дэглэмд 10 жилийн хорих ялаар шийтгүүлжээ. Тэрбээр 15 иргэнээс 6731.0 мянган төгрөг, 2500 ам.доллар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэх өөртөө 1750.0 мянган төгрөгийн ашиг олсон байв.

Ялтан "Д"-гийн гэмт хэргийн энэхүү үйлдэл олон муу үр дагаврыг төрүүлж байна. Тэрээр хорих ангид ял эдлэхээр 5 сартай хүүхдийн хамт ирсэн юм.

Хүүхдийн эрх ашгийг харгалзан үзж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн дагуу 0-1 хүртэл насны хүүхэдтэй ялтуудыг тусгайлан зассан нөхцөл сайтай байранд

оруулах учиртай, гэтэл "Д" чанга дэглэмд ял эдлэх шийдвэртэй байдаг. Жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдтэй хамт хоригдох ёсгүй. Тэгээд яах вэ? Хуулийн зохицуулалт байдаггүй.

Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд бодолцож, түүнийг хүүхэдтэй эхчүүдийн байранд оруулснаар дэглэм, харуул хамгаалалт, хүмүүжил, хөдөлмөр гэхчилэн олон асуудалд сөргөөр нөлөөлнө. Өөр нэг бодох асуудал, төрөөс эх ба нярай хүүхдэд нэмж зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө мөнгө байхгүй. Гэтэл цаана нь хүүхдийн хүмүүжил, хувь заяа, гэр бүлийн асуудал гээд өч төчнөөн зүйл урган гарна.

Өнөөдөр монголчууд гадаадад гарч ажил хийж амьжиргаагаа дээшлүүлэх сонирхол унэхээр их байна. Монгол гэр бүлийн тавны нэг гишүүн гадаадад ажиллаж байдаг ажээ. Тэр хэмжээгээр улсын маань сан хөмрөг арвижин гадны хөрөнгө оруулалт өсч байна гэхчилэн ярьж бичих боллоо.

Энэ сонирхол, энэ эрх ашиг дээр дөрөөлж гэмт хэрэг үйлдэгчдийн тоо өсөж байгаа нь нууц биш юм. Энэ төрлийн бизнесийн гэмт хэргийг эмэгтэйчүүд бусдаас илүү авьяастай үйлддэг.

Солонгос, Япон, Герман гэх мэт оронд зорчих виз олгож өгнө гэх хэлбэрээр залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгч зарим ялтан эмэгтэйчүүдийн нэр дээр л гэхэд 324 эзэн холбогдогчтой, бусдад учруулсан гэм хорын төлбөр нь 360 сая 286 мянган төгрөг, 98720 ам.доллар байгааг харахад ойлгомжтой болов уу.

Эдгээр гэмт хэрэгтний дотор кино судлаач эрдэмтэн хүн хүртэл бий. Хүч хэрэглэсэн танхайн сэдэлтэй, аль эсвэл хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэгчдэд хорих ялыг ногдуулах нь зүйн хэрэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Гэвч бусдад онц их хэмжээний хохирол учруулсан толгой залилан мэхлэгчид байхад бас ядруу нэг нь ч байх юм.

2003 оноос эхлэн эмэгтэйчүүдээс үйлдэгдэж буй бүх гэмт хэргийн гарал, хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хэргийн зүйл

ангид ямар өөрчлөлтүүд гарч байгааг судалж үзэхэд хулгайн гэмт хэрэг буурах хандлага байгаа ба хохирлын хэмжээ харьцангуй багасаж байгаа хэдий ч жижиг хулгайн гэмт хэргийг давтан үйлдэгчдийн тоо буурахгүй байна.

5 сараас 3.8 жил хүртэл хугацаанд ял эдэлж байгаа 16 ялтны эдийн засгийн хохирлыг тусгайлан судалж үзэхэд тэднээс бусдад учруулсан гэм хорын төлбөргүй 3, төлбөр төлсөн 1, 31.7 хүртэл мянган төгрөгийн төлбөртэй 3, 59.0-650.6 мянган төгрөгийн төлбөртэй 9, бүгд 14 ялтны 2 сая 95 мянган төгрөгийн төлбөр байна. Хэрэв эдгээр 16 ялтан 3 жилийн дотор ял эдэлж дуусаад суллагдана гэж тооцож үзвэл төрийн сангаас 83 сая 641 мянган төгрөгийн зардал гарч байна. Товчхон хэлбэл, 16 ялтан эмэгтэйн үйлдсэн гэмт хэргийн улмаас 2 сая төгрөгийн эдийн засгийн хохирол учирч дээрээс нь 83 сая төгрөгийн зардал төрөөс нэмж зарцуулж байна /Судалгааны дүнг хүснэгтээс үзнэ үү/.

Ийм байдлаар улсын хэмжээний бүх ялтууд төрөөс ямар хэмжээний зардал гаргаж ял эдэлдэггүй тооцож үзвэл их сонин дур зураг гарах нь ойлгомжтой.

Хоёр баримт дурдася.

Ялтан "Д" 20 настай, тэрээр насанд хүрээгүй байхдаа хулгайн гэмт хэрэг үйлдэж 2001 онд Эрүүгийн хуулийн дагуу 3 жилийн хорих ялаар шийтгүүлж, ялаас хугацааны өмнө тэснэн суллагдсан байна.

2004 онд хулгайн гэмт хэрэг давтан үйлдсэн тул 10 жил 2 сарын хорих ялыг чанга дэглэмд эдлэх болсон. Энэ нь хуульд нийцэж байгаа боловч 62300 төгрөгийн хохиролтой энэ эмэгтэй 10 жил ял эдлэхдээ төрөөс хоол, хувцас, орон байр, гэрэл, дулаан, харуул хамгаалалтын, сургалтын гэхчилэн жилд 605200 төгрөг, 10 жил 2 сар болоход 6 сая 52 мянган төгрөгийн зардал гаргаж ял эдлэх юм.

Нөгөөтэйгүүр 20 настай бүсгүй хорих газраас 30 настай суллагдахад түүнийг ямар орчин хүлээж авах, цаашид эмэгтэй хүний насны онцлогтой холбоотой бие сэтгэлийн өөрчлөлт, гэр бүл, үр хүүхэд гээд өч төчнөөн зүйлийг

№	Үлс	Хүсний зүйл	Хүсний зүйл байдал	Ял эзлэхийн байдол	Хүсний байдал	Хүсний үзвэл	Дэлгэм	Үүрчлэсэн бүх хохирол	Басгалуулсан байдал	Нэг хонигддаг төрөөс гаргаж байгаа бодит зардал - хонигт 2017		Тайлбар
										Өнөөдрийн байдлаар гарсан бодит зардал	Явцын нийт хувиараа гаргаж бодит зардал	
1	УБ	22	145.2	нэг адуу, ам бул 8	2ж 6с	2ж 2с 8ж	3	жир	164.1 мт	үүд	1815300	Цүнхэн дотор 144 000 төг, 5 кг гурил, 1 ш талх, 1 ш пудра, 1 булчин цэг зэрэг байсныг хуулайж авсан.
2	Ун	23	145.2, 58.1	нэг адуу, ам бул 3	2ж 6с	1ж 9с	2	жир	30000	баргалуулсан	1815300	Иргэний хэлбэлснээс мөнгө хуулайсан.
3	ОБ	41	145.4	өрх толгойлсон	10ж 3с 2ж	3ж 6с	3	жир	59.0 мт	үүд	7446764	Насанд хүрээгүй хүнийг татан оролцуулж орон байранд нэвтрэн орж хуулайсан.
4	ОЦ	32	145.4	нэг адуу, ам бул 7	5ж 2с	1ж 2с 27ж	3	чонга	650.6 мт	үүд	3751620	Төмөр хуулайсан.
5	БД	20	145.4	нэг адуу, ам бул 7	10ж 2с	онц хүнд	3	жир	24.6 мт	үүд	7382220	Насанд хүрээгүй баймдаа хуулай хийж байсан.
6	ГТ	33	145.2, 261.1	нэг адуу, ам бул 7	10ж 1х	онц хүнд	2	жир	телбөрүй	үүд	7262127	5 ш булганы арьс хуулайж баймдаа үлдэл дээрээс боригдсан.
7	Оу	40	145.4	элдүүл, ам бул 6	10ж 1х	онц хүнд	6	чонга	62.0 мт	үүд	7263217	Цүнх зүүсэн.
8	ГХ	19	148.3, 261.1	оов, эзлэхийн хамт	10ж 1с	1ж 4с 26ж	2	чонга	317850	үүд	7321710	Бусдын эд хөрөнгийг онц их хэмжээгээр хуулайсан, бусдыг заллисан мээлсэн.
9	Дн	20	145.4	адуу	10ж 1с	2ж 2с 6ж	4	чонга	62300	үүд	7321710	Иргэдийн орон байранд нэвтрэн 687900 төгрөгийн эд зүйл хуулайсан.
10	Дж	34	145.4	адуу	10ж 10х	9с 22ж	5	чонга	телбөрүй	үүд	7281370	Иргэн Энхзавалийн цүнхээс 150000 төгрөг хуулайсан.
11	Нд	26	145.1, 58.1	эхж, хүүхдүүдийн хамт, ам бул 5	1ж 3с	3с 12ж	2	жир	телбөрүй	үүд	907650	Марал супермаркетээс 8 шил Чингис архи хуулайсан.
12	Бц	33	145.2, 58.1	оов, эзлэх, дүү нарын хамт, ам бул 4	3ж 6с	3ж 6х	2	жир	85000	үүд	2541420	2005.12.17-нд иргэн Сийн гэрээс мөнгөн ага 1ш, Бадмажуунай гэрээс хөгжим 1ш, Цэрмэдэгийн гэрээс дорж 1ш хуулайсан.
13	Гц	19	145.4	ах, элч, дүү нарын хамт, ам бул 5	10ж 1с 24ж	3ж 3с 17ж	3	жир	18000	үүд	7370118	Иргэн Насанжаралын Ким нарийн зурвийн элээрээ хуулайсан. Долгоржавын Түрийвчтэй 10500 төг хуулайсан.
14	ТБ	32	145.2	ам бул 2, хүүгийн хамт, ам бул 5	3ж	9с 29ж	3	жир	275500	үүд	2178360	2005.2.10-нд дэлгүүрээс 80000 төг, 2005.5.9-нд дэлгүүрээс 40000 төг, 2005.6.23-нд дэлгүүрээс 70000 төг хуулайсан.
15	Цс	21	145.2	нөхөр, хүүхдүүдийн хамт	2ж 4с	5с 11х	2	жир	235000	үүд	1694280	Иргэдийн гэрт нэвтрэн 523000 төгрөгийн хонирол учруулсан.
16	Сб	22	145.2	эм бул 10, эмээ, эзлэх, элч, дүү нарын хамт	3ж 5с 16ж	3ж 5с 16ж	3	жир	141685	үүд	2904480	Иргэн Чингэдэлзэрийн хэлбэлснээс 95 доллар 14500 төг, Давасзүрэнгээс 14600 төг, Внөрмөнөөс монетон эмзэг, бөгж, Оюунсүрэнгээс эмзэг, нийж, 10 доллар, 8000 төг тус тус хуулайсан.
Дүн										1769279	83640956	

Тайлбар: 5 сардээс 3 жил 8 сар хүртэл ял эзлэж байгаа 16 хүнд төрөөс 17 сая 682 мянга 799 төгрөгийн зардал гаргаж байна. Цэвэрхэд эдгээр жилүүд ял эзлэж байгаа 83 сая 640 мянга 956 төгрөг зарцуулаа тооцож орж байна.

ургуулан бодоход сөрөг үр дагавар илүү байна.

Ялтан "А" хулгайн гэмт хэрэг дахин давтан үйлдэж бусдын цүнхнээс 11155 төгрөг хулгайлж, цагдаад үйлдэл дээрээ баригдахдаа 1300 төгрөг үргэдүүлж бусдыг эзэнд нь эргүүлэн өгсөн байна.

Шүүхийн шийтгэх тогтоолд "Эрүүгийн хуулийн 145.4-т зааснаар түүнд 10 жил 5 хоногийн хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хориход эдлүүлсүгэй. "А" бусдад төлөх төлбөргүй" гэжээ.

Гэтэл ялтан "А" төрөөд нэг сар болж байгаа учраас 1 сартай нярай хүүхдээ тэврэн хорих ангид ирсэн юм.

Эдгээр баримтыг дурдах болсон шалтгаан нь буруу шийтгэж байна гэж хэлэх гэсгүй боловч Эрүүгийн хуулийн зарим заалтыг өөрчлөхийг амьдрал шаардаж байна.

Өнөө үед ялын бодлого чангахан байхыг эрүүгийн нөхцөл байдал шаардаж байгаа хэдий ч гэмт хэрэгтийг баривчлах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах шатанд гэмт хэрэгтнээс учруулсан эдийн засгийн хохирлыг нөхөн төлүүлэхэд хамгийн үр дүнтэй үе шат гэж боддог. Яагаад гэвэл хорих ял шийтгүүлээд хорих ангид ирсэн ялтны сэтгэл зүйд нэгэнт ял эдэлж байгаа учраас төлбөр хамаагүй гэсэн нэгэн бичигдээгүй хууль үйлчилдэг юм.

Тэд зөвхөн хорих ангийн дотоод журмыг сайн биелүүлж яаж ийгээд ялаас чөлөөлөгдөхийг чухалчилдаг. Зарим хохирогчид дараах бодолтой байдаг. "Хорих анги ялтнаар хөдөлмөр хийлгэдэг, ажлын хөлснөөс нь төлбөрөө авна" гэсэн ойлголт байдаг. Хорих анги ялтны нэрийн дансанд сард дунджаар 5-10 мянган төгрөг бичиж, шүүхийн гүйцэтгэх хуудсын дагуу шилжүүлдэг боловч хэдэн арван сая төгрөгний хохирол учруулсан ялтны төлбөр барагдахгүй гэдэг нь ойлгомжтой.

Шүүхийн практикаас харахад бусдад учруулсан хохирол төлөгдөөгүй л бол "хорих анги руу"

явуулах хандлага газар авч байгаа нь нууц биш юм. Ялтан болсноор улс, нийгэмд учруулж байгаа эдийн засгийн хохирлыг тооцож үзэхгүй байна.

Ингэснээр хорих ангиуд хүнээр дүүрч, улмаар хорих ял эдлүүлэх ажиллагааны наад захын стандарт хангагдахгүйд хүрнэ.

Өнөөдөр хорих ангиудад тулгамдсан олон асуудал байна. Заримыг дурдвал ялтан д ял эдлүүлэх, хийсэн гэмт хэрэгт нь гэмшүүлэх, гэм хорыг арилгах, суллагдан гарахад нь бэлдэх, нийгэмшүүлэх гэх мэт.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 10 дугаар зүйлд хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлэх, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна хэмээн заасан байдаг. Ялтны дунд зохиох сургалт, хүмүүжлийн ажлын хүрээнд дэлхийн болон өөрийн оронд болж буй үйл явдлуудын мэдээллээр хангах, нийгмийн амьдралд бэлдэх ажлуудыг авч үзэх нь чухал байдаг.

375 хүнийг оролцуулсан олон нийтээс авсан санал асуулганд:

Таны бодлоор хоригдож буй хүмүүст нэн түрүүнд анхаарах шаардлагатай зүйл юу гэж бодож байна гэсэн асуулганд 23.2 хувь нь илчлэг хоол хүнсээр хангах, 5.3 хувь нь хувцсаар хангах гэж үзэж байхад 32.0 хувь нь эвдрэлтэй хүмүүсийг хүмүүжүүлэх нь чухал гэжээ. 10.4 хувь нь харгалзагчийн зүгээс дарамт шахалт байдаг, 17.8 хувь нь эмнэлгийн үйлчилгээ төдийлөн хангалттай биш, 11.2 хувь нь чийрэгжүүлэх биеийн тамирын дасгал, спорт танхимаар хангах нь чухал гэхчилэн хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 78.9 хувь нь хорих газарт сургалт хүмүүжлийн ажил хангалтгүй, эх орондоо болон дэлхий дахинд болж байгаа мэдээллийг дутуу авдаг гэж үзжээ.

Хамт ял эдлэгсдийн зүгээс бусдынхаа эрхэнд халдах тохиолдол байдаг уу. Хэрэв

байдаг бол ямар хэлбэрээр илэрдэг бол гэсэн асуултад 26.6 хувь нь бие махбодийн дарамт үзүүлдэг гэж үзсэн байхад 54.2 хувь нь сэтгэл зүйн дарамт үзүүлдэг, 12.1 хувь нь гадуурхдаг гэжээ.

Ялтнууд өөр хоорондоо хов ярих, хэрүүл, зодоон хийх, янз бүрийн муу зүйлийг бодож олохоос урьдчилан сэргийлэх хамгийн сайн арга бол тэднийг завгүй байлгах, өөрөөр хэлбэл, хөдөлмөр хийлгэх юм. Хүмүүжлийн нөлөө үзүүлэхэд гол анхаарах зүйл бол хууль, эрх зүй, сэтгэл зүй, криминологи судалгаан дээр түшиглэн тэднээс гэмт хэрэг үйлдэх болсон шалтгааныг бодитой тогтоож хийсэн гэм бурууг нь ойлгуулж, гэмшүүлэх нь үр дүнтэй байдаг. Тухайлбал, сэтгэл санааны дэм үзүүлэх, урам хайрлах, нэн тэргүүний хэрэгцээт зүйлийн хангалт хийх, энэ ажилд хүмүүнлэгийн болон төрийн бус байгууллагуудтай сайн хамтын ажиллагаа тогтоох, төрөл бүрийн сургалтанд хамруулах, мэргэжлийн баримжаа олгох, ирээдүйдээ итгэх итгэл найдвар төрүүлэх, гэр бүл, хүүхэд садан төрөлтэй нь холбож өгөх, уулзалт өдөрлөг зохиох, ялтныг нийгмийн амьдралд буцаан оруулах, суллагдах ажиллагааг эртнээс бэлтгэх зэрэг ажлууд орно.

Хорих ангиас суллагдан гарч байгаа иргэдэд цаашид ажиллах, амьдрах эрх зүйн орчин ямар байна вэ гэдгийг хаа хаанаа бодож үзэх асуудал мөн.

Нийгмийн сэтгэлгээнд хоригдож байгаа хүнийг мөнхийн ялтан байх юм шиг үзэл бодол бий. Иймээс тэдний хүн гэдэг эрхэм зүйлсийг орхигдуулж, хий хоосон жигшин зэвүүцэж, ял эдэлж байх хугацаанд нь гэр бүл, ойрын садан төрлийн хүмүүс нь нүүр буруулж тэдэнд сэтгэл санааны дарамт учруулдаг. Эхнэр нөхөр нь салж, үр хүүхэд нь хараа хяналтгүй орхигдож, ял эдлэхийн өмнө эдэлж хэрэглэж байсан эд хөрөнгө нь үгүй болсон байдаг. Хорих ангиас суллагдаад очиход нь наашаа гэж харж хандах хүнгүй болж, албан байгууллагууд нүүр буруулан цэрвэж холдуулдагаас дахин давтан гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Ийнхүү хүний мөсгүй хандлага нь ял эдэлж байгаа буюу суллагдсан хүмүүст хүндээр тусч тэдний амьдрах итгэлийг алдагдуулаад зогсохгүй нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлдэг.

Үүнтэй холбогдуулан 2 төрлийн санал асуулга явуулсан юм.

1. Хорих ангид ял эдэлж байгаа 91 ялтнаас хэрэв та суллагдвал цаашдын амьдралаа хэрхэн зохион байгуулах вэ, суллагадад яаж амьдрах вэ? гэж асуухад 39.7 хувь нь ажил хайна, 25.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлнэ, 7.5 хувь нь ар гэрийнхээ тусламжийг харна, 1.07 хувь нь гадаад руу гарна, 10.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Иргэний үнэмлэхтэй эсэх асуулганд 56.9 хувь нь байхгүй, 5.3 хувь нь солиулж амжаагүй гэж хариулжээ.

2. Ял эдэлж байгаад суллагдсан 41 иргэдээс танд амьдралын ямар баталгаа байна вэ гэж асуухад 6 нь буюу 14.6 %

нь ажил хайх итгэлтэй, 29 хүн буюу 70 хувь нь бичиг баримтгүй, 35 хүн буюу 85 хувь нь ажил олж чадахгүй гэж хариулсан байна.

Амьдралын баталгаа хэр зэрэг байдгийг судалж үзэхэд 27.9 хувь нь амьдралын баталгаагүй гэж хариулсан ба 39.5 хувь нь хувийн хашаа байшинтай, 4.6 хувь нь өөрийн гэсэн өмч хөрөнгө байхгүй ах дүү, төрөл садан дээрээ очно гэж хариулсан байна.

Хорих ангид ял эдэлж буй хүмүүс ямар боловч зохих хэмжээгээр өөрчлөгддөг. Тэд суллагадад хорих ангийн хаалгаар гарахдаа "сайхан амьдарна" гэсэн өөдрөг сэтгэл өвөрлөөд гардаг.

Энэ үед эрх зүйн таатай орчин хэрэгтэй. Гэтэл хуульд зохицуулалт үгүй байдаг. Юуны өмнө эндээс эхлэх нь чухал.

Эрүүгийн ял шийтгэлийг эрх зүйгээр зохицуулах түүхэн үеийг авчирсан 1931 оны БНМАУ-ын Засан сайжруулах хуулиас эхлээд 1993 онд батлагдан гарсан Хорих байгууллагын болоод хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль хүртэлх бүх хуулиудад ялаас

чөлөөлөгдсөн иргэнийг нийгмийн амьдралд буцаан оруулахтай холбогдсон олон сайхан заалт байсан. Үүний дагуу практик амьдралд хэрэгжиж байсан баримтууд олныг дурдаж болно.

Харамсалтай нь 1993 оны хуулиас хойшхи хуулиудад суллагдсан иргэнээ нийгэм хэрхэн хүлээж авах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй болсон.

Өмнөх хуулиудын дэвшилттэй заалтыг уламжлал болгон хуульчилж өгөх нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Ялтан хүний хөдөлмөр бол Монгол Улсад хийгдэж байгаа хөдөлмөрийн нэг төрөл яахын аргагүй мөн. Гэтэл Монгол Улсын Хөдөлмөрийн хууль тогтоомжид хорих ялаас суллагдсан хүн улс нийгэмдээ хөдөлмөр хийсэн үнэлэмж нь байх ёстой. Гэтэл ийм зохицуулалт байхгүй байна. Үүний нэгэн адил Нийгмийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж өгмөөр байна.

Суллагдсан иргэдийг эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамжинд хамруулж, тэдний хүүхдүүдэд мөнгө олгох гэх мэт олон зүйлийг нэрлэж болно.



“ГАНЦ ХУДАГ” БУЮУ ЦАГДАН ХОРИХ ТӨВИЙН ЭРТ, ЭДҮГЭЭГИЙН АСУУДАЛ*

Хууль зүйн ухааны доктор профессор А.Лхагваа “Гяндан салаанаас шүүхийн шийдвэр биелүүлэх газар болж өргөжсөн түүхэн замнал 1921-2001 он” номондоо тэмдэглэж хэлэхдээ: “Шинэхэн үеийн нэгэн үе буюу 1921 оноос хойшхи үеийн судалгааны материалд түшиглэн энэхүү номоо бүтээсэн тул энэ удаад 1921 оноос өмнөх түүхийн эх сангаас судлах, суралцах асуудлыг нээлттэй орхилоо” гэжээ.

Миний бие 1921 оноос өмнөх түүхийн эх сангаас судалж байгаа бөгөөд шинэхэн үеийн боловч хараахан судлагдаагүй байгаа орчин луу нэвтрэн орж, багагүй материалтай болсон хэдий ч олж мэдээгүй, дутуу дулимаг судалсан, бас ч эргэлзээтэй зүйл их байна.

Энэ удаад Ганц худаг буюу өнөөгийн Цагдан хорих төв цаг үеэ даган хэрхэн өөрчлөгдөж ирсэн түүх, түүний ирээдүйн дүр төрхийг хэрхэн төсөөлдөгөө уншигч таньтай хуваалцахыг хүсч байна.

Монгол Улсын төр эрх зүйн түүхийн томоохон хэсгийг шорон гяндангийн түүх эзэлдэг гэвэл маргах хүнгүй бизээ.

1912 оноос эхлэн Монгол Улсын тусгаар тогтнолыг хамгаалах зорилгоор Богд хаант төрөөс олон чухал арга хэмжээ авч явуулсны дотор 1913 онд Богд хаан гяндан гадаад улсын янзтай шинэ байшин болгон үйлдэгтүн гэсэн зарлиг гаргасан байна. Жил өнгөртөл шинэ гянданг барилуаагүй учир олноо өргөгдсөний 1914 онд Богд хаан улаан бийрээр цохож Дотоод яаманд тусгай зарлиг буулгасан байна.

Богд хааны зарлигийн дотор өгүүлсэн нь: “Улсын гяндан элж

хуучирсан, хэрэг халдаж хорьсон цэргүүд, жич бусад ялтан хүн нар шахцалдан багталцахгүй болсон ба угаас Чин улсын дүрмээр үйлдэгдсэн нь ялт хүн нар тусгай шээх, баах газаргүй, цөм хольцолдон үнэхээр үзэмжгүй байтугай, хэдий хэрэг халдсан хэмээвч олох ял тусгай буй бөгөөд үнэхээрийн хөөрхий мэт ... иймд гянданг нэн даруй шинэтгэх” гэжээ.

Богд хааны зарлигийг шаламгайлан биелүүлээгүй 2 яамны сайд ихэд сандарч Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам 1914 оны 4 дүгээр сарын 16-нд шинэ гяндан барилуахаар Юан Хуй Мин хэмээх морин толгой, Чин Да Жин хэмээх Долнуурын хужаа, Да Сан Циа хэмээх эр малгай нарын 3 нүүстэй гэрээ байгуулан ажил эхэлжээ.

Уг гяндан нь төв өмнөдөд 5 өрөөтэй, урт нь 5 хос алд, өндөр нь нэг хос алд нэг тохой, өргөн нь нэг хос алд 2 тохой, тоосгон туургатай, шавардсан, орос их цонх 4, бага цонх 4, өмнө хойноо банзан хаалга 2, чулуун довжоотой, хоёр ямх¹ банзан дэвсгэр шалтай, дотор нь шавар ханз зуухтай, шургаагаар дэвэр тавьж, шавардсан байшин нэг. Үүнд сахиx дарга, хуяг нар сууж, ялтны идэж уух зүйлийг бэлтгэнэ.

Гадуур нь хоёр хос алд,² бүдүүн шургаагаар шорон үзүүртэй хашаа барилуулж, хос алдын шургаагаар давхар хашаа барихаар гэрээнд тусгаж, гянданг 3 сарын дотор барилуулж дуусгасан бололтой байна. Гяндангийн өртөг 1 түм 7 мянга, 300 төгрөг болжээ. Гяндан нь Шүүх яамны харьяанд байгуулагдав. Ингэж Богд хаан шинэ гяндан барилсан байх бөгөөд Богдын Засгийн газар хууль хамгаалах байгууллагуудын ажилд ч шинэтгэл хийсэн юм.

Эдгээр гянданд Халх даяар алдартай Нийслэл хүрээний их гяндан, Их шавийн гяндан, Баруун хүрээний гяндан зэрэг шоронгууд зүй ёсоор багтан орж байна.

Эдгээр гянданд төрд тэрсэлсэн, хулгай дээрэм хийсэн, хүний бие эрхтэнийг гэмтээсэн, албан татвар төлөөгүй зэрэг гэмт хэрэг үйлдэгсдийг хорьж шийтгэдэг байсан гэнэ.

Сэцэн хан аймгийн суурин жасааны дэнжийн баруун өмнөдөд Зүүн Сэлбийн зүүн хөвөөнд Манжийн амбан сайдын газар, түүний харьяа төлөөний түшмэлийн газруудын ялтан хорих гянданг Нийслэл хүрээний их гяндан буюу Батгүний шорон хэмээн нэрлэдэг байж.

1. Батгүн нь хатуу чанга гяндан байсан ба тэндээс нэг ч хэрэгтэн ялтан оргож чадаагүй учраас “Бат” гэсэн бөгөөд Манжийн засгийн үед өгдөг байсан гүн цолыг нэмж нэрлэсэн гэж ярьцгаадаг.

Батгүний шорон гадуураа 2 давхар шовх үзүүртэй модон өндөр хашаатай, хашаа бүрдээ өндөр модон хаалгатай, дотроо тоосгоор хийсэн болов уу гэмээр шавардсан, нэг дан цагаан байшин байжээ. Ийм байшин дотроо хэд хэд байсан байж магадгүй юм.

Засан сайжруулах газрын 1926 оны эхний хагас жилийн тайлан мэдээнээс үзвэл шинээр барьсан модон ба тоосгон барилга 46, хуучин барилга 13, эсгий гэр 26 байжээ. Улаанбаатар хотод төв гяндангийн шинэ барилгыг 1928 онд эхэлж бариад 1929 оны 9 дүгээр сард шинэ байрандаа хуучин гяндангийн хүмүүсийг шилжүүлсэн байна.

Энэ үеэс эхэлж Гяндан салааг өргөтгөж Улсын төв засан сайжруулах газар байгуулснаар Батгүний гяндан татан буугдаж

* ШШГЕГ-ын харьяа Хорих 407 дугаар ангийн дарга, хурандаа, гавьяат хуульч Р.Оюунбадам

¹ 1 ямх 3.2 см, 2 алд гэдэг нь дунджаар 1 м 60 см, 1 дэлэм гэдэг нь 2 алдыг хуваасны 1-тэй тэнцнэ

² “Өчил сонин”. 1992 он, №5

Батцагаан хэмээх шорон баригдсан гэж үздэг.

2. **Батцагааны шоронгийн хоёр давхар.** "П" маягийн тоосгон байшинг 1929 оны 9 дүгээр сарын 12-нд барьж ашиглалтанд оруулжээ. Үүний голын том байшинг нь мөрдөнгийн зориулалтаар, бусад өрөө тасалгааг эмнэлэг, халуун ус, угаалга, гал тогоо, ялтны байр, үйлдвэрийн зориулалтаар ашиглаж эхэлсэн.

Батцагааны шоронд цаазаар авах ялтай хүмүүсийг хорьдог. Энэ нь их хатуу чанга подвалтай байсан бөгөөд 18 камертай байжээ. **(18 дугаар камерын хаалга одоо хэлмэгдүүлэлтийн музейд тавиагтай бий.)** Камерийн хаалга нь модоор хийсэн, 170 см орчим өндөртэй, бор өнгийн зосон будгаар будсан, жижиг шайгайвчтай, шайгайвчаа тойрсон хааш хаашаа дөрвөлжин шар өнгийн будагтай. Энэ хаалга нь дотор талдаа төмөрлөсөн, нилээд бөх бат хийгдсэн, дээр доор хоёр хөндлөн торон бэхэлгээтэй байв.

Байшинг тойруулан жижиг дан байшингууд барьжээ. Энэхүү урьдчилан хорих байруудыг тойруулан хуучин Батгүний гяндангаас шилжүүлэн авчирсан оройг нь шовхолсон өндөр модон шургааган хашаатай байшин нь гаднах хашаанаасаа дээш нилээд илүү гарсан харагддаг байжээ. Бас харуулын өндөр модон цамхагтай байсан хэмээн 1981 онд 85 настай байсан Цогт овогтой Лувсансамдан /энэ Батцагааны шоронд хоригдож арьс нэхий элдэж байсан/, Өвгөөдэй Дамдинсүрэн нар тодорхойлжээ.

Батцагааны гяндан урьдчилан хорих байрыг 1955-1956 онд цонхыг нь өөрчлөн томруулж, гол хаалгыг хойд талд нь гаргаж их засвар хийгээд Арьс өнгөний больниц болгон өөрчилжээ. **(Батцагааны шоронг байрлалын хувьд хотын төв дунд орсон гэсэн шалтгаанаар)**

1. Түүнийг нүүлгэн шилжүүлж 1955 онд нийслэл хотын хойд талд Цагаан давааны энгэрт зэвсгийн склад байсан улаан тоосгон

байшин болон дүнзэн байшинд байрлуулжээ.

2. Энэ гяндан нь Ганц худгийн аманд 1961 онд Германы зураг төсвөөр шинэ гяндан барьснаар нүүн шилжүүлэгджээ. 1961 онд баригдсан гяндан балгас болсоор олон жилийг үдэж, 2006 оны 4 дүгээр сард буулгасан билээ.
3. Одоогоор 1995, 2000 онуудад шинэчлэн барьсан 5 давхар байшинд сэжигтэн, яллагдагчийг урьдчилан цагдан хорьж байна.

Монгол Улсын нийслэл хотын зүүн хойт аманд орших цагдан хорих төв ийнхүү өөрийн түүхэндээ нийслэл хотынхоо баруун урьд талаас нар буруу эргэж, зүүн хойт талд гартлаа таван удаа буйраа сэлгэжээ. Түүний бас нэг халаа сэлгээ нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас Цагдаагийн Ерөнхий газрын харьяанд, эргээд ШШГБ-ын харьяанд гэх мэтээр харьяаллаа ч олон солиод авсан байна.

Буйраа олон удаа сэлгэж, хоёр хэргийн дүнд өнхөрлөө гээд энэ байгууллагын нэр сайнаар дурсагдаж байсангүй гэвэл хэтрүүлэг болохгүй байх. Дашрамд дурдахад, Монгол Улсын хорих байгууллагууд түүхийн аль ч цаг үед нийгэм, иргэдэд гадурхагдаж хотын зах руу оршин тогтнож иржээ.

1990 оноос ардчилал, зах зээлийн системд шилжсэн үеэс хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийн эрхийн асуудал хүчтэй яригдаж буй өнөө үед ШШГБ-ын харьяа Цагдан хорих төв болон хорих ангиуд: **Дэд бүтэц хөгжөөгүй газар байрлаж** байна. Энэ нь: төвийн нэгдсэн халаалт, төвийн халуун, хүйтэн усны холболтонд ордоггүй гэсэн үг юм. Ийнхүү хүнд орчноос улбаалан амьдрал ямар байхыг төсөөлөхөд хялбар болно.

Дэлхийн бусад оронд, өндөр хөгжилтэй орнуудын шорон гяндангууд хотын төв дундаа, дэд

бүтэц хөгжсөн газарт байрладаг юм билээ.

Жишээ нь, АНУ-ын Алабама муж улсын Мобаль хотын төв гяндан хотын төвдөө, хотын шүүхийнхээ хажууд байрлаж байдаг. Энэ гянданд ойролцоогоор 1200 сэжигтэн, яллагдагчийг хорьж цагддаг бөгөөд түүнээс 160 нь эмэгтэйчүүд байв.

АНУ-ын Алабама муж улсын Алабама хотын од хэлбэрийн гяндан хотын төв дунд оршдог. Мужийн шоронгуудад хүнээ хуваарилдаг.

Холбооны Герман улсын Баруун Берлин хотын төвд "Алдарт Моабитын шорон" байдаг. Энд Германы Коммунист намын дарга Эрх Хоникер гэх мэт нийгэм, улс төрийн алдар цуутай хүмүүс хоригдож байсан түүхтэй юм.

Хамгийн сонирхолтой нь Холбооны Герман улсын Ерөнхийлөгчийн "Bellevue" ордны хажууд энэ шорон оршдог гэх мэтээр улс орнуудын шорон гяндангийн байрлалыг тоочвол олон жишээ бий.

Дэлхийн бусад оронд зөвхөн гяндан, цагдан хорих төв биш зарим Засан хүмүүжүүлэх газрууд (Correction facility, Correction center, Correction institution) нь хотын захад байсан ч тэнд нь дэд бүтэц хөгжсөн байдаг юм билээ.

Энэ бүхнээс харвал Монгол Улс хүний эрхийг эрхэмлэн дээдэлж үздэг орны тоонд ордог бол дээрх асуудлыг төрийн бодлого болгон авч үзэх цаг болжээ.

Монгол төрийн бодлого нь зөв цэгцтэй байвал хорих байгууллагын ажилтны нийгмийн асуудал, боловсрол, мэргэжлийн ур чадвар дээшлэх нь мэдээж юм.



Үргэлжлэл. (түрүүч нь 2006 оны №2-т)

Компьютерийн гэмт хэрэг^{*}

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш,
докторант Ц.Хүрэл-Очир

• Компьютерийн гэмт хэргийн объектив, субъектив тал

• Компьютерийн гэмт хэргийн ангилал

Дэлхий нийтийн даяаршлын өнөө үед эрх зүйн шинэ салбар нь тухайн орны нийгэм, эдийн засгийн хөгжлөөс хамаарахгүйгээр мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн хурдац, эдийн засгийн либералчлал, улс төрийн бодлогын хүрээнд үндэсний болон олон улсын эрх зүйн түгээмэл хэм хэмжээ шинээр үүсэн бүрэлдэж, үндэсний эрх зүйд нөлөөлөх замаар хөгжих боллоо.

Гэмт хэргийн бүлэглэлүүд мэдээлэл, холбооны техник, технологийг ашиглан улс үндэстэн, хил хязгаар дамнасан гэмт халдлага, хууль бус үйл ажиллагаа эрчимтэй явуулж байгааг дэлхийн улс орнуудын шүүхийн практик, эх сурвалжууд баримтаар нотолж, хувь хүн, нийгэм, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг улс үндэстний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тулгуур хүчин зүйлийн нэг гэж үзэх хандлага түгээмэл болжээ.

Орчин үеийн мэдээлэл, холбооны технологийг ашиглан үндэсний мэдээллийн нөөц баялаг, түүний эрх ашигт заналхийлэх аливаа халдлагаас хамгаалах асуудал өдгөө нэг үндэстний хэмжээнд бус, дэлхийн олон улсын өмнө хурцаар тавигдаж, уг асуудлыг эрх зүйгээр төрөлжүүлэн зохицуулах, эсвэл технологийн оновчтой шийдлийг эрэлхийлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

"Компьютерийн гэмт хэрэг"-тэй тэмцэх асуудал судлаачдын дунд олон янзын үзэл бодол, маргаан мэтгэлцээнийг өрнүүлж буй бөгөөд уг гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголттой болох, тулгарч буй бэрхшээлийг зөв тодорхойлж, шийдвэрлэх арга зам боловсруулах, нэгдсэн системчлэл бүрдүүлэх боломжийг шинжээчдэд олгох нь хууль зүйн практикт чухал ач холбогдолтой юм.

Компьютерийн гэмт хэргийн объектив, субъектив тал

Компьютерийн гэмт хэргийг зүйлчлэхэд хэд хэдэн онцлог шинжийг харгалзан үзэх шаардлагатай. Тэдгээрийн нэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал болно. Гэмт хэргийн объектив тал буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх үр дагаварт хүргэсэн үйлдлүүдийг практикт илрүүлэн нотлоход нилээд бэрхшээлтэй байдаг. Энэхүү бэрхшээл нь компьютерийн систем, түүний процессийн нарийн үйл ажиллагаа, үйлдэгдсэн гэмт хэргийн санаатай болон болгоомжгүй хэлбэртэй шууд холбоотой. Ялангуяа болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдсэн компьютерийн гэмт хэргийн хувьд дээрх бэрхшээл илүү их тулгардаг.

Компьютерийн гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талыг зөв тогтоох явдал маш чухал. Хэрэв программист үйлдлийн дарааллыг өөрчилсний улмаас үйлдвэрлэлийн дамжлага зогсож, ажил үйлчилгээ тасалдсан бол санаатай болон болгоомжгүй үйлдэл, эсхүл мэргэжлийн алдаа гаргасан зэрэг шалтгаан нөхцөлийг тогтооход

төвөгтэй. Программистыг буруугийд тооцож болох үндэслэлийн нэг нь мадаггүй алдаагүй, төгс программ хангамж одоогоор гараагүй байгаа нь түүний үйлдлийг цагаатгах хууль зүйн нэгэн гарц байж болох юм. Гэхдээ дээрх үйлдлүүдийн улмаас учруулсан нийгмийн хор аюул, хохирлын хэр хэмжээгээр нь эрүүгийн, эсвэл захиргааны болон эрх зүйн бусад зөрчилд хамааруулах эсэхийг нарийн зааглаж өгөх нь онол, практикийн ач холбогдолтой.

Заримдаа компьютерийн гэмт хэргийн халдлагын зүйлийг тодорхойлоход нилээд төвөгтэй байдаг. Жишээлбэл, аль нэг хэрэглэгчийн компьютерийн эсрэг чиглэсэн гэмт халдлага эцсийн үр дүндээ хоорондоо холбогдсон глобаль сүлжээ, түүний бүтцэд илүү их хор нөөц учруулж болзошгүй юм.

Хууль зүйн практикт компьютерийн дийлэнх гэмт хэргийн объект нь "нийгмийн харилцааны аюулгүй байдал" байдаг. Хэрэв нэгэнт "компьютерийн" гэсэн тодотголтой нийгмийн шинэ төрлийн харилцаа бий болсон бол түүнийг эрүүгийн эрх зүйн, өргөн утгаараа эрх зүйн хамгаалалтын объект гэж үзэх боломжтой.

Компьютерийн халдлагыг ерөнхийд нь:

- Компьютерийн техникийн ашиглалт, түүний хэрэглээтэй холбоотой харилцаанд халдах;
- Компьютерийн мэдээллийн аюулгүй байдалд халдах;

* "Компьютерийн гэмт хэрэг" гэж томъёолох нь зөв эсэх, хэрэв ингэж томъёолбол ямар төрлийн гэмт хэрэг энэ ангилалд багтах талаар олон жилийн турш судлаачид маргаан өрнүүлж байна. Энэ нь нийгэмд аюултай үзэгдлийн ангилалд "компьютерийн гэмт хэрэг" багтах эсэх; мөн "компьютерийн гэмт хэрэг" гэсэн нэр томъёог хэрэглэхдээ "мэдээллийн гэмт хэрэг", "мэдээллийн технологи ашиглаж үйлдсэн гэмт хэрэг", "кибер гэмт хэрэг", "өндөр технологийн орчин дахь гэмт хэрэг"-үүдтэй холж хутгаж зэрэг асуудлаас үлдэлтэй ажээ.

• Компьютерийн системийг хариуцсан ажилтны "найдавартай" байдалд халдах гэж ангилж болох юм.

Дээр дурдсанчлан онолын хувьд алдаагүй, төгс программ гэж нэгэнт бий болоогүй, эсвэл байх боломжгүй гэж үзэж буй нөхцөлд энэ нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талыг үгүйсгэж байгаа учир программистад хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй гэж үзэж болох юм. Гэвч тухайн субъект болгоомжгүй хэлбэрээр ТЭМ (тооцоолох электрон машин)-ны өгөгдлүүдэд өөрчлөлт хийсний улмаас бусдад учруулсан нийгмийн хор аюул, хохирлын хэр хэмжээг үндэслэн хууль зүйн хариуцлага хүлээлгэх боломжтой.

Ерөнхийдөө техник ашиглалтын хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэг ихэнх тохиолдолд тусгай субъектгүй байхыг шаарддаг. Гэвч компьютерийн гэмт хэргийн хувьд хэдийгээр техник ашиглалттай холбоотой хэдий ч дээрх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээс ялгаатай байдаг. Нийгмийн компьютержих процесс энэмдэгж, компьютерийн сүлжээ улам олширч байгаагаар уялдан жирийн хэрэглэгчид ч санаатай болон болгоомжгүй байдлаар энэ төрлийн гэмт хэргийн субъект болох тохиолдол ихсэх хандлагатай боллоо.

Компьютерийн гэмт хэргийг мөрдөн шалгах явцад яагаад хүндрэл учирдаг вэ? Хууль зүйн практикт компьютерийн гэмт хэргийг мөрдөн шалгах явцад түүний объектив, субъектив талыг тогтооход нилээд бэрхшээл тулгарч байна. Гэмт этгээд "тодорхой бус" орон зайд ажилладаг учир үүсэх үр дагавар нь мөн нэгэн адил тодорхойгүй байдаг. Тиймээс гэмт этгээд уг гэмт үйлдлийн улмаас учрах нийгмийн хор аюулыг гүйцэд тооцоолох боломж хярацангүй бага. Энэ нь зөвхөн вирус (нян) зохиогч, тархаагчид төдийгүй, компьютерийн бусад гэмт хэрэгтнүүдэд ч хамааралтай бөгөөд

иймэрхүү тодорхой бус нөхцөл байдал байнга үүсэж болзошгүй. Тухайлбал, компьютерийн сүлжээнд зөвшөөрөлгүй буюу хууль бусаар нэвтрэх оролдлогын үед дээрх тодорхойгүй нөхцөл байдал бий болдог. Гэмт этгээд өөрчилж, устгаж, ашиглах боломжгүй болгож буй мэдээллийн үнэ цэнийг, тэр тусмаа түүний үйлдэл хор уршиг бүхий "гинжин урвал" үүсгэж болзошгүйг тэр бүр сайн ухаарч ойлгодоггүй. Нэг төрлийн үйлдэл тооллын системийн төлөв, түүний ачаалал, хамгаалалт болон найдавартай байдлын зэрэглэлээс хамаарч харилцан адилгүй хууль зүйн үр дагавар үүсгэдэг.

Хэрэв гэмт этгээд математик загварчлалын "тоглоомын онол"-ыг ашиглаж буй бол өрсөлдөгчийнхөө ухаалаг, эсвэл хайхрамжгүй үйлдэл, бусад үйл ажиллагааг ямагт тооцоолж, өөрийн хэрэглэх стратеги, тоглоомын дүрмээ нөхцөл байдалд тохируулж өөрчилж, сайжруулж байдаг. Тэгэхдээ тэрээр буруу шийдвэр гаргаснаас буй болох эрсдлийг бууруулахыг оролддогосой биш, түүний үйлдлээс үүссэн нийт хохирлыг тооцдоггүй. Энэ бүхэн компьютерийн гэмт хэргийн шалтгаант холбоо, түүнээс үүсэх үр дагавар, санаатай болон болгоомжгүй хэлбэрийг тогтооход хүндрэл учруулж болох юм.

Академич С.Нарангэрэл материаллаг бүрэлдэхүүнтэй гэж "тухайн гэмт хэргийн төгсгөлд Эрүүгийн хуулиар бодитой хор уршиг буй болгохоор тогтоосныг ойлгоно" гэж үзжээ. Энэхүү онолын тайлбарыг үндэслэн компьютерийн зарим төрлийн гэмт хэргийн объектив талыг (Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 226, 229 дүгээр зүйл) материаллаг бүрэлдэхүүнтэй гэж үзэх боломжтой.

Электрон гарын үсгийн тухай АНУ-ын Холбооны хуулинд мэдээллийг "Текстэн, зураг, дуу авиа, код, компьютерийн программ, мэдээллийн сан гэх мэт үүнтэй ижил төстэй хэлбэр бүхий мэдээ"² гэж тодорхойлсон байна. Мэдээллийн технологийн стандартад

зөвшөөрөгдсөн энэхүү хялбар, ойлгомжтой томъёоллыг цаашид Монгол Улсын хууль зүйн практикт хэрэглэхэд тохиромжтой.

Компьютерийн мэдээллийг санаатайгаар өөрчилсөн, эвдсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, мэдээллийн сүлжээг сүйтгэсний улмаас уг мэдээллийг эзэмшигчид хууль зүйн үр дагавар учруулах нь Эрүүгийн хуулийн 226 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын зайлшгүй шинж юм.

Энэ гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр илэрнэ.

Нянтай программ зохион бүтээсэн, ашигласан, тараасны улмаас мэдээлэл эзэмшигч, ашиглагчид хор уршиг бүхий үр дагавар учруулах нь Эрүүгийн хуулийн 229 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын зайлшгүй шинж болно.

Нянтай программ зохион бүтээх гэдэг нь ТЭМ-д зориулсан программчлалын аль нэг хэлийг ашиглаж, хорлон сүйтгэх зориулалттай алгоритм (программ)-ыг зохион бичихийг хэлнэ. Программыг ашиглах, тараах гэдэгт түүнийг бүтээгчийн "орчноос" гадна уг программыг хэрэглэх хүрээг тэлэх явдлыг хамааруулан үзэж болно. Өөрөөр хэлбэл, энэхүү гэмт хэргийн субъектив тал нь компьютерийн мэдээллийг устгах, хаах, өөрчлөх, хуулбарлах, тараах зорилго бүхий шууд санаатай үйлдэл байна.

Мэдээллийг устгах гэдэгт түүнийг сэргээж ашиглах боломжгүй болгосон гэмт үйлдэл, мэдээллийг хаах гэдэгт тухайн мэдээлэл бүрэн бүтэн байх хэдий ч түүнийг чөлөөтэй ашиглахад саад учруулах, мэдээллийг өөрчлөх гэдэгт эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тухайн мэдээллийн хэлбэр, агуулгыг өөрчилж, түүнийг хууль ёсоор ашиглах гэж тус тус тодорхойлж болох юм.

Профессор Г.Совд "Монгол Улсын Эрүүгийн хуулийн 227 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн объектив талыг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байна"³ гэж тайлбарлажээ. Энэ гэмт хэрэг нь мэдээллийг зөвшөөрөлгүй олж авахаар завдсанаар бүрдэл төгсдөг

¹ С.Нарангэрэл "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги". УБ., 1999, 113 дахь тал

² Электрон гарын үсгийн тухай АНУ-ын Холбооны хууль. 15 U.S.C. § 7006 (2002)

³ Г.Совд "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар". УБ., 2002, 321-323 дахь тал

хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Харин энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр илэрнэ. Эрүүгийн хуулийн 228 дугаар зүйлд заасан гэмт хэргийн объектив тал нь компьютер, мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ болон техник хэрэгсэл бэлтгэсэн буюу борлуулсан үйлдэл байх бөгөөд гэмт этгээд ТЭМ, түүний систем, компьютерийн сүлжээнд хууль ёсны эзэмшигчийн зөвшөөрөлгүй нэвтэрсэн үйлдлийг "хууль бус" гэж үзэж болно. Энэ гэмт хэргийн объектив талын онцлог нь түүний хэлбэрийн бүрэлдэхүүнтэйд оршино.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 25 дугаар бүлгийн зүйлүүдийн диспозицийг хэрэглэхийн тулд мэдээлэл, холбооны харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн бусад актын холбогдох заалтыг авч үзэх шаардлагатай. Хэдийгээр ийм шаардлага байгаа ч гэсэн манай улсад одоогоор "Мэдээллийн аюулгүй байдал", "Мэдээллийн технологи"-той холбогдох харилцааг зохицуулсан хууль тогтоомж батлагдаагүй байгаа нь нэлээд хүндрэл учруулж байна.

Компьютерийн гэмт хэргийн ангилал

Компьютерийн системд нөлөөлөх үйлчлэлээс нь хамаарах компьютерийн гэмт хэргийг дараах ерөнхий төрөлд хувааж болох юм. Үүнд:

1. Механик үйлчлэл - тоног төхөөрөмж гэмтээх, өгөгдөл, программ хангамж устгах, худал мэдээлэл оруулах, мэдээлэл хулгайлах үйлдэл;

2. Үйлдлийн үйлчлэл - залилан (өөр этгээдийн эрх ашиглах, эсхүл өөр этгээдээр өөрийгөө төлөөлүүлэх), зөвшөөрөлгүйгээр янз бүрийн хэрэгсэл, төхөөрөмж ашиглах үйлдэл;

3. Программын үйлчлэл - программ хангамжин системийг өөрчлөх янз бүрийн арга (тухайлбал, "трояны морь" - прогарммын ажлын горимыг өөрчлөхгүйгээр өөрийн тодорхой

зорилгыг гүйцэтгэх командыг бусдын программд нууцаар оруулах, "логик бөмбөг" - тодорхой нөхцөл буюу цаг хугацааны агшинд ямар нэг зөвшөөрөлгүй үйлдэл хийх командыг бусдын программд нууцаар оруулах);

4. Электрон үйлчлэл - программ хангамжийг өөрчлөхтэй ижил үр дүнд хүргэдэг схемийн болон аппаратын хэсгийг өөрчлөх үйлдэл гэж тус тус хамааруулж болох юм.

ОХУ-ын судлаач Ю.М.Батурин компьютерийн гэмт хэргийг үйлдэгдэх аргаар нь ангилж, замаас нь барих, зөвшөөрөлгүй нэвтрэх, арга заль хэрэглэх гэсэн гурван үндсэн бүлэгт хуваасан байна.¹

Замаас нь барих арга: Шууд барих (interception) - Холбооны сүвгийн систем, эсхүл компьютерийн сүлжээнд шаардлагатай төхөөрөмжийг (микрофон, радио хүлээн авагч, диктофон, модем, принтер г.м.) холбож, мэдээллийг замаас нь барина. Чагнах объект нь кабелийн, шугамын, газрын богино долгионы, сансарын холбооны, төрийн холбооны зэрэг төрөл бүрийн систем байдаг.

Цахилгаан соронзон барилт (electromagnetic pickup) - Шууд контактгүй ажилладаг төхөөрөмж ашиглана. Холбооны систем, төв процессор, дэлгэц, хэвлэх төхөөрөмж зэрэг техник, хэрэгслийн үүсгэх цахилгаан соронзон цацрагийг ашиглаж мэдээлэл авдаг. Гэмт этгээд мэдээлэл авч буй объектоос хангалттай зайтай байрлаж, энэ үйлдлийг гүйцэтгэх боломжтой.

Зөвшөөрөлгүй нэвтрэх арга: Мэргэжлийн хүрээнд эдгээр арга нь дараах тусгай хэллэгийг хэрэглэдэг. "Тэнэгийн араас"

(pigbacking) - Хаалттай электрон бүс, бусад орон зайд зөвшөөрөлгүй нэвтрэхэд ашиглана. Компьютер дээр ажиллахад хэрэглэдэг аль болох олон эд зүйлийг гартаа барьж, "терминал" байрлах цоожтой хаалганы дэргэд ажил хэрэгч байдалтай эргэлдэж байгаад, нэвтрэх зөвшөөрөлтэй хэрэглэгч

ирэхэд түүний хамт итгэлтэй нэвтрэнэ гэсэн үг.

"Сүүлнээс нь барих" (between the lines entry) - Гэмт этгээд холбооны шугамд холбогдсон хууль ёсны хэрэглэгчийн ажлын идэвхтэй горимоо дуусгах дохиог хүлээн авмагц түүнийг шүүрэн авч системд нэвтрэх аргыг хэлнэ.

"Компьютерийн зэрэгцсэн тулалдаан" (hacking) - Бусдын мэдээллийн сүлжээнд нэвтрэхийн тулд хэрэглэдэг энгийн арга. Гэмт этгээд телефон утасны шугаманд холбогдсон аль нэг компьютерт нэвтрэхийн тулд хэрэглэгчдийн дугааруудын хувилбарыг автоматаар оруулж, идэвхтэй бусад компьютерт хариу өгөх хүртэл оролдлого хийнэ. Үүний дараа дохио өгсөн харилцах дугаар өөрийн компьютерыг холбож, кодыг нь тааж олсноор бусдын мэдээллийн санд нэвтрэх боломжтой.

"Яаралгүй сонгох" (browsing) - Хамгаалалтын систем дэх сул талыг ашиглаж, хууль ёсны хэрэглэгчийн мэдээллийн сан, файлд зөвшөөрөлгүй нэвтрэх үйлдэл. Гэмт этгээд хамгаалалтын сул талыг илрүүлснээр мэдээллийн системд агуулагдаж буй мэдээллийг унших, шинжилгээ хийх, түүнийг хуулж авах, мөн дуртай үедээ нэвтрэх боломжтой болно.

"Онгорхой зай хайх" (trapdoor entry) - Программ зохиогчдын гаргасан программ хангамж дахь логик алдааг ашиглаж үйлдэл. Илрүүлсэн "онгорхой зай"-г нэг бус удаа ашиглаж болно.

"Люк" (trapdoor) - Өмнөх аргын сайжруулсан хувилбар. Илрүүлсэн "онгорхой зай"-д программыг "дэлбэлж", тэнд хэрэгцээтэй тооны командыг оруулна. Шаардлагатай үед "люк"-ийг нээхэд суурилуулсан командууд автоматаар өөрийн үүргийг биелүүлнэ.

"Хуурамч баг" (masquerading) - Энэ тохиолдолд гэмт этгээд шаардлагатай техник хэрэгсэл ашиглаж, өөрийгөө хууль ёсны хэрэглэгчээр төлөөлүүлж системд нэвтрэнэ.

"Мэхлэн төөрүүлэх" (spoofing) - "Бусдын" системд тохиолдлоор нэвтрэсэн үед ашиглах үйлдэл. Гэмт этгээд санамсаргүй (алдаатай) холбогдсон

¹ Батурин Ю.М. Проблемы компьютерного права. - М.: Юриздат, 1991.

хэрэглэгчид үнэмшилтэй хариу өгч, түүний төөөргдлийг тодорхой хугацааны турш барьж, өөрт ашигтай зарим мэдээллийг (тухайлбал, хэрэглэгчийн код) олж авна.

"Ослын" (emergency) - Аль ч компьютерийн төвд тооцоолох электрон машины ажиллагаанд саатал, эсвэл бусад гажилт гарсан үед ашиглагдах онцгой программыг хэрэглэдэг. Энэ арга нь ийм нөхцөлд тулгуурладаг бөгөөд гэмт этгээдийн гарт дээрх программ орсон тохиолдолд хүчтэй, аюултай зэвсэг болно.

"Ханагүй агуулах" (warehouse without walls) - Системийн эвдрэлийг ашиглаж, зөвшөөрөлгүй нэвтрэнэ. Тухайлбал, хэрэглэгчийн зарим файлууд нээлттэй үлдсэн тохиолдолд гэмт этгээд түүний мэдээллийн санд нэвтрэх боломжтой.

Арга заль хэрэглэх: "Мэдээлэл солих" (data change) - Тооцоолох электрон машинд мэдээлэл оруулах буюу гаргах үед түүнийг өөрчлөх, эсхүл шинэ мэдээлэл оруулна. Энэ нь хамгийн энгийн арга тул түгээмэл ашиглагддаг. Тухайлбал, код солих үйлдэл нь мэдээлэл солих аргын нэг хувилбар юм.

"Удирдлагын самбарыг хуурах" (Manipulation with a control panel) - Тооцоолох электрон машины техник, хэрэгсэлд механикаар нөлөөлж, мэдээлэл солих (запилах) боломж бүрдүүлнэ.

"Трояны морь" (trojan horse) - Хэрэглэгчийн программын ажлын горимыг өөрчлөхгүйгээр тодорхой ажиллагаа гүйцэтгэх бололцоог хангах командыг бусдын программд нууцаар оруулах үйлдэл.

"Логик бөмбөг" (logic bomb) - Тодорхой нөхцөл буюу агшинд зөвхөн нэг удаа ажиллах командуудыг бусдын программд нууцаар оруулахыг хэлнэ.

"Хугацаатай бөмбөг" (time bomb) - Тодорхой цагт ажилладаг, логик бөмбөгийн нэг төрөл.

"Асинхрон дайралт" (asynchronous attack) - Хоёр буюу хэсэг тооны хэрэглэгчдийн командыг хооронд нь "холоход" компьютерийн систем эдгээр командыг нэгэн зэрэг

биелүүлдэгт энэ аргын агуулга оршдог.

"Загварчлах" (simulation modelling) - Оролцож болох процессст шинжилгээ хийх, гэмт үйлдлээ төлөвлөх, халдлага хийх аргаа боловсруулах, нуухын тулд гэмт этгээдүүдийн ашигладаг арга зүй.

"Буцах загвар" (reversive model) - Энэ аргын агуулга дараах байдлаар илэрнэ. Тодорхой системийн загварыг боловсруулна. Дараа нь системд анхны бодит мэдээллийг оруулж, төлөвлөсөн үйлдлүүдийг тоолж, зөв бодогдсон үр дүнгээс шаардлагатай үр дүнг түүвэрлэж авна. Үүний дараа загварыг анхны цэг рүү буцаахад оруулах мэдээллийн хамт ямар арга заль хэрэглэх боломжтой нь тодорхой болдог. Зарчмын хувьд цөөнгүй алхмын дараа зорилгодоо хүрэхийн тулд "урагш-хойш" гэсэн загварыг нэг бус удаа гүйцэтгэнэ гэсэн үг.

"Агаарын могой" (air snake) - "Буцах загвар"-ын нэг хувилбар. Хоёр банкинд бага хэмжээний мөнгөтэй данс нэзнэ. Дараа нь нэг банкаас нөгөө рүү аажмаар нэмэгдсэн дүнгээр буцааж мөнгө шилжүүлнэ. Шилжүүлгийн даалгавар шаардлагатай мөнгөн дүнг хангахгүй байгаа нь илрэх хүртэл ерөнхий мөнгөн дүн анхны шилжүүлгийг хаацайлж (далдалж) байдагт энэ "ов заль"-ийн мөн чанар оршдог. Зохиц хэмжээний мөнгөн дүн дансанд хуримтлагдах хүртэл энэ циклийг давтана. Үүний дараа данс эзэмшигч мөнгийг авч, алга болдог. Энэхүү тоглоомд хэдийчинээ олон банкныг татан оруулбал төдийчинээ хурдан мөнгө хуримтлагдаж, шилжүүлгийн даалгаврын тоог сэжиглэх аргагүй болдог. Гэвч зөвхөн компьютерийн тусламжтай л энэ процессыг удирдаж болно.

Харин АНУ-ын судлаач Марк Екенвайлер (Mark Eckenwiler) гэмт хэрэг үйлдэх үед компьютерийг ашигласан аргаас нь хамааруулж дараах бүлэгт хуваасан байна¹. Үүнд:

- Гэмт этгээдийн зорилго мэдээлэл хулгайлах, эсхүл өөрийн сонирхсон системд хор уршиг

учруулах тохиолдолд компьютер нь гэмт үйлдлийн объект болно.

- Системийн хамгаалалтыг эвдэх, эсхүл бусад "уламжлалт" гэмт хэргийг (тухайлбал, залилан хийх) электрон хэрэгслийн тусламжтай үйлдсэн тохиолдолд компьютер гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл (зэвсэг) болно.
- Компьютерийг санах хэрэгсэл болгон ашигладаг гэж үздэг.

1. Компьютер гэмт хэргийн объект болох нь

Компьютер халдлагын объект болдог хоёр төрлийн гэмт үйлдэл:

а. Гэмт этгээдийн үйлдэл бусдын эд хөрөнгөд халдахад чиглэсэн "уламжлалт" энгийн аргаар үйлдсэн гэмт халдлагыг;

б. Тухайн системийн үнэгүй ашиглах (тухайлбал, үйлчилгээ хулгайлах), эсхүл түүнийг гэмтээх, хадгалагдаж буй мэдээллийг хулгайлах, ТЭМ, түүний систем, компьютерийн сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх зорилготой хийсэн дайралтыг тус тус хамааруулж болно.

Эдгээр зөрчлийн ихэнх нь "эвдэх" аргын тусламжтай системд зөвшөөрөлгүй нэвтрэх үйлдлээ гүйцэлдүүлдэг. Компьютерийн гэмт хэрэгтнүүдийн ашигладаг зөвшөөрөлгүй нэвтрэх аргачлалыг:

1. Дотроос нь "эвдэх". Гэмт этгээд сонирхож буй мэдээлэлдээ нэвтрэх, тодорхой хугацаанд гадны хяналтгүй уг мэдээлэл дээр ажиллахын тулд терминалд биеэр нэвтэрдэг байх;

2. Гаднаас нь "эвдэх". Гэмт этгээд компьютерийн системд шууд нэвтрэх боломжгүй боловч ямар нэг аргаар (ихэнхдээ компьютерийн сүлжээг ашиглан) нэвтрэхийн тулд хамгаалалтын системд нь "тусгай" программ суурилуулах, мэдээллийн системд агуулагдаж буй, эсхүл боловсруулж байгаа мэдээллийн агуулгыг өөрчлөх гэж хоёр төрөлд ангилж болох юм.

Түүнчлэн энэхүү төрлийн гэмт хэргүүдийг Интернет, компьютерийн сүлжээнд агуулагдаж буй компьютерийн мэдээллийн

¹ www.cybercrimeconference.org/Eckenwiler.html

харилцаатай холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг; ТЭМ-д агуулагдаж буй компьютерийн мэдээллийн харилцаатай холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг гэж бас ангилж болно.

Мэдээлэл хулгайлах.

Мэдээлэл хулгайлах гэмт үйлдлүүд нь зөвшөөрөлгүй нэвтрэсэн тухайн системийн онцлогоос шалтгаалж янз бүрийн хэлбэртэй байж болно. Энэхүү гэмт халдлагын объект буюу мэдээлэл нь:

1. Хувийн мэдээлэл;
2. Бизнесийн нууц агуулсан байгууллагын мэдээлэл;
3. Зохиогчийн эрхээр хамгаалагдсан оюуны өмчийн бүтээл;
4. Улс орон, бүс нутгийн эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхэц өгөхүйц глобал мэдээлэл гэсэн нийтлэг шинжийн аль нэгийг агуулсан байдаг.

Үйлчилгээ хулгайлах. Аль нэг байгууллагын үйлчилгээг үнэгүй ашиглахын тулд түүний ямар нэг систем рүү зөвшөөрөлгүй нэвтрэх хууль бус үйлдлүүдийг энэ бүлэгт хамааруулж үздэг. Тухайлбал, хот хоорондын телефон утасны үйлчилгээг хууль бусаар ашиглах (phone breaking) зорилгоор телефон утасны холбооны дамжуулах (коммутица) системд нэвтрэхийн тулд компьютерийг ашигласан үйлдэл энэ ангилалд хамаарна.

Уивинг. “Ул мөрөө нуух” явцад тохиолддог, үйлчилгээ хулгайлах төрлийн гэмт хэргийн хамгийн түгээмэл тархсан хэлбэр. Гэмт этгээд өөрийн жинхэнэ нэр, байрлалыг нуухын тулд холбооны теле дамжуулах систем, Интернет, гар утас, телефон утасны систем зэрэг маш олон тооны системээр нэвтрэдэг. Энэ тохиолдолд гэмт этгээд тухайн компьютерийн системд нэвтрэх, түүнийг бусад систем рүү довтолх хэрэгсэл болгон ашиглана.

Системийг гэмтээх. Нэг зээмшигчтэй, эсхүл олон хэрэглэгчтэй системийн чухал

мэдээлэл агуулах өгөгдлийг өөрчлөх буюу эвдэх зорилгоор үйлдсэн зөвшөөрөлгүй нэвтрэх гэмт үйлдлүүд энэ бүлэгт хамаарна. Дээрх үйлдлийг:

1. WWW сервер, локал сүлжээ эг ажиллагаанаас гаргах зорилгоор тусгайлан бэлтгэсэн программ хангамжийг ашиглан их хэмжээний электрон сигнал (доххио)-ыг явуулах;
2. ТЭМ-ны өгөгдлийн сан, байгууллагын дотоод сүлжээнд “тодорхой” агшинд компьютерийн файлуудыг устгах, гажуудуулах үйлдэл хийх чадвартай “вирус (нян) - робот” -ыг оруулах;
3. Бусад арга заль хэрэглэх гэсэн үндсэн чиглэлээр хэрэгжүүлдэг байна.

Интернетийн сүлжээнд холбогдсон компьютерийн төрлийн довтолгооны объект болж болзошгүй. Чиглүүдэгч компьютер (Интернетээр дамжиж буй багц мэдээллийн замыг тодорхойлогч) телефон утасны коммутатортай төстэй тул сүлжээн дэх “зам”-ын маршрутыг эвдэх буюу бүрмөсөн өөрчлөхийг хүсэж буй туршлагатай хакарийн халдлагын объект болдог.

Вирус (нян) ашиглах. Өнөө үед компьютерийн системийг гэмтээхийн тулд зөвхөн мэргэжлийн программистаас гадна энэ талын өнгөц мэдлэгтэй хүмүүс ч тус аргыг хэрэглэх боломж бүрдсэн байна. Учир нь ийм хор уршиг тарих боломжтой программууд нилээд элбэг, түүнийг бүтээх технологи нь харьцангуй хялбар болжээ.

Нөгөө талаас компьютерийн сүлжээний хамгаалалтын системийг эвдэх зориулалттай, эсхүл ТЭМ-д халдах зорилгоор багц вирустэй компакт диск худалдан авч, ашиглах асуудал хөндөгх болов. Түүнчлэн вирус үүсгэх зориулалттай тусгай “зохион бүтээгч программ”-ыг худалдаалах болов. Түүний тусламжтай мэргэжлийн бус хүн ч вирусын үндсэн стандарт хэсгүүд дээр

нэмэлт хийж, вирусын шинэ хувилбар үүсгэх боломжтой. Дээрх программаар бүтээсэн вирусын энэхүү хувилбар вирусын эсрэг программ зохиогчдоод “олзлогдох” хүртэл антивирус программ түүнийг илрүүлж чаддаггүй. Вирус “зохион бүтээгч программ”-ыг хэн нэг этгээд чөлөөтэй хэрэглэх явдал нь эрх зүйн ноцтой сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Интернетийн сүлжээгээр дамжуулж вирус тараасан гэмт үйлдлүүд онцгой аюул, хор хохирол учруулдаг.

2. Компьютер гэмт хэргийн хэрэгсэл болох нь

Компьютерийг хоёр аргаар хууль бус үйлдлийн хэрэгсэл болгож ашиглах боломжтой. Үүнд:

- а. “Уламжлалт” гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл болгох;
- б. Өөр компьютер лүү довтолх хэрэгсэл болгох үйлдэл хамаарна.

Компьютер ердийн гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл болох нь. Энэ бүлгийн дийлэнх гэмт хэрэг нь Интернетийг ашиглаж үйлдэгдсэн байдаг. Тухайлбал, урьдчилсан төлбөрийн залилан, “гинжин хэлхээ” зарчмын захидал ба пирамид, виртуаль санхүүгийн пирамид, он-лайн (on line) хууль бус бооцоот тоглоом, порно материал тархаах зэрэг олон гэмт хэрэг хамаарна.

Компьютер бусад компьютер лүү довтолх хэрэгсэл болох нь. Зарим тохиолдолд компьютер нь нэгэн зэрэг зөвшөөрөлгүй нэвтрэх болон довтолх хэрэгсэлийн объект болдог. Ихэнх тохиолдолд тухайн компьютер лүү нэг сүлжээнд хамт холбогдсон бусад компьютерээс довтолдог байна. Ийм сүлжээнүүд олон тивд хэдэн мянган зангилаатай байдаг тул зөвшөөрөлгүй нэвтрэх, бусад зөрчлийг үйлдэх өндөр боломжийг агуулдаг. Зайнаас (алсаас) үйлдэж буй зөрчлүүдийг зөвшөөрөлгүй нэвтрэх, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах гэж ангилж болно.

Зөвшөөрөлгүй нэвтрэх зөрчлийн үед гэмт этгээд системд нэвтрэхдээ түүний аюулгүй байдлын сул талыг хэрэгсэл болгон ашиглахыг оролддог. Тэрээр энэ зорилгоо биелүүлж чадвал мэдээлэл устгах, хулгайлах, эсхүл

эвдэлсэн системийг өөр компьютер лүү довтолх талбар болгож ашиглах боломжтой. Интернет дэх ийм гэмт халдлагууд онцгой аюултайд тооцогддог.

Үйлчилгээ үзүүлэхээс татгалзах зөрчлийн үед гэмт этгээд тухайн системийг ажиллагаанаас гаргах зорилго агуулдаг. Тэгэхдээ гэмт этгээд түүнд нэвтрэхийг зорилгоо болгохгүй. Ийм төрлийн зөрчлүүд Интернетийн сүлжээнд маш их тархсан байдаг.

3. Компьютерийг санах хэрэгсэл болгон ашиглах

Гэмт үйлдлийн явцад компьютер идэвхгүй санах хэрэгслийн үүргийг биелүүлдэг. Тэгэхдээ компьютер ямагт зөвшөөрөлгүй нэвтрэх объект болдог. Тухайлбал, компьютерийн системийг эвдсэний дараа гэмт этгээд программын хэрэгслийг агуулсан файлуудыг (бусад холболтонд нэвтрэх түлхүүр үг, эзэлийн картын дугаарын жагсаалт г.м) хадгалах тусгай хавтас үүсгэдэг.

Интернетийн сүлжээг ашиглах явцад компьютерийг гэмт зорилгодоо ашиглах явдал маш их өсч байна. АНУ-ын 492 компанийн аюулгүй байдлын албаны төлөөлөгчдөөс авсан компьютерийн гэмт хэргийн тухай судалгааны дүнг нэгтгэж, хүснэгтээр үзүүлэв.¹

улсын төвшинд хэрэгжүүлэх арга замыг ямагт эрэлхийлж, холбогдох бага хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж ирэв.

1995 оны 10 дугаар сарын 4-10-нд хуралдсан Интерполын ерөнхий ассамблейн хуралдааны "Интерполын хүрээнд компьютерийн гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх зорилгоор үндэсний хууль сахиулах байгууллагуудын ажиллагааг чиглүүлэх ажлын зөвлөмж"², 1997 оны 7 дугаар сарын 1-2-нд Английн Брамшилл хотод хуралдсан "Их найм"-ын уулзалтын "Өндөр технологийн орчин дахь гэмт хэрэг"-ийн тухай салбар хуралдааны баримт бичиг³, 2005 оны 4 дүгээр сарын 18-25-нд Тайландын Бангкок хотод хуралдсан НҮБ-ын XI чуулганаас гаргасан "Компьютерийн гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээ"⁴ зэрэг баримт бичигт энэхүү шинэ төрлийн гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээ, холбооны теле дамжуулах хэрэгсэл, компьютерийн системийн найдвартай хэрэглээг баталгаажуулсан стандарт, универсаль хэм хэмжээг боловсруулжээ.

Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон талт хөтөлбөр

эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, ёс суртахууны хэм хэмжээ, мэргэжлийн стандарт, техникийн ажиллагааны журам, хариуцлагын зарчмыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

- Төрийн арга хэмжээ. Үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгож, компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх тусгай хөтөлбөрийг төрийн оролцоотой боловсруулах;

- Олон улсын хамтын ажиллагаа. Олон улсын эрх зүйн түгээмэл стандарт хэм хэмжээг нэг мөр болгох, хууль сахиулах байгууллагуудын хамтын үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг олон асуудлыг тусгах зайлшгүй шаардлага бий болов.

Эдүгээ мэдээллийн технологийн олон талт харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг боловсруулан баталж, хэрэгжүүлэх хууль хяналтын байгууллагын ажилтнуудын энэ талын онолын мэдлэг, хэрэглээний дадал чадвар сул, ашиглаж буй техник хэрэгсэл хангалтгүй байна. Тиймээс өрнөдийн болон мэдээллийн технологийн өндөр хөгжилтэй улс орнуудын туршлагыг нарийвчлан судалж, мэргэшсэн кибер-мөрдөгчдийг бэлтгэх тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг төрийн оролцоотой эхлүүлэхийг мэдээллийн технологийн олон талт харилцаа зүй ёсоор шаардаж байна.

Сүүлийн 12 сарын дотор илрүүлсэн хамгийн ноцтой аюул занал, довтолгооны төрөл

№	Төрөл	Хувь
1	Компьютерийн вирус (нян) тараах	83%
2	Интернетийг зүй бусаар ашиглах	69%
3	Зөөврийн компьютер хулгайлах	58%
4	Зохиогчийн эрх зөрчих	40%
5	Холбооны теле дамжуулах хэрэгсэл ашиглаж залилан хийх	27%
6	Байгууллагын нууцтай холбоотой мэдээлэл хулгайлах	21%
7	Хууль бусаар системд нэвтрэх	20%

НҮБ, олон улсын хамтын нийгэмлэгийн бусад байгууллагууд компьютерийн гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох чиглэлээр олон

боловсруулахын тулд үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд:

- Төрийн бус арга хэмжээ. Үйлдвэрлэл, эдийн засгийн салбарт



¹ Computer Security Institute-ийн 2004 оны тайланг ашиглав.

² <http://newasp.omsereg.ru/bekryash/app1.htm#6>

³ <http://newasp.omsereg.ru/bekryash/app10.htm>

⁴ http://pravo.by/science/sc_conf.htm

БАРИВЧЛАХ БА ХОРИХ ЯЛЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЦИН

2002 оны Эрүүгийн хуульд баривчлах ялыг шинээр ялын төрөлд тусгаж 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт "энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэнэ." гэж заасан байна. Баривчлах ялыг хорих ялтай харьцуулж үзэхэд ялгагдах нэг онцлог нь гэмт этгээдийн эрх чөлөөг нь хязгаарлахгүйгээр нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар нийгмээс тусгаарлахад оршиж байна.



УЕПГ-ын Ял эдлүүлэх
ажиллагаанд хяналт тавих
хэлтсийн прокурор,
докторант Ц.Мөнхбат

Баривчлах ялын зорилго нь шүүхээр шийтгэгдсэн этгээдийг тодорхой дэглэм бүхий байранд хөдөлмөр эрхлүүлэхгүйгээр ганцаарчлан байлгах хугацаанд тэд хийсэн хэргээ тунгааж бодох, улмаар гэмших, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх хүмүүжилтэй болгоход гол санаа нь агуулагдаж байгаа нь ойлгомжтой.

Хуулийг мөрдөж эхэлснээс хойшхи хугацаанд баривчлах ялын зорилго, энэ талаарх анхны үзэл баримтлалын хэрэгжилт ямар байна вэ?

Эрүүгийн хуульд баривчлах ялыг эдлүүлэх дэглэмийг нарийвчлан заагаагүй, бүрхэгдүүлж зөвхөн "тодорхой дэглэм бүхий байранд байлгах"-ыг зааснаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд үүнийг "амарчилж" дээр дурдсан "тодорхой дэглэм" нь өөр ялын төрөл болох хорих ялын жирийн дэглэмтэй адилхан байхаар зааж өгсөн нь баривчлах ялын үндсэн зорилго, агуулгыг жагуудуулах эхлэлийг тавьсан байна.

Эрүүгийн өөр өөр төрлийн ялуудыг хэрэгжүүлэхдээ хооронд нь

энэ хуулийн 107.4-107.7 –д заасан заалт нэгэн адил хамаарна гэснээс үзвэл баривчлах ялтай ялант жирийн дэглэмтэй хорих ялтны хуульд заасан эрхийг нэгэн адил эдлэх ёстой гэж ойлгогдож байна.

Баривчлах ял эдлүүлэх байр нь хорих байгууллагын бүрэлдэхүүнд багтах ба Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн "Хорих байгууллагын дотоод журам"-ыг тогтоохыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заажээ.

Хуульд зааснаар батлан гаргах "Хорих байгууллагын дотоод журам"-д баривчлах ял эдлүүлэх дэглэм, онцлогийг маш тодорхой тусгах ёстой атал одоо мөрдөж буй Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 215 тоот тушаалаар баталсан "Хорих ангийн дотоод журам" нь зөвхөн хорих ангийн үйл ажиллагааг зохицуулсан өрөөсгөл эрх зүйн акт болсон байна.

Нөгөө талаар хуулийн заалтын нэг мөр хэрэгжүүлэхээр гаргасан эрх бүхий байгууллагын тушаал, заавар, журам нь холбогдох хуулийн үзэл санаатай явцав нийцсэн байх ба эсрэг тохиолдолд уг эрх зүйн актыг хүчингүй болгох буюу мөрдөхгүй байх учиртай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2002 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн А/158 дугаар тушаалаар баталсан "Баривчлах ял эдлүүлэх байрны түр журам"-ын /зүй нь энэ асуудал "Хорих байгууллагын дотоод журам"-аар зохицуулагдах ёстой/ зарим заалт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж баривчлах ялтай ялтны хуульд заасан эрхийг илт дордуулсныг дараах хүснэгтээс харж болно.

Хууль ба эрх зүйн актыг харьцуулсан
товч судалгаа

Зүйл, анги	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд	Зүйл хэсэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2002 оны А/158 дугаар тушаалаар баталсан "Баривчлах ял эдлүүлэх байрны түр журм"
107.4 дэх хэсэг	Ялтан жилд 8 удаа удаан хугацааны уулзалт хийнэ.	6.1 хэсэг	Удаан уулзалтыг 2 сард 1 удаа хийнэ. /Жилд 6 удаа/
107.5 дахь хэсэг	Ялтанд 7 хүртэл хоногийн чөлөө олгож болно.	3.14 хэсэг	Ялтанд 5 хүртэл хоногийн чөлөө олгож болно.
119.2 дахь хэсэг	Удаан хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 72 цагаас дээшгүй байна.	6.1 хэсэг	Удаан хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 24 цагаас илүүгүй байна.
126 дугаар зүйл	Ялтныг урамшуулах а/ хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх б/ урьд ногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах в/ хуульд заасны дагуу шагналын хоног олгох	8.1 хэсэг	Ялтныг урамшуулах а/ Баяр хүргэх, сайшаалын үнэмлэх б/ удаан хугацааны уулзалтын тоог нэмэх

Баривчлах ял жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүй байгаа нь дараах шалтгаантай холбоотой гэсэн дүгнэлт хийсэн судалгаанаас гарч байна.


1. Хууль батлахаас өмнө баривчлах ял эдлүүлэх эдийн засгийн хамааралтай нөхцөлийг бүрдүүлээгүйн улмаас ялтнууд уг ялыг хэлбэрийн төдий байдлаар эдэлж эхэлсэн.

2. Хууль хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнаас холбогдох хуулийн заалттай нийцээгүй тушаал, журам, зааврыг нэг бус удаа гаргаж, батлан мөрдүүлсэн.

3. Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд баривчлах ял түүнийг хэрэгжүүлэх ажиллагааг нарийвчлан зааж өгөөгүй орхигдуулснаас баривчлах ба хорих ялыг эдлүүлэх нөхцөл дэглэмийн хувьд адилхан болсон.

4. Хууль хяналтын байгууллагууд уялдаа холбоогүйгээс баривчлах ялтай ялтныг шаардлага хангасан зохих байранд хүргэж ялыг эдлүүлэх ажиллагаа хангалтгүй, жишээ нь: 2004 онд 57, 2005 онд 104, нийт 161 ялтан цагдан хорих байранд баривчлах ялыг эдэлж дуусгасан байна.

Иймд баривчлах ба хорих ялыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, биелэлтийг зөв хангах тогтолцоог буй болгох, эсхүл Монгол орны өнөөгийн нөхцөл байдалд тохирохгүй, үр дүн багатай байгааг харгалзан баривчлах ялыг бүр мөсөн халах шаардлагатай гэсэн санал дэвшүүлж байна.



ФРАНЧАЙЗИЙН ГЭРЭЭ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
магистрант Г.Мөнхболд

Нэг. Франчайзийн гэрээний
ойлголт, хэрэглээний хүрээ

1.1. Франчайзийн гэрээний ойлголт:

Франчайзийн гэрээ нь манай иргэний эрх зүй, иргэний хууль тогтоомжийн хувьд нэн шинэ ойлголт юм. Энэхүү гэрээний харилцааны эрх зүйн зохицуулалтыг 2002 оны Иргэний хуулиар анхлан тогтоосон байна.

Иргэний хуулийн 333 дугаар зүйлийн 333.1-д "Франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэгч нь өөрийн фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ" хэмээн уг гэрээг тодорхойлсон байна.

Уг гэрээний талаархи ойлголтыг авч үзэж байгаатай холбоотойгоор франчайз гэх нэр томъёоны тухай товч өгүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Франчайз гэдэг нь дундад зууны үеэс Францад хэрэглэгдэж

байсан бөгөөд тодорхой үйл ажиллагаа явуулах онцгой эрхийг эзэн хаанаас худалдаж авах явдлыг үүгээр тэмдэглэж байжээ.¹

Энэ нь Enfranchise буюу албат ард гэсэн франц үг ажээ.

Франчайзийн гэрээг зарим улсуудад худалдааны концесс буюу contrat de concession commerciale гэх ойлголтоор илэрхийлэх нь байдаг.

Өөрөөр хэлбэл, энэ салбарт franchise болон contrat de concession commerciale гэх 2 нэр томъёо ижил төстэй байдлаар хэрэглэгддэг. Гэхдээ энэхүү хоёр нэр томъёоны илэрхийлж буй утга санаа нь хоорондоо бүрэн давхцдаггүй, хэдий үнэхээр нэг төрлийн харилцааг зохицуулж байгаа боловч тэдгээрийг бүрэн адилтгаж хараахан болохгүй юм.

Учир нь "...барууны онолын дагуу худалдааны концессийн гэрээгээр фирмийн нэр, барааны тэмдгийг ашиглах эрхийг бараа бүтээгдэхүүн дамжуулан борлуулах худалдааны хүрээнд ашиглуулахаар шилжүүлдэг бол франчайзийн гэрээгээр фирмийн нэр, барааны тэмдэг зэргийг зөвхөн худалдаа төдийгүй адил төрлийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт хэрэглэх боломжтой байдагт оршино".²

Хойд хөршийн тухайд хэдийгээр contrat de concession commerciale гэх томъёоллыг хэрэглэсэн боловч агуулгын хувьд уг нэр томъёогоор илэрхийлэгдэх ойлголтоос илүү өргөн харилцааг,

өөрөөр хэлбэл, франчайзийн харилцааг хуульчилсан гэж дүгнэж болно.

Франчайзийн гэрээ нь өнгөрсөн зуунд АНУ-д өнөөгийн төрхөө олж, өнөөгийн утга агуулгаар хэлбэржсэн байна. 1930-аад оноос франчайзийн харилцаа АНУ-д үүсч хөгжсөн бөгөөд 1970-аад оноос дэлхий нийтээр эрчимтэй хөгжиж эхэлсэн байдаг.

Франчайзийн гэрээг лицензийн гэрээний нэг төрөл хэмээн үзэх хандлага байдаг. Ингэхдээ уг гэрээний зайлшгүй байх зүйл нь онцгой эрхийг ашиглах эрхээ бусдад шилжүүлэх тухай зөвшөөрөл буюу лиценз байдаг явдлыг үндэслэлээ болгож байгаа бололтой байдаг. Энэ хандлагыг баримтлагчид лицензийн гэрээ нь фирмийн нэр, барааны тэмдэг болон бусад зүйлийн талаархи тэдгээрийг эзэмшигч этгээдийн онцгой эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэрэгсэл болдог гэж үздэг байна.

Лицензийн гэрээ гэдэг нь лиценз эзэмшигч буюу онцгой эрхийг эзэмшигч этгээд өөр этгээдийн ашиглалтад уг онцгой эрхээ шилжүүлж, эрхийг хүлээн авагч нь гэрээгээр тохирсон төлбөрийг лиценз эзэмшигчид төлөх болон гэрээнд заасан бусад үйлдлийг хийх үүрэг хүлээдэг харилцаа³ ажээ.

Лицензийн гэрээний дагуу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд хамаарах онцгой эрхүүдийг шилжүүлж байгаа боловч энэ нь түүнийг франчайзийн гэрээ гэж үзэх үндэслэл бас хараахан болохгүй юм.

Лицензийн гэрээнээс ялгаатай нь франчайзийн гэрээ нь оюуны өмчийн объект буюу аж ахуй эрхлэгч этгээдийн фирмийн нэр,

¹ Монгол Улсын Иргэний хууль. Төрийн мэдээлэл. 2002 он. №7

² Гражданское право: В 2 т. Том II. Полнотом 1: Учебник/Отв. ред. Проф. Е.А.Суханов. 2-е изд., перераб. И. Доп. М., 1999. с. 623.

³ Комментарий к ГК РФ. В 3-т. Т. 2: Комментарий к ГК РФ, части второй /под ред. Т.Е.Абовой и А.Ю.Кабалкина. Инст-т государств и права РАН: М., Юрайт-Издат; 2004. Профессиональные комментарии. с. 859.

⁴ Гражданское право: В 2 т. Том II. Полнотом 1: Учебник/Отв. ред. Проф. Е.А.Суханов. 2-е изд., перераб. И. Доп. М., 1999. с. 605. Бүлгийн зохиогч И.А.Зенин

барааны тэмдэг болон өөр бусад зүйлийн талаархи онцгой эрхийн ганц нэг объектыг бус харин иж бүрдлээр нь эрх хүлээн авагчид олгодог. Тэгэхээр франчайзийн гэрээг лицензийн гэрээний нэг төрөл гэж үзэж болохгүй юм¹. Өөр нэгэн ялгаатай тал нь лиценз эзэмшигч этгээд нь уг лицензийг ашиглах хэдий боловч зах зээлд өөрийн нэрээр гарч, өөрийн болон үйл ажиллагааны талаархи мэдээллийг үйлчлүүлэгчиддээ өгөх үүрэг хүлээж байдаг. Өөрөөр хэлбэл, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгч буюу лиценз эзэмшигчийн далбаан дор нуугдах, түүний нэрээр үйл ажиллагаа явуулах эрхгүй байдаг бол франчайзийн гэрээ нь үүний эсрэгээр, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн нэгж, салбар нь мэтээр, эсхүл эрх шилжүүлэгч мэтээр үйл ажиллагаа явуулдагт ялгаа нь оршино.

Франчайзийн гэрээ нь иргэний эрх зүйн гэрээний бусад төрлүүдээс ялгагдах ялгаа болон нийтлэг төстэй шинжийн тухай асуудлыг хөндөх нь түүний мөн чанарыг ойлгоход ихээхэн аж холбогдолтой юм. Франчайзийн гэрээ нь аж ахуйн нэгж, иргэдийн өмчилж буй онцгой эрхийг ашиглах эрхийг олгохтой холбоотой харилцааг зохицуулдагаараа лицензийн гэрээтэй, нийтлэг зорилгод хүрэх үүднээс эрх шилжүүлэгч ба эрх хүлээн авагч нар хамтран ажиллах харилцааг зохицуулж байгаагаараа нөхөрлөлийн /нөхөрлөлийг үүсгэн байгуулах гэрээ/ гэрээтэй, техникийн болон аж ахуйн баримт бичгийг хариу төлбөртэйгээр шилжүүлж байгаа байдлаараа худалдах, худалдан авах гэрээтэй, мөн комисс, агентийн гэрээ болон өөр бусад гэрээний төрлүүдэд байх шинжүүдийг өөртөө агуулж байдаг².

Гэлээ гэхдээ дээрхид үндэслэн франчайзийн гэрээг **холлимог гэрээ** гэж дүгнэж огтхон ч болохгүй. Франчайзийн гэрээ нь иргэний эрх зүйн өөр бусад ямар нэгэн гэрээнд үндэслэн үүсч, хөгжөөгүй.

Энэхүү гэрээ нь бие даасан, үүргийн нэгэн тусгай төрөл мөн. Өмнө өгүүлсэнчлэн нэг хэсэг

судлаачид франчайзийн гэрээг лицензийн гэрээний нэг төрөл, нэг хэлбэр гэж үзэх нь бий ч энэ нь үндэслэлгүй болохыг нотолсон билээ.

Франчайзийн гэрээ нь иргэний эрх зүйн гэрээний бие даасан төрөл, үүргийн тусгай төрлүүдийн нэг болох хувьдаа өөрийн гэх **Sui generic** буюу ялгагдах онцлог шинжүүдтэй. Эдгээрийг товч авч үзвэл:

1. Уг гэрээний оролцогч тал хоёулаа бизнесийн үйл ажиллагаа эрхлэж байгаа иргэн, хуулийн этгээд байдаг.

2. Франчайзийн гэрээний заавал байх объект буюу зүйл нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн бизнес үйл ажиллагаатай холбоотойгоор эзэмшиж буй онцгой эрх, тэгэхдээ уг эрх нь салангид байдлаар бус гагцхүү иж бүрнээрээ болдог. Энэ нь дээр өгүүлснээр уг гэрээг лицензийн гэрээнээс ялгаж гол шинж нь болдог. Мөн гэрээний зүйлээрээ эд хөрөнгө шилжүүлэх гэрээнээс ялгагдана.

3. Франчайзийн гэрээгээр онцгой эрх эзэмшигч этгээдийн онцгой эрхийг ашиглах эрхийг л эрх хүлээн авагч нь олж авдаг бөгөөд ингэхдээ уг онцгой эрх нь эрх хүлээн авагчид заавал шилжих шаардлагагүй. Үүгээрээ лицензийн болон патентийн гэрээнээс ялгагдана.

4. Эрх шилжүүлэгчийн эзэмшиж буй онцгой эрхийн иж бүрдлийг ашиглах эрхийг эрх хүлээн авагчид шилжүүлэх нь уг гэрээний зорилго юм. Нөгөө талаар эрх шилжүүлэгч нь уг гэрээний тусламжтайгаар өөрийн бизнесийн хүрээг өргөжүүлж, зах зээлээ өргөтгөх, ашиг орлогоо нэмэгдүүлэхийг зорьдог нь ч мөн уг гэрээний нэг зорилго болдог.

5. Уг гэрээгээр талуудын эдлэх эрх, хүлээх үүргийн хүрээ болон гэрээний агуулга нь өөр хоорондоо ихээхэн ялгаатай байдаг. Эрх шилжүүлэгч нь өөрийн онцгой эрхээ эрх хүлээн авагчид шилжүүлснээр түүнд техникийн болон бусад зөвлөгөө тусалцааг үзүүлэх, ажилтнуудыг сургаж, дадлагажуулах, үйлдвэрлэж буй

бараа бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээ, гүйцэтгэж буй ажлын чанар байдлыг ханах үүрэг хүлээдэг. Тэгвэл эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн зааврыг чанд сахин биелүүлэх үүргийг хүлээдэг. Өөрөөр хэлбэл, эрх шилжүүлэгчийн тогтоосон ажлын горим, журам, чанар стандартыг хангах, бусад нөхцөл зэргийг дагаж мөрдөж үйл ажиллагаа явуулах үүргийг эрх хүлээн авагч нь хүлээдэг.

6. Эрх хүлээн авагч эдийн засгийн хувьд эрх шилжүүлэгчээс бүрэн хараат байх боловч тэрээр худалдан авагч, захиалагчид тэдэнд үзүүлж буй ажил үйлчилгээ, худалдаж байгаа бараа бүтээгдэхүүнийг франчайзийн үндсэн дээр нийлүүлж байгаа тухайгаа мэдээлсэн тохиолдолд ч гэсэн хууль зүйн хувьд бие даасан байдлаа хадгалж, зарим талаар өөрийн нэрээр эдийн засгийн харилцаанд оролцох боломжтой байдаг.

7. Эрх хүлээн авагчийн явуулж буй үйл ажиллагаа нь тухайн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зах зээлийн өрсөлдөөнийг хурцатгах, эсхүл эрх шилжүүлэгчийн ашиг сонирхолд хохирол учруулах нөхцөл бүрдүүлэхийц байдлалд хүргэхээс сэргийлэн гэрээний талууд өөрсдийн хооронд үүсч байгаа харилцааг зохицуулах тусгай журам бий болгож мөрдөх шаардлагатай болдог. Энэ тухай Иргэний хуулийн 333 дугаар зүйлийн 333.1-д "... эрх хүлээн авагч нь хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж..." байхаар заасан байна.

Франчайзийн гэрээ нь иргэний эрх зүйн гэрээний нэг төрөл болох хувьдаа хууль зүйн шинж чанарын хувьд урьдчилан тохирсон, хоёр талын, хариу төлбөртэй гэрээ юм.

1.2. Франчайзийн гэрээний ач холбогдол, хэрэглэгдэх хүрээ

Энэхүү гэрээ нь онцгой эрх эзэмшиж томоохон бизнес эрхлэгч хуулийн этгээд, иргэдийн хувьд өөрсдийн бизнесийг өргөжүүлэх хамгийн тохиромжтой арга хэрэгслүүдийн нэг болдог бөгөөд уг гэрээний тусламжтайгаар тухайн бизнесийн үйл ажиллагаа нь стандартын өндөр түвшинд байх боломжийг олгож байдагт түүний ач холбогдол оршино.

¹ Гражданское право: В 2 т. Том II. Полетом 1: Учебник/Отв. ред. Проф. Е.А.Суханов. 2-е изд., перераб. И. Дон. М., 1999, с. 627.

² Брагинский М.И., Витрянский В.В. Договорное право. Книга третья. Договоры о выполнении работ и оказании услуг. Издание доп и исп. М. Статут. 2003, с. 983

Эрхээ шилжүүлж буй хуулийн этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа нээх эсхүл шинээр хуулийн этгээд байгуулах, нэмж ажилтан, албан хаагч хөслөх зэргээр нэмэлт зардал гаргахаас уг гэрээ чөлөөлдөг явдал нь түүний бас нэг ач холбогдол мөн.

Уг гэрээний дагуу эрх шилжүүлэгч хуулийн этгээд нь өөрийн фирмийн нэр болон барааны тэмдэг, бусад онцгой эрхийн объектыг ашиглах эрхээ бусдад шилжүүлэх буюу тэдгээрийг ашиглуулж, эрх хүлээн авагчтай хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулж, түүний үйлдвэрлэл буй бараа бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээ, гүйцэтгэж буй ажлын чанар байдлыг өөрийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанар байдалтай жишин хянаж байдаг.

Өнөө үед барууны өндөр хөгжилтэй улс орнуудад бизнесийн зохион байгуулалтын салбарт франчайзийн гэрээг өргөнөөр хэрэглэж байна. Дэлхийн Оюуны өмчийн байгууллагаас гаргасан тоо баримтаас үзэхэд жижиглэн худалдааны гуравны нэгээс илүү хувь нь франчайзийн гэрээний загвараар зохион байгуулагдсан байхад, Австрали улсад түргэн үйлчилгээний байгууллагуудын 90 гаруй хувь нь франчайзийн нөхцлөөр ажиллаж байгаа ажээ¹.

Уг өгүүллийн эхэнд франчайзийн гэрээний эрх зүйн зохицуулалт нь 2002 оны Иргэний хуулиас л эхэлж байгаа тухай өгүүлсэн. Гэхдээ энэ нь франчайзийн харилцаа Монголд 2002 оноос эхэлж хэрэгжиж эхэлсэн гэсэн үг огт биш юм. Хуулийн энэхүү зохицуулалгаас өмнө уг гэрээний харилцаа манай улсад бодитойгоор үүсч бий болж хэрэгжиж эхлээд байсан юм.

Манай улсын тухайд франчайзийн гэрээний харилцаа нь өргөн хэрэглээний тэр дундаа хүнсний бараа бүтээгдэхүүний худалдааны салбарт анхлан үүсч хөгжсөн байдаг.

1996-1999 онуудад "БЭЭТ" ХХК гэх нэгэн аж ахуйн нэгж Архангай аймгийн төв Цэцэрлэг

болон аймгийн бүх сумдуудыг холбосон дэлгүүрийн сүлжээг ажиллуулж байсан ба сүлжээнд хамрагдсан дэлгүүрүүдийн зарим нь тусдаа бие даасан аж ахуйн нэгжүүд байсан боловч "БЭЭТ" ХХК-тай хамтын ажиллагааны нэгдмэл хөтөлбөртэй, түүний үндсэн дээр ажиллаж байсан нь франчайзийн гэрээний харилцааны нэгэн хэлбэр байсан гэж үзэх үндэстэй юм.

Нийтэд илэрхий түгээмэл байдлаар дэлгэрсэн хамгийн анхны тохиолдол нь "Монхангай групп" ХХК-ийн санаачилгаар байгуулагдсан "Миний дэлгүүр" сүлжээ дэлгүүр бөгөөд тэд анхлан нийслэлийн хүн амын төвлөрөл, нягтарлыг харгалзаж салбаруудаа өөрийн хөрөнгөөр нээн ажиллуулж байснаа хожим нь бусад бизнес эрхлэгчдэд өөрийн "Миний дэлгүүр" гэх фирмийн нэр, барааны тэмдэг, үйл ажиллагааны тогтолцоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэргээ ашиглуулан хамтын ажиллагааны нэгдмэл хөтөлбөртэйгээр үйл ажиллагаа явуулах болсон байна. Энэ нь франчайзийн харилцааны эхлэл байсан гэж дүгнэхэд нэг их буруудахгүй болов уу.

Франчайзийн гэрээ нь хэмнэлттэй, хамгийн бага зардлаар, тэрч байтугай бүр ашигтайгаар бизнесээ өргөжүүлэх боломжийг эрх шилжүүлэгчид олгодог. Дээр өгүүлсэн зүйлс нь франчайзийн гэрээний нэг тал болох эрх шилжүүлэгчид уг гэрээний үзүүлэх ач холбогдлын тухай байлаа. Одоо гэрээний нөгөө тал болох эрх хүлээн авагчид энэхүү гэрээ нь ямар ач тус үзүүлэх, ямар ач холбогдолтой тухайд хэдэн үг хэлнэ.

Эрх хүлээн авагчийн тухайд уг гэрээг байгуулж, түүний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах нь түүний бизнесийн үйл ажиллагаанд үлэмж их зарим тохиолдолд бүр шийдвэрлэх ач холбогдолтой байдаг.

Гэрээний нэг тал болох эрх шилжүүлэгч нь ямагт зах зээлд өөрийн байр сууриа хэдийнэ олж, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй этгээд байдаг. Тэгвэл эрх хүлээн авагч нь түүнийг бодвол

харьцангуй даруухан намтартай эсхүл бүр дөнгөж шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа бизнес эрхлэгч байдаг. Тэдэнд дан ганц өөрсдийн хичээл зүтгэл, хүчин чармайлтаар хүссэн үр дүндээ хүрэх боломж тэр бүр бүрдэхгүй байх тохиолдол цөөнгүй. Тиймээс л ижил төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг буюу ажил үйлчилгээ эрхэлдэг нэр хүндтэй бизнес эрхлэгчийн ивээлд орох нь тэдэнд дангаар зүтгэснээс илүү үр дүнг авчрах явдал түгээмэл байх бөгөөд ийм бололцоо байгаа нөхцөлд франчайзийн гэрээг эрх хүлээн авч байгаа бизнес эрхлэгч сонгодог. Ингэснээр эрх хүлээн авагч шинэхэн эсхүл жижиг, дунд бизнес эрхлэгч нь бизнесийн эрсдлээс хэрэглэгч олж хайх, борлуулалтын зах зээлээ олоогүйн улмаас дампуурах/хамгаалагддаг ач холбогдолтой. Тэд хамгийн наад зах нь үйлдвэрлэл буй бараа бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээ, гүйцэтгэж буй ажлын талаар явуулбал зохих бүхий л зар сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардалаа хэмнэх өргөн боломжийг энэхүү гэрээг байгуулснаар олж авдаг.

Дээр өгүүлсэн 2 зүйл нь гэрээний оролцогч талуудад уг гэрээний үзүүлэх ач холбогдлын тухай асуудал байлаа. Тэгвэл уг гэрээний харилцааны хувьд хөндлөнгийн гуравдагч этгээд болох хэрэглэгчийн хувьд ямар үр нөлөө, ач тусыг уг гэрээ үзүүлэх гэдэг асуудал зүй ёсоор анхаарал татаж байна.

Франчайзийн нөхцлөөр бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлж байгаа явдал нь хэрэглэгчид нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн чанарын өндөр түвшинд үйлдвэрлэгдсэн, эрх шилжүүлэгч этгээдийн нэр хүндэд баталгаажсан бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр хэрэглэгчид хангагдах бололцоог бүрдүүлдэгт уг гэрээний гуравдагч этгээдүүдэд үзүүлэх ач холбогдол оршино. Франчайзийн гэрээний ач холбогдлын тухайд өгүүлэхэд ийм байна.

Тэгвэл уг гэрээний хэрэглэгчид хүрээний тухайд юуг өгүүлж болох вэ?

¹ Брагинский М.И., Витрянский В.В. Договорное право. Книга третья. Договоры о выполнении работ и оказании услуг. Издание доп и исп. М. Статут. 2003, с. 987 дахь талд. В.Евдокимовын бичсэний дамжуулал нь татав.

Франчайзийн гэрээний хэрэглэгдэх хүрээг бизнесийн ганц нэг салбараар хязгаарлан ойлгож болохгүй.

Барууны улс орнуудад бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүнийг худалдан борлуулах салбарт хэрэглэгдэх франчайзинг буюу **Product distribution franchising**, үйлчилгээ үзүүлэх салбарт хэрэглэгдэх франчайзинг буюу **Business format franchising** гэх төрлийг хэрэглэж байна.

Франчайзийн гэрээг бизнесийн хамгийн олон янз салбарт хэрэглэж байгааг дурдвал автомашины үйлдвэрлэл, засвар үйлчилгээ, шатахуун түгээх салбар, хувцас загварын болон гоо сайхны бүтээгдэхүүнийн үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт, эмийн сан, түргэн хоол, ресторан, зочид буудлын бизнесийн гэх мэт салбарууд байна.

Хоёр. Франчайзийн гэрээний объект

Өмнө өгүүлсэнчлэн франчайзийн гэрээний зүйл /объект/ нь эрх шилжүүлэгчийн эзэмшиж /өмчилж/ буй онцгой эрх, тэдгээрийн иж бүрдэл байдаг бөгөөд уг эрхийн тухайд эрх хүлээн авагч нь түүнийг бизнесийн үйл ажиллагаандаа ашиглах эрхтэй байдаг.

Иргэний хуулийн 333 дугаар зүйлийн 333.1 дэх заалтаас харахад уг гэрээний зүйл нь фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгө болдог байна.

Эдгээрийг ач холбогдлоор нь өөрөөр хэлбэл, франчайзийн гэрээний заавал байх зүйл /объект/ мөн эсэхээр нь **үндсэн ба нэмэгдэл** зүйл хэмээн хувааж болох юм. Гэхдээ ингэж ангилал нь заавал ийм байх шаардлагатай гэсэн санааг огтхон ч агуулаагүй болно.

Үндсэн объект гэдэг нь тодорхой хэсэг объектуудын аль нэг нь байхгүй, уг гэрээнд хамрагдаагүй

байх аваас түүнийг байгуулагдсанд тооцох боломжгүй, өөрөөр хэлбэл франчайзийн гэрээг байгуулагдсанд тооцох, уг гэрээг франчайзийн гэрээ гэж үзэх боломжгүй байдалд хүргэж байгаа тэдгээр объектууд юм. Үүнд энэ тэргүүн фирмийн нэр, барааны тэмдэг, Know how зэргийг хамааруулан ойлгож болно.

Нэмэгдэл объект гэдэг нь тухайн нэг объектыг гэрээнд хамааруулалгүйгээр гэрээг байгуулахад, бидний тохиолдолд франчайзийн гэрээний зүйл болохоор заагаагүй байдал нь уг гэрээг байгуулагдсанд тооцоход саад болохгүй, тодруулбал уг гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох хууль зүйн үр дагаварт хүргэхгүй тэдгээр объектуудыг хамааруулан ойлгоно.

Одоо Иргэний хуулийн 333 дугаар зүйлийн 333.1-д заасан объектуудын тухайд онцлох зүйлүүдийг дурдая.

Фирмийн нэр

Энэ нь утгаа аж ахуйн нэгжийн нэр болой. Аж ахуйн нэгжийн нэр гэдэгт аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд оноосон, түүгээрээ эрх зүйн харилцаанд оролцож, түүнийг иргэний гүйлгээний бусад оролцогчдоос ялгаруулж буй оноосон нэрийг ойлгох ажээ.¹

Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна" гэж заасан. Иргэний хуулиар хуулийн этгээдийн нэрийг ашиглах эрх зүйн үндсийг хуульчлан тогтоосон. Тодруулбал, Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-д "Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглоно. Энэ заалтыг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг энэ хуулийн 497 дугаар зүйлд заасан журмын дагуу арилгана" гэж заасан байна.

Аливаа хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлж, нэртэй холбоотой эрх нь зөрчигдөөл Иргэний хуулийн 21

дүгээр зүйлд заасан эрх зүйн хамгаалалтаар хангагдана. Нэр нь тухайн хуулийн этгээдийн өмч болж, нэрийг өмчлөх, ашиглах талаар онцгой эрхийг эдлэх бөгөөд энэ нь уг хуулийн этгээдийн өмчлөлийн эдийн бус хөрөнгө болно.

Нэрийн талаархи энэхүү онцгой эрхийг хуулийн этгээд эдэлснээр эрх зүйн болон эдийн засгийн харилцаанд өөрийн фирмийн нэрээр оролцох эрх /нөгөө талаас энэ нь үүрэг байдлаар ойлгогддог болохыг анхаарах нь зүйтэй/-тэй болох төдийгүй нэрийг хууль бусаар ашигласантай холбогдуулан эрхээ сармаалах, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай шаардлага гаргах эрхтэй болдог.

Бараа буюу ажил үйлчилгээний тэмдэг

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "барааны тэмдэг" гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусдын бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг" ойлгохоор заасан.

Фирмийн нэрээс ялгаатай нь барааны тэмдэг нь зөвхөн үгэн илэрхийллээр бус мөн дүрс, дуу авиа, орон зайн болон бусад илэрхийллээр, эсхүл тэдгээрийн нийлмэл байдлаар илэрхийлэгдэж болдог оршино.

Барааны тэмдгийг өмчлөх онцгой эрх нь түүнийг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авснаар түүнийг эзэмшигчид үүснэ. Ингэснээр бүртгэгдсэн барааны тэмдэг гэх ойлголт бий болох бөгөөд түүнийг өмчлөгч буюу эзэмшигч нь түүнийгээ ашиглаж, захиран зарцуулах, түүнийг бусад этгээд ашиглахыг хориглох буюу ашиглуулах зэрэг онцгой эрхийг эдэлдэг.

Энэ тухай Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлд бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч нь тухайн тэмдгийн хувьд дараах онцгой эрх эдлэх, үүнд, бүртгэгдсэн тэмдгээ өмчлөх /эзэмших,

¹ Сергеев А.П. Право интеллектуальной собственности в РФ. М. 1996. 521 дэх талд

ашиглах, захиран зарцуулах/; өөрийн бараа, үйлчилгээнд бүртгэгдсэн тэмдгийг ашиглах; тэмдгийг бусад лицензийн гэрээгээр ашиглуулах; барааны тэмдгийг бусдад шилжүүлэх; бүртгэгдсэн тэмдгийн талаар оюуны өмчийн байгууллагаас лавлагаа, нотолгоо гаргуулж авах; бүртгэгдсэн тэмдгийг бусад этгээд хууль бусаар ашиглах эрхийг нь зөрчсөн бол уг үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шаардах; бүртгэгдсэн тэмдэгтэй ижил буюу төсөөтэй тэмдгийг бусад этгээд ашиглахыг зогсоох, учруулсан хохирлыг арилгуулахыг шаардах эрхтэй байхаар заасан.

Түүнчлэн уг онцгой эрхийн хүрээ хязгаарыг мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т "Энэ хуулийн 19.1.7-д заасан эрх нь бүртгэгдсэн барааны тэмдгийн анхдагч огнооноос өмнө түүнтэй ижил тэмдгийг адил бараа, үйлчилгээнд хэрэглэж байсан этгээдийн эрхийг хөндөхгүй", 19.3-д "Барааны тэмдэг эзэмшигчийн онцгой эрх нь уг тэмдгийг бүртгүүлсэн бараа, үйлчилгээний жагсаалтын хүрээнд үйлчилнэ" хэмээн хуульчилсан байна.

Барааны тэмдэг өмчлөгч нь түүнийгээ бараа, түүний сав, баглаа боодол, үйлчилгээнд хэрэглэх; барааны тэмдэг бүхий барааг нийлүүлсэн, худалдаанд гаргасан буюу энэ зорилгоор хадгалсан, үйлчилгээ үзүүлсэн; барааны тэмдэг бүхий барааг хилээр нэвтрүүлсэн; барааны тэмдгийг албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернэт, сурталчилгаанд гаргах байдлаар ашиглаж болно.

Франчайзийн гэрээний хүрээнд эрх шилжүүлэгч этгээд нь өөрийн барааны тэмдгийг ашиглах эрхээ лицензийн гэрээ байгуулсны үндсэн дээр бусдад шилжүүлж болох бөгөөд ингэхдээ Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай Монгол Улсын хуулийн 21, 22 дугаар үйлд заасан журмыг баримтална.

Барааны тэмдгийн бүртгэл нь хуулийн шаардлага хангасан тохиолдолд 10 жилээр олгох бөгөөд 10 жилээр тухай бүрд нь сунгаж болно.

Барааны тэмдэг нь хамтын тэмдэг, гэрчлэх тэмдэг гэсэн өөр 2 хэлбэртэй байж болно.

Бүтээгдэхүүний загвар

Бүтээгдэхүүний загвар нь франчайзийн гэрээний зүйл /объект/ болно.

Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хүрээнд дан ганц бүтээгдэхүүний загвар төдийгүй шинэ бүтээл, ашигтай загвар гэх мэт өөр объектууд багтдаг. Эдгээр нь дор бүрнээ франчайзийн гэрээний зүйл болох боломжтой. Гэтэл Иргэний хуулийн 333 дугаар зүйлийн 333.1-д зөвхөн барааны загвар гэх ойлголтыг дангаар нь хуульчилсан.

Тиймээс Иргэний хуулийн бүтээгдэхүүний загвар гэдэгт мөн шинэ бүтээл, ашигтай загвар зэргийг хамааруулан ойлгох нь хуулийн утга санаатай нэг их зөрчилдөхгүй болов уу гэж бодож байна.

Бүтээгдэхүүний загвар

Гэдэгт үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой бүтээгдэхүүний хэлбэр, хийцэд хамаарах өвөрмөц, цор шинэ шийдлийг; шинэ бүтээл гэдэгт байгалийн хуульд тулгуурлан анх сэжд, үндэслэлийг нь нээн илрүүлсэн үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах цор шинэ шийдлийг; ашигтай загвар гэдэгт аливаа үйлдвэрлэлийн арга, хэрэгсэл, бүтээгдэхүүн, тэдгээрийн үндсэн хэсэг, зохион байгуулалтад хамаарах, шинэ, үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой ашигтай шийдлийг тус тус ойлгох ажээ /Патентийн тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйл/.

Бүтээгдэхүүний загвар, шинэ бүтээл болон ашигтай загварын тухайд хэрэгжих онцгой эрх нь патентаар нотлогдох бөгөөд энэхүү патент нь эзэмшигч этгээддээ давуу байдлыг олгодог.

Патент гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, эсхүл бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичиг бөгөөд үүнийг Оюуны өмчийн газар олгоно.

Ашигтай загварын тухайд патент бус ашигтай загварын гэрчилгээг олгох бөгөөд энэ нь ашигтай загварыг улсын бүртгэлд

бүртгэн авч, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгож буй баримт бичиг болно.

Патент болон ашигтай загварын гэрчилгээгээр хамгаалагдсан онцгой эрхийг эзэмшигчийг патент эзэмшигч буюу гэрчилгээ эзэмшигч гэнэ.

Патент буюу ашигтай загварын гэрчилгээ эзэмшигч энэ талаархи онцгой эрхээ өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж болно. Эсхүл бусдад шилжүүлэн ашигуулж болох бөгөөд энэ тохиолдолд лиценз үйлдэнэ.

Франчайзийн гэрээгээр бүтээгдэхүүний загвар, шинэ бүтээл, ашигтай загварыг ашиглах эрхийг шилжүүлэх бөгөөд энэ тохиолдолд лиценз шаардлагатай болно.

Бусад объект

Үүнд эрх шилжүүлэгчийн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг нь хамаарна.

Эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан бизнесийн үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, бүтцийг үйл ажиллагаандаа хэрэглэх үүргийг франчайзийн гэрээний дагуу хүлээнэ. Эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн хамтран ажилладаг байгууллага, иргэдтэй харилцаж, тэдгээрээс түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг авах буюу эрх шилжүүлэгчийн үйл ажиллагааны чиглэлд хамрагдах хэрэглэгчдэд зориулан бараа бүтээгдэхүүнээ худалдаж, үйлчилгээ үзүүлнэ. Энэ бүх загвар, хөтөлбөр зэрэг нь франчайзийн гэрээний нэгэн зүйл буюу объект болно.

Гурав. Франчайзийн гэрээний субъект

Франчайзийн гэрээний субъект нь бизнесийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн аль нь ч байж болно.

Франчайзийн гэрээний зорилго нь эрх шилжүүлэгч этгээд бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ

нийлүүлэх сувгаа бий болгох буюу өргөжүүлэх явдал байдаг тухай дээр өгүүлсэн. Тэгэхээр эрх шилжүүлэгч нь бизнесээ өргөжүүлэх сонирхол бүхий томоохон бизнес эрхлэгч байх нь түгээмэл байдаг.

Эрх шилжүүлэгч этгээд наад зах нь дараах үндсэн хоёр шаардлагыг хангаж байж уг гэрээний оролцогч болох боломжтой. Үүнд:

- ◆ Бизнесийн үйл ажиллагаа явуулдаг, бизнес эрхлэгч байх.

- ◆ Франчайзийн гэрээний зүйл болох онцгой эрхийн объектыг эзэмшдэг буюу өмчилдөг байх явдал хамаарна.

Бизнес эрхлэгч иргэн нь аж ахуйн нэгжийн нэр буюу фирмийн нэрээс бусад объектын өмчлөгч байж болох бөгөөд ингэснээр фирмийн нэрээ франчайзийн гэрээгээр ашиглуулахаас бусад тохиолдолд эрх шилжүүлэгчийн байр сууринаас уг гэрээний харилцаанд оролцох боломжтой. Харин эрх хүлээн авагч нь иргэн, хуулийн этгээдийн хэн аль нь байх боломжтой. Гэхдээ иргэн фирмийн нэрийг франчайзийн гэрээний дагуу ашиглах тохиолдолд хүссэн хүсээгүйгээр хуулийн этгээд үүсгэн байгуулах шаардлага зүй ёсоор урган гарна.

Франчайзийн гэрээний субъектын хувьд өөр ямар нэгэн хязгаарлалт болон бусад шаардлагыг хуулиар тогтоогоогүй байна.

Дөрөв. Франчайзийн гэрээний хэлбэр, байгуулах журам

Иргэний хуулийн 335 дугаар зүйлийн 335.1-д зааснаар франчайзийн гэрээг бичгээр хийнэ. Иргэний хуульд уг гэрээг байгуулах тухай ямар нэгэн журам тогтоогоогүй. Ингэхээр гэрээ байгуулах нийтлэг журмын дагуу уг гэрээг байгуулна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, талууд гэрээний бүхий л гол нөхцлүүдийн талаар тохиролцоонд хүрсний үндсэн дээр нэг баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурснаар буюу гэрээний саналыг зөвшөөрснөө илэрхийлсэн тал гарын үсгээ зурсан захидал, албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах баримт бичгийг нөгөө тал хүлээн

авснаар франчайзийн гэрээ байгуулагдсанд тооцно /Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.1.2 дахь хэсэг/.

Тав. Франчайзийн гэрээний агуулга

Иргэний эрх зүйн гэрээний агуулга гэдэгт түүний бүхий л нөхцлүүдийн нийлбэрийг ойлгодог. Энэ утгаараа тодорхой нэг гэрээний агуулгын /талуудын зүгээс гэрээнд оруулсан бүхий л нөхцлүүдийн нийлбэр/ тухайд болон хууль тогтоомжид тусгагдсан идеаль гэрээний агуулга, түүнд хамаарах ямар нэгэн гэрээний үүргийн төрлийн тухай ярьж болох юм. Хууль тогтоомжид тухайн гэрээний үүргийн мөн чанарт хамаарах нөхцлүүдийг тусгадаг бөгөөд эдгээр нь нийлбэрээрээ тухайн төрлийн гэрээг иргэний эрх зүйн гэрээ гэж үзэх бололцоог бүрдүүлдэг. Иргэний эрх зүйн харилцаанд талуудаас оролцож, байгуулж байгаа тодорхой нэг гэрээ нь агуулгын хувьд хууль тогтоогчийн зохиосон гэрээний идеаль загвараас үлэмж баян, илүү нарийвчилсан нөхцөлүүдийг агуулсан байдаг. Үүний зэрэгцээ энэхүү тодорхой гэрээ нь агуулгын хувьд гэрээний идеаль загварын агуулгад үндэслэсэн эсэхийг анхаарч үзэх шаардлагатай байдаг. Зөвхөн ингэснээр л талууд гэрээний бүхий л гол нөхцөлүүдийн талаар тохиролцоонд хүрсэн эсэх, тухайн гэрээг байгуулагдсанд тооцож болох эсэх, уг гэрээ нь гэрээний үүргийн тухайн төрлийн ялгарах шинжүүдийн цогцыг бүрдүүлэгч нөхцлүүдийг агуулсан эсэх, уг гэрээ нь иргэний эрх зүйн гэрээг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний үйлчилгээд хамаарч байгаа эсэхийг тогтоох боломжтой болно.¹

Хууль зүйн шинжлэх ухаанд гэрээний агуулга гэдэгт ихэвчлэн гэрээний талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг ойлгодог. Энэ нь ч зүй ёсны юм.

Ямар учраас гэрээний нөхцлүүдийг талууд тохиролцон тогтоодог юм бэ?

Утгаа талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлох гэж л гэрээний нөхцөлийг талууд тохиролцон тогтоодог. Гэхдээ хууль

тогтоомжийн түвшинд буюу гэрээний идеаль загварын тухайд гэрээний агуулгыг талуудын эрх үүргийг нэгдэл байдлаар тодорхойлодог бол бодит амьдрал дээр гэрээний агуулгыг дан ганц талуудын эрх үүргээр хязгаарлах боломжгүй байдаг. Гэрээнд зохион байгуулалт, техникийн болон өөр бусад олон талын үзүүлэлтүүдийг тохиролцон тогтоох зайлшгүй шаардлага тулгардаг. Тийм ч учраас Иргэний хуулийн 335 дугаар зүйлийн 335.2-д "франчайзийн гэрээнд гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээ цуцлах, хугацаа сунгах журам, талуудын хүлээх үүргэд бусад гол нөхцөлүүдийг заахын зэрэгцээ франчайзийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг бүрэн тусгана" гэж заасан.

Дээр өгүүлсэн бүгдэд үндэслэн гэрээний агуулга нь:

- ◆ Гэрээний гол ба нэмэлт нөхцөл, стандарт нөхцөл,

- ◆ Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг гэх үндсэн хоёр хэсгээс бүрддэг гэж дүгнэж болно.

Франчайзийн гэрээний гол нөхцөл

Гэрээний гол нөхцөл гэдэг нь гэрээний зүйлийн тухай нөхцлүүд, хууль тогтоомжид гол буюу тухайн төрлийн гэрээг байгуулахад зайлшгүй шаардлагатай хэмээн нэрлэсэн буюу заасан нөхцлүүд, түүнчлэн талуудын хэн нэгнийх нь санал болгосноор гол нөхцөл гэж үзэхээр тохиролцон тогтоосон тэдгээр бүх нөхцлүүд юм.

- Франчайзийн гэрээний хамгийн гол нөхцөл нь франчайзийн гэрээний объектын талаархи нөхцлүүд болно.

Фирмийн нэр, барааны тэмдгийг өмчлөх гэх мэт онцгой эрх нь уг гэрээний объект болох бөгөөд энэ талаар гэрээнд орсон заалтууд нь гэрээний гол нөхцөл болно.

Гэрээний зүйл ба гэрээний объект гэх хоёр ойлголт нь өөр хоорондоо ялгаатай.

Гэрээний зүйл гэдэг бол гэрээнд заасны дагуу үүрэг хүлээсэн талын гүйцэтгэвэл зохих үйлдэл юм. Тэгвэл франчайзийн гэрээний зүйл гэдэг нь гэрээгээр тохирсны дагуу талуудаас хийвэл зохих үйлдлүүд болно.

¹ Брагинский М.И., Витрянский В.В. Договорное право. Книга третья. Договоры о выполнении работ и оказании услуг. Издание доп и исп. М. Статут. 2003. с. 1004

Франчайзийн гэрээний зүйлийн талаархи нөхцөл гэдэгт гэрээний дагуу эрх хүлээн авагчаас /мөн эрх шилжүүлэгчийн зүгээс/ явуулах үйл ажиллагааны талаар талуудаас тохиролцож тогтоосон нөхцлүүдийг ойлгоно. Түүнээс бус фирмийн нэрийг өмчлөх гэх мэт онцгой эрх нь гэрээний объект болохоос гэрээний зүйл хараахан биш юм. Объект бүрийн онцлогтой холбоотойгоор үүрэг гүйцэтгэгчийн явуулбал зохих үйл ажиллагаа буюу гэрээний зүйлийн талаархи нөхцлүүд харилцан адилгүй байна.

- Иргэний хуулийн 335 дугаар зүйлийн 335.2 дахь заалтаас харахад гэрээний үргэлжлэх хугацаа нь франчайзийн гэрээний гол нөхцөл болох нь тодорхой байна. Ингэхээр уг гэрээг байгуулахад талууд гэрээний үргэлжлэх хугацааг заавал тохиролцон тогтоосон байх шаардлагатай.

- Эрх шилжүүлэгчид эрх хүлээн авагчийн зүгээс тодорхой төлбөр төлөх ёстой болох ба энэ нь гэрээний гол нөхцлүүдийн нэг мөн. Төлбөр төлөх асуудлыг эрх хүлээн авагчийн үүрэг болох байдлаар хуульчилсан. Хариу төлбөр нь шагнал, хураамж, эсхүл орлогоос тодорхой хувиар эрх шилжүүлэгчид өгөх зэрэг хэд хэдэн арга замаар хийгдэх болохоор хуульчилсан байна.

- Талууд харилцан тохиролцон тогтоосон гол нөхцөл үүнд, гэрээг нотариатчаар гэрчүүлснээр хүчин төгөлдөр болохоор заасан тохиолдолд энэ нь гол нөхцөлд тооцогдох боломжтой.

Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

Өмнө өгүүлсэнчлэн франчайзийн гэрээ нь хоёр талын, хариу төлбөртэй гэрээ юм. Тиймээс гэрээний хоёр тал нь хоёулаа эрх эдэлж, үүрэг хүлээж байдаг. Гэхдээ гэрээгээр эрх хүлээн авагч нь дан ганц гэрээний нөгөө тал болох эрх шилжүүлэгчийн үүрэг хүлээх бус мөн түүний шилжүүлсэн онцгой эрх, ажил хэргийн нэр хүнд, туршлагыг ашиглан бизнесийн үйл ажиллагаа

явуулах үед өөртэй нь харилцаанд орж байгаа гуравдагч этгээдийн өмнө үүрэг хүлээх тохиолдолд гардаг.

Эрх хүлээн авагчийн үүрэг

- Эрх хүлээн авагчийн үндсэн үүргийн нэг нь гэрээнд заасан үйл ажиллагааг явуулахдаа эрх шилжүүлэгчийн фирмийн нэр, барааны тэмдэг зэргийг гэрээнд заасан байдлаар ашиглах үүрэг хүлээдэг. Иргэний хуулийн 334 дүгээр зүйлийн 334.2.1-д "гэрээгээр хүлээж авсан эрх, эд хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай ашиглах" үүргийг эрх хүлээн авагч хүлээхээр заажээ. Хууль зүйн шинжлэх ухаанд энэхүү үүргийн тухайд харилцан адилгүй байр суурийг судлаачид илэрхийлсэн байдаг. Тодруулбал, нэг хэсэг судлаачид эрх хүлээн авагчийн тухайд түүний гэрээний дагуу бусдын фирмийн нэр болон барааны тэмдэг зэргийг ашиглах эрхийг олж авч байгаа хэдий боловч энэ нь мөнхнэгэн зэрэг түүний хүлээх үүрэг болж байгаа нь төдийлэн онговчтой биш. Онцгой эрхийг ашиглах эрх нь эрх хүлээн авагчийн явуулж болох тэдгээр үйлдлүүдэд гол нь хамааралтай байна. Эрх хүлээн авагчийн үүрэг нь гэрээгээр тохирсон ашиглалтын хүрээ хязгаараас хэтрэхгүй байхад оршино гэж нэг хэсэг нь үздэг байна. Тэгвэл нөгөө хэсэг судлаачид "Эрх хүлээн авагч нь гэрээнд заагдсан бизнесийн үйл ажиллагаагаа бүрэн хэмжээнд, гэрээгээр тогтоосон чанарын түвшинд хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд энэ үйл ажиллагааныхаа хүрээнд тэрээр эрх шилжүүлэгчийн фирмийн нэр болон барааны тэмдэг, бусад онцгой эрхийн дор эдийн засгийн харилцаанд орох үүрэг хүлээж, бараа бүтээгдэхүүний ялгах тэмдэг, баримт, зар сурталчилгаандаа заавал дурдаж байх үүрэг хүлээдэг гэж үздэг байна. Миний хувьд өөрийн байр сууриа илэрхийлэхэд дээрх хоёр байр суурийн аль нь эрх хүлээн зөвшөөрч болох талтай, учир нь эрх хүлээн авагч нь хэдийгээр франчайзийн гэрээний дагуу фирмийн нэр, барааны тэмдэг зэрэг онцгой эрх болон эд хөрөнгө, бусад зүйлийг ашиглах эрхийг олж

авч байгаа боловч уг эрхээ хэрэгжүүлэхэд эрх шилжүүлэгчээс гэрээгээр тогтоосон болзол, нөхцөлийг заавал биелүүлэх, тогтсон дүрэм журмыг мөрдөж ажиллах үүрэг хүлээж байдаг. Учир нь эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн зах зээл дээрх нэр хүндэд дулдуйдан өөрийн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг зах зээлд борлуулахыг хүсдэг бөгөөд хэрэв зээ тэрээр дураар авирлах аваас эрх шилжүүлэгчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал бий болохыг учир ийнхүү эрх нь мөн тодорхой хэмжээнд хязгаарлагдаж, зарим талаар үүрэг мэтээр бууж хэрэгжихээс өөр аргагүй болно. Энэ нь уг гэрээний харилцааны мөн чанараас үүдэлтэй гэж үзэж болох юм.

- Хэдийгээр Иргэний хуульд тусгагддаггүй боловч франчайзийн гэрээний дагуу эрх хүлээн авагчийн зүй ёсоор хүлээх нэг үүрэг нь уг гэрээний үндсэн дээр түүний үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нь эрх шилжүүлэгчийн үйлдвэрлэж байгаа ижил төрлийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарын төвшинтэй дүйцэж, тийм чанарын түвшинг хангаж ажиллах явдал юм. Энэ ч үүднээс эрх шилжүүлэгч нь эрх хүлээн авагчийн бараа, ажил үйлчилгээний чанарт хяналт тавих эрхийг эдэлдэг. Эрх хүлээн авагчид хүлээлгэж буй энэхүү үүрэг нь эн тэргүүнд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

- Иргэний хуулийн 333 дугаар зүйлийн 333.1-д зааснаар "... эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулах... үүргийг тус тус хүлээнэ". Эрх шилжүүлэгч нь энэхүү тогтолцоо болон үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг франчайзийн гэрээг байгуулах үед болон гэрээ үйлчлэх аль ч хугацаанд эрх хүлээн авагчид өгөх эрхтэй. Ингэхдээ эрх шилжүүлэгч нь өөрийн үйл ажиллагаанд баримталж ирсэн тэрхүү шаардлага, тогтолцоо, хөтөлбөрийг эрх хүлээн авагчид өгөхөөс бус өөрийн үйл ажиллагаанд

мөрддөггүй тэдгээр тогтолцоо, хөтөлбөрийг шилжүүлэх аваас энэ нь эрх шилжүүлэгч өөрийн хүсэл зоригийг гэрээний тэгш эрх бүхий оролцогч эрх хүлээн авагчид тулгасан хэрэг болно.

- Иргэний хуулийн 334 дүгээр зүйлийн 334.2.2-д зааснаар "зохиц, шагнал, хураамж, орлогын тодорхой хувийг тогтоосон хугацаанд төлөх" үүрэг хүлээн.

- Эрх хүлээн авагч нь гуравдагч этгээдтэй холбоотой үйл ажиллагаа явуулахдаа эрх шилжүүлэгчийн өмнө мөн хэд хэдэн үүрэг хүлээж байдаг. Эдгээрийн нэг нь Иргэний хуулийн 334 дүгээр зүйлийн 334.2.6-д зааснаар "эрх шилжүүлэгчийн барааны болон ажил үйлчилгээний тэмдгийг хэрэглэхдээ лицензээр хэрэглэж байгаа тухай харилцагч болон үйлчлүүлэгчид заавал мэдэгдэх" үүргийг хүлээн. Энэхүү үүргийг эрх хүлээн авагчид хүлээлгэснээр өөрийн фирмийн нэр, барааны тэмдэг ашиглуулж буй эрх шилжүүлэгчийн эрх ашгийг хамгаалах төдийгүй, ингэснээр түүний бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ түгээх сүлжээг бий болгох, өргөжүүлэх зорилтыг шийдвэрлэх бөгөөд бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг хүлээн авч буй захиалагч гуравдагч этгээдийн тухайд тэдний хүртсэн ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэгч нь эрх шилжүүлэгчийн үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, худалдааны сүлжээний нэгэн хэсэг нь гэх мэдээллийг олж байх явдал эрх шилжүүлэгчийн хувьд ихээхэн чухал байдаг. Хэрэглэгч-захиалагчид нь өөрсдийн хүртсэн ажил үйлчилгээ, худалдан авсан бараа бүтээгдэхүүнийг франчайзийн үндсэн дээр дээрх ажил үйлчилгээг үзүүлж байгаа этгээдээс авсан гэдгээ мэдсэнээр чанар байдал, эрхийн болон биет байдлын талаархи дутагдалтай холбоотой гомдлын шаардлага, нэхэмжлэлийг зөвхөн шууд нийлүүлэгч-эрх хүлээн авагчид төдийгүй мөн эрх эзэмшигч буюу эрх шилжүүлэгчид хандаж гаргах эрхтэй болдог. Энэ тохиолдолд эрх шилжүүлэгч нь нөхөх хариуцлага хүлээх учиртай болдог ийм

зохицуулалт зарим улс орнуудад байдаг. Тухайлбал, ОХУ-ын Иргэний хуулийн 1034 дүгээр зүйлд нөхөх хариуцлага хүлээх тухай хуульчилсон байна. Тэгвэл манай Иргэний хуулийн 338 дугаар зүйлийн 338.4-д "Эрх хүлээн авагчийн гэм буруутай үйл ажиллагаанаас болж үйлчлүүлэгчид учирсан хохирлыг эрх шилжүүлэгч хариуцахгүй" гэж заасан. Энэ нь бас төдийлэн оновчтой зохицуулалт болоогүй гэж хувьдаа дүгнэж байна. Учир нь хэрэглэгч гагцхүү эрх шилжүүлэгчийн шилжүүлсэн фирмийн нэр, барааны тэмдэг зэрэгт итгэн эрх хүлээн авагчийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг захиалж авсан байдаг. Эрх хүлээн авагчийн шууд гэм буруутай үйлдэл хэдий байгаа боловч тэр нь эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлэгчийгээ үүдэлтэй байх тохиолдолд эрх хүлээн авагч дангаар хариуцлага хүлээх нь учир дутагдалтай юм. Тодруулбал эрх шилжүүлэгч нь хамтын ажиллагааны хөтөлбөр, үйл ажиллагааны тогтолцоо зэргээр хангаагүйгээс болж хэрэглэгчид хохирол учирвал эрх шилжүүлэгч уг хохирлыг хариуцан арилгах нь шударга ёсонд нийцэх юм болов уу.

- Эрх хүлээн авагч нь гуравдагч этгээдтэй холбоотой харилцаанд франчайзийн гэрээгээр хүлээж байдаг өөр нэг үүрэг нь тэрээр гуравдагч этгээд болох худалдан авагч, захиалагчид тэд эрх шилжүүлэгчээс шууд авч болох бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг тийм чанарын бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг олж авах, түүнчлэн бусад нэмэлт үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээдэг.

- Иргэний хуулийн 334 дүгээр зүйлийн 334.3-д "Талууд гэрээ байгуулахдаа шаардлагатай бүхий л мэдээллийг шударгаар харилцан солилцох, гэрээ байгуулагдахгүй тохиолдолд мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй" гэжээ. Энэ нь дан ганц эрх хүлээн авагчийн бус мөн эрх шилжүүлэгчийн үүрэг байна. Гэрээ байгуулах үед олж мэдсэн мэдээлэл гэдэгт Ноу хау, барааны тэмдэг, фирмийн нэр зэрэг франчайзийн гэрээний зүйлийн талаархи мэдээлэл төдийгүй ерөөсөө уг харилцаанд орсноор

нөгөө талынхаа талаар олж авсан бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

- Иргэний хуулийн 334 дүгээр зүйлийн 334.3, 334.4, 334.2.5 зэрэг хэсэгт гэрээнд заасан болон шилжүүлэн авсан эрх, эд хөрөнгийг эрх шилжүүлэгчид ашигтайгаар даатгуулах, эрх шилжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр лиценз болон франчайзийн гэрээг гуравдагч этгээд шилжүүлэхгүй байх, гэрээнд заасан бол эрх шилжүүлэгчээс хэрэгжүүлж байгаа сургалтад ажиллагсдыг хамруулах, холбогдох зардлыг төлөх гэх мэт үүрэг хүлээхээр хуульчилжээ.

Эрх шилжүүлэгчийн үүрэг

- Франчайзийн гэрээний дагуу түүний хүлээх үндсэн үүрэг нь эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээлэлээр хангах /ИХ-ийн 334.1.3/ буюу түүнд техникийн туслалцаа үзүүлэх /ИХ-ийн 334.1.4/, түүнчлэн эрх хүлээн авагчийн ажиллах хүчнийг сургах /ИХ-ийн 334.1.5/ үүргийг хүлээн.

- Франчайзийн гэрээг байгуулсны үр дүнд фирмийн нэр зэрэг онцгой эрх болон эд хөрөнгийг шилжүүлэх явдал лицензийг шилжүүлэх замаар хэрэгжих бөгөөд лиценз шилжүүлэхтэй холбоотойгоор лицензийн гэрээ байгуулагдана. Энэ талаар үүсэх харилцааг Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиар нарийвчилан зохицуулсан.

- Эрх шилжүүлэгч нь өөрсдийн боловсруулсан хамтын ажиллагааны хөтөлбөрийг гуравдагч этгээдийн оролцооноос хамгаалах үүрэг хүлээх бөгөөд ингэснээр эрх хүлээн авагч нь франчайзийн гэрээгээр олж авсан эрхийн найдвартай байдалд итгэх бүрэн итгэлийг олж авдаг.

Гэрээний дагуу талуудад ногдох хязгаарлалт тогтоосон үүргүүд

- Уг гэрээг байгуулснаар эрх шилжүүлэгч нь эрх хүлээн авагчийн үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гуравдагч этгээдэд фирмийн

нэр, барааны тэмдэг, бусад зүйлийг ашиглуулах эрх шилжүүлэхгүй байх, шилжүүлэхээс татгалзах үүргийг зүй ёсоор хүлээнэ.

- Дээрх үүрэгтэй адилаар эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн үйл ажиллагаагаа явуулж байгаа нутаг дэвсгэрт гэрээгээр олж авсан эрхээ ашиглан өрсөлдөх үйл ажиллагааг явуулахгүй байх үүрэг хүлээнэ. Энэхүү хоёр үүрэгтэй холбоотой заалтыг Иргэний хуулийн 337 дугаар зүйлийн 337.1-д "Эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээ дуусгавар болсны дараа эрх хүлээн авагчийг тодорхой нутаг дэвсгэрт өөртэйгээ өрсөлдөхийг нэг хүртэл жилийн хугацаагаар хориглох эрхтэй" гэж заасан. Хуулийн энэ заалт нь зөвхөн эрх шилжүүлэгчид эрх олгосон байх бөгөөд уг заалтад дан ганц эрх шилжүүлэгчийн эрх бус мөн эрх хүлээн авагчийн энэ талаархи харилцан эдлэх эрхийг тогтоосон заалтыг нэмж оруулах нь зүйд нийцэх юм болов уу.

- Эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн өрсөлдөгч байгууллагаас адил төрлийн эрхийг шилжүүлэн авахаас татгалзах үүргийг хүлээнэ. Өөрөөр хэлбэл, эрх хүлээн авагч нь өрсөлдөгч хоёр газраас нэгэн зэрэг ижил төрлийн эрхийг франчайзийн гэрээний үндсэн дээр олж авч болохгүй гэсэн үг юм.

Ийм төрлийн хязгаарлалт тогтоосон нөхцлүүдийг талууд гэрээгээр тохиролцож тогтоож болох бөгөөд энэ байдал нь Иргэний хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д "Иргэний эрх зүйн чадамжийг хэлцэл хийх замаар хязгаарлахыг хориглоно" гэж заасантай зөрчилдөхгүй байх, түүнчлэн хүчин төгөлдөр бус байх /ИХ-ийн 56 дугаар зүйл/ эсхүл сонирхогч этгээдийн хүсэлтээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл /ИХ-ийн 57 дугаар зүйл/ гэж үзэхгүй нөхцөл байдлыг бий болгохгүй байх ёстой юм.

Зургаа. Франчайзийн гэрээний үүргийг гүйцэтгэх

Өмнө тэмдэглэсэнчлэн франчайзийн гэрээ нь урьдчилан

тохиролцсон гэрээ учир уг гэрээнээс үүсэх үүргийг гүйцэтгэх үйл ажиллагаа нь доорх хоёр үе шатыг дамжиж хэрэгждэг гэж үздэг байна.¹

Эхний үе шат.

Энэ үе шатанд эрх шилжүүлэгч нь бодит байдалд үүрэг гүйцэтгэгчийн байр сууринд очих бөгөөд дараах хэд хэдэн үйлдлийг гүйцэтгэх үүрэгтэй болох бөгөөд үүнийг гүйцэтгэхийг шаардах эрх нь эрх хүлээн авагчид хадгалагдах ажээ. Франчайзийн гэрээг байгуулснаар хэрвээ гэрээг бүртгүүлэх нь эрх хүлээн авагчийн үүрэг байхаар гэрээнд заагаагүй бол гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх, эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах /ИХ-ийн 334.1.3/ буюу түүнд техникийн туслалцаа үзүүлэх /ИХ-ийн 334.1.4/, түүнчлэн эрх хүлээн авагчийн ажиллах хүчнийг сургах /ИХ-ийн 334.1.5/ үйл ажиллагааг явуулах үүрэг хүлээнэ.

Эрх шилжүүлэгч эдгээр үүргээ зохих ёсоор гүйцэтгэсний дараачаар эрх хүлээн авагч нь франчайзийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжтой болдог.

Хоёр дахь үе шат.

Энэ үе шатанд талуудын эрх үүргийн харьцаа солигдож, эрх хүлээн авагч нь үүрэг гүйцэтгэгч болж, эрх шилжүүлэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн байр сууринд шилждэг.

Эрх шилжүүлэгчийн хүлээж буй зарим нэгэн үүргүүд нь гэрээний энэхүү үе шатанд төдийлэн ач холбогдолтой биш болж ирдэг. Тодруулбал, эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах /ИХ-ийн 334.1.3/ буюу түүнд техникийн туслалцаа үзүүлэх /ИХ-ийн 334.1.4/, түүнчлэн эрх хүлээн авагчийн ажиллах хүчнийг сургах /ИХ-ийн 334.1.5/ зэрэг үүрэг хэдий хэвээр байх боловч энэ нь анхлан гэрээг байгуулж байх үеийнхийг бодвол харьцангуй ач холбогдол нь буурдаг.

Энэ үе шатанд эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчээс шилжүүлэн авсан фирмийн нэр, барааны тэмдэг зэргийг ашиглах талаархи гэрээнд заасан үйл

ажиллагааг хэрэгжүүлэхдээ гэрээгээр тохирч тогтоосон нөхцөл журмыг чанд баримтлан үйл ажиллагаагаа явуулах үүрэг хүлээх ажээ. Эрх хүлээн авагч нь үүргээ ийнхүү гүйцэтгэснээр түүний үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээ, гүйцэтгэж буй ажлын чанар байдал нь эрх шилжүүлэгчийн өөрийн нь гаргаж байгаатай нэг түвшинд байх боломж бүрддэг.

Франчайзийн гэрээний талуудын хүлээх хариуцлага

Аливаа гэрээгээр талуудын хүлээх хариуцлага нь эн тэргүүнд хуулиар, эрх дундаа Иргэний хуулийн нийтлэг зохицуулалтын дагуу хүлээх хариуцлагыг тогтоосон хэм хэмжээгээр, үүний дараа гэрээгээр тодорхойлогдож байдаг билээ. Энэ жишгийн дагуу франчайзийн гэрээний талуудын хүлээх хариуцлага нь эн тэргүүнд Иргэний хуулийн 17 дугаар бүлэг Үүргийн гүйцэтгэлд саад болох нөхцөл байдал, 227 дугаар зүйл болон холбогдох бусад зүйл заалтуудаар тогтоосон хариуцлагыг хэрвээ гэрээний үүргийг зөрчсөн бол хүлээнэ. Гэхдээ Иргэний хуулийн франчайзийн гэрээний талаархи зохицуулалтад энэ талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй боловч аливаа гэрээнд нийтлэг байдлаар мөрдөгдөх зохицуулалт гэдэг утгаараа Иргэний хуулийн 17 дугаар бүлгийн зохицуулалтын тохирох заалтууд нь франчайзийн гэрээнд хамааран үйлчлэх нь ойлгомжтой юм. Үүний дагуу эрх шилжүүлэгч эсхүл эрх хүлээн авагчийн хэн нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.1-д зааснаар "...нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаа шаардах эрхтэй" байх бөгөөд 227.3-д заасан тохиолдолд "...олох байсан орлогыг хохиролд тооцож" шаардах эрхийг эдэлнэ.

Франчайзийн гэрээний ямар нэгэн нөхцөлийг л зөрчсөн байх нь энэхүү хариуцлагыг хүлээлгэх хууль зүйн үндэслэл болно.

Ингэхдээ дараах нөхцөл байдал бодитой бий болсон байх

¹ Брагинский М.И., Витрянский В.В. Договорное право. Книга третья. Договоры о выполнении работ и оказании услуг. Издание доп и исп. М. Статут. 2003. 1026 дахь талаарх дэлгэрүүлэн үзнэ үү.

шаардлагатай. Үүнд:

- Хохирсон гэх талд хохирол бодитойгоор учирсан байх;

- Гэрээний үүргийг зөрчсөн зөрчил, учирсан хохирлын хооронд шалтгаант холбоо байх явдлыг хамруулан ойлгоно.

Хохирлыг арилгуулахыг шаардахын зэрэгцээ гэрээгээр тохирсон бол анз төлөхийг шаардах эрхийг мөн эрх нь зөрчигдсөн тал нь эдэлнэ.

Иргэний хуулийн 338 дугаар эвдэлд талуудын хүлээх хариуцлагын талаархи зохицуулалтыг тогтоосон байна. Иргэний хуулийн 338 дугаар зүйлийн 338.1-д "Талууд гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл болон өгсөн мэдээллийн үнэн зөвийг хариуцна" гэжээ. Эндээс харахад эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл, эрх хүлээн авагчид өгсөн мэдээллийн үнэн зөвийг эрх хүлээн авагчийн өмнө; харин эрх хүлээн авагч нь дээрх үүргийг эрх шилжүүлэгчийн өмнө төдийгүй мөн хэрэглэгч, захиалагч, үйлчлүүлэгч гэх гуравдагч этгээдүүдийн өмнө хариуцдаг онцлогтой.

Хэрвээ эрх хүлээн авагч нь франчайзийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйтэй холбоотойгоор эрх шилжүүлэгчид хохирол учруулах болон илүү зардал гаргахад хүргэсэн бол хохирол, зардлыг түүнд нөхөн төлөх үүрэг хүлээнэ. /ИХ-ийн 338 дугаар зүйлийн 338.2 дахь хэсэг/.

Энэ гэрээг байгуулснаар эрх хүлээн авч байгаа этгээд өөрийн бизнесийн үйл ажиллагааны ашиг орлого нь түүний хүсч байсан тэр хэмжээнд нэмэгдэхгүй байгаа байдал нь эрх шилжүүлэгчид ямар нэгэн үүрэг, хариуцлагыг бий болгохгүй. Өөрөөр хэлбэл, эрх шилжүүлэгч нь түүний фирмийн нэр, барааны тэмдгийг ашиглах эрхээ эрх хүлээн авагчид шилжүүлж байгаа нь эрх хүлээн авагчийн ашиг орлогыг нэмэгдүүлэх амлалтыг өөртөө авч байгаа хэрэг огтхон ч биш бөгөөд ингэж ашиг орлого олох баталгаа гаргаж байгаа асуудал биш юм. Фирмийн нэр зэргийг бизнесийн үйл ажиллагаандаа ашигласнаар ашиг орлого нь нэмэгдэж, хүсэн хүлээж байсан үр

дүндээ хүрэх эсэх талаар эрх хүлээн авагч өөрийн тооцоо, судалгааг хийсний үндсэн дээр франчайзийн харилцаанд оролцох шаардлага зүй ёсоор тавигддаг. Энэ тухайд Иргэний хуулийн 338 дугаар зүйлийн 338.3-д "Эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээний үр дүнд эрх хүлээн авагчийн олох орлогын талаар баталгаа гаргахгүй, хариуцлага хүлээхгүй" гэж заасан байна.

Түүнчлэн эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчээс боловсруулсан хамтын ажиллагааны хөтөлбөр, өмжл, хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо зэргээс гамжиг байдалаар, эсхүл уг журмын дагуу явуулсан боловч эрх хүлээн авагчийн гэм буруутай үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдэд өөрөөр хэлбэл, эрх хүлээн авагчаар ажил гүйцэтгүүлсэн буюу түүнээс бараа бүтээгдэхүүн худалдан авсан, эсхүл үйлчилгээ хийлгүүлсэн этгээдэд хохирол учирсан бол хохирлыг эрх шилжүүлэгч хариуцахгүй /ИХ-ийн 338 дугаар зүйлийн 338.4/.

Долоо. Гэрээг шинэчлэх, өөрчлөх, цуцлах.

Гэрээг шинэчлэх

Франчайзийн гэрээний нэг онцлог шинж гэвэл гэрээний бүхий л үүргээ хугацаанд нь, сайн дураар, зохих ёсоор гүйцэтгэсэн эрх хүлээн авагч этгээд гэрээний хугацаа дууссан тохиолдолд өмнө байгуулсан нөхцлөөр франчайзийн гэрээг сунгаж болдог явдал юм.

Энэ тухай Иргэний хуулийн 336 дугаар зүйлийн 336.3-т "Гэрээнд заасан хугацаа дууссан боловч аль нэг талын санаачилгаар талууд харилцан итгэлцэх, хамтран ажиллах зарчмыг удирдлага болгон ажил хэргийн харилцаа дуусгавар болох хүртэл гэрээгээ тодорхой буюу тодорхой бус хугацаагаар тухайн буюу шинэчилсэн нөхцлөөр сунгаж болно" гэжээ.

Гэрээг өөрчлөх, дуусгавар болгох

Франчайзийн гэрээг түүний үйлчлэх хурацаанд нь Иргэний эрх зүйн гэрээг өөрчлөх, цуцлах нийтлэг журмын дагуу талууд өөрчилж, цуцалж болно.

Эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээг эрх хүлээн авагчид ашиглуулж буй фирмийн нэр, барааны тэмдэг гэх мэт/тухайд хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд ингэхдээ эрх хүлээн авагчийн зөвшөөрөл зайлшгүй байх шаардлагатай.

Хугацаа заагаагүй франчайзийн гэрээ нь талуудын аль нэг нь гэрээг цуцлах тухай нөгөө талдаа мэдэгсэнээр 1 жилийн дотор цуцалж, дуусгавар болж болно. Харин хугацаатай байгуулсан франчайзийн гэрээ нь гэрээний үүрэг биелэгдсэн гэх нийтлэг үндэслэлээр дуусгавар болно. Үүнээс гадна франчайзийн гэрээ нь:

- Эрх шилжүүлэгчийн фирмийн нэр, барааны тэмдэг гэх мэт онцгой эрхийн объект, түүний эрх нь дуусгавар болж, түүний оронд ямар нэгэн объект шинээр гарч ирээгүй тохиолдолд /ялангуяа хуулийн этгээдийг татан буулгах болон өөрчлөн байгуулах эсхүл хуулийн этгээд нь онцгой эрхээ удаан хугацааны туршид ашиглаагүй зэрэг тохиолдолд/;

- Эрх шилжүүлэгч нь фирмийн нэр, барааны тэмдэг зэргээ өөрчилж, энэ тухайд эрх шилжүүлэгчийн зөвшөөрөл байхгүй тохиолдолд;

- Гэрээний аль нэг тал дампуурсанд тооцож, татан буулгасан бол;

- Эрх шилжүүлэгч нь иргэн байх тохиолдолд тэрээр нас барсан, ингэхдээ түүний өв залгамжлагч нь фирмийн нэр, барааны тэмдгийн эрхийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тус тус франчайзийн гэрээг цуцалж, дуусгавар болно.



Шилжилтийн үеийн нийгмийн хангамжийн эрх зүй

Монгол орон зах зээлийн эдийн засагт шилжсэнээр нийгэм эдийн засгийн салбарт хийгдсэн томоохон өөрчлөлтийн нэг нь нийгмийн хамгааллын тогтолцоог шинэ нөхцөл байдалд тохируулан өөрчилж төлөвшүүлж байгаа явдал юм.

Эдийн засгийн хямрал гүнзгийрч үйлдвэрлэл буурч, ард иргэдийн амьжиргааны түвшин доошилж байсан тухайн нөхцөлд нийгмийн хангамжийн тогтолцоог өөрчлөх нь тийм ч хялбар бус байсан гэдэг нь ойлгомжтой.

Монгол Улсад нийгмийн хангамж үүссэн зүй тогтлыг цаг хугацааны хувьд дараах байдлаар авч үзье. Үүнд:

1. 1990 оноос өмнөх үе;
2. 1990-1994 оны үе;
3. 1995 оноос хойшхи үе.

1990 оноос өмнөх үе: Монголын эртний түүхэн эх сурвалжаас авч үзвэл иргэдийн энэрэл, өтгөс, ядуус, өнчидгийг асран тэтгэх явдал монголын төрийн нийгмийн бодлогын чухал хэсэг байжээ. 1206 онд Их Монгол улс байгуулагдсан үеэс өнчин ядуусыг тэтгэх ажил төрийн бодлогын хэмжээнд тавигдаж байсныг түүхэн баримт нотолж байна¹.

Богд хаант Монгол Улсын хувьд 70 наснаас дээш 80 насанд хүртэлх хөгшдөд мөнгө гурван лан, 90 наснаас дээш 100 насанд хүрэгсдэд есөн лан, 100 насанд хүрэгсдийг ирүүлээд жич өршөөн шагнахыг үзүүлүгэй хэмээн Өвгөд хөгшид өнчин дорд ядуу зүдүү иргэдийг асран тэтгэх тухай зарлигтаа заажээ².

Ардын хувьсгалын жилүүд буюу 1921-1940 онуудад иргэдийн материаллаг хангамжийг сайжруулах талаар авсан арга хэмжээний үр дүнд зарим төрлийн тэтгэвэр, тэтгэмж олгох, өндөр настан, хөдөлмөрийн чадваргүй иргэдийг



ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Отгонтэнгэр их сургуулийн багш Д.Эрдэнэчимэг

асран тэтгэх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх зэрэг нийгмийн хангамжийн үндсэн хэлбэрүүдийг тогтоож нийгмийн хангамжийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам батлагдан, ажилчин албан хаагчдын материаллаг хангамжийг хөгжүүлэх хөрс суурь тавигдсан юм.

1940 оны Үндсэн хуулиар анх иргэдийн өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдахад материалын хангамж эдлэх үндсэн эрхийг: "...Монгол Улсын хөлсний ажил хийгч ард иргэд нь нас хөгшрөх цагт мөн түүнчлэн өвдөх ба хөдөлмөрийн чадвараа алдвал эдийн засгийн тусламж авах эрхтэй" хэмээн хуульчлан баталгаажуулжээ³.

1958 онд БНМАУ-ын Ардын Их Хурлаас БНМАУ-ын Тэтгэврийн хуулийг баталсан нь нийгмийн хангамжийн эрх зүйн хөгжлийн түүхэнд гарсан чухал үйл явдлын нэг байв. Энэ хуулиар тэтгэврийн хангамжийн үндсэн зарчим болох тэтгэврийн хангамж нь бүх ажилчин, албан хаагч болон нийгмийн даатгалд даатгагдсан бусад иргэдэд

хамаарах, тэтгэврийн хөрөнгийг улс бүрэн хариуцах, иргэдэд олон хэлбэрийн хангамж үзүүлэх, тэтгэврийн эрхийг нь бүх талаар хамгаалан бодит баталгааг төрөөс тогтоох, тэтгэврийн хангамжийг хэрэгжүүлэхэд үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг өргөн оролцуулах зэрэг зарчмыг нэгтгэн тодорхойлжээ.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлээр Монгол Улсын иргэд нас хөгшрөх, өвдөх, хөдөлмөрийн чадвараа алдах, тэжээгчээ алдахад эдийн тусламж авах эрхийг нь тунхагласны зэрэгцээ энэ эрхээ хангах баталгааг нь тогтоож, нийгмийн даатгал, улсын тэтгэвэр, хоршооллын байгууллагын тусгай фондын системээр дамжуулж хөдөлмөрчдөд тусламж олгох, амралт сувилалын газрыг олшруулж эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлэх тухай заасан нь социалист тогтолцооны үеийн нийгмийн хангамжийн бодлогын эрх зүйн үндэс нь болсон юм. Энэ үеийн нийгмийн хангамжийн үйл ажиллагааны нэг хэсэг нь нийгмийн даатгалын хангамж юм. Нийгмийн даатгалын хангамжийг тэтгэврийн хангамж, тэтгэмжийн хангамж, хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үйлчилгээ, материалын биет тусламж, соёл ахуйн үйлчилгээ гэсэн дөрвөн төрлөөр авч үзэж байсан. Нийгмийн даатгалын хангамжийн үндсэн төрөл нь тэтгэврийн хангамж юм. Тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжоор тэтгэврийн хангамжийг:

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Удаан жил ажилласны тэтгэвэр
- Тусгай тэтгэвэр гэж ангилж байжээ.

Эдгээрээс удаан жил ажилласны тэтгэвэр нь цэргийн албан хаагчдад цэргийн алба хаасных нь төлөө, урлагийн зарим мэргэжлийн жүжигчдэд уг мэргэжлээрээ ажилласных нь төлөө тус тус олгож байжээ. Харин тусгай тэтгэврийг тэтгэвэр авагчийн эрхэлж

¹ Монголын нууц товчоо. 1999

² С.Уянга "Нийгмийн хангамжийн эрх зүй". 2001.

³ Монгол Улсын Үндсэн хуулийн 91 дүгээр зүйл. 1940.

байсан ажил албан тушаалын зиндааг харгалзан олгож байжээ. Энэ зохицуулалт нь тэтгэвэр авагч иргэдийг ялгаварлаж байсны илрэл юм.

Иргэд нийгмийн даатгалаас тэтгэвэр авах нэг гол үндэслэл бол улсад ажилласан хугацаа байсан бөгөөд тэтгэврийн нэмэгдэл дотор тасралтгүй ажилласны нэмэгдлийг тооцон олгож байжээ.

Мөн энэ үед нийгмийн даатгалыг ажилчин албан хаагчдын, ХААН-ийн гишүүдийн гэж ангилж авч үзээд ажилчин албан хаагчдын нийгмийн даатгалын хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө, үйлдвэр аж ахуйн газар, албан байгууллагаас нь төлсөн шимтгэлээс бүрдүүлдэг харин ХААН-ийн хамтын хөдөлмөрөөр олсон орлогын тодорхой хувиар бүрдүүлсэн нийгмийн хэрэглээний фондоос ХААН-ийн гишүүдийн нийгмийн даатгалын хөрөнгийг гаргаж байв.

1990-1994 оны үе: Монгол Улс эдийн засгийн шинэ хэвшлийг хүлээн зөвшөөрч зах зээлийн эдийн засагт шилжсэн нь нийгмийн хангамжийн эрх зүйн хүрээнд хийгдсэн өөрчлөлт шинэчлэлийн гол шалтгаан болсон юм. 1990 оны 4 сард Улсын бага хурлаас Монгол Улсын тэтгэмжийн тухай хууль, Улсын нийгмийн даатгалын шимтгэл төлөх тухай хууль, мөн оны 12 сард Монгол Улсын тэтгэврийн хуулийг тус тус батлан гаргасан нь энэхүү өөрчлөлт, шинэчлэлийн үйл ажиллагааны эхлэл болсон юм.

1990 оны Тэтгэврийн хуулийн ололтийг тал нь тэтгэврийн хангамжаг нэгэнт бий болсон ялгаварлан гадуурхах бодлогыг өөрчилж улсын байгууллага, хоршоолол, хувийн үйлдвэр, аж ахуйн нэгжид ажиллагсдын тэтгэврийг бодох хувь хэмжээ нь ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан тогтоогдох, өөрөөр хэлбэл, тэтгэвэр тогтоох үндсэн нөхцөл нь адил байхаар хуульчилсан явдал юм. Энэ нь өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч субъектүүдийн тэгш эрхийг хангахад чиглэгдсэн анхны алхам байлаа. Хэдий тийм боловч энэ хууль нь нилээд хуучинсаг бөгөөд тэгшитгэх аргыг халж чадаагүй бөгөөд

тэтгэврийн хөрөнгийг бүрдүүлэхэд даатгуулагчийн оролцоог үгүйсгэж түүнийг хөндлөнгийн хүний түвшинд авч үзсэн байдаг.

Зохих судалгаа хийж үзэхэд 1990 оны Тэтгэврийн тухай хуулиар 1958 онд батлагдаж, 1978 онд шинэчлэн найруулсан Тэтгэврийн тухай хуулиар тогтоосон нийгмийн даатгалын тогтолцоог хэвээр үлдээж харин өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэл болзлуудыг нэлээд өргөтгөжээ. Эл хуулиар өөрсдөө хүсэлт гаргасан бол 32 жил нийтдээ ажилласан 55 нас хүрсэн эрэгтэйчүүд, нийтдээ 27 жил ажилласан эсхүл 4 ба түүнээс дээш тооны хүүхдийг төрүүлж 6 нас хүртэл өсгөж бойжуулсан 20-оос доошгүй жил ажилласан эмэгтэйчүүд нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол журмыг тогтоожээ. Энэ зохицуулалтаар зөвхөн 1991 онд гэхэд л 53.1 мянган хүн шинээр тэтгэвэр тогтоолгосон бөгөөд ээж охин хоёр зэрэг өндөр насны тэтгэвэр тогтоолгох явдал ч гарч байжээ.

1991-1994 оны үеийг өндөр насны тэтгэвэр эрчимтэй тогтоох үе гэж үздэг ба энэ нь тухайн үеийн нийгмийн амьдралд тэр бүр нийцсэн зохицуулалт болж чадаагүй юм. Үүнийг тод жишээ нь 2005 онд тэтгэвэр авагчдын хөдөлгөөнөөс Монгол Улсын Засгийн газарт өргөсөн бичигт¹ ... 1991 оны үед хөдөлмөрийн чадвартай бид бүхнийг олон хүүхэдтэй, олон жил ажилласан гэж хөөрцөглүүлэн хоморголж тэтгэвэрт гаргасан... гэж дурдсан байна. 1990 оны Тэтгэврийн хуулийн түүхэн үүрэг, ач холбогдлыг доктор, профессор Б.Уранцэцэг дараах байдлаар үнэлэн цэгнэсэн байдаг. "... олон тооны эмэгтэй нас харгалзахгүйгээр насны тэтгэвэрт гарсныг 1990 оны тэтгэврийн хуулийн нэг доголдол гэж үздэг. Судлаачийн хувьд би үүнийг зөвхөн уг хуулийн дутагдал гэж үздэггүй. Учир нь нас харгалзахгүйгээр насны тэтгэвэр тогтоолгосон гэх эхчүүдэд 1990 оны тэтгэвэрийн хууль зөвхөн тэтгэвэр тогтоолгох эрхийг нь олгоосон. Уг эрхээ эдлэх сонирхлын дагуу насны тэтгэвэр тогтоолгосон эхийн тоо харьцангуй цөөн байсан. Харин

хөнгөлөлттэй нөхцлөөр ийм олон тооны эмэгтэйчүүд тэтгэвэрт гарсан явдлыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд Тэтгэврийн хуулийн энэхүү заалтыг буруу хэрэглэсэн нь зонхилох шалтгаан болсон гэж бодит талаас нь би дүгнэдэг..." гэжээ².

Энэ хууль нь улс орны нийгмийн хангамжийн бодлогыг эрчимжүүлэх тухайн үеийн төрийн бодлогыг тодорхойлогч чухал баримт бичиг төдийгүй Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог халж, нийгмийн чиг баримжаат зах зээлийн эдийн засгийг хэвшүүлэх хүртэлх завсрын түүхэн зурвас үед үйлчилж байснаараа онцлог юм.

1992 онд батлагдсан Үндсэн хуульд "... Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн өмчийн олон хэвшил бүхий эдийн засагтай байх..."-аар тунхаглаж мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "...иргэд өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй..." гэж заасан нь тэтгэвэр, тэтгэмжийн хуулийг ч, нийгмийн даатгалын тогтолцоог ч үндсээр нь өөрчлөх үндэслэл болсон юм.

Үндсэн хуульд заагдсан энэхүү үзэл баримтлалын дагуу 1995 оноос эхлэн нийгмийн даатгалын асуудал шинэ агуулга, зарчмаар зохицуулагдах болов.

1995-аас хойшхи үе: Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудыг боловсруулах ажлыг үндсэндээ 1994 оноос эхэлсэн бөгөөд 1995 оны 1 сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

Түүнчлэн 1995 онд Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай

¹ "Өдрийн сонин", 2005 оны 11 сарын 25-ны өдрийн № 284

² Монголын эрх зүйн шинэтгэл 8 жил, УБ., 2003 он, 313 дахь тал

хууль, Нийгмийн халамжийн сангаас хүн амын эмзэг хэсэгт төрөөс үзүүлэх нийгмийн болон асрамжийн үйлчилгээний тухай хууль, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай хуулийг Монгол Улсын Их хурлаас батлан гаргасан нь нийгмийн эмзэг хэсэг болон ахмад настан нэн ядуу өрхийн нийгмийн халамжийн асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болсон юм.

Ингэснээр Монгол Улсад нилээд орчин үеийн, зах зээлийн хөгжлийн зүй тогтолд илүү нийцтэй тогтолцоо бүрдэж эхэлсэн гэж хэлж болно.

Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн багц хуулийг боловсруулахад дараах үзэл баримтлалыг удирдлага болгосон. Үүнд:

1. Дэлхий нийтийн эдийн засаг, эрх зүйн харилцааны хөгжлийн түгээмэл чиг хандлагыг өөрийн орны хөгжлийн чиг хандлагатай нийцүүлж хуульчлах
2. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах нөхцөлийг улам боловсронгуй болгох: Нийт иргэд адил нөхцөл болсноор нийгмийн даатгалын харилцаанд оролцох болсон нь Үндсэн хуулиар тунхаглагдсан хүн бүр тэгш эрхтэй байх зарчмын баталгаа болсон. Түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс болон даатгуулагч, ажил олгогч нар хослон хариуцах зарчмыг удирдлага болгосон. Өөрөөр хэлбэл, өмнөх тогтолцооны үед иргэд нийгмийн даатгалын санд ямар нэг шимтгэл төлдөггүй байсан бол Нийгмийн даатгалын багц хууль батлагдсанаар иргэд авч буй цалин хөлс орлогоосоо, ажил олгогч цалингийн сангаасаа тодорхой хувиар шимтгэл төлөх үүрэгтэй болсон байна. Ингэснээр нийгмийн даатгалын санг бүрдүүлэхэд даатгуулагч иргэн, ажил олгогч, төр хэн аף нь адил эрх, үүрэгтэйгээр оролцох

нөхцөл бүрдсэн гэж хэлж болно.

3. Үндсэн хуульд заагдсан иргэд өндөр наслха, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхийн хамгаалалтын баталгааг илүү нарийвчлан тодорхойлох: Үүний тулд даатгалын төрөл бүр өөр өөрийн сантай байх бөгөөд сангийн хөрөнгийг өөр хооронд нь холих, нэгээс нөгөөд шилжүүлэхийг хориглосон байна. Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмжийн санг бий болгохдоо ажил олгогчоос төлөх шимтгэлээс бүрдүүлэхээр заасан нь ажил олгогчдын хариуцлагыг хөдөлмөр хамгааллын хүрээнд нэмэгдүүлсэн төдийгүй ажилтан үйлдвэрлэлийн осолд өртөх, мэргэжлээс шалтгаалах өвчин тусах тохиолдолд тэдэнд олгох хөнгөлөлт, тусламжийг илүү баталгаатай болгож өгсөн зохицуулалт болжээ. Үүнээс гадна төр улсын төвлөрсөн төсвөөс нийгмийн хангамжийн үйл ажиллагааны тодорхой хувийг санхүүжүүлэх үүрэг хүлээжээ.
4. Нийгмийн хангамжийн харилцаанд төрийн зохицуулалт, гэрээний эрх чөлөөний зарчмыг илүү оновчтой хослуулах: Төрөөс энэ асуудлыг шийдвэрлэхдээ нийгмийн даатгалын заавал даатгал, нийгмийн даатгалын сайн дурын даатгал гэсэн хоёр хэлбэрийг сонгон авсан юм.
5. Эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгах: Өмнө нь нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хэлбэрүүд холилдон байсныг зааглаж иргэдийн нийгмийн даатгалын тогтолцоо, иргэдийн нийгмийн халамжийн тогтолцоо гэсэн хоёр үндсэн тогтолцоог бий болгосон. Эл хоёр тогтолцоо нь санхүүжилтийн эх үүсвэр, хангамж үзүүлэх болзол, нөхцөл, зорилго зэргээрээ ялгаатай.

Ийнхүү нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн багц хуулиуд нь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан шинэ зарчмаар өөрчлөгдөн шинэчлэгдсэн боловч Монгол Улсад үйлчилж буй нийгмийн хангамж нь нэр төрлийн хувьд цөөн, хүртээмж муутай, хэмжээний хувьд амьжиргаа залгуулж чадахгүй өчүүхэн бага байгааг дурдахгүй орхиж болохгүй юм.

Эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг 7.5-аас дээшгүй хувиар нэмэгдүүлэхээр тусгагдсан зорилтыг хангах чиглэлээр Засгийн газрын 22 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, зарим иргэдийн тэтгэврийн хэмжээг 7.5 хувиар нэмэгдүүлсэн.

Энэ тогтоолоор 1990 он ба түүнээс өмнө тогтоогдсон тэтгэврийн зөрүүг арилгаж байгаа боловч энэ нь түр зуурын гал унтраах төдий эдийн засгийн арга хэмжээ болж байна. Иймээс тэтгэврийн зөрүү гэдэг ойлголт, яриа хууль тогтоогогдоос эхлээд ард иргэдийн дунд яригдах болж түүнийг арилгахын төлөө ахмад настанууд нэгдэн тэмцэх болсон. Энэ нь ижил албан тушаалд ижил хугацаагаар хөдөлмөр эрхэлж байсан иргэд өөр өөр цаг хугацаанд тэтгэвэрт гарснаар янз бүрийн хэмжээтэй тэтгэвэр тогтоолгосонтой холбоотой.

Зах зээлийн эдийн засгийн эрх зүйн харилцааны зарчим, үндсэн үзэл баримтлал нь дэлхий дахинаа нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, өөр хоорондоо ижил төстэй байдагтай уялдуулан, зах зээл өндөр хөгжсөн орнуудын эрх зүйн зохицуулалтын түүхэн туршлага, хөгжлийн зүй тогтлыг харгалзан 1999 онд Улсын Их Хурлаас Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансыг тухай хуулийг батлан гаргасан. Тэтгэврийн нэрийн дансыг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нөхцөл журмын дагуу тэтгэврийн даатгалд хамрагдсан, 1960 оны 1 сарын 1-ээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээнэ. 1999 онд төрөөс боловсруулсан Тэтгэврийн

шинэчлэлийн үзэл баримтлалд¹ тэтгэврийн даатгалын хуваарилалтын одоогийн тогтолцоонд нэрийн дансны аргыг хэрэглэж, 2005 оноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж угтвар нөхцөл бүрдүүлж, 2021 оноос бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжинэ хэмээн заасан нь энэ хууль батлагдан гарах үндэслэл болсон юм. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль нь ирээдүйг харсан зохицуулалтыг хийсэн нилээд өвөрмөц бүтэцтэй хууль болсон бөгөөд энэ талаар эрдэмтэн судлаачдын дунд санал бодлын зөрөлдөөн байдгийг үгүйсгэхгүй ээ.

Манай улс энэ зохицуулалтыг сонгон авснаар даатгалын хөрөнгөтэй холбоотой гарч болзошгүй хямралаас сэргийлэх, улсын төсвөөс нийгмийн даатгалын хангамжинд зориулдаг ачааллыг бууруулах, иргэд төлсөн шимтгэлээ бүрэн хэмжээгээр буцаан авах боломжийг бүрдүүлэх, улмаар иргэд тэтгэврийн даатгалын шимтгэлээ өсгөх сонирхлыг бий болгож, даатгалын хуваарилалтын тогтолцоог өөрчилж, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулж шударга хуваарилалтыг баталгаажуулах зэрэг ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, даатгуулагч иргэний авах тэтгэврийн хэмжээ нь зөвхөн төрөөс нь буюу дансанд нь хуримтлагдсан шимтгэлийн хэмжээнээс шууд хамаардаг. Даатгуулагчийн төлсөн шимтгэл өөр хэнд ч биш зөвхөн тухайн даатгуулагчдаа зарцуулагддаг учир шударга тогтолцоо гэж тооцогддог.

Гэхдээ эдийн засгийн хөгжил тогтворжоогүй, хүн амын орлого хангалттай биш байгаа өнөөгийн нөхцөлд тэтгэврийн санд зохих нөөц хуримтлагдаж эхэлсэн эсэх, үгүй бол энэ хүндрэлээс хэрхэн гаргах нь гэсэн асуулт өнөөдөр хариултаа хүлээж, анхаарах татсаар байна. Тэтгэврийн нэрийн дансны зохицуулалтыг хэрэглэдэг хөгжингүй орнуудын туршлагаас харахад нэрийн дансанд хуримтлагдсан мөнгийг засгийн газрын гишүүн, төрийн эрх бүхий албан тушаалтнууд эргэлтэнд оруулж нийгмийн даатгалын байгууллагыг

дампуурлын ирмэг дээр авчирч байсан гашуун түүх тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Иймээс тэтгэврийн хуулийг хэрэгжүүлэх явцад буруу хэрэглэн хуулийн утга санааг гажуудуулсан 1991 оны гашуун туршлагаа санаж Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг хэрэглэх явцад гаргасан хөгжингүй орнуудын алдаа дутагдлыг давтахгүй байх гарц боломжийг судалж, анхаарах шаардлагатай.

Монгол Улсад ажилгүйдэл, ядуурал өдрөөс өдөрт улам бүр нэмэгдэж төр засаг нь нийгмийн наад захын үйлчилгээг хангаж чадахгүй байдалд хүрч байгаа нь нууц биш ээ. Гэхдээ 2006 онд УИХ-аас Нийгмийн халамжийн бапц хуулийг шинэчлэн боловсруулж Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудыг тус тус батлан гаргасан юм. Эдгээр хуулиар өмнө нь үйлчилж байсан халамжийн төрөл, хэмжээг нилээд өөрчилсөн бөгөөд нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэдэд амьжиргааны тусалцаа үзүүлэх арга хэмжээний төрөл зүйлийг нь нэмэгдүүлсэн шинэлэг зохицуулалт хийгдсэн юм.

Дээр дурдсан нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тогтолцооны дагуу хангамж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэхэд төрөөс баримталж байгаа гол шалгуур нь хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээ болон амьжиргааны баталгаажих доод түвшин юм.

Нийгмийн хангамжийн харилцаа болон нийгмийн даатгалын хууль тогтоомжид хийгдсэн өөрчлөлттэй уялдан нийгмийн хангамж гэсэн ойлголтыг зөв томьёолон, тодорхойлох нь чухал юм. Социалист тогтолцооны үед иргэдийг нийгмийн даатгал, эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулж төр иргэдийнхээ нийгмийн хамгааллын асуудлыг өөрийн нуруундаа бүхэлд нь үүрч, энэ талаархи бүхий л хариуцлагыг бүрэн хүлээж байсан үед нийгмийн хамгааллын цогцолбор арга хэмжээг

төрөөс ханган хэрэгжүүлдэг гэсэн утгаар нийгмийн хангамж гэсэн нэр томьёог хэрэглэж заншсан байв. Харин зах зээлийн харилцаанд шилжиж тэтгэврийн өөрчлөлт шинэчлэл хийгдэж иргэд авч буй цалин хөлснөөсөө нийгмийн даатгалд шимтгэл төлөх үүрэг хүлээж улмаар даатгалын санд оруулсан шимтгэл, шимтгэл төлсөн цалин, хөлстэй холбоотойгоор тэтгэвэр олгогдох эдийн засгийн хууль үйлчлэх болсон өнөө үед нийгмийн хангамж гэсэн нэр томьёо нь тийм ч оновчтой биш байгааг энэ дашрамд дурдах нь зүйтэй болов уу.

Нийгмийн даатгалын тогтолцооны гол зорилго нь нийгмийн даатгалын шимтгэл төлж бий болгосон даатгалын аль нэг сангаас даатгуулагч амьжиргааны эх үүсвэргүй болсон тохиолдолд амьжиргааны эх үүсвэрээр хангахад оршдог бол нийгмийн халамжийн тогтолцооны үндсэн зорилго нь хөдөлмөр эрхэлж байгаагүй боловч ямар нэгэн шалтгаанаар амьжиргааны эх үүсвэргүй болсон иргэдэд улсын төсвөөс эд материалын болон санаа сэтгэлийн тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэхэд оршдог. Харин энэ хоёр тогтолцоо нь бүхэлдээ иргэдэд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох, халамжийн сангаас иргэдийн эмзэг хэсэг буюу даатгалын сангаас ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсвэргүй иргэдэд тэтгэвэр олгох, төрөл бүрийн үйлчилгээ, хөнгөлөлт үзүүлэх зэргээр иргэдийн амьжиргааг хангах, эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс авч хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн өргөн хүрээтэй, асран тэтгэх шинжтэй нийгмийн хамгааллын олон талт арга хэмжээ юм. Иймд энэ харилцаанд *нийгмийн хангамж* бус *нийгмийн хамгаалал* гэсэн нэр томьёог хэрэглэх нь илүү зохимжтой байх болов уу.



¹ Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл, Төрийн мэдээлэл, 1999, №29

Үргэлжлэл. (түрүүч нь 2005 оны №2, №3, №4, 2006 оны №1, №2-т)



ИРГЭНИЙ ХУУЛИЙН ТАЙЛБАР¹

/Цуврал/

28 дугаар зүйл. Хуулийн этгээдийн оршин байгаа газар

28.1.Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ.

28.2.Хуулийн этгээд нь оршин байх нэг газар буюу хууль ёсны хаягтай байна.

ТАЙЛБАР

28.1 дэх хэсэг

Хуулийн этгээдийн үүрэг гүйцэтгэх газар, маргааныг шийдвэрлэх харьяалал, татвар төлөх газрыг тодорхойлох зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд хуулийн этгээдийн оршин байгаа газрыг тогтоох явдал хууль зүйн ач холбогдолтой байдаг. Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ. (28.1 дэх хэсэг) Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газар гэдэгт үүсгэн байгуулах баримт бичигт дурдсан уг хуулийн этгээдийн удирдах байгууллага (удирдах зөвлөл, захиргаа)-ын оршин байгаа газрыг ойлгоно.

28.2 дахь хэсэг

Хуулийн этгээд нь үүсгэн байгуулах баримт бичигт заасан ерөнхий захиргаа оршин байгаа газраас өөр нэг буюу хэд хэдэн газарт үйл ажиллагаа явуулдаг байж болно. Энэ тохиолдолд уг хуулийн этгээд хэд хэдэн газарт оршин байгаа мэт төөрөгдөл үүсэж болох талтай. Иймд Иргэний хуулийн 28.2-т хуулийн этгээд нь оршин байх нэг газар буюу албан ёсны хаягтай байна гэж заасан. Энд дурдсан "нэг газар" бол уг хуулийн этгээдийн

ерөнхий захиргаа (салбар, төлөөлөгчийн газар биш) байрлаж байгаа аймаг (нийслэл), сум (дүүрэг), гудамж (баг), байшин (өрөө)-ийн албан ёсны хаягаар тодорхойлогдоно.

Жишээ:

А компани барилга барих, алт олборлох зэрэг хэд хэдэн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Дорнод аймагт барилгын чиглэлээр, Өвөрхангай, Сэлэнгэ аймагт алт олборлох чиглэлээр салбаруудаа байгуулан ажиллаж, эдгээр аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байж болно. Гэхдээ А компани улсын бүртгэлд бүртгэгдсэн албан ёсны хаяг буюу тус компанийн захиргаа байрлах байгаа "Улаанбаатар хот, Энхтайваны өргөн чөлөө-15А"-д, өөрөөр хэлбэл, Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутагт оршин байгаа хуулийн этгээд гэж үзнэ.

Үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь өөр өөр нутаг дэвсгэрт явагдаж байгаа тохиолдолд маргааныг ерөнхий захиргаа оршин байгаа газрын нутаг дэвсгэрийн шүүх харьяалан шийдвэрлэдэг гэж ойлгож болохгүй. Бидний жишээн дээр А компанийн Дорнод аймаг дахь салбарын барьсан барилга чанаргүй болж, захиалагчид учирсан хохирлыг арилгах тухай маргаан гарч, А компани хариуцагчаар татагдлаа гэж үзвэл уг маргааныг Баянзүрх дүүргийн шүүх бус, Дорнод аймгийн шүүх шийдвэрлэнэ. Учир нь үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой маргааныг түүний оршин байгаа нутаг дэвсгэрийн шүүх шийдвэрлэх журамтай (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн

16.1 дэх хэсэг). Түүнчлэн алтны уурхай татвар, хураамжаа үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа харьяалагдан төлнө. Харин А компанийн салбаруудын үйл ажиллагаа зогсонги байдалд орж, төлбөрийн чадваргүй болбол А компанийн дампуурлын хэргийг түүний салбарын үйл ажиллагаа явуулж байгаа газраар бус, харин ерөнхий захиргаа оршин байгаа Баянзүрх дүүргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ. Мөн гэрээнд үүрэг гүйцэтгэх газрыг тусгайлан заасан бол түүнтэй холбогдсон нэхэмжлэлийг уг гэрээг биелүүлбэл зохих газрын шүүхэд гаргаж болно (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.2 дахь хэсэг).

29 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар

29.1.Хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан бол хуулийн этгээд өөрийн салбар, төлөөлөгчийн газраа тогтоосон журмын дагуу байгуулж болно.

29.2.Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу заримыг нь гүйцэтгэдэг тусгай нэгжийг салбар гэнэ.

29.3.Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ.

29.4.Салбар, төлөөлөгчийн газрын эрх, үүргийг тухайн хуулийн этгээдийн дүрмээр тодорхойлно.

¹ Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төслөөс эрхлэн гаргасан "Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар"-аас Уншигч Танд зориулан цувралаар нийтэлж байна.

29.5. Салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчид үйл ажиллагаагаа хуулийн этгээдээс олгосон этгэмжлэлийн үндсэн дээр явуулна.

29.6. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар хуулийн этгээдийн эрхгүй байна.

ТАЙЛБАР

29.1 дэх хэсэг

Компанийн тухай, Банкны тухай, Төрийн бус байгууллагын тухай зэрэг хуульд компани, банк, төрийн бус байгууллага нь салбар, төлөөлөгчийн газар байгуулж болох тухай заасан байдаг. Мөн гадаадын хуулийн этгээд Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа байгуулах боломж ч байдаг (Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль).

Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын талаар түүний дүрэмд зааж, хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд (ерөнхий захиргаа оршин байгаа болон салбар, төлөөлөгчийн газрын оршин байгаа газрын) бүртгүүлсэн байна. Хуулийн этгээд байгуулагдаж бүртгэгдсэнийхээ дараа хэдийд ч салбар, төлөөлөгчийн газраа нээж ажиллуулж болох бөгөөд энэ тухай дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулж, зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр салбар, төлөөлөгчийн газар байгуулагдсанд тооцогдоно.

29.2 дахь хэсэг

Иргэний хуулийн 29.2-т зааснаас үзвэл хуулийн этгээдийн салбарын дараах 3 шинжийг тодорхойлж болно:

- хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрладаг;
- хуулийн этгээдийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу заримыг нь гүйцэтгэдэг;
- тусгайлан нэгж байна.

Жишээ:

Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт оршин байгаа "А" компани нь Дорнод аймагт барилгын ажил гүйцэтгэдэг салбараа байгуулсан. Уг салбар нь А хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа Улаанбаатар хотоос өөр газар

байрлаж, түүний эрхэлдэг үйл ажиллагааны нэг чиглэл болох барилгын ажил эрхэлж байна. Өөрөөр хэлбэл, А компанийн үндсэн чиг үүргийн заримыг нь гүйцэтгэж байна.

Өөр нэг жишээ авъя. Монголын хуульч эмзэгтэйчүүдийн холбоо нь хуульч эмзэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэднийг хөгжүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах, эмзэгтэйчүүд, эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалж, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Уг холбооны салбарууд нь бүх аймагт мөн энэ чиглэлээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг. Иймд тус холбооны салбарууд нь түүний үндсэн чиг үүргийг орон нутагт бүхэлд нь гүйцэтгэж байна гэж үзнэ.

Хуульд "тусгай нэгжийг салбар гэнэ" гэж заасан нь салбар бол хуулийн этгээдийн бүрэлдэхүүн хэсэг, ердийн нэгж болох цех, тасаг, газар, хэлтэстэй харьцуулбал илүү тусгаарлагдсан нэгж юм гэдгийг тодотгосон хэрэг болно. Гэхдээ энэ тусгай нэгж бол иргэний эрх зүйн бие даасан оролцогч-хуулийн этгээд болохгүй (29.6 дахь хэсгийн тайлбарыг үзнэ үү).

29.3 дахь хэсэг

Хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын үндсэн шинж нь:

- Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрладаг;
Нэг дэх шинжийн хувьд салбартай ижил байна. Харин төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэггүй, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах (шүүх, арбитрт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, харилцагч нартай хэлэлцээр хийх, уулзалт, ярилцлага зохион байгуулах гэх мэт) эсвэл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хэлцэл хийх гэрээнд гарын үсэг зурах, бараа материал хүлээн авах, илгээх, төлбөр тооцоо гүйцэтгэх зэрэг эрх зүйн бусад үйлдэл хийх эрх, үүрэгтэй байна.

- хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн үйлдэл хийх үүрэг бүхий;

Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрын ялгаа нь тэдгээрийн чиг үүргийн шинж чанар, хүрээгээр тодорхойлогдоно. Иргэний хуулийн 29.2, 29.3 дахь хэсгийн агуулгыг харьцуулан үзвэл салбарын чиг үүрэг нь төлөөлөгчийн газрынхаас илүү өргөн хүрээтэй байна. Салбар нь хуулийн этгээдийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу заримыг нь гүйцэтгэдгийн хувьд төлөөлөгчийн газрын чиг үүргийг ч гүйцэтгэж болно гэж ойлгоно.

нэгж байна.

Төлөөлөгчийн газар бол хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж юм.

Жишээ:

Эрдэнэт үйлдвэрийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар нь зэс олборлох үйл ажиллагаа эрхлэхгүй, харин Эрдэнэт үйлдвэр-хуулийн этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллагатай харилцах, гадаад, дотоодын бусад харилцагчтай хийх гэрээ хэлэлцээр, уулзалт ярилцлагын явцад хамгаалах, эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгж юм.

29.4 дэх хэсэг

Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны чиглэл, эрх, үүргийн талаар тухайн хуулийн этгээдийн дүрэмд заана.

Жишээ:

А компани дүрэмдээ Дорнод аймаг дахь салбар нь барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулна, Өвөрхангай, Сэлэнгэ аймаг дахь салбар нь алт хайх олборлох үйл ажиллагаа явуулна гэдгийг зааж ёстой.

29.5 дахь хэсэг

Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй, иргэний эрх зүйн бие даасан чадваргүй байна. Иймд салбар, төлөөлөгчийн газар нь иргэний эрх зүйн харилцаанд өөрийн нэрийн өмнөөс бус, харин үндсэн хуулийн этгээдийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд оролцоно.

Хуулийн этгээдийн төлөөлөгч нь тухайн салбар, төлөөлөгчийн газрын эрх баригч байна. Иймд тухайн хуулийн этгээдээс салбар, төлөөлөгчийн газрын нэр дээр биш, харин тэдгээрийн эрх баригчийн нэр дээр түүний бүрэн эрхийг тодорхойлсон итгэмжлэл олгогдоно. Салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчийн итгэмжлэлээр тодорхойлогдсон бүрэн эрх нь тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан салбар төлөөлөгчийн газрын эрх, үүрэгтэй уялдсан байна.

29.6 дахь хэсэг

Салбар төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй байна (29.5 дахь хэсгийн тайлбараас харна уу). Хэрэв хуулийн этгээд нь салбар төлөөлөгчийн газраа хуулийн этгээд болгон өөрчлөн байгуулбал тэдгээр нь ямар нэг хуулийн этгээдийн тусгайлсан нэгж байхаа больж, бие даасан хуулийн этгээд болно. Хуулийн этгээд нь өөрийн салбар буюу төлөөлөгчийн газраа бие даасан хуулийн этгээд болгон өөрчлөн байгуулбал энэ нь хуваах, тусгаарлах аргаар хуулийн этгээд өөрчлөн байгуулагдаж байгаагийн илрэл болно (Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн тайлбарыг харна уу). Энэ мэтээр хуулийн этгээд өөрийн салбар, төлөөлөгчийн газраа бие даасан хуулийн этгээдийн эрхтэй болгон хараат болон охин компанийн эрхтэйгээр үйл ажиллагаа явуулж болно.

30 дугаар зүйл. Хуулийн этгээдийг байгуулах

30.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно.

30.2. Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно.

ТАЙЛБАР**30.1 дэх хэсэг**

Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн (Иргэний хуулийн 7.2 дахь хэсгийн тайлбарыг харна уу), хуулийн этгээд (Иргэний хуулийн 25.1 дэх хэсгийн тайлбарыг үзнэ үү) хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно. Иргэний хуулийн 30.1 дэх хэсгийн "хуульд өөрөөр заагаагүй бол" гэдгийг хуульд заасан тохиолдолд дээр дурдсан иргэний эрх зүйн харилцааны оролцогчид нь хуулийн этгээд үүсгэн байгуулах эрхгүй буюу тодорхой хязгаарлалт байж болно гэж ойлгоно.

Жишээ нь: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд: "Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, бусад хэлбэрээр улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулж болохгүй" гэж заасан тул гадаадын иргэн улс төрийн нам, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилго бүхий бусад хуулийн этгээд үүсгэн байгуулах эрхгүй. Харьяалалгүй хүн гадаадын иргэний нэгэн адил эрх зүйн чадвартай байдаг тул энэ журам харьяалалгүй хүнд ч хамаарна гэж ойлгоно. Мөн Банкны тухай хуульд зааснаар төсөвөөс санхүүждэг, буяны болон шашны байгууллага, олон нийтийн байгууллага банк үүсгэн байгуулахыг хориглосон байдаг.

А. Иргэний хуулийн 7.1-д зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага бол иргэний эрх зүйн харилцааны оролцогч мөн. Гэвч хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хуулийн этгээд үүсгэн байгуулах эрхгүй болох нь Иргэний хуулийн 30.1-ийн агуулгаас тодорхой байна.

Б. Иргэний хуулийн 30.1-д заасан "хуульд заасан журмын

дагуу" гэдгийг Иргэний хууль болон тодорхой төрлийн хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлсон Компанийн, Нөхөрлөлийн, Төрийн бус байгууллагын, Банкны, Даатгалын, Төр, сүм хийдийн харилцааны тухай, Боловсролын тухай зэрэг хуульд заасан журмын дагуу тухайн төрлийн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна гэж ойлгоно.

30.2 дахь хэсэг

Иргэний хуулийн 7.3-т зааснаар төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцдог. Иймд төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа буюу хамтран ашгийн төлөө ба ашгийн төлөө бус хуулийн этгээд үүсгэн байгуулж болно. **Жишээ нь:** газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, газрын зураг зүйтэй холбоотой төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор газрын харилцаа, геодези зураг зүйн хэрэг эрхлэх газрыг Засгийн газар байгуулж болно. Мөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр сумын төсөвөөс тодорхой хөрөнгө тусгаарлан сум, багийн төвийг цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах зорилгоор дулааны цахилгаан станцыг бусад хөрөнгө оруулагчтай хамтран хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулж болно. Энэ тохиолдолд тухайн сумын оршин суугчдыг цахилгаан дулаанаар хангах нийгмийн хэрэгцээ бодитой байгаа учир тус сум энэ хуулийн этгээдийг байгуулж байна. Энэ дулааны цахилгаан станц (ХХК) хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлж, хэрэглэгчид цахилгаан, дулааны эрчим хүч ашиглах хэрэгцээ улам өргөжиж, уг хуулийн этгээд ашигтай ажиллаж эхэлбэл сум (үүсгэн байгуулагч-хуулийн этгээд) өөрийн оруулсан хөрөнгө буюу эзэмшиж байгаа хувьцаатайгаа хувь тэнцүүлэн ногдол ашиг авах ч боломжтой.

31 дүгээр зүйл. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах

31.1.Хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

31.2.Хоёр буюу хэд хэдэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нийлүүлэх гэнэ.

31.3.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нэгтгэх гэнэ.

31.4.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг хуваах гэнэ.

31.5.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг тусгаарлах гэнэ.

31.6.Хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар зохион байгуулагдаж болно.

ТАЙЛБАР

31.1 дэх хэсэг

Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох буюу зогсоохгүйгээр шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах арга бол хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах явдал мөн. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах шийдвэрийг:

- хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч (жишээ нь, ганц гишүүнтэй компанийн гишүүн);
- үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллага (жишээ нь,

Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд зааснаар хувь нийлүүлэгчдийн хурал) гаргана.

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 14.1.3-т зааснаар хянан зохицуулах алба давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж байгаа аж ахуйн нэгжийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулахыг аж ахуйн нэгжийн удирдлагаас шаардах, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг зогсоох бүрэн эрхтэй байдаг. Энэ тохиолдолд аж ахуйн нэгжийг өөрчлөн байгуулах шийдвэр гаргах эрх бүхий байгууллага нь (жишээ нь, компанийн хувь нийлүүлэгчдийн хурал) хянан зохицуулах албаны шаардлагаар өөрчлөн байгуулах шийдвэр гаргах үүрэгтэй гэж ойлгоно. Түүнчлэн иргэний эрх зүйд "шаардах эрхтэй" гэдэг нь шаардлага тавиад сайн дураар биелүүлээгүй тохиолдолд уг шаардлагыг хангах тухай шийдвэр гаргуулахаар шүүхэд хандах эрхтэй. Шаардлага нь үндэслэлтэй бол шүүх түүнийг хангах тухай шийдвэр гаргана гэж ойлгодгийг анхаарах нь зүйтэй.

Хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу өөрчлөн байгуулна. Тухайлбал, Компанийн тухай хуульд зааснаар компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж, хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэр хүчин төгөлдөр болох кворум, өөрчлөн байгуулах ажиллагаа, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх журам зэргийг нарийвчлан зохицуулсан байдаг.

Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах таван арга байна:

А. Нийлүүлэх

А, Б, В, Г дөрвөн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан С хуулийн этгээдэд шилжүүлжээ. Бид А, Б, В, Г хуулийн этгээдүүдийг нийлүүлэх замаар С хуулийн этгээдийг байгуулж байна. Иймд хуулийн этгээдүүдийг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулахад хэд хэдэн хуулийн этгээд бие даан оршин

тогтнохоо больж, улсын бүртгэлээс хасагдан тэдгээрийн суурин дээр / оронд/ шинэ хуулийн этгээд байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдэнэ. "Эрх, үүрэг, хариуцлага шинээр бий болсон хуулийн этгээдэд шилжинэ" гэдэг нь юу гэсэн үг вэ?

Жишээ нь: бидний жишээн дээр К банк А хуулийн этгээдэд 10 сая төгрөг тодорхой хүүтэйгээр зээлдүүлсэн, харин Б хуулийн этгээд нь татварын албанаас илүү төлөгдсөн 5 сая төгрөгөө буцаан авах ёстой байсан гэж үзвэл энэ өөрчлөн байгуулалтын дараа С хуулийн этгээд К банкинд 10 сая төгрөгийг хүүгийн хамт төлөх үүрэгтэй, харин татварын албанаас 5 сая төгрөгийг шаардан авах буюу төлөх ёстой татвартаа суутган тооцуулах эрхтэй болно. Нэгэнт А, Б хуулийн этгээдүүд иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохоо больж, үйл ажиллагаа нь дуусгавар болсон тул тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага шинээр үүссэн С хуулийн этгээдэд шилжжээ гэдэг нь энэ жишээнээс харагдаж байна.

Б. Нэгтгэх

Хуулийн этгээдийг нэгтгэхэд нэг буюу хэд хэдэн хуулийн этгээд нь нөгөөд нэгдэж, цаашид оршин тогтнохоо больж, харин "нөгөө" хуулийн этгээд оршин тогтносон хэвээр үлдэнэ.

Жишээ нь: "Марал" ХХК нь "Мичид" ХХК-д нэгдсэнээр "Марал" ХХК оршин тогтнохоо больж, улсын бүртгэлээс хасагдан түүний бүх эрх, үүрэг, хариуцлага "Мичид" ХХК-д шилжин, "Мичид" ХХК иргэний эрх зүйн харилцааны оролцогч хэвээрээ үлдэнэ гэсэн үг. Энэ тохиолдолд "Марал" ХХК-хуулийн этгээдийн тусгайлан хөрөнгө нь бүх өгнөг, авлагын хамт "Мичид" ХХК-д шилжин түүний хөрөнгө, эрх, үүрэг, хариуцлага төдий хэмжээгээр нэмэгдлээ гэж ойлгож болно. Хуулийн этгээдийг нэгтгэх аргаар өөрчлөн байгуулахад шинэ хуулийн этгээд үүсэхгүй.

В. Хуваах

Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах хуваах арга нь нийлүүлэх аргын яг эсрэг өөрчлөлт юм. Иймд Иргэний хуулийн 31.4-т: "Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг,

хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг хуваах гэнэ” гэж заасан.

Бидний жишээн дээр С хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, С хуулийн этгээд иргэний эрх зүйн харилцааны оролцогч байхаа больж, оронд нь түүний хөрөнгө дээр А, Б, В, Г гэсэн 4 шинэ хуулийн этгээд үүсэх замаар С хуулийн этгээд хуваагдаж болно. Энэ тохиолдолд С хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлага, тусгайлан хөрөнгө нь шинээр үүсэх А, Б, В, Г хуулийн этгээдэд ямар хувь хэмжээгээр, хэрхэн шилжихийг хуваах балансаар тодорхойлно.

Г. Тусгаарлах

Хуулийн этгээдийг тусгаарлах арга нь нэгтгэх аргын эсрэг өөрчлөлт юм. Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг тусгаарлах гэнэ.

Бидний жишээн дээр “Мичид” ХХК үйл ажиллагаагаа зогсоохгүйгээр өөрийн зарим хөрөнгө, эрх, үүрэг, хариуцлагаа шинээр байгуулагдсан “Марал” ХХК-д шилжүүлбэл бид “Мичид” ХХК өөрөөсөө “Марал” ХХК-г тусгаарлаж байна гэнэ. Тусгаарлах аргаар өөрчлөн байгуулагдахад шинэ хуулийн этгээд үүсэж, өөрөөсөө уг шинэ хуулийн этгээдийг тусгаарласан хуулийн этгээд оршин тогтносон хэвээр байна. Харин энэ жишээн дээр “Мичид” ХХК-ийн чухам ямар эрх, үүрэг, хариуцлага, хэдий хэмжээний ямар хөрөнгө нь шинээр үүссэн “Марал” ХХК-д шилжих вэ? гэдгийг хуваах балансаар тодорхойлно.

Д. Өөрчлөх (Энэ зүйлийн тайлбарын 2-6 дахь хэсгийг үзнэ үү.)

Өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдахад хуулийн этгээд өмнөх төрөл, хэлбэр, зорилгоороо оршин тогтнохоо больж, түүний оронд шинэ хуулийн этгээд үүснэ. Хуулийн этгээд зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдана.

Жишээ нь: ХХК өргөжиж хувьцаагаа нийтэд чөлөөтэй санал

болгож байх зорилгоор ХК болох, хоршоо нь нөхөрлөл буюу компани болох гэх мэт.

З а р и м
тохиолдолд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэдэг буюу банк бус санхүүгийн байгууллага банк болж өөрчлөн байгуулагдаж болно. Өмч хувьчлалын явцад төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан явдал нь өөрчлөх замаар хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах хамгийн тод жишээ юм. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах журам, эрх залгамжлах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, нөхцөл, журмын талаар тодорхой төрлийн хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлсон тусгай хуулиудад тодорхой тусгасан байдаг.

32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах

32.1.Хуулийн этгээдийг дараахь үндэслэлээр татан буулгана:

32.1.1.өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан;

32.1.2.дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

32.1.3.үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан;

32.1.4.хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

32.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

32.2.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ.

32.3.Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдсан тухай нийтэд мэдээлнэ.

32.4.Татан буулгах комиссоос нэхэмжлэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа нь

хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас ихгүй байна.

32.5.Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараахь дарааллаар хангана:

32.5.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр;

32.5.2.хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал;

32.5.3.дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага;

32.5.4.хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;

32.5.5.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад төлөх хөдөлмөрийн хөлс;

32.5.6.хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.

32.6.Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална.

32.7.Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь харилцагчдын шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдаж, төлбөрийг барагдуулж болно.

32.8.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дарааллын дагуу харилцагчдад хуваарилна.

32.9.Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид, хууль буюу дүрэмд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.

32.10.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээж авах этгээд байхгүй бол төрийн өмчлөлд шилжүүлнэ.

32.11.Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухай нийтэд мэдээлнэ.

ТАЙЛБАР

32.1 дэх хэсэг

Хуулийн этгээд татан буугдсанаар түүний эрх, үүрэг эрх залгамжлалын журмаар өөр хуулийн этгээдэд шилжихгүй. Татан буугдсан хуулийн этгээдийн нэхэмжлэгч нарын нэхэмжлэлийн шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийн хувь заяаг хэрхэн шийдвэрлэдэг талаар Иргэний хуулийн 32.9, 32.10, 38.3 дахь хэсгийн тайлбарласнаас үзнэ үү. Хуулийн этгээдийг сайн дурын үндсэн дээр, эсхүл албадан татан буулгаж болно. Иргэний хуулийн 32.1-д заасан хуулийн этгээдийг сайн дурын үндсэн дээр буюу албадан татан буулгах үндэслэлүүд нь зөвхөн энд дурдсанаар хязгаарлагдахгүй.

32.1.1. Хуулийн этгээдийг татан буулгах тухай түүний өмчлөгч (жишээ нь, ганц гишүүнтэй компанийн гишүүн), буюу түүнээс эрх олгосон байгууллагын (жишээ нь: хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн хоёр талын оролцоотой байгуулагдсан зөвлөлд талууд эрх олгосон) шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын /жишээ нь: компанийн хувь нийлүүлэгчдийн хурал/ шийдвэр гарсан нь уг хуулийн этгээдийг сайн дурын үндсэн дээр татан буулгах үндэслэл болно.

32.1.2. Хуулийн этгээдийг шүүхийн шийдвэрээр татан буулгах хэд хэдэн үндэслэлийг Иргэний хуулийн 32.1.2-т заасан байна:

- “дампуурсанд тооцсон” гэдэг нь Дампуурлын тухай хуульд заасны дагуу эрх бүхий этгээдийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө ирээгүй, ирсэн боловч шүүх түүнийг батлаагүй, эсхүл төлөвлөгөөг хэрэгжүүлэх

боломжгүй бол шүүх хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргахыг хэлнэ;

- “хуулийг удаа дараа зөрчсөн” гэдэгт тухайн хуулийн этгээд хуулиар тогтоосон хэм хэмжээг гурав буюу түүнээс дээш удаа зөрчсөнийг ойлгоно;
- “хуулийг ноцтой зөрчсөн” гэж тухайн хуулийн этгээдийн гаргасан зөрчил нь хуулийн этгээдийг татан буулгахгүйгээр залруулах боломжгүй байхыг ойлгоно; **Жишээ нь:** үйлдвэрээс гарах хаягдлаа шууд гол руу цутгадаг байхаар барилга, тоног төхөөрөмж нь суурилагдсан, үйлдвэрийн үйл ажиллагааг явуулах өөр шийдэл байхгүй, уг байршил нь байгаль орчинд ноцтой хор хөөнөөл учруулж байгаа тохиолдолд шүүх уг хуулийн этгээдийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг ноцтой зөрчсөн гэж үзэж татан буулгах тухай шийдвэр гаргаж болох юм.
- хуульд заасан бусад үндэслэлээр шүүх тухайн хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргаж болох юм. **Жишээ нь:** хуульд заасан тусгай зөвшөөрөл авалгүйгээр үйл ажиллагаа явуулсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, ашгийн төлөө бус хуулийн этгээд үйл ажиллагааныхаа үндсэн зорилгод харшилсан үйл ажиллагаа явуулсан зэрэг тохиолдолд шүүх татан буулгах тухай шийдвэр гаргаж болно.

32.1.3. Иргэний хуулийн

32.1.3-т хуулийн этгээдийг татан буулгах өөр нэг үндэслэлийг заасан байна:

- “Үйл ажиллагаа явуулах хугацаа дууссан” гэдэг нь тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулахдаа тодорхой хугацаанд (10 жил, 5 жил, дайн дуустал, хайгуулын тайлан эцэслэн

гартал гэх мэт) үйл ажиллагаа явуулахаар дүрэмдээ зааж, уг хугацаа дуусахад цаашид үргэлжлүүлэх тухай шийдвэр гараагүй байхыг ойлгоно;

- “Зорилгодоо хүрсэн буюу цаашид үйл ажиллагаа явуулах шаардлагагүй” гэдэг үндэслэлээр хуулийн этгээд татан буугдах тухай шийдвэрээ өөрөө гаргах тохиолдол байдаг.

Жишээ нь: Тухайн нөхөрлөл анх байгуулагдхдаа зуслангийн бүх байшинд засвар хийх зорилгоор байгуулагдсан бөгөөд уг ажлаа хийж дуусган цаашид ажиллах шаардлагагүй болсон гэж үзсэн бол уг нөхөрлөлөө татан буулгахаар шийдвэрлэж болно.

32.1.4. “Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан” гэдэг үндэслэл нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд илүү хамааралтай.

Жишээ:

А дүүрэгт шүүх байгуулах тухай шийдвэр гаргаж байсан Улсын Их Хурал нь 20 жилийн дараа тус дүүрэгт бие даасан шүүх ажиллах шаардлагагүй гэж үзсэн бол уг шүүхийг татан буулгах тухай шийдвэр гаргаж болох юм.

32.1.5. Хуульд заасан бусад үндэслэлээр хуулийн этгээд татан буугдаж болно.

Жишээ:

А хуулийн этгээдийг үүсгэн байгуулахдаа хуульд заасан журам зөрчсөнийг сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр шүүх тогтоосон гэж бодъё. Энэ тохиолдолд шүүх уг хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон шийдвэр гаргана. Нэгэнт бүртгэл нь хүчин төгөлдөр бус болж буй тул уг хуулийн этгээд оршин тогтнох хууль зүйн үндэслэлгүй болно. Иймд уг хуулийн этгээдийн дүрмээр эрх олгосон байгууллага татан буулгах шийдвэр гаргахаас өөр аргагүйд хүрнэ. Энэ бол албадан татан буулгах нэг үндэслэл болно.

32.2 дахь хэсэг

Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан этгээд нь татан буулгах комисс томилогддог үүрэгтэй. Түүнчлэн бүртгэх байгууллагад уг хуулийн этгээд татан буугдах болсныг мэдээлэх ёстой. Татан буулгах комисс томилогдмогц хуулийн этгээдийг удирдах бүрэн эрх уг комисст шилжинэ. Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн нэрийн өмнөөс татан буулгах комисс шүүх болон гурвадгач этгээдтэй харилцана.

32.3 дахь хэсэг

Хуулийн этгээдийг татан буулгах нь нэлээд төвөгтэй, ихэнх тохиолдолд их цаг хугацаа шаардсан, нарийн журмын дагуу явагддаг үйл ажиллагаа бөгөөд ямагт нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Тухайлбал, өдөр тутмын сонин, радио, телевизээр мэдээлэх зэргээр мэдээллийг аль болох нийтэд хүртээмжтэйгээр түгээх арга хэмжээ авна.

32.4 дэх хэсэг

Татан буулгах комиссийн зорилго нь хуульд заасан хугацааны дотор татан буугдаж байгаа хуулийн этгээдийн харилцагчдыг, үүсгэн байгуулагч, оролцогчдод аль болох бага хохиролтойгоор хуулийн этгээдийн үйл ажиллагааг дуусгавар болгоход оршино. Татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийн харилцагчдын нэхэмжлэлийг хүлээн авах хугацааг хуулийн этгээдийг татан буулгах тухай нийтэд мэдээлснээс хойш 2 сараас багагүй, 6 сараас ихгүй байхаар тооцож, нийтэд мэдээлнэ. Ийнхүү зарлагдсан өдрөөс хойш хуулийн этгээдийн хүлээн авахгүй. Татан буулгах комисс энэ хугацаанд уг хуулийн этгээдийн бусдаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авна.

32.5 дахь хэсэг

Иргэний хуулийн 35.2-т заасан татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хангах дарааллыг тухайн хуулийн этгээдийн нэхэмжлэгч нарын бүх нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хуулийн этгээдийн хөрөнгө нь хангалттай хүрэлцэхээр байсан тохиолдолд төдийгүй, уг

хуулийн этгээдийн эд хөрөнгө нэхэмжлэгчдийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй, Дампуурлын хуулийн дагуу татан буулгах үед ч зайлшгүй баримтлах учиртай.

32.5.1. Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөрийг эхний ээлжинд хангана. Бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорын талаар Иргэний хуулийн 505, 508, 509 дүгээр зүйлээс харна уу. Иргэний хуулийн 505, 508, 509 дүгээр зүйлд заасан гэм хорыг арилгах үүрэг уг хуулийн этгээдийн хувьд шүүхийн шийдвэрээр ногдсон эсэхийг үл харгалзан эхний ээлжинд шаардлагыг хангана. Харин шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу уг хуулийн этгээдээс гаргуулах аливаа бусад төлбөрийг мөн эхний дараалалд хангана гэж ойлговол зохино.

32.5.2. Татан буулгах комиссийн талаар Иргэний хуулийн 32.2 дахь хэсгийн тайлбарас үзнэ үү. Иргэний хуулийн 32.5.2-т заасан "тэдгээртэй адилтгах бусад этгээд" гэдэгт дампуурлын үе дэх хэрэг гүйцэтгэгч, банкны эрх хүлээн авагч зэргийг ойлгоно. Дампуурлын хэргийн үед хариуцагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий этгээдийг хариуцагч гэнэ. Банкныг албадан татан буулгах ажиллагааг зохион байгуулахаар Төв банкнаас томилогдсон этгээдийг банкны эрх хүлээн авагч гэнэ. Эдгээр нь хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээдээс томилогдон уг үйл ажиллагааг удирдаж байгаагийн хувьд эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааныхаа зардлыг хоёр дахь дараалалд авах эрхтэй.

32.5.3. Дампуурлын үед хариуцагчийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн санхүү, удирдлага, үйл ажиллагааны талаар өөрчлөлт хийх боломж, тэдгээрийн тооцоо, өөрчлөн байгуулалдсан аж ахуйн нэгжийн хэтийн төлвийн талаар эрх бүхий этгээдийн боловсруулж шүүхэд оруулж байгаа баримт бичгийг

дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гэх ба уг төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн хурлаас дэмжиж, шүүх баталбал хэрэгжүүлэх ажлыг хэрэг гүйцэтгэгчийн удирдлага, хяналт дор зохион байгуулдаг. Ийнхүү дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлагыг 3 дахь дараалалд хангадаг.

32.5.4. Хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгийг 4 дэх дараалалд хангана. Энэ нь банк, хадгаламж эзэлийн хоршоо зэрэг хадгаламж авах үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдэд хамаарна. Хадгаламж эзэмшигч нь татан буугдаж байгаа хуулийн этгээдэд мөнгөн хадгаламжийн гэрээгээр мөнгөө хадгалуулсан бөгөөд эргүүлж авч чадаагүй байгаа иргэн, хуулийн этгээд байна. Мөнгөн хөрөнгө гэдэгт хадгаламж эзэмшигчийн тухайн хуулийн этгээдэд хадгалуулсан үндсэн хадгаламж, гэрээгээр тохирсон хүү, хууль буюу гэрээнд заасны дагуу гаргуулан авбал зохих алданги хамаарна.

32.5.5. Татан буугдаж байгаа хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлсийг 5 дахь ээлжинд барагдуулна. Хөдөлмөрийн гэрээг Иргэний хуулийн 369 дүгээр зүйл болон Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Иргэний хуулийн 32.5.5-д заасан "хөдөлмөрийн хөлс" гэдэгт тухайн ажилтны уг хуулийн этгээдээс авбал зохих үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагналыг урамшуулал, хөдөлмөрийн тухай хуульд заасан бусад нөхөх олговор, хугацаандбаа цалингаа төлөөгүйгээс төлбөл зохих алдангийг ойлгоно.

32.5.6. Дээр дурдсанаас бусад нэхэмжлэгч нар 6 дахь ээлжинд нэхэмжлэлийнхээ шаардлагыг хангуулна. Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн тодорхой эд хөрөнгийг барьцаанд барьсан нэхэмжлэгчийн хувьд барьцааны зүйл нь хуваарилагдах эд хөрөнгөд хамаарахгүй бөгөөд барьцааны зүйлийг худалдсан үнээс тэргүүн

ээлжинд нэхэмжлэлийн шаардлагаа хангуулах давуу эрхээ эдэлнэ. Харин барьцааны зүйлийг борлуулсан үнэ нь барьцаалагчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хүрэлцээгүй бол үлдсэн шаардлагаа бусад нэхэмжлэгчийн нэгэн адил зургаа дахь дараалалд хангуулна.

Зургаа дахь дараалалд ихэвчлэн тухайн хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ хэлцлийн дагуу хийгдэх бусад төлбөр тооцоо хамаарна. **Жишээ нь:** бараа нийлүүлээд үнийг нь аваагүй, ажил гүйцэтгэхчээд хөлсийг нь аваагүй, мөнгө эзэлдүүлчихээд буцааж аваагүй зэргээс үүдсэн нэхэмжлэлүүд байдаг.

32.6 дахь хэсэг

Тухайн дараалалд байгаа нэхэмжлэлүүдийн шаардлагыг гагцхүү өмнөх дараалалд байгаа бүх шаардлагыг хангасны дараа хангадаг журамтай.

Өөрөөр хэлбэл, нэг дэх дараалалд бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөрийн талаар нийт 12 этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзвэл уг 12 шаардлагыг бүрэн хангасны дараа л хоёр дахь дарааллын буюу татан буулгах комисс үйл ажиллагааныхаа зардлыг авах эрх нь нээгдэнэ гэсэн үг юм.

32.7 дахь хэсэг

Харилцагчдын шаардлагыг юуны өмнө татан буугдаж байгаа хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгөөр хангана. Харин мөнгөн хөрөнгө нь харилцагчдын шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулсан борлуулж төлбөр барагдуулах арга хэмжээ авна. Дуудлага худалдаа явуулах журам нь Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиар тодорхойлогдоно.

32.8 дахь хэсэг

Татан буулгах комисс тухайн хуулийн этгээдийн нэхэмжлэгч нарын нэхэмжлэлийн

шаардлагыг хангах явцад тухайн дараалалд байгаа нэхэмжлэгч нарын шаардлагыг хангахад үлдсэн эд хөрөнгө нь хүрэлцэхгүй байвал түүнийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн тухайн дараалалд байгаа нэхэмжлэгч нарт олгоно. **Жишээ нь:** зургаа дахь дараалалд 10 нэхэмжлэгч байгаа бөгөөд тэдний шаардлагын дүн 20 сая, харин өмнөх дараалалд байгаа нэхэмжлэгч нарт хуваарилаад үлдсэн хөрөнгө нь 15 сая байгаа бол татан буулгах комисс уг 20 сая төгрөгийг 10 нэхэмжлэгч нарт авбал зохих мөнгөнд нь хувь тэнцүүлэн хуваарилан өгнө гэсэн үг юм. Ийнхүү нэхэмжлэлийн шаардлагаа бүрэн хангуулж чадаагүй хэсэгтээ нэхэмжлэгч нар эрсдэлээ өөрөө хүлээж, тухайн хуулийн этгээдийн эрх бүхий байгууллага зохих шийдвэр гарган данснаасаа хасалт хийнэ.

32.9 дэх хэсэг

Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгч (нөхөрлөл, хоршооны гишүүд, компанийн хувь нийлүүлэгчид г.м)-д, хууль буюу гэрээнд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ. Энэ бол долоо дахь дараалал гэж ойлгож болно. Энэхүү хууль ёсны өмчлөгч нар мөн үлдсэн эд хөрөнгөөс бусдаасаа тэргүүн ээлжинд авах давуу эрхтэй тохиолдлыг хуульд заасан байдаг. Нөхөрлөлийн тухай хуульд зааснаар зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл татан буугдахад түүний оруулсан хөрөнгөөрөө хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг гишүүн нь бүрэн хариуцлагатай гишүүнээс тэргүүн ээлжинд үлдсэн эд хөрөнгөөс оруулсан хөрөнгөө авах эрхтэй байдаг. Мөн Компанийн тухай хуульд зааснаар давуу эрхийн хувьцаа эзэмшигчид нь энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжинд үлдсэн эд хөрөнгөөс эзэмшиж байгаа хувьцааныхаа төлбөрийг авах эрхтэй.

Долоо дахь ээлжинд өмчлөгчөөс гадна хууль буюу гэрээнд заасан бол эрх бүхий этгээдэд үлдсэн эд хөрөнгийг шилжүүлдэг талаар заасан байна.

Жишээ нь: сан татан буугдсан тохиолдолд харилцагч нартай

тооцоо хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг уг сантай зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд шилжүүлдэг журамтай (Иргэний хуулийн 38.3 дахь хэсэг). Мөн Иргэний хуулийн 36.3-т зааснаар "Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө" гэж заасан тул сүм хийд татан буугдахад харилцагч нартай тооцоо хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг уг сүм хийдтэй зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий (шашны нэг урсгалыг баримталдаг зэрэг) нэг, эсхүл хэд хэдэн сүм хийдэд шилжүүлэхээр татан буулгах комисс шийдвэрлэж болно.

32.10 дахь хэсэг

Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах этгээд байхгүй бол төрийн өмчлөлд шилжүүлнэ. Энэ нь хуулийн этгээд татан буугдсанаар эрх залгамжлалын асуудал яригддаггүй тул өв залгамжлалын нэгэн адилаар уг эд хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлж байгаа хэрэг юм (Иргэний хуулийн 533.4 дэх хэсэг).

32.11 дэх хэсэг

Иргэний хуулийн 32.11-д зааснаар татан буулгах комисс нь хуулийн этгээдийн эд хөрөнгийг ийнхүү хуваарилан татан буулгах ажиллагааг дуусгавар болгож, энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. Бүртгэх байгууллага уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасч, энэ тухай нийтэд мэдэглэнэ. Хуулийн этгээд татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар түүний эрх зүйн чадвар дуусгавар болно.

/үргэлжлэл дараагийн дугаарт/



МОНГОЛ УЛС ДАХЬ ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА



ШУА-ийн ФСЭХ-ийн
Хууль зүйн судалгааны төвийн
захирал, Олон улсын эрх зүй,
эрх зүйн харьцуулсан
судалгааны төвийн захирал,
Хууль зүйн үндэсний төвийн
захирал, Академич
Ж.Амарсанаа

Би энэхүү товч илтгэлээ тавихдаа өмнө нь тавьсан илтгэлийг иш үндэс болгож байна¹. Өнгөрсөн зууны наяд он дунд үеэс Дорнод Европ, Ази, Латин Америк, Африкийн олон орон дарангуйллын тогтолцооноос ангижирч чөлөөт сонгуулиар байгуулагдсан төр, засгийн газартай болсон юм. Хүн төрөлхтний түүхэн тодорхой агшинд бий болсон энэхүү ололтыг бататгаж, цаашид төгөлдөржүүлэн хөгжүүлнэ гэвэл хүний эрх, эрх чөлөөг хангах, ардчиллыг хөгжүүлэн дэмжих, чөлөөт зах зээлийг урамшуулан хөгжүүлэх эрх зүйн механизмыг буй болгосон байх шаардлагатай. Мэдээж хэрэг, ийм механизмыг бий болгохдоо тухайн орны улс төр, эдийн засгийн байдал, соёл уламжлалтай нийцүүлэх нь зүйн хэрэг.

Сүүлийн хорь орчим жил ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын улс төр, эрх зүй, нийгмийн чиглэлээр хийж буй өөрчлөлтөөс харахад тэдгээрийн хооронд багагүй ялгаа, онцлог ажиглагдсаар байна. Хэдийгээр ялгаатай тал, өвөрмөц онцлог байх нь тодорхой боловч хууль ёсны бөгөөд мэдрэмжтэй, төсөөлөл болон оролцоог хангасан, ил тод бөгөөд хариуцлагатай, эрх зүйд үндэслэсэн ардчиллыг тогтоох, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд нийцсэн хүний эрх, эрх чөлөөг хангахын тулд зарим нэг нийтлэг суурь зарчмыг хэрэгжүүлсэн байх хэрэгтэй юм. Үүнд юуны өмнө дараахь гурван асуудлыг хамааруулж болох юм.

Нэг, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчимд нийцүүлэн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн шууд нөлөө, хяналтаас

гадуур байх бие даасан шүүх эрх мэдлийн байгууллагыг хуулийн дагуу бүрдүүлсэн байх ёстой.

Хоёр, хүний эрхийг үр нөлөөтэй хангаж чадахуйц, тэр тусмаа хувь хүний наад захын суурь эрхийг иргэдийн дийлэнх олонхийн санаа бодлын эсрэг байсан ч хангаж чадахуйц эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн байх учиртай.

Гурав, иргэд өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх, мэдэх эрхээ баталгаатай байлгах үүднээс чөлөөт хэвлэлийн тогтолцоог бий болгох шаардлагатай.

Аливаа улсад тухайн орны түүх, соёл, уламжлал, бусад онцлогийг илэрхийлсэн эрх зүйн тогтолцоо байх нь зайлшгүй.

гэхдээ дээр дурдсан гурван асуудлыг улс үндэстний хоорондхи ялгаа, зөрөөнөөс дээгүүр тавих учиртай. Энэхүү нийтлэг заалтыг хэрэгжүүлэх нь даяаршлын шаардлага гарцаагүй мөн билээ.

Өнөөгийн ертөнцөд улс үндэстнүүд хүн амын олон цөөн, христос, будда шүтлэгтэн, далайд гарцтай, гарцгүй, мэдээллийн технологи өндөр хөгжсөн, хөгжөөгүйгээс үл хамааран хил хязгааргүй даяаршиж байна. Ийм түүхэн бодит нөхцөлд улсууд янз бүрийн чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулах, олон улсын байгууллага байгуулж үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах эрх зүйн тогтолцоог харилцан судлах, ойртуулах алхам хийж байна. Аливаа улс орны эрх зүйн тогтолцооны шинэтгэл нь эрх зүйн харьцуулсан судалгааны ажилтай нягт уялдаатай хэрэгжиж байна.

Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралыг ардчилан шинэтгэх нөр их бүтээлч үйлсийн хүрээнд эрх зүйн шинэтгэл амжилттай хэрэгжиж байна. Хамгийн товчоор хэлбэл, дэлхийн жишиг, Монголын онцлог хоёрын зааг уулзвар дээр эрх зүйн шинэтгэлийн ажил өрнөж байна. Олон талтай, өргөн хүрээтэй энэ ажил 1980-аад оны дунд үеэс эхэлсэн бөгөөд цаашдын өрнөлтийн уг суурь нь 1992 оны Үндсэн хууль юм. Хэдий бэрхшээлтэй, зарим ухралт, эргэлзээ тээнэгэлзээ, гацаа, гуйвуулга байгаа боловч Үндсэн хуулийн үзэл санаа, үзэл баримтлалын дагуу эрх зүйн шинэтгэлийн ерөнхий чиг баримжаа, чиглэл, хандлага зөв байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй.

Хэдийгээр цаг хугацааны хувьд оройтсон боловч Монгол Улсын Их Хурлаас 1998 онд

¹ "Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил". УБ., 2004 он. 9-15 дахь тал

баталсан "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр" нь энэ хүрээнд явуулах төрийн үйл ажиллагааны гол удирдамж болж байна. Энэхүү хөтөлбөрийн агуулгаас үндэслэн Монгол Улсад хэрэгжүүлж байгаа эрх зүйн шинэтгэлийг дараах чиглэлээр тодорхойлж болох юм. Үүнд:

Нэг, эрх зүйн шинэтгэлийн даацын тулгуур болох хууль тогтоомжийг шинэчлэх;

Хоёр, хууль хэрэгжүүлэх, түүний биелэлтийг хангах механизмийг эрс шинээр үүсгэн төлөвшүүлэх;

Гурав, Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэх;

Дөрөв, хууль зүйн судалгаа шинжилгээний ажлыг шинэ арга барилаар зохион байгуулах;

Тав, эрх зүйн дэд боловсролыг чанаржуулах, хуулийн сонгон шалгаруулалт, үргэлжилсэн сургалтын зөв тогтолцоог бий болгох;

Зургаа, мэдээллийн шинэ технологид суурилсан эрх зүйн мэдээллийн үр ашигтай, шуурхай ажиллах, оночтой механизм арга барилыг хөгжүүлэх;

Долоо, хүн амын эрх зүйн ухамсар, соёлыг нийгмийн бүлэг болон бусад онцлогийг харгалзаж нийтлэг шаардлагын дагуу төлөвшүүлэх;

Найм, хүний эрхийг хангах хууль зүйн үндэс, баталгааг бий болгох.

Эдгээр нь хоорондоо уялдаатай, дотор нь зэрэглэж дугаарлах боломжгүй, нэг нь нөгөөгөөсөө хамаарч байгаа цогцолбор арга хэмжээ юм. Гэхдээ энэ арга тулгын чулуу нь хууль тогтоомжийн шинэтгэл юм. Хууль тогтоомжийг цэгцлэхгүйгээр, шинээр бий болгохгүйгээр бусад асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. 1980-аад оны сүүлийн хагасаас тэр үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Засгийн газар

(Сайд нарын Зөвлөл, яам, улсын хороо, тусгай газар)-ын олон мянган эрх зүйн актыг хүчингүй болгосноор эрс шинэтгэл хийх таатай суурь бүрэлдэж эхэлсэн юм.

Улмаар 1990 оны 3 дугаар сард Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, улс төрийн олон ургальч ёс, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн юм.

Мөн оны 5 дугаар сард "Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль" нэртэй бие даасан, Үндсэн хуульчилсан акт батлан гаргаж, улс төрийн тогтолцооны шинэ бүтцийг бий болгожээ. Энэ хуулийн дагуу 1990 оны 7 дугаар сард анхны ардчилсан сонгуулийг явуулж, Ардын Их Хурлыг, түүнээс олон намын төлөөлөл бүхий, байнгын ажиллагаатай парламент болох Улсын Бага Хурлыг байгуулсан байна. Энэ үед баталсан, тухайлбал, хувийн өмчийн эрхийг бататгасан, банк, санхүү, зах зээлийн шинэ харилцааны үндсийг тогтоосон, нийгэм, улс төрийн шинэтгэлийн суурийг тавьсан 40 орчим хууль шинэ Үндсэн хуулийн утгал, үзэл баримтлал болсон юм. 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталснаар 1930-1990 оны хооронд (оныг харьцангуй тооцож байсан социалист эрх зүйн тогтолцоог бүрнээ халсан юм. Үндсэн хуулийн хамт түүний нэгэн адил хүчинтэй "Хавсралт хууль"-ийг баталж, түүнд хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэх, эрх зүй үндсэнд нь шинэтгэх заалтыг тусгажээ. Уг хавсралт хуулийн дагуу хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэн шинэтгэх ажлыг 1996 онд багтааж буюу дөрвөн жилийн дотор дуусгах ёстой байв. Энэ шаардлага хугацаандаа багтаж, бүрэн хэрэгжээгүй сунжирсныг тэмдэглэх нь зүйд нийцнэ.

Улсын Их Хурал 1992 оноос 2004 оны 5 дугаар сар хүртэл 1000 гаруй хууль тогтоомж (шинээр хууль гаргах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, олон улсын гэрээнд нэгдсэн буюу соёрхон баталсан хууль батлах, хууль хүчингүй болгох, тогтоол гаргах)

баталсан байх бөгөөд 2004 оны 5 дугаар сарын 13-ны байдлаар 300 орчим хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Улсын Их Хурлын хууль тогтоох ажиллагааны сүүлийн 10 гаруй жилийн дүр зургийг тоймлохдоо зарим асуудалд шүүмжлэлтэй хандах нь зүйтэй гэж бодож байна. Энэ нь цаашид хуулийг цэгцлэх, сайжруулахад хэрэгтэй байж ч болох талтай. Үүнд, хууль батлахдаа үзэл баримтлалгүй байх, эрх зүйн тогтолцооны үүднээс асуудалд хандахгүй байх, хууль тогтоомжийн салбар, институтын уялдаа сул, нэр томьёо, ойлголт оночтой биш, зөрүүтэй, захиргааны элдэв шийдвэрийг хуулийн хэмжээнд өргөмжлөхийг оролдсон, давхардсан заалттай, гадны хуулийг хийсвэрээр хуулах зэргийг дурдаж болох юм.

Ялангуяа Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлээгүй эрх зүйн янз бүрийн тогтолцоотой орны хуулийг хуулбарлаж байгаа нь хууль тогтоомж дотооддоо авцалдаа уялдаа муутай, зөрчилтэй болж, хэрэгжих бататгах, үр нөлөө нь сулардаг байна. Үндсэн хуулийн үзэл баримтлал хийгээд Монголын төрт ёсны хөгжлийн сүүлийн 80 орчим жилийн түүхэн туршлагаас үзвэл Монгол Улс яах аргагүй Ром-Германы буюу иргэний эрх зүйн тогтолцоотой улс юм. Үүнийг нотлохын тулд онолын гүнзгий судалгаа, шинжлэх ухааны нарийн нотолгоо, гаргалгаа шаардлагагүй байх гэж бодож байна. Гэхдээ энэ асуудалд хэт өрөөсгөлөөр хандмааргүй байна.

Орчин үед эх газрын эрх зүйн тогтолцоотой орнууд шүүхийн шийдвэрийг үл үндэстэй судалж, хууль хэрэглэх практикт төгтрүүлэх, шүүхийн шийдвэрийг нийтэд хэвлэж хуульчид, оюутан, иргэдэд мэдээлэх зэргээр прагматик алхам олонтаа хийх болсон байна. Нөгөө талаар нийтлэг эрх зүй буюу Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой орнууд нийгмийн харилцааг хуулиар зохицуулах хандлага нэмэгдэж байна. Бидэнд ирээдүйд мэдээллийн технологид

суурилсан, даяаршсан тогтвортой хөгжлийн эрх зүй үйлчилнэ. Энэ бол мөрөөдөл юм уу, алс ирээдүйн зорилго биш. Харин ч хаяанд тулж ирээд байгаа ойрын ирээдүй юм. Монгол Улс, Герман, Япон, Америк, Орос, Солонгос, Хятад улстай буюу бусад аль ч орноос илүү өргөн хүрээнд хамтран ажиллаж байна. Эдгээр орны хуулийг мэдэх, судлах, өөрийн орны хуулийг тэдэнд ойлгуулах, мэдээлэх хэрэгцээ, шаардлага нэмэгдэж байна. Тэр ч бүү хэл, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд олон арван гэрээ байгуулах, эрх зүйн зарим асуудлаар уялдуулах, ойртуулах, нийцүүлэх шаардлага байгааг ч үгүйсгэж болохгүй.

Монгол Улс 1990 оноос хойш Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн худалдааны байгууллагатай хамтран ажиллаж, олон талаар үр өгөөжийг нь хүртэж байна. Манай улс гишүүн нь болсон Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллага болох Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон Дэлхийн шуудангийн холбоо зэрэг олон улсын байгууллага нь гишүүн орнуудын эрх зүйн тогтолцооны хамгийн үр ашигтай хэм хэмжээг судлан, гишүүн улсуудын дагаж мөрдөх нийтлэг журам тогтоодог байна. Иймд бид эх газрын эрх зүйд суурилсан, Монголын онцлогийг харгалзсан эрх зүйн тогтолцоог төлөвшүүлэхдээ дээрх хүчин зүйлүүдийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай. 1950-аад оноос улс орноо эрчимтэй хөгжүүлж байгаа Азийн орон болох Япон, Солонгосын эрх зүйн тогтолцооны хөгжил, эрх зүйн шинэтгэлийн үйл явц бидэнд зохих туршлага болох нь дамжиггүй.

Иймд Монгол Улсын эрх зүйн үр ашигтай тогтолцоо бий болгохын тулд харьцуулсан эрх зүй судлалд онцгойлон анхаарах цаг нэгэнт болжээ. Харьцуулсан

эрх зүйг хөгжүүлснээр Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах, даяаршилд алхаа нийлүүлэн явах, дэлхийн эдийн засгийн интеграцид багтах, олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, уламжлалаа хадгалах эрх зүйн тогтолцоог бий болгон төлөвшүүлэх бүрэн боломжтой. Харьцуулсан эрх зүйг хэрхэн хөгжүүлснээс эрх зүйн шинэтгэл шууд хамааралтай гэж хэлж болно. Харьцуулсан эрх зүй Монголд цоо шинэ зүйл биш гэдгийг энэ дашрамд тэмдэглэн хэлмээр байна.

Бүр 1924 оны анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах явцад Англи, Америк, Швед, Солонгос зэрэг орны эрх зүйн тогтолцоо, төрийн байгуулал, Үндсэн хуулийг харьцуулан судалж байсан баримт улсын нийтийн номын санд хадгалаатай байна. 1960-аад оны дунд үеэс 1990-ээд оны эхэн үе хүртэл хууль зүйн шинжлэх ухаанд харьцуулсан эрх зүйг аргынх нь хувьд өргөн хэрэглэж байсан нь эрдэмтэд, судлаачдын бүтээлээс тодорхой харагдаж байна. Манай эрдэмтдийн эрх зүйн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан бөгээлгийг судалж үзэхэд бараг бүгд харьцуулсан эрх зүйг арга болохын нь хувьд судалгааны ажилдаа хэрэглэсэн гэж дурджээ. 1997 онд Хууль зүйн болон Гэгээрлийн сайдын тушаалаар хууль зүйн их, дээд сургуульд заавал үзэх хичээлийн жагсаалт, судлах цагийн доод хязгаарыг батлахдаа харьцуулсан эрх зүйг хичээл хийгээд шинжлэх ухаан болохын нь хувьд заах нь зүйтэй гэж үзжээ. 2000 онд "Харьцуулсан эрх зүй судлаачдын нийгэмлэг" нэртэй төрийн бус байгууллага байгуулагджээ. Профессор Б.Чимидийн тэргүүлсэн уг нийгэмлэг нь Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль тогтоомжийн үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн тодорхой сэдвээр харьцуулсан эрх зүйн судалгаа явуулах; хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх; судалгааны үндсэн дээр эрх зүйн тогтолцоо,

хууль тогтоомж, практикийг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх талаар төр засгийн байгууллагатай харилцан ажиллах; олон улсын байгууллага, бусад орны харьцуулсан эрх зүй судлаач эрдэмтэд, ижил төстэй байгууллагатай холбоо тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулахаар дүрэмдээ тусгажээ. 2003 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв¹ байгуулагдаж, одоо Зүүн хойд Ази дахь хүний эрхийн төлөв байдал, дэлхийн улсуудын шүүх, дэлхийн улсуудын эрх зүйн тогтолцоо сэдэвт судалгааны ажлыг ШУА, ХЗҮТ-тэй хамтран хийж байна. 2003 оны эцсээр Солонгос Улсын Сөүлийн их сургуулийн эрдэмтэд Монголын эрх зүйн тогтолцоог судлан "Монголын эрх зүйн тогтолцооны судалгаа" гэсэн бүтээл гаргаад байна. Энэ ажилд Ж.Амарсанаа, С.Нарангэрэл нар оролцсон юм.

ХЗҮТ, МУИС, ШУА-аас Солонгосын Коокмины их сургууль, түүний харьяа Хойд Солонгосын хууль зүйн судалгааны төвтэй хамтран хойт, өмнөд Солонгос, Монголын улс төр, эдийн засгийн өөрчлөлт, хүний эрхийн хууль зүйн сэдвээр судалгаа хийж байна. Мөн Японы Нагоягийн их сургуулийн Азийн хууль зүйн судалгааны солилцооны төвтэй хамтран газрын эрх зүйн чиглэлээр судалгаа хийж, хамтарсан хурал зохион байгуулав. Монголын эрх зүйн тогтолцоог харьцуулан судлахад 2000 онд Ханнс-Зайделийн сантай хамтран зохион байгуулсан "Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо" сэдэвт олон улсын симпозиум чухал алхам болсныг онцлон тэмдэглэе.

Ялангуяа АНУ, ОХУ, Монгол Улс, Герман Улсын эрдэмтэд оролцсон уг симпозиумаас төгсгөлийн баримт бичиг гаргасан хийгээд доктор, профессор Б.Чимид "Зохистой тогтолцоог баримжаалах нь эрх зүйн шинэтгэлийг үр нөлөөтэй хийх үндэс болох нь" илтгэл хэвлэлцүүлсэн нь өнөө хэр

¹ Т.Сэнгэдзорж "Хууль зүйн шинжлэх ухаан". УБ. 2005 он. 60 дахь тал.

эрдэмтэд, судлаачдын анхаарлыг татсаар байна.

2004 оны 5 дугаар сарын 20-нд Улаанбаатар хотноо "Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил" сэдвээр Хууль зүйн үндэсний төв, Дэлхийн банк хамтран олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан бөгөөд уг хуралд Монгол, Орос, Хятад, Америк, Герман, Солонгос, Японы судлаачид илтгэл тавьсан юм.

Доктор, профессор Г.Совд "Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (Харьцуулсан эрх зүй)" (1999), Ж.Амарсанаа "Хүний эрх: Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал" (2000), Академич С.Нарангэрэл "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" (2001), Докторант Н.Отгончимэг "Харьцуулсан эрх зүй судлал" (2001), Докторант Ж.Сүхбаатар "Харьцуулсан эрх зүй судлал. Сургалтын гарын авлага" (2000), Б.Чимэд "Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй" (2002) (Номын I бүлэг. 4. Бүсэд орны жишиг), Г.Совд нарын "Хууль зүйн тайлбар толь" (2003), Т.Мэндсайхан "Олон улсын хувийн эрх зүйн үндэс" (2003), П.Одгэрэл "Захиргааны эрх зүйн ерөнхий анги" (2004), ХЗҮТ-өөс эрхлэн гаргасан хамтын бүтээл болох "Бизнесийн эрх зүй" (2003), "Компанийн эрх зүйн асуудал" (2003) зэрэг бүтээл нь судалгаа, судалгааны дотор манайд харьцуулсан эрх зүй судлал хурдацтай хөгжиж буйн нотолгоо яах аргагүй мөн. Хууль зүйн үндэсний төвөөс (2003 оноос) эрхлэн гаргаж байгаа "Хууль дээдлэх ёс" сэтгүүлд "Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй" гэсэн тусгай булан нээсэн бөгөөд харьцуулсан эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба конвергенц (2003, №2, Б.Гүнбилэг), "Олон улсын эрх зүй, хувийн эрх зүйн харилцан хамаарал" (2003, №3, А.Төмөр), "Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил, хандлага, Монгол Улсын оролцоо" (2003, №4, Ж.Энхсайхан), "Олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүйн харилцан хамаарал" (2006, №2, М.Мөнхбат) зэрэг өгүүлэл нийтлэгдсэн байна.

Мөн дэлхийн улсуудын Үндсэн хуулийн шүүхийн талаар (Э.Лхагвасүрэн) цуврал нийтлэл хэвлэгджээ. Б.Амарсанаа 2005 онд "Харьцуулсан эрх зүй судлал" ном хэвлүүлжээ. Б.Гүнбилэг, А.Төмөр нар "Харьцуулсан эрх зүй (Жишгийн эрх зүй: Олон улсын нийтийн эрх зүй ба олон улсын хувийн эрх зүйн харилцан хамаарал)" сэдэвт номыг 2005 онд хэвлүүлжээ. Ер нь харьцуулсан эрх зүйн талаар гарсан бүтээлийг Б.Батзориг, Л.Отгонбаяр нарын бэлтгэсэн "Хууль зүйн шинжлэх ухааны ном зүй" (2006) бүтээлээс харж болно.

Монголд харьцуулсан эрх зүйгээс гадна харьцуулсан хууль тогтоомж амжилттай хөгжиж байна. ХЗҮТ-өөс ШУА-тай хамтран 2004 онд УИХ-аас 1992-2004 онд баталсан, одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа 300 орчим хуульд судалгаа хийсэн бөгөөд уг ажлын эхний дүн гараад байна. Бид судалгааг хийхдээ тухайн хуулийг боловсруулж батлахдаа аль улсын хуулийг харгалзсан, олон улсын ямар байгууллага санал, зөвлөмж өгсөн, хууль тогтоомжийн аль салбарт хамаарах хуулиар голчлон харьцуулсан судалсан, ямар субъект хууль санаачилсан, олон улсын ямар баримт бичигт нийцүүлсэн зэрэг асуудалд анхаарлаа хандуулсан юм. Энэ судалгааны ажил цаашид үргэлжлэх болно. Хууль тогтоомжийг харьцуулсан судлахад АНУ-ын хөгжлийн агентстваас хэрэгжүүлж буй "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр", Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Ханнс-Зайделийн сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр ихээхэн түс дэмжлэг үзүүлж, Монгол Улсын эрх зүйн шинэтгэлд, харьцуулсан эрх зүй судлалд оюуны маш том хөрөнгө оруулалт хийж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Хамгийн сүүлчийн жишээ дурдахад Ханнс-Зайделийн сан, Дэлхийн банк, АНУ-ын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр УИХ, ХЗДХЯ, МУИС, ХЗҮТ, Удирдлагын академи, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комиссын эрдэмтэн, судлаач, мэргэжилтний оролцоотойгоор Захиргааны хэрэг


хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсруулж, УИХ-аас батлан гаргасан байна.

Дээр дурдсаныг нэгтгэж үзвэл харьцуулсан эрх зүйн судалгааны үр дүнг:

- а) Хууль тогтоох үйл ажиллагаанд;
- б) Хууль тайлбарлахад;
- в) Хуулийг хэрэглэхэд;
- г) Хууль зүйн судалгааны ажилд;
- д) Хүний нөөц бэлтгэхэд;

е) Гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллахад ашиглах хамгийн их хэрэгцээ, шаардлага байгаа нь харагдаж байна.

Цаашид үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд харьцуулсан эрх зүйг хөгжүүлэхдээ түүний арга зүйг сайжруулах, түүнийг багш судлаачид, эрдэмтэд, хууль боловсруулагч, батлагчид эзэмших, ажилдаа хэрэглэж сурах шаардлагыг тавин ажиллах нь зүйтэй байна. Тухайлбал, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзсан (асинхрон, синхрон), дотоод, гадаад (өөрийн орны дотоодод болон гадаад улстай), макро, микро (эрх зүйн тогтолцооны ерөнхий асуудал ба институт гэх мэт) харьцуулсан судалгааны аргыг эзэмшүүлэх хэрэгтэй юм.



Сүүлийн үед харьцуулсан эрх зүйн сэдвээр бичсэн зарим бүтээл

№	Ном	Агуулга
Номын нэр зохиогч		
1	Улаанбаатар-Эрдэм дээд сургууль Ж Сүхбаатар "Харьцуулсан эрх зүй судлал" /схем, тайлбар/ ерөнхий ба тусгай анги Улаанбаатар хот 2000 он, 5.4 х.х.	Ерөнхий ба тусгай анги гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд ерөнхий ангид харьцуулсан эрх зүйн судлалын онолын асуудал, тусгай ангид иргэний эрх зүй болон нийтийн эрх зүйн зарим асуудлыг схемчлэн харуулжээ.
2	Сүлд хууль зүйн дээд сургууль Н.Отгончимэг "Харьцуулсан эрх зүйн судлал" 2001 он, 6.6 х.х	Ерөнхий ба тусгай анги гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд ерөнхий ангид харьцуулсан эрх зүйн судлалын онолын асуудал, тусгай ангид эрх зүйн бүлгүүдийн талаар харьцуулсан судалгааг багтаажээ. мэйл хаяг n.olgongchimeg@hml.com
3	Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо С.Нарангэрэл Улаанбаатар 2001 он, 28 х.х	Номын 1 дүгээр хэсэгт эрх зүйн ойлгол, эрх зүйн онолын үндсэн урсгал, орчин үеийн эрх зүйн чиг үүрэг, 2 дугаар хэсэгт үндэсний эрх зүйн тогтолцоо, 3 дугаар хэсэгт дэлхийн эрх зүйн тогтолцоог харуулжээ.
4	"Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги" зохиогч Кристофер Осаке, редактор Н.Лүндэндорж Улаанбаатар хот 2005 он, 21 х.х	Номын эхний хэсэгт харьцуулсан эрх зүйн орчин үеийн онолын асуудлыг задлан шинэчилсэн бол ерөнхий ангийн хэсэгт англи, франц, герман, оросын эрх зүйн тогтолцоог харьцуулсан тус бүрийн нь үндэсний оноллогийг нэгтгэн харуулжээ. Харин тусгай ангийн хэсэгт америк, оросын иргэний эрх зүйн үндсэн институтыг харьцуулан авч үзжээ
5	Харьцуулсан эрх зүй судлал Б.Амарсанаа Улаанбаатар хот 2005 он, 21 х.х	http://unidroit.org/english/home.htm -хувийн эрх зүйг ижилсүүлэх олон улсын институт http://unidroit.org/en-index.htm -Олон улсын худалдааны эрх зүйн НҮБ-ын хороо http://www.law.cornell.edu/ -Америкийн Корнеллийн их сургууль http://www.austlii.edu.au/Австрали-Азийн эрх зүйн мэдээллийн институт www.lexis-nexis.com www.westlaw.com www.ebsco.com-erx зүйн мэдээллийг сэтгүүлээр дамжуулан авах http://www.law.com.gov.uk http://www.legislation.hms.gov.uk/acts2003/20030021.htm
6	Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил /илтгэлийн эмхтгэл/ Улаанбаатар хот 2005 он	2004 оны 5 дугаар сарын 20-нд болсон "Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлийг эмхтгэсэн болно.
Сэтгүүл		
Сэтгүүлийн нэр	Зохиогч, эрдэм шинжилгээний бүтээлийн нэр	
1	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 1/2000	"Монгол эрх зүй-дэлхийн эрх зүй бүлийн нэг гишүүн" ХБНГУ-ын Мюнхены Их сургуулийн доктор Хайнрих Шоллер
2	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 1/2000	Харьцуулсан эрх зүйн онолын асуудал доктор Ж.Амарсанаа
3	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 2-3/2000	Олон улсын болон үндэсний эрх зүй уялдаулах арга зам доктор Ж.Амарсанаа
4	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 2-3/2000	Үндэсний Үндсэн хуулийн эрх зүйн ба олон улсын нийтийн эрх зүйн хоорондын уялдаа харьцааны тухайд Д.Байрсайхан
5	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 2-3/2000	МУ-ын Олон Улсын гэрээ, үүний эрх зүйн зохицуулалт В.Энхтамир
6	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 6-7/2001	Харьцуулсан эрх зүй судлалын үүсэл хөгжил Н.Отгончимэг
7	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 6-7/2001	Харьцуулсан эрх зүй судлал ба хууль зүйн соёл F.H.Lawson "Many Laws" Орчуулсан Х.Тэмүүжин
8	Монгол Улсын дээд шүүх "Монголын төр эрх зүй" сэтгүүл 1999" №4	Олон улсын хэм хэмжээ ба хөдөлмөрийн тухай Монгол Улсын хөдөлмөрийн хууль Л.Баасан
9	Монгол Улсын дээд шүүх "Монголын төр эрх зүй" сэтгүүл 2001" №2	Харьцуулсан эрх зүйн судалгааны арга зам Ж.Амарсанаа
10	Монгол Улсын дээд шүүх "Монголын төр эрх зүй" сэтгүүл 2001" №2	Ажлын цаг ашиглалтын зарим асуудал /Харьцуулсан судалгаа/ Л.Баасан
11	Монгол Улсын дээд шүүх "Монголын төр эрх зүй" сэтгүүл 2002" №2	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн онцлог, эрх зүйн харьцуулалт Ц.Сарантуяа
12	Монгол Улсын дээд шүүх "Монголын төр эрх зүй" сэтгүүл 2003" №2	"Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ОХУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуультай харьцуулах нь" А.Э.Жалинский
13	Хууль зүйн дээд сургууль "Эрх зүй" сэтгүүл онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал 12/2004	"Харьцуулсан эрх зүйн арга зүйн үндсэн зарчим" Хууль зүйн дээд сургуулийн 5 курсын оюутан О.Мөнхсайхан
14	Хууль зүйн үндэсний төв "Хууль дээдлэх ёс" 2003 он №2	"Харьцуулсан эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба конвергенци" ХЗҮТ-ийн ажиглан Б.Гүнбилэг
15	Хууль зүйн үндэсний төв "Хууль дээдлэх ёс" 2004 он №4	"Хууль зүйн шинжлэх ухаанд харьцуулсан эрх зүйн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг" ХЗҮТ-ийн ажиглан Н.Отгончимэг
16	Хууль зүйн үндэсний төв "Хууль дээдлэх ёс" 2005 он №2	"Монгол Улс ба Болгар Улсын эрх зүйн тогтолцоо" ХЗҮТ-ийн ажиглан П.Байр



Газар өмчлөх эрх ба газрын хэвлийн баялгийг ашиглах эрх: Германы эрх зүй дэх ашиг сонирхлын зөрчил

Доктор, профессор Л.Л.Чантурия

Герман улс нь ашигт малтмалын баялгийн нөөцөөрөө бусад улсаас гойд ялгарах зүйлгүй билээ. Тэрээр байгалийн шатдаг хий, газрын тос болон бусад түүхий эдийг гадаадад нийлүүлдэг улс биш бөгөөд харин ч эсрэгээрээ, эрчим хүчний экспортоос хараат байдаг. Гэхдээ Герман улс нь түүхэн уламжлалын хүрээнд ашигт малтмалын эрх зүй (горное право) сайн хөгжсөн. Энд газар өмчлөх эрх ба байгалийн баялгийг ашиглах эрхийн хоорондын харилцан хамаарлын асуудал онцгой анхаарал татдаг. Энэ салбарт өмчлөх эрхийг нийгэмшүүлэх (социализация) үзэгдэл илүү тод илэрдэг бөгөөд түүнийг нийгэм, төрийн ашиг сонирхолд нийцүүлэх гэсэн нэмэлт үүрэг давхар ногдоно.

Германы Иргэний хуулийн 905-д "Эдлэн газрын өмчлөгчийн эрх нь хөрсөн дээрх болон түүний доорхи баялагт мөн адил хамаарна" гэж заасан. Энэхүү хэм хэмжээг Ромын эрх зүйн түүхэн уламжлал, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг туйлын байдлаар илэрхийлэхийг эрмэлзэж байсан агуу их кодификациллын эрин үеийн уламжлал болохын хувьд үнэлж болох билээ. Уг хэм хэмжээ нь өмчлөгчийн ашигт малтмалын бүрэн эрхийг илэрхийлдэг бодит хэм хэмжээ байхаа аль хэдийн больсон. Түүний байр суурийг байгалийн баялаг болон агаарын орон зайг газар өмчлөгчийн ноёрхлын хүрээндээ гаргаж орхисон нийтийн эрх зүйн хэм хэмжээ эзэлсэн.

Энэ талаар Германы эрх зүйн ном зохиолд Германы иргэний хуулийн 905 дугаар зүйл нь байгалийн баялаг болон агаарын орон зайн өмчлөлийн үндэс болж чадахгүй гэж зүй ёсоор онцолсон юм. Нарийвчлан авч үзвэл эдлэн

газар өмчлөх эрх нь байгалийн баялгийн хувьд эдлэн газраа боломжит хэмжээнд ашиглах төвшинд хүртэл л үйлчилдэг бөгөөд үүнийг "тодорхой ашиг сонирхол байгаа" гэдгээр зөвтгөдөг ажээ.

Гэхдээ дээр өгүүлсэн зүйл бол эдлэн газрын өмчлөгч нь байгалийн баялгийн хувьд ямар ч эрхгүй гэсэн үг биш юм.

Харин газрын хэвлийн баялгийн хувьд эдлэх түүний эрхийг нийтийн эрх зүйн хуулиар тодорхойлдог гэж хэлэх нь илүү тохиромжтой юм. Байгалийн баялгийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулдаг гол хууль бол 1980.8.13-ны Байгалийн баялгийн тухай Холбооны хууль билээ. Энэхүү хууль нь байгалийн баялгийг ашиглах журмыг, ялангуяа улс оронд эдийн засгийн ач холбогдол бүхий ашигт малтмалын харилцааг бэхжүүлсэн. Уг хуулийн дагуу ашигт малтмалын хувьд төр нь монополь байдалтай байх бөгөөд тухайн ашигт малтмал нь эдлэн газрын доор оршин байсан ч гэсэн газар өмчлөгчийн эрхэд хамаардаггүй. Үүнд эдлэн газар өмчлөх эрх үйлчлэхгүй. Энд эдлэн газар өмчлөгчөөс гадна ашигт малтмал ашиглах эрх бүхий уул уурхайн аж ахуйн нэгж оролцдог. Тухайн аж ахуйн нэгжийн эрх нь газар өмчлөх эрхтэй ижил байдаг.

Үүнээс гадна Германы Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар байгалийн баялгийг ашиглах эрх нь өмчлөх эрхтэй ижилхэн хамгаалагдана. Энэ нь түүнийг жишээлбэл, ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд нь саад болох барилга, байгууламж барих гэх мэт замаар хязгаарлах, хүчингүй болгох, хураан авч болохгүй гэсэн үг мөн.

Концесссын тогтолцоо

Төрийн монопольт байдалд байгаа байгалийн баялгийг ашиглах явдлын үндэс нь концесссын нийтийн эрх зүйн тогтолцоо юм. Тухайн ашигт малтмалын хайгуул хийх, олборлоход төрөөс зөвшөөрөл авах шаардлагатай. Зөвшөөрөл нь төрийн захиргааны актын хэлбэрээр олгогдоно. Ингэхэд нь эдлэн газрын өмчлөгч нь концессын эрх авах давуу эрх эдлэхгүй. Германы Холбооны Үндсэн хуулийн шүүх эдлэн газар өмчлөгчийн эрх зүйн байдалд өөрийн нэгэн шийдвэртээ ийм үнэлгээ өгсөн ажээ.

Байгалийн баялгийг ашиглах зорилго болон төрлөөс концессын төрөл хамаарч байдаг. Жишээлбэл, байгалийн баялгийн хайгуул хийхэд зөвшөөрөл олгодог. Энэхүү зөвшөөрөл нь эдлэн газарт хайгуулын ажил хийх онцгой эрхийг хангадаг. Ашигт малтмалыг олборлоход хуулиар лиценз олгогдох ёстой. Энэ нь бас л эдлэн газарт хайгуул хийх болон олборлолт хийх онцгой эрхийг илэрхийлнэ.

Уул уурхайн аж ахуйн нэгжийн байгалийн баялгийн эрх нь өөрийн өвөрмөц шинжтэй байна. Уул уурхайн аж ахуйн нэгжийн хувьд өмчлөл нь өмчлөх эрхийг батлах захиргааны актын үндсэн дээр үүсдэг. Энэ нь ашигт малтмал олборлох туйлын, эксклюзив (онцгой, тусгай) эрхийг илэрхийлнэ. Уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөх эрх нь туйлын эрх байх бөгөөд эдлэн газрыг өмчлөх эрхтэй ижил байдгаараа лицензээс ялгагддаг. Уул уурхайн аж ахуйн нэгж өмчлөх эрхтэй байна гэдэг нь лицензтэй байгааг илтгэнэ. Энэ нь газрын бүртгэлд бүртгэгдэх бөгөөд

зээлийн баталгааг ипотекаар хангаж болно. Уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөх эрх нь бие даасан эрх байх бөгөөд түүнийг эдлэн газартай, эсхүл эдлэн газрын нэг хэсэг гэж үзэхийг хүлээн зөвшөөрдөггүй. Гэхдээ газар өмчлөх эрхээс ялгаатай нь уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөх эрх нь хязгааргүй урт хугацаатай байдаггүй. Хэрэв уул уурхайн аж ахуйн нэгж ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулахгүй 10-аас дээш жил өнгөрсөн бол тухайн эрхийг цуцална.

Концессын эдгээр 3 хэлбэр (зөвшөөрөл, лиценз, уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөх эрх) нь түүнийг эзэмшиж буй этгээдэд эрх зүйн өөр өөр байдлыг бий болгодог. Мэдээт тэдгээр нь янз бүрийн хугацаагаар олгогдоно. Жишээ нь, зөвшөөрөл 5 жилийн хугацаатай олгогдоно. Харин лиценз болон уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөх эрх нь шинэ хөрөнгө оруулалт татахад урт хугацаа шаардлагатай байгаа гэдэг шалтгаанаас бусад тохиолдолд 50 жилээс илүүгүй хугацаагаар олгогдоно. Ашигт малтмалын нөөц барагдаагүй тохиолдолд байгалийн баялаг ашиглах эрхийг сунгаж бас болдог.

Зөвшөөрөл болон лицензийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, мөн түүнчлэн уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөх эрхийг шилжүүлэхэд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл заавал шаардагдана.

Газар өмчлөгчийн үүрэг

1. **Эдлэн газрыг шилжүүлэх.** Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагааны эрх зүйн хувь заяа нь эдлэн газар өмчлөгчийн оролцоогүйгээр шийдвэрлэгддэг. Ашигт малтмалын тодорхой төрөл дэх төрийн монопольт байдал нь түүнийг өмчлөгчийн эрх хэмжээг хязгаарладаг. Үүнээс гадна байгалийн баялаг ашиглах эрх олгох нь газар өмчлөгчид нэмэлт үүрэг ногдуулна. Жишээлбэл, байгалийн баялаг ашиглах этгээд нь ашигт малтмалын лицензид заагдсан олборлолт хийхэд зайлшгүй шаардлагатай эдлэн

газрыг шилжүүлэхийг газар өмчлөгчөөс шаардах эрхтэй.

Газар өмчлөгчийн хүсэл зоригоос гадуур олборлолт хийхэд зайлшгүй шаардлагатай эдлэн газрыг шилжүүлэх институт нь шинэ зүйл огт биш ээ. Үүнийг бүр дундад зууны үеийн уул, уурхайн тухай хуулиас ч олж харж болно. Өмнө үүнийг өмчлөх эрхийн хувийн эрх зүйн хязгаарлалтын нэг боломж гэж үзэж байв. Өнөө үед энэ нь **өмчийг экспроприацилах** акт гэж тооцогддог ба Германы Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заагдсан өмчлөх эрхийн нийтийн эрх зүйн хязгаарлалт гэж үздэг. Энэхүү **экспроприацийн** онцлог нь нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд хувийн аж ахуйн нэгжид ашигтайгаар хэрэгждэг явдал юм. Үүнээс эдлэн газрыг шилжүүлэх институт нь экспроприацитай (**квазиэкспроприаци**) төсөөтэй боловч ижил биш юм.

Байгалийн баялгийг уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөлд шилжүүлэх болон лиценз олгож байгаа нь эрх бүхий этгээдэд газар өмчлөгчөөс эдлэн газраа шилжүүлэхийг шаардах онцгой (эксклюзив) эрх олгодог. Үүнээс гадна хуулиар заавал биелэгдэх ёстой шилжүүлэх асуудлыг тодорхой заасан байдаг. Байгалийн баялгийн тухай Холбооны хуулийн 79 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт газрыг энэ нь зөвхөн "нийтийн сайн сайханд тустай" тохиолдолд шилжүүлж болно гэж заасан. Нийтийн сайн сайханд тустай гэдэгт зах зээлийг түүхий эдээр хангах, уул уурхайн салбарт ажлын байрыг хадгалах, эдийн засгийг сайжруулах болон энэхүү зорилгод хүрэхэд тухайн газрыг ашиглахаас өөр боломжгүй байхыг ойлгоно. Шүүхийн практик болон хууль зүйн ном зохиолуудад газрын өмчлөлийг ингэж экспроприацилахыг "уул уурхайн үйлдвэрлэл бол нийтийн ашиг сонирхолд хамаарна" гэдэг үндэслэлээр зөвтгөдөг ажээ.

Энэ тохиолдолд бид газар өмчлөгчийн ашиг сонирхол болон нийтийн ашиг сонирхлын хоорондын зөрчлийг олж харж болох бөгөөд Германы эрх зүйд нийтийн ашиг сонирхлын төлөө өмчлөх туйлын эрхийг золиос болгон шийдвэрлэдэг байна.

Өмчлөгч өөрийн өмчид ийм байдлаар халдахыг зөвшөөрөх ёстой гэдэг шүүхийн практикаар бэхжсэн бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үзэл бодол оршдог.

Эдлэн газрыг уул уурхайн аж ахуйн нэгжид ашиглуулахаар шилжүүлэх үйл явц нь талууд өмчлөгчид олгох нөхөн төлбөрийг тохиролцсон гэрээгээр зохицуулагддаг. Харин өмчлөгч уул уурхайн аж ахуйн нэгжийн шаардлагаар газраа шилжүүлэхээс татгалзсан тохиолдолд төрийн байгууллагаас эдлэн газар өмчлөгчийг газраа уул уурхайн аж ахуйн нэгжид ашиглуулахыг үүрэг болгосон захиргааны акт гаргах замаар шилжүүлнэ.

2. Эдлэн газрыг хураах.

Эдлэн газрыг хураах гэдэг ойлголтыг эдлэн газрыг шилжүүлэх зэргээс ялгаж ойлгох хэрэгтэй. Эдлэн газрыг шилжүүлэхийн гол зорилго нь тухайн газрын өмчлөх эрхийг алдахгүйгээр уул уурхайн аж ахуйн нэгжид шилжүүлэх явдал юм. Өмчлөх эрх хадгалагдах боловч байгалийн баялаг ашиглах эрхээр хязгаарлагддаг. Харин эдлэн газрыг хураахад өмчлөгч нь өмчлөх эрхээ алдаж тухайн газар байгалийн баялаг ашиглагч этгээдийн өмчлөлд шилжинэ. Эдлэн газрыг дараах тохиолдолд хурааж болно. Үүнд:

1. Хэрэв эдлэн газарт барилга байгууламж барьсан бөгөөд байгалийн баялгийг ашиглахын тулд тэдгээрийг буулгах шаардлагатай бол;

2. Хэрэв эдлэн газрыг урьдын байдлад нь сэргээхэд хэт өндөр зардал гарахаар бол;

3. Хэрэв тухайн эдлэн газрын өмчлөгч нь өмчлөх эрхээ байгалийн баялаг ашиглагчид шилжүүлэхийг өөрөө шаардаж байгаа бол.

Газар өмчлөгчийн эрх

1. **Экспроприациаас учирсан хохирлыг нөхөн төлөх.** Эдлэн газрыг шилжүүлэх явдал нь (бусдын эрхэд албадан халдах нь ч гэсэн) тодорхой тогтоосон хүрээнд л хэрэгжих ёстой. Энэхүү хүрээ нь

"байгалийн баялгийг ашиглах зорилгод хүрэх зайлшгүй байдлаар" тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, өмчлөгчид өөрийн ашиг сонирхлоо хамгаалах боломж олгогдоно. Тэрээр юуны өмнө нөхөн төлүүлэх эрхтэй байна. Энэ нь иргэний эрх зүйн гэм хорыг арилгаж байгаа хэрэг биш юм. Энд экспроприациас учирсан хохирлыг нөхөн төлөх журам үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, эрхийг нийтийн эрх зүйгээр хамгаалж буй хэлбэр юм. Хамгаалалтын энэ хэлбэрийн онцлог нь экспроприацийг зохицуулж буй хууль нь нөхөн төлбөрийн нөхцөл, төрөл, хэмжээг нарийвчлан тодорхойлсон байх явдал билээ. Энэхүү журам нь зөвхөн өмчлөгчид зориулсан нэмэлт баталгааг агуулаад зогсохгүй хууль тогтоогчоос өмчийг экспроприацилахыг заасан хуумгай зохицуулалттай хууль батлан гаргахыг сэргийлэх чухал хэрэгсэл болно.

Газар шилжүүлснээс үүссэн хохирлыг нөхөн төлөх үүрэг газрыг шилжүүлж авсан байгалийн баялаг эзэмшигчид ногдоно. Хохирлыг мөнгөн хэлбэрээр тогтоох ёстой. Нөхөн төлбөрийг газрыг хурааж авах үед нэг удаа олгоно. Газрыг шилжүүлсэн бусад тохиолдолд үргэлжилсэн хугацаагаар төлж болно. Хохирлыг нөхөн төлөх хэмжээг төрийн эрх бүхий байгууллага тогтооно. Эдлэн газраа өмчлөх эрхээ алдсан болон газрыг шилжүүлсэнтэй холбоотой газар өмчлөгчид учирсан эд хөрөнгийн бусад хохирлыг нөхөн төлнө. Олборлох зорилгоор шилжүүлсэн газарт буй ашигт малтмалын үнэ нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлоход ямар ч үүрэг гүйцэтгэхгүй бөгөөд газрыг шилжүүлэх үеийн байдал, түүний зах зээлийн ханш, уг газарт учирч болох боломжит хохирол л шийдвэрлэх ач холбогдолтой.

Уул уурхайн аж ахуйн нэгжийн өмчлөгч болон лиценз эзэмшигчийн төрд тогтмол төлөх төлбөр нь хохирлыг нөхөн төлж буй төлбөрөөс ялгаатай юм. Энэ нь олборлосон ашигт малтмалын зах зээлийн үнийн 10 хувьтай тэнцэхүйц хэмжээтэй байна. Хэрэв ашигт малтмал нь зах зээлийн үнэлгээ өгөх боломжгүй бол төлбөрийг төрийн байгууллага тогтооно.

Эдлэн газрыг ашиглах хугацаа дууссанаа даараа өмчлөгч нь газраа буцаан авахыг шаардах, түүнийг шилжүүлэхээс өмнө байсан байдалд нь оруулж өгөхийг шаардах эрхтэй.

2. Эдлэн газрыг худалдан авах үүрэг. Эдлэн газрыг өмчлөгч нь байгалийн баялаг ашиглагч этгээдээс уг газрыг худалдан авахыг шаардах эрхтэй. Энэ нь газар өмчлөгч нь газраа шилжүүлснээс үүсэх бүх үр дагаврыг хүлээж авах боломжгүй үед тохиолдоно. Газрын үнийг зах зээлийн ханшаар тохиролцоно. Шилжүүлэх зүйл нь эдлэн газрын нэг хэсэг нь байгаа тохиолдолд өмчлөгч нь хэрэв газрын үлдсэн хэсэг нь зориулалтын дагуу ашиглах боломжгүй бол бүх газраа шилжүүлэн авахыг шаардаж болно.

3. Учирсан хохирлыг арилгах. Эрх зүй зөрчсөн үйлдлээс учирсан гэм хорыг арилгах институтыг хохирлыг нөхөн төлөхөөс ялгаж ойлгох хэрэгтэй. Уул уурхайн аж ахуйн нэгжийн хууль бус үйлдлээс гуравдагч этгээдэд, тэр дундаа өмчлөгчид учирсан гэм хорыг аж ахуйн нэгжийн гэм буруутай эсэхээс үл харгалзан арилгах ёстой. Энэ тохиолдолд уул уурхайн аж ахуйн нэгжид гэм буруугүйгээр хариуцлага ногдуулахыг хуульд тодорхой зохицуулсан. Үүний үндэслэлд:

1. Уул уурхайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь орчин тойрондоо аюул үүсгэхийг тодорхойлсон;
2. Лиценз олгох үед аж ахуйн нэгжийн ажлын аюулгүй байдлыг нөхцөлийг шалгасан байдаг.

Ийм байдлаар гэм хор учруулсан тохиолдолд хуулийн дагуу хувийн эрх зүйн хариуцлага үүснэ.

4. Төрийн монопольт байдал үйлчилдэггүй ашигт малтмал. Төрийн монопольт байдал үйлчилдэггүй ашигт малтмал нь эдлэн газрыг

өмчлөгчийн өмчлөлд байх бөгөөд түүнийг чөлөөтэй ашиглах эрхтэй. Гэхдээ энэ хүрээнд үндсэндээ байгаль хамгаалах зорилготой хязгаарлалт үйлчлэх ба тэдгээрийг ихэвчлэн Холбооны мужийн хуулиар тогтоодог. Энд Байгалийн баялгийн тухай Холбооны хуулийн хэм хэмжээ хэрэглэгдэхгүй.

Эндээс өмчлөх эрх ба бусад эрхийн хоорондын зөрчил нь тухайн объектийн нийгмийн чиг үүргээс хамааран шийдэгддэг гэж дүгнэж болох юм. Нийгмийн буюу нийтийн ашиг сонирхолд давамгайл ач холбогдол өгч байгаа бөгөөд ийм байдлаар өмчлөх эрхийн тухай уламжлалт үзэл бодолд гүнзгий өөрчлөлт орсон ажээ.

"Государство и право"
сэтгүүлийн 2006 оны №3-аас
орчуулсан Р.Мухийт

Залруулга

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2006 оны 2006 оны №2-т доктор, профессор Эрик Хилгэндорфын бичиж, Д.Чанцалдуламын орчуулсан "Эмгэнэлт хэргүүд: Туулын ноцтой байдлууд болон эрүүгийн эрх зүйн гарцаагүй байдлыг эрх зүйн харьцуулсан төлөвт авч үзэх нь" нэртэй материалыг манай ажилтан болон ГТХАН-ийн "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төслийн ажилтны хоорондын үл ойлголцлын улмаас ГТХАН-ийн ажилтан Б.Жавхлангийн орчуулсан материал гэснийг Д.Чанцалдуламын орчуулсан гэж залруулан уншина уу.

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн
редакц

Ажил гүйцэтгэх гэрээ, түүний үндсэн нөхцөл

Ажил гүйцэтгэх гэрээг тодорхойлох нь:

Хууль зүйн тайлбар толь: Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүрэг тус тус хүлээнэ.¹ Манай эрдэмтдийн хувьд ажил гүйцэтгэх гэрээг хуульд тодорхойлон заасан утгаар авч үзэж, тайлбарласан байна.

ОХУ-ын хувьд ажил гүйцэтгэх гэрээг Иргэний кодексын /1995 он/ 702 дугаар зүйлд: "Ажил гүйцэтгэх гэрээгээр гэрээний нэг тал нь /ажил гүйцэтгэгч/ нөгөө талын /захиалагч/ тодорхойлсон ажлыг захиалгын дагуу гүйцэтгэх, түүний үр дүнг захиалагчид шилжүүлэн өгөх үүрэгтэй, харин захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авах, түүний хөлсийг төлөх үүрэгтэй" гэж заасан байна. Гэвч худалдах, худалдан авах гэрээний тодорхой заалтууд хэрэглэгдэж болно. Тухайлбал, ажлын чанарыг тодорхойлох, чанарын талаарх гомдлын шаардлага гаргах гэх мэт харилцаа байна.² ОХУ-ын иргэний эрх зүйн уламжлалт хандлагаар ажил гүйцэтгэх гэрээг тодорхой ажлын гүйцэтгэлийн талаарх гэрээ мэтээр тодорхойлж байсан. Энд ажил гүйцэтгэлийн материал, ажил гүйцэтгэгчийн эрсдлийн талаар ярьдаггүй байсан 1964 оны Иргэний кодексыг бодвол шинэ хууль нь илүү боловсронгуй болсон юм.

ХБНГУ-ын Иргэний хуулиар: Ажил /үйлчилгээ/ гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцөлийн дагуу ажил /үйлчилгээ/ гүйцэтгэх гэрээний салшгүй хэсэг буюу холимог хэлбэрийн ажил /үйлчилгээ/



ХЗҮТ-ийн ажилтан
М.Доржханд

гүйцэтгэх гэрээний харилцааг ойлгоно.³

АНУ-ын хувьд: Хууль зүйн үр дагавар үүсгэсэн гэрээнд заавал биелэх хүчин чадалтай бөгөөд шүүхэд хүчин төгөлдөр байх болно. Гэрээний эрх зүй судлаач Самуэль Виллистоны илэрхийлснээр: гэрээ гэдэг нь амлалт ба хуулар засвар хийж болох эсвэл үүргээ хүлээн зөвшөөрсөн хуулийг гүйцэтгэх, зөрчлөөс сэргийлэх амлалтын хэлбэр ажээ. Гэрээний зорилго нь тодорхой, тогтвортой байх ёстой. Гэрээний тогтвортой байдлын ач холбогдлыг АНУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд тодорхойлсон: "нэг ч муж улс ...гэрээний үүргийг супруулах хууль...батлан гаргахгүй" гэсэн байна. Шүүхэд хууль бус зорилго гэж үзэгдэхгүй л бол иргэд чөлөөтэйгээр тохиролцож гэрээний чөлөөт байдлын зарчмыг хэрэгжүүлдэг.

БНХАУ-ын Иргэний эрх зүйн нийтлэг үндэслэлд тодорхой төрлийн гэрээний хэм хэмжээг нарийвчлан тусгаж өгөөгүй боловч

аж ахуйн гэрээний хуулийг 1999 онд гаргасан байна.

Ажил гүйцэтгэх гэрээний гол нөхцөл нь ажил гүйцэтгэх гэрээний тодорхойлолтоос урган гарах юм. Өөрөөр хэлбэл, нэг талаас ажил гүйцэтгэгч гэрээнд заасан ажил гүйцэтгэх, мөн Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.6 дахь заалтад зааснаар захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх, нөгөө талаас захиалагчийн төлөх хөлс, ажлыг хүлээн авах үүрэгтэй холбоотой нөхцөл орно.

Үндсэн нөхцөлийн хувьд ажлын үр дүнгийн чанар, хөлс тодорхойлох арга, хариуцлага, хугацаа зэрэг нөхцөлүүд орох бөгөөд эдгээр нөхцөлийг өөрчилсөн тохиолдолд шинэ оферт болж, шинээр акцепт шаардсан хууль зүйн фактыг илэрхийлнэ.

Ажил гүйцэтгэх гэрээ нь гэрээний талууд гүйцэтгэх ажлын талаар бөгөөд бусад гэрээний нэгэн адил гэрээний гол нөхцлүүдийн талаар тохиролцсон үед байгуулагддаг. Ялангуяа гүйцэтгэх ажил нь төлбөртэй байхыг талууд харилцан тохиролцох нь үүнд мөн хамаардаг. Хэрэв гэрээний талууд хөлсний хэмжээний талаар харилцан тохиролцож чадаагүй бол Иргэний хуулийн 344 дүгээр зүйлийн 344.2 дахь хэсэг нэмэлт зохицуулалтын байдлаар хэрэгжинэ. Энэ зүйлийг хэрэглэх нь нийтлэг зохицуулалтын дагуу гэрээ хүчин төгөлдөр бус болохоос сэргийлэх ач холбогдолтой байдаг.⁴

Ажил гүйцэтгэх гэрээнд заавал тусгах императив хэм хэмжээ болон талуудын зөвшилцөх диспозитив хэм хэмжээ бий.

Эндээс дүгнэхэд, ажил гүйцэтгэх гэрээ гэдэг нь гүйцэтгэл, үр дүнгийн талаарх тохиролцоонд үндэслэн хуулийн императив хэм хэмжээнд тулгуурлан, нөгөө талаар чөлөөтэй тохиролцон субъектив

¹ Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003 он. 9 дэх тал.

² Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации. Часть вторая. Москва., 1997 год. с. 272.

³ Leverkusen Institute, January 2004.

⁴ Contracts /USA/, 1997.

⁵ Монгол Улсын шинэ иргэний эрх зүй. Дэд дэвтэр. УБ., 2005 он. 153 дахь тал.

эрхээ хэрэгжүүлэх боломжтой гэрээ юм.

Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь гүйцэтгэсэн ажлын үр дүн байна.¹ Энэхүү үр дүн гэдэгт шинээр бүтээсэн бодит эд хөрөнгө байхаас гадна шинэчлэн сайжруулсан, засварласан барилга, барилгын дизайн, инженерийн ажлыг багтаан ойлгох нь түгээмэл бөгөөд зохистой байна.

Иргэний хуулийн 343.3-т "Ажил гүйцэтгэгч ямар нэгэн эд зүйлийг хийсэн бол түүнийг захиалагчийн өмчлөлд шилжүүлнэ" гэж заасан нь тухайн ажил гүйцэтгэх гэрээний гол зорилгоос үүдэн, захиалагчийн захиалгаар бүтсэн зүйл байх бөгөөд түүний захиран зарцуулах эрх мэдэлд шилжинэ гэсэн ууль зүйн үр дагавартай. Иргэний хуулийн 343.4-т "Төрлийн шинжээр тодорхойлогдох эд юмс хийж захиалагчийн өмчлөлд шилжүүлсэн бол худалдах, худалдан авах гэрээг зохицуулсан журам үйлчилгээ" гэж заасан нь Худалдах, худалдан авах тухай Венийн конвенцтой нийцсэн бөгөөд худалдах, худалдан авах гэрээнээс ялгагдах онцлогийг зааж өгсөнд ач холбогдол нь оршиж байна. Ажил гүйцэтгэх зарим төрлийн гэрээний буюу хөдөлмөрийн гэрээний онцлог зохицуулалтыг тусгай хуулиар зохицуулах явдлыг хуулиар хүлээн зөвшөөрсөн байна.²

Ажил гүйцэтгэх гэрээний гүйцэтгэлд саад болох нөхцөл байдал, хүлээлгэх хариуцлага

а. Үүрэг гүйцэтгэх

Монгол Улсын Иргэний хуулийн 16 дугаар бүлэгт заагдсан үүрэг гүйцэтгэх харилцаа нь ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалтад ч хамаарах бөгөөд үүргийн эрх зүй нь ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалтыг нөхөн зохицуулах шинжтэй юм.

Судлаач Б.Улаанбаатар "Иргэний эрх зүй" тайлбар тольдоо үүргийн эрх зүйг дараах байдлаар тодорхойлжээ: "Эд хөрөнгөй шилжүүлэх, ажил гүйцэтгэх, тусалцаа үзүүлэх, мөнгө төлөхтэй

холбогдон үүссэн нийгмийн харилцааг зохицуулж байгаа иргэний эрх зүйн хэм хэмжээний нийлбэр" гэжээ.³

Үүрэг гүйцэтгэх зарчим болох үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэх газрыг тогтоох журам ажил гүйцэтгэх гэрээнд хэрхэн илэрч болохыг Иргэний хуулийн заалтаас ишлэн дүгнэлт хийвэл:

✓ Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдсон үүргийг тухайн үл хөдлөх эд хөрөнгө байгаа газарт /Иргэний хуулийн 207.1.1/. Барилга, дизайн, инженерийн ажлыг тухайн барилга баригдах газарт үүргийг гүйцэтгэх нь ойлгомжтой, харин захиалагчийн гаргаж өгсөн тоног төхөөрөмж нь үл хөдлөх шинжтэй үйлдвэрийн газарт байвал энэ нь үл хөдлөх хөрөнгөтэй холбогдож байгаа утгаараа тухайн үйлдвэрийн газарт үүргээ гүйцэтгэх шаардлагатай болж байна.

Ажил гүйцэтгэх гэрээнд тодорхой хугацаа тогтоогоогүй бол 208.3-т зааснаар "Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол үүргийн шинж чанараас шалтгаалан үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг шаардсанаас хойш 10 хоногийн дотор үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэх үүрэгтэй" байна. Эндээс дүгнэвэл гэрээнд тохиролцоогүй байсан ч энэхүү заалт үйлчлэх боломжтой. Анхаарах ганц зүйл нь тухайн ажлын хэмжээ, бодит байдал, үүргийн шинж чанарыг харгалзах хэрэгтэй байна.

Хууль буюу гэрээнд үүрэг гүйцэтгэгч үүргээ заавал биечлэн гүйцэтгэхээр заагаагүй буюу үүргийн шинж чанарт харшлахгүй бол үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болно. Энэ журмаар туслан гүйцэтгэгчтэй үндсэн ажил гүйцэтгэгч дэд гэрээ байгуулснаар

захиалагчийн эрх зүйн статустай болно.

Үүргийн гүйцэтгэлд саад болох нөхцөл байдал дараах үндэслэл орж байна. Үүнд:

- Үүрэг гүйцэтгэгчийн буруугаас үүрэг гүйцэтгэх боломжгүй болох;
- Нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй болох;
- Хүндэтгэн үзэх үндэслэлээр талууд гэрээнээс татгалзах.

Эхний тохиолдолд үүргийн гүйцэтгэлд саад болсон гэм буруутай тал нөгөө талд учирсан хохирлыг арилгах хариуцлага хүлээнэ.

Нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр талууд өөрчлөгдсөн нөхцөл байдалд гэрээг зохицуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Хэрвэ зохицуулах боломжгүй бол эрх ашиг нь хөндөгдсөн тал гэрээнээс татгалзах эрхтэй байна.

Хүндэтгэн үзэх үндэслэлд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгахыг шаардах боломжгүй нөхцөл байдал орно.

Захиалагчийн буруугаас ажлын гүйцэтгэлд саад учирал захиалагч гэрээг цуцалсан тохиолдолд ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөх үүрэг бий болно.

Иргэний хуулийн 225 дугаар зүйлийн 225.4 дэх хэсэгт талуудын үүрэг гүйцэтгэхээс татгалзаж болохгүй тохиолдлыг заасан байна. Үүнд: 1. Үүргийг ялимгүй зөрчсөн, 2. ...үүрэг гүйцэтгүүлэгч гэрээг хүчин төгөлдөр байлгахыг шаардах эрхтэй байвал, 3. Үүрэг гүйцэтгэгч үүрэг зөрчсөн явдалд бүхэлд нь буюу ихэнх хэсэгт нь үүрэг гүйцэтгүүлэгч өөрөө буруутай, 4. Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзахаас өмнө үүрэг гүйцэтгэгч хариу шаардлага гаргасан, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзсаны дараа хариу шаардлага нэн даруй гаргах боломжтой бол. Эдгээр заалт нь талуудын эрх ашиг, ашиг сонирхлыг хамгаалан хангах, гуравдагч этгээдийг хохироохгүй байх хамгаалалт болж байна.

¹ Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.2 дахь хэсэг.

² Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.5 дахь хэсэг.

³ Б.Улаанбаатар. "Иргэний эрх зүй" тайлбар толь. УБ., 2005 он. 114 дэх тал.

Хамтран үүрэг гүйцэтгэгчийн зохицуулалт энэхүү судлагдаж буй гэрээтэй илүү холбоотой, ач холбогдолтой байна. Энэ нь зөвхөн үндсэн ажил гүйцэтгэгчтэй холбоотой, Иргэний хуулийн 242 дугаар зүйлд заагдсан субьектэд хамаарахгүй болно.

б. Хариуцлага

Иргэний хуулийн 186 дугаар зүйлийн 186.2 дахь хэсэгт яригдах бие даасан бус туслах шинжтэй үүргүүд нь үүргийн ерөнхий гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасан хэмжээнд хангахтай л холбоотой яригдахаас бус түүнээс өөр ямар нэгэн онцгой зорилгыг агуулаагүй. Ихэнх тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь туслах шинжтэй үүргүүд биелэгдээгүйгээс түүнийг гүйцэтгүүлэхээр үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхгүй болно.¹

Гэрээнд өөрөөр заагаагүй, эсхүл үүргийн мөн чанарт харшлахгүй бол үүргийн зүйлийг өөр этгээдээс хүлээн авах ёстой байсан үүрэг гүйцэтгэгч түүнийгээ авч чадаагүйгээс үүрэг биелээгүй бол үүнээс үүдэн гарах хариуцлагыг өөрөө хүлээнэ. Энэ нь дэд гэрээний ажил гүйцэтгэгчийн хариуцлага алдсан байдлыг үндсэн ажил гүйцэтгэгч өөрөө хариуцаж болох агуулгатай холбоотой.

Үүрэг зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг Иргэний хуулийн 227 дугаар зүйлд заасан бөгөөд энэхүү заалттай холбогдуулан судалбал: нэг тал нөгөө талын гэрээнээс татгалзах үйлдэлд нөлөөсөн бол хохирлыг нөхөн төлөх нь зайлшгүй ойлголт юм. Гэвч практикт үүнтэй холбоотой маргаан түгээмэл байгаа юм.

Энд хохирлыг нөхөн төлөх хариуцлага голлох байр суурийг эзлэх бөгөөд зайлшгүй олох байсан орлогыг хохиролд тооцон нөхөн төлүүлэх нь шударга ёс, иргэний эрх зүйн зарчимтай нийцэж байна, гэвч энэхүү олох байсан орлогын хэмжээг хэрхэн тодорхойлон, тогтоох нь тодорхойгүй байна. Тухайлбал, барилгын ажил гүйцэтгэх гэрээний гүйцэтгэгч тал үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс захиалагч гэрээнээс татгалзах үедээ олох байсан орлогыг хэрхэн тодорхойлох

вэ гэсэн асуудал үүснэ. Тэрхүү барилгын баригдаад үйл ажиллагаа явуулах байсан үеийн орлогыг тооцох уу, эсвэл барилгыг худалдах үнэлгээгээр үү гэдэг нь захиалагч талын хувийн хүсэл зоригоор шийдэгдэх болж байна. Харин энэхүү маргаан шүүх, арбитраж шийдвэрлэгдэх үед тухайн шүүхийн шүүгчийн дотоод итгэл үнэмшлийн асуудал болно.

Хариуцлагаас чөлөөлөх асуудал нь Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.2 дахь хэсэгт зааснаар нэг тал гэрээнээс татгалзсан явдалд нөгөө тал нь буруугүй бол хохирлыг арилгуулах хариуцлага хамаарахгүй болно.

Ажил гүйцэтгэх гэрээний төрөл ба гэрээний бусад төрлөөс ялгагдах нь

Ажил гүйцэтгэх гэрээний төрөлд ахуйн, барилгын, хайгуул шинжилгээний, төрийн албанд зориулсан ажил гүйцэтгэх гэрээ гэх мэт төрлүүдтэй. Эдгээртээс барилгын ажил гүйцэтгэх гэрээг нарийвчлан авч үзэхийг зорилоо.

Ажил гүйцэтгэх гэрээний нэг төрөл болох барилгын ажил гүйцэтгэх гэрээний талаарх ойлголтыг судалгааны эхэнд тодотгох нь зүйтэй гэж үзлээ. Барилгын ажил гүйцэтгэх гэрээ нь ажил гүйцэтгэх гэрээний нэгэн өөрмөц бөгөөд онцгой бие даасан төрөл юм. Их барилга (Construction) нь барилга барих, өргөтгөх, засварлах, сантехникийн угсралт, цахилгаан шугам сүлжээ, гоёл засал гэх мэт тус тусдаа бие даасан хийгээд хоорондоо зайлшгүй холбогдох иж бүрэн ажлын нийлбэр байна.

Манай 2002 оны иргэний хуульд барилгын ажил гүйцэтгэх гэрээний онцлог шинжийг нарийвчлан заагаагүй байна.

Ажил гүйцэтгэх гэрээ, гэрээний бусад төрлөөс ялгагдах онцлог болон төсөөтэй шинж

- Ажил гүйцэтгэх гэрээ ба хөдөлмөрийн гэрээ. Ажил гүйцэтгэх гэрээ нь хөдөлмөрийн гэрээтэй төсөөтэйн зэрэгцээ

дараах шинжүүдээр ялгарна. Ажил гүйцэтгэх гэрээ нь эд хөрөнгийн ба түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаагаар, харин хөдөлмөрийн гэрээ нь хөдөлмөрийн харилцаагаар тус тус тодорхойлогдоно. Субьектын шинжээр: хөдөлмөрийн гэрээнд нэг талаас хөлсний ажилчин, албан хаагч, нөгөө талаас байгууллагын захиргаа гэсэн тогтвортой хоёр субьект оролцдог бол ажил гүйцэтгэх гэрээний аль ч талд иргэн, хуулийн этгээд, зарим тохиолдолд төр ч байж болдог оролцогтой байна. Хугацаагаар: Хөдөлмөрийн гэрээнд хугацаа заагдсан байдаг бол ажил гүйцэтгэх гэрээнд тухайн ажлыг хийх хугацаа л байдаг. Мөн голмлын шаардлага гаргах хугацаа нь зөвхөн ажил гүйцэтгэх гэрээнд л байдаг бол хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээнд байдаггүй. Ажил гүйцэтгэх дэглэмээр: хөдөлмөрийн гэрээний ажилчин, албан хаагч тухайн байгууллагын дотоод журамд захирагдан тодорхой ажил мэргэжлийн тодорхойлолт, албан тушаалын зааврын дагуу мөн ажил олгогчийн өгсөн даалгаврын дагуу гэрээнд заагаагүй зарим чиг үүргийг хэрэгжүүлж болно. Гэрээний зүйлээр: Ажил гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэсэн ажлын биежсэн үр дүн байдаг бол хөдөлмөрийн гэрээнд биежсэн үр дүн болон үйл ажиллагаа байж болно. Ажил гүйцэтгэх хэрэгслээр: Ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчийн хэрэгслээр эсвэл ажил гүйцэтгэгч өөрийн багаж, техникээр гүйцэтгэдэг бол хөдөлмөрийн гэрээнд ажил олгогчийн багаж, техник хэрэгслээр гүйцэтгэдэг байна. Нийгмийн даатгалд хамруулах онцлогоор ялгаатай: Ажил гүйцэтгэх гэрээнд захиалагч хүсвэл ажил гүйцэтгэгчийг нийгмийн даатгалд хамруулна. Цалин, хөлсөөр ялгаатай. Хэрэв ажил гүйцэтгэх гэрээнд урьдчилан тохиролцоогүй бол ажил гүйцэтгэгч гүйцэтгэлтэй холбоотой материал, хүч, хөрөнгийг өөрөө гаргах өөрийн эрсдлийг ажил гүйцэтгэх үед үүрэхийг хүлээн зөвшөөрсөн

¹ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ., 2006 он. 725 дахь тал.

байдаг.¹ Маргаан шийдвэрлэх байдлаар: Хөдөлмөрийн гэрээнд маргааныг Маргаан таслах комисс, шүүхээр шийдвэрлэдэг байхад ажил гүйцэтгэх гэрээнээс үүссэн маргааныг шүүх, арбитраар хянан шийдвэрлэдэг.

• **Ажил гүйцэтгэх гэрээ ба даалгаврын гэрээ.** Даалгаврын гэрээгээр даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчийн нэрийн өмнөөс түүний зардлаар тодорхой үйлдэл хийдэг бол АГГ-ээр гүйцэтгэгч тодорхой биет зүйлийг шинээр бий болгох буюу засвар үйлчилгээ хийдэг. Даалгаварын гэрээний хувьд даалгавар гүйцэтгэгч нь даалгавар олгогчийг заавар, сонирхлыг нийтэд нь харгалзан үзэх ёстой байдаг бол ажил гүйцэтгэх гэрээний хувьд ажил гүйцэтгэгч нь өөрийн мэдлэг чадварт түшиглэн ажлыг гүйцэтгэж байдагараа ялгаатай. Мөн даалгаварын гэрээг хариу төлбөргүй байгуулж болдог.²

• **Ажил гүйцэтгэх гэрээ ба хөлсөөр ажиллах гэрээ.** Хөлсөөр ажиллах гэрээний зүйл нь үйлчилгээ байдаг бол ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь гүйцэтгэсэн ажлын биежсэн үр дүн байдаг. Ажил гүйцэтгэгч гэрээт ажлын үр дүнг захиалагчийн өмнө хариуцах ёстой. Харин хөлсөөр ажиллах гэрээнд ийм үр дүнг хариуцдаггүй. Хөлсөөр ажиллах гэрээний тухайд тодорхой нэгэн амжилт биш харин ажлыг гүйцэтгэх нь голлох ач холбогдолтой байдаг аргаатай.³

• **Ажил гүйцэтгэх гэрээ ба худалдах, худалдан авах гэрээ.** Тоо хэмжээний асуудал дээр ялгаа гарч ирэх нь бий. Ямар нэг тодорхой этгээдэд зориулж биежсэн, нарийвчилсан шинж чанартай зүйлийг хийж байвал ажил гүйцэтгэх гэрээ болно, харин олон тооны, төрлийн шинжээр

тодорхойлогдох буюу нэгээр нь нөгөөг нь орлуулж болох зүйл нь худалдах, худалдан авах гэрээнд хамаарна.⁴ Худалдах, худалдан авах гэрээнд бэлтгэн нийлүүлэх аргаар эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг зохицуулсан байдаг. Захиалагчийн хувьд ажил гүйцэтгэх гэрээгээр бий болох өртөг, түүний борлуулалт гүйлгээтэй холбогдуулан өмчлөх ба эзэмших эрхийг шилжүүлэх асуудал тэргүүн зэргийн ач холбогдолтой байдаг. Ажил гүйцэтгэх гэрээний гол онцлог нь: Захиалагч материалаа нийлүүлэн, хэрхэн, яаж тухайн үүргийг гүйцэтгэх талаар заавар өгч болдог, мөн гэрээний үүргийн гүйцэтгэл тодорхой хугацаанд үргэлжлэн биелэгддэг зэрэгт оршдог. Ажил гүйцэтгэгчийн материалаар ажил гүйцэтгэж, захиалагчид үр дүнг шилжүүлж буй гэрээг худалдах, худалдан авах гэрээнээс ялгах хэрэгтэй. Энд хоёр ялгаа байна: А/ Худалдах, худалдан авах гэрээний зүйл нь бэлтгэсэн эд хөрөнгө байна. Б/ Ажил гүйцэтгэх гэрээний нөхцөл нь юуны өмнө талуудын харилцааг тодорхойлох заавраар бэлтгэсэн эд хөрөнгө байдаг бол, худалдах, худалдан авах гэрээ нь нөгөө талаас гэрээний зүйлийг худалдан авагчид шилжүүлдэг.⁵ Ажил гүйцэтгэгчийн олсон амжилт нь ажил гүйцэтгэх гэрээний цөм болж байдаг. Худалдах, худалдан авах гэрээний хувьд нийлүүлэлт ба өмчлөх эрхийг олж авах нь чухал байдаг. Эд хөрөнгийг хэн, яаж, ямар арга замаар үйлдвэрлэсэн нь худалдах, худалдан авах гэрээний хувьд зөвхөн дагалдах шинжтэй асуудал байдаг.⁶

• **Ажил гүйцэтгэх гэрээ ба хамтран ажиллах гэрээ.** Хамтран ажиллах гэрээний үр дүнд хуулийн этгээд байгуулагдаж

хуульд бүртгүүлэх шаардлагатай⁷ бол ажил гүйцэтгэх гэрээнд ийм шаардлага байдаггүй. Иргэний эрх зүйн үүргийн харилцааны хувьд хамтран ажиллах гэрээнд үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч гэж ялгах боломжгүй. Хамтран ажиллах гэрээний талууд нэгдмэл зорилготой. Гэтэл манай практикт ажил гүйцэтгэх гэрээг гадаадын байгууллагатай байгуулах тохиолдолд хамтран ажиллах гэрээ хэмээн нэрлэж байгаа нь буруу юм.

• **Ажил гүйцэтгэх гэрээ ба контрактын гэрээ.** Контрактын гэрээ нь хөдөлмөрийн гэрээний нэг төрөл бөгөөд онцгой ур чадвар, мэргэшил бүхий хүмүүсийг контрактын гэрээгээр авч ажиллуулдаг байна. Ажил гүйцэтгэх гэрээнд шаардлагатай бол тусгай зөвшөөрөл шаардана. Бусад тохиолдолд талуудын зөвшилцлөөр гэрээ байгуулагдана. Барилгын ажил гүйцэтгэх гэрээнд инженертэй байгуулж буй гэрээний агуулгыг контрактын гэрээнээс ялган ойлгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, контрактын гэрээгээр ажилтантай хөдөлмөрийн хуулийн дагуу байнгын ажлын байранд ажиллах нөхцөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулдагт гол ялгаа нь оршино.

• **Ажил гүйцэтгэх гэрээ ба зуучлалын гэрээ.** Зуучлалын гэрээ нь зуучлагч зуучуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үүрэг хүлээдэг. Өөрөөр хэлбэл, ажил гүйцэтгэх гэрээнд ажил гүйцэтгэгч гэрээг хэрэгжүүлэх гол субъект байдаг бол зуучлагч тэрхүү гол субъектыг зуучуулагчтай холбож өгдөгөөр ялгарч байна гэсэн үг.

• **Холимог гэрээ.** 1000 ширхэг тоглоом /тодорхой стандартын дагуу үйлдвэрлэсэн/ худалдах, худалдан авах гэрээ нь ажил гүйцэтгэх гэрээ + худалдах, худалдан авах = холимог гэрээ болно. Иймд холимог гэрээг аль нэг гэрээний төрөлд бүрэн хамруулах шаардлагагүй бөгөөд тухай бүрд тохирсон

¹ ОХУ-ын Иргэний кодексын 704, 705 дугаар зүйл.

² Монгол Улсын шинэ иргэний эрх зүй. Дэд дэвтэр. УБ., 2005 он. 155 дахь тал.

³ Монгол Улсын шинэ иргэний эрх зүй. Дэд дэвтэр. УБ., 2005 он. 155 дахь тал.

⁴ Худалдах, худалдан авах гэрээний тухай Венийн конвенц. 1980 он. 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг.

⁵ Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации. Часть вторая. Москва., 1997г. с. 273.

⁶ Монгол Улсын шинэ иргэний эрх зүй. Дэд дэвтэр. УБ., 2005 он. 154 дэх тал.

⁷ Иргэний хуулийн 481 дүгээр зүйл.

зохицуулалтыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Сүүлийн үед түгээмэл болсон орон сууц худалдах болзолтойгоор барилга барьж байгаа нь мөн холимог гэрээний жишээ болно.

Ажил гүйцэтгэгч төрлийн шинжээр тодорхойлогдох эд зүйл бүтээх ёстой бол худалдах, худалдан авах гэрээний зохицуулалтыг хэрэглэж болно.¹

АНУ, ХБНГУ, ОХУ, БНХАУ-ын иргэний эрх зүй дэх ажил гүйцэтгэх, барилгын ажил гүйцэтгэх гэрээний харьцуулалт

Олон талт ажил гүйцэтгэх гэрээний олон улсын эрх зүйн зохицуулалт хийх зорилготой ЮНИСТРАЛ², НҮБ-ын Европын эдийн засгийн комисс³ зэргийг энд дурдаж болно.

Харин барилгын ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, зөвлөмжийн шинжтэй гэрээнүүд бий. Тухайлбал, ENAA – Японы инженерийн хөгжлийн нийгэмлэг, FIDIC – Зөвлөх инженерүүдийн олон улсын холбоо, ICE – ИБНВУ-ын Хувийн инженерүүдийн институт, JCT – Нэгдсэн гэрээний трибуналь зэрэг нь гэрээний загварыг зөвлөмж маягаар гаргасан байна.

Ажил гүйцэтгэх гэрээний эрх зүйн зохицуулалтыг агуулсан үндсэн эх сурвалж:

1. АНУ-ын хувьд: АНУ-ын Үндсэн хууль 1787 он, Муж улс бүрийн Үндсэн хууль, Гэрээний тухай муж улсуудын хууль, Шүүхийн жишиг.

2. ХБНГУ-ын хувьд: Иргэний хууль 1896 он; 2 дугаар дэвтэрт /Үүргийн эрх зүй/ аливаа гэрээ байгуулах, биелүүлэхэд хамаарах нийтлэг журам, тэдгээрийн тодорхой төрөл буюу ажил гүйцэтгэх гэрээг

зохицуулсан хэм хэмжээг агуулсан байна. Гэрээний нийтлэг нөхцөлийн тухай хууль 1978 он.

3. ОХУ-ын хувьд: Иргэний кодекси 1995 он, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль 1992 он.

4. БНХАУ-ын хувьд: Үндсэн хууль 1993 он, Иргэний эрх зүйн нийтлэг үндэслэл 1986 он, БНХАУ-ын Гэрээний тухай хууль 1999 он.

5. Монгол Улсын хувьд: Иргэний хууль 2002 он, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль 1994 он, Барилгын тухай хууль 1998 он, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль 1999 он.

Дараах харьцуулалтын хүрээнд бусад улсын хувьд Монгол Улсын ажил гүйцэтгэх гэрээний заалтаас ялгагдах зохицуулалтыг авч үзэж оруулсан болно.

А/ Ажил гүйцэтгэх гэрээний хамрах хүрээ:

ХБНГУ-ын эх сурвалжид⁴: Ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээний хувьд ерөнхий зохицуулалттай байна. Гэрээг бичгээр байгуулсан тохиолдолд л талуудад үүрэг үүсэх бөгөөд эс бөгөөс талуудын саналыг заавал биелүүлэх албагүй болно. Тухайн гэрээнд хэрэглэгдсэн бичиг баримт, бусад зааврыг өөр гэрээнд хэрэглэхийг хориглоно.

ОХУ-ын Иргэний хуульд⁵: Ажил-гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэх ажлын үнийг эсвэл үнийг тодорхойлох аргыг заавал тусгах ёстой. Санхүүгийн тооцоог байгууллага өөрийн хөрөнгөөр; захиалагчийн зээлийн хөрөнгөөр /банкны хөрөнгө байж болно/; мөн

захиалагчийн худалдан авсан акцийн хөрөнгөөр хийж болно.

АНУ-ын эх сурвалжид⁶: Гэрээний эрх зүйн судлаач Самуэль Виллестоны хэлцлийн тодорхойлолт ажиг гүйцэтгэх гэрээнд ч мөн хамаарах бөгөөд муж улс бүр өөрийн хуулиараа харилцан адилгүй нарийвчилсан зохицуулалт хийж болдог.

Хэлцэл нь амлалт буюу амлалтуудын нийлэмж бөгөөд тэдгээрийн гүйцэтгэлийг хууль, зарим тохиолдолд үүрэг гэж үзнэ⁷. Амлалтыг эс гүйцэтгэвэл хуулиар нэхэмжлэл гаргаж болно гэж тус тус томъёолсон байна.⁸

Харьцуулах гэж буй хүрээнд, АНУ, ОХУ, ХБНГУ, БНХАУ, Монгол Улсын ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтаас нэлээд өвөрмөц, ялгаатай ойлголтуудыг дараах байдлаар гаргах нь харьцуулахад илүү дөхөмтэй хэмээн үзэж байна. Харьцуулалтыг ФИДИК-ийн барилгын ажил гүйцэтгэх гэрээтэй уялдуулан дүгнэлт хийх юм.

УНИДРОУ-ын олон улсын арилжааны гэрээний зарчмын дагуу Contra Proferentem зарчим⁹ үйлчлэх боломжтой. Энэ нь: хэрэв ал нэг талын гаргасан гэрээний нөхцөл тодорхой бус бол уг нөхцөлийг тухайн талын ашиг сонирхлын эсрэг тайлбарлаж болно. Эндээс дүгнэвэл, талуудыг гэрээ байгуулах шатанд хариуцлага оногдох зарчим үйлчлэх бөгөөд маргаанаас зайлсхийх шуурхай арга байж болох тайлтай. Тиймд гэрээний нөхцөл тодорхой, хоёрдмол утгагүй байх хэрэгтэй.

БНХАУ-ын эх сурвалжид¹⁰: Гэрээний зүйл, тоо хэмжээ, чанар, хөлс, ажлын арга, материал нийлүүлэх, гүйцэтгэх хугацаа, шалгалт хийгдэх арга, хэрэглэгдэх стандарт зэрэг нөхцөлийг агуулсан ажил бүтээх, турших, болосруулах зэрэг ажил багтана.⁸

Б/ Барилгын ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой зохицуулалт:

ХБНГУ-ын эх сурвалжид¹¹: Өгсөн мэдээллийг шалгах эсэх талаар мөн ярилцан тохиролцоно. Барилгын ажил гүйцэтгэх гэрээний санал заавал биелүүлэх албагүй байдаг. Дүрслэл, шугам зураг, жин, хэмжил зүйн зэрэг саналуудыг эд хөрөнгийн бичиг баримтад заавал биелүүлэхтэй холбоогүй байдлаар тогтоодог. Талуудын санал болон бүх

¹ Монгол Улсын шинэ иргэний эрх зүй. Дэд дэвтэр. УБ., 2005 он. 154 дэх тал.

² Зөвхөн 1981 онд эрх зүйн зохицуулалт хийж байжээ.

³ 1979 онд эрх зүйн зохицуулалт хийсэн баримт байна.

⁴ Leverkusen Institute-ээс гаргасан мэдээ January 2004.

⁵ Гэрээний тухай хоёрдогч хуулийн /Second Restatement on Contract/ 1 дүгээр зүйл.

⁶ Т.Антангэрэл. "Харьцуулсан судалгаа: Хэлцэл". "Legis" сэтгүүл. №2(3). 2003 он. 4 дүгээр сар. 42 дахь тал.

⁷ УНИДРОУ-ийн олон улсын арилжааны гэрээний зарчим. 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг.

⁸ <http://www.unidroit.org/english/home.htm>

⁹ БНХАУ-ын Гэрээний тухай хуулийн 252 дугаар зүйл.

тооцоо, загвар гаргах, шугам зураг зэрэг нь бичгээр зөвшилцөөгүй бол гуравдагч этгээдээр хийлгэх буюу дахин зохиож болохгүй бөгөөд ажил гүйцэтгэлчийн хөрөнгөөр гүйцэтгэнэ. Уг бичиг баримтууд нь зөвхөн гэрээний хүрээнд хэрэглэгдэнэ; ялангуяа, ижил буюу төстэй бүтээгдэхүүн хийхэд хэрэглэгдэхгүй. Захиалагчийн гаргасан бичгээр үйлдсэн захиалга нь сүүлд нь заавал биелэгдэнэ. Энэ гэрээ нь Ажил гүйцэтгэгч захиалгыг бичгээр хүлээн авах хүртэл хэлбэрээ олоогүй байх болно. Энэхүү гэрээний агуулга нь хожим нь хоёр талын хооронд зөвхөн харилцан бичгээр гэрээ байгуулснаар өөрчлөгдөж болно.

Өөрөөр хэлбэл барилгын ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчийн заавар, зураг төслийг ажил гүйцэтгэгч өөрт хэлбэрээр хүлээн авч, хүлээн авах боломжтой хэмээн акцент гаргаснаар гэрээ байгуулагдах юм.

ОХУ-ын эх сурвалжид: Их барилга гэдэг нь үйлдвэрийн болон үйлдвэрийн бус санд тулгуурлан шинээр болон орчин үеийн загвараар бүтээгдэхэд чиглэсэн хуулийн этгээд, иргэн, өөрөө үйлдвэрх газрын байгууллага, төрийн байгууллагын үйл ажиллагаа юм. Их барилгын ажил нь төсөл, хайгуул шинжилгээний ажил гүйцэтгэлтэй холбогдож байдаг. Энэ нь техникийн шинжтэй ажил буюу барилга, угсралт /монтаж/ хийх, ашиглалтад оруулахтай холбоотой ажиллагаа болон бусад нарийн мэргэжлийн ажил хийх бичиг баримт бэлтгэдэгтэй холбоотой. Барилгын ажлын объект нь тодорхой төсөл, төсвийн үндсэн дээр баригдсан барилга байдаг. Их барилгын ажил нь шинэ барилга барих, өргөтгөх, шинэ техник ашиглан сэргээх, орчин үеийн болгосон барилга байна.

Энэхүү гэрээг зогсоох олон үндэслэл бий: барилгыг гэмтлээс хамгаалах зорилгоор түр зогсоох, талуудын үүргийн зөрчил гэх мэт. Хэрэв барилгын ажлын явцад сантехник, цахилгааны зэрэг зөрчил гарвал эрх бүхий байгууллагын шийдвэрээр гэрээг зогсоодог байна.

АНУ-ын эрдэмтдийн бүтээлд: Construction Contract гэх

ойлголтдоо "Building contract", "Engineering contract"-ийг багтаан ойлгодог байна. Энэ нь уг гэрээний техник шинжтэй холбоотой байна. Барилгын гэрээ нь ихэвчлэн бүтцийн шинжийг зааж байхад инженерийн гэрээ нь барилгын угсралтын ажилтай холбогддог байна.¹ Ажил гүйцэтгэх гэрээгээр захиалагчийн худалдан авсан бүтээгдэхүүний чанарын асуудлыг хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулиар зохицуулаж, хамгаалсан байна. Мөн боломжгүй хугацаанд "хэтэрхий давасан байдлаар хийгдсэн гэрээ"-г хүчингүйд тооцдог.

Их барилгын ажил гүйцэтгэх гэрээ /Construction contract/-г байгуулахад ажлын хүрээ хэмжээ, үнэ, гүйцэтгэх хугацаа, зураг, гүйцэтгэлийн шалгуурын талаар хэлэлцэх шаардлагатай болно.

Энэ сэдвийн хүрээнд, ФИДИК-ийн гэрээ² Монгол Улсын Иргэний хуультай харьцуулбал дараах дүгнэлт, санал гарч байна. Үүнд:

Ажил эхлэх өдөр: ФИДИК-ийн нөхцөлд - гэрээ нь хүчин төгөлдөр болсноос хойш буюу гэрээний талуудын зөвшөөрсөн өөр нэг өдрөөс эхлэн 14 хоногийн хугацааг ойлгоно. Монгол Улсын Иргэний хуульд - гэрээний гүйцэтгэл эхлэх хугацааг нарийн заагаагүй, гэрээгээр талууд хугацааг тохиролцож болох боловч ихэнх тохиолдолд гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээний үүрэг талуудад ирж, гэрээ хүчин төгөлдөр болмогч нэн даруй гүйцэтгэн, эхлэх хугацааг тоолдог практиктэй байна. Нэн даруй гэдгийг ихэд хонго гэж ойлгох нь тодорхой бүс.

Дэд гэрээ байгуулах: ФИДИК-ийн нөхцөлд - ажил гүйцэтгэгч бүх ажлын хувьд дэд гэрээ байгуулж болохгүй. Ажил гүйцэтгэгч захиалагчийн зөвшөөрөлгүйгээр ажлын нэг хэсгийн хувьд дэд гэрээ байгуулж болохгүй. Монгол Улсын Иргэний хуульд - Дэд гэрээ байгуулж ажиллах боловч тухайн ажлыг бүхэлд нь дэд ажил гүйцэтгэгчид шилжүүлэх явдал хориглогдоогүй, гагцхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн ажлын хувьд бүрэн

хариуцлагыг захиалагчийн өмнө хүлээнэ.

Гүйцэтгэлийн аюулгүй байдал: ФИДИК-ийн нөхцөлд - гэрээний хавсралтад заасан бол, ажил гүйцэтгэгч нь захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гуравдагч талаас ажлын гүйцэтгэлийн аюулгүй байдлын талаарх баримтыг ажил эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор захиалагчид хүргэнэ. Энэ нь тухайн ажлын хувьд туслах ажил гүйцэтгэгч тухайн аюулгүй байдлынхаа төлөө захиалагчийн ч өмнө хариуцлага хүлээж буйгаар манай хуулийн заалтаас ялгаатай байна.

В/ Гэрээний оролцогчдын хүлээх үүргийн онцлог, ажлын чанар:

ХБНГУ-ын эх сурвалжид: Гэрээг цуцлах буюу өөрчлөхөд талууд заавал бичгээр харилцан тохиролцож ёстой. Гэрээнээс хойш 5 жилийн турш гэрээний талаарх нууцлалыг хамгаалах үүргийг талууд хүлээнэ.

Ажлын чанарыг Иргэний хуулийн дагуу хэвийн түвшинд тодорхойлох бөгөөд ялимгүй доголдол ажлын чанарт нөлөөлөхгүй гэж үздэг байна.

ОХУ-ын Иргэний хуульд: Хэрэв ажил гүйцэтгэгч нь захиалагчийн материалаар ажил гүйцэтгэхээр урьдчилан тохиролцсон бол захиалагчийн материалыг аль болох хямгатай ашиглах үүрэг хүлээдэг байна.³

Захиалагчаас хүлээн авсан материал, тоног төхөөрөмж нь гэрээгээр тохиролцсон ажлыг гүйцэтгэхэд шаардлага хангахгүй, тохирохгүй, тааламжгүй, аюултай тохиолдолд ажил гүйцэтгэгч нэн даруй мэдэгдэх, мэдээлэх үүрэгтэй.⁴ Энэ нь манай Иргэний хуультай ижил зохицуулалт байна.

Ажил гүйцэтгэгч чанарын шаардлага хангахгүй тоног төхөөрөмж, материалаар ажил гүйцэтгэх, түүний буруутай үйлдлээс болж ажлын үр дүн гэрээнд заасан шаардлагыг хангахгүй тохиолдолд гүйцэтгэгчийн ажлын хохирлын нөхөн төлөхийн зэрэгцээ гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.⁵

Ажлын чанар нь гэрээнд тодорхойлсны дагуу байх бөгөөд энгийн шаардлагад нийцсэн байх ёстой. Ажил нь хавсралтад заагдсан зураг, гүйцэтгэлийн загвар тодорхойлсноор байх ёстой. Гэрээндээ чанарын баталгааг

¹ Chitty on Contracts. Volume 2. Specific Contracts. Page 37-001.

² <http://www.fidic.com>

³ ОХУ-ын Иргэний кодексын 713 дугаар зүйл.

⁴ Уг кодексын 716 дугаар зүйл.

⁵ Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации. Часть вторая. Москва. 1997г. с. 275.

тодорхой хугацаагаар зааж өгөөгүй бол 2 жилээс ихгүй хугацаа байх нь тохиромжтой гэж ном, бүтээлүүдэд дурдсан байна. ОХУ-ын Иргэний кодекс мөн чанарын баталгааны талаар тодорхой хугацаа зааж өгөөгүй юм.

БНХАУ-ын эх сурвалжид: Ажил гүйцэтгэгч захиалагчийн шаардлагад нийцүүлэн итгэл дааж ажиллана, захиалагчийн зөвшөөрөлгүйгээр техник материал авч, хуулбарлаж, хадгалж болохгүй.

Ажил гүйцэтгэгч шаардлага хангахгүй этгээдтэй барилгын ажлын аль нэг хэсгийн талаар дэд гэрээ байгуулахыг хориглоно. Туслах ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээний ажлын талаар цаашд дэд гэрээ байгуулахыг хориглоно.

Ажил гүйцэтгэгчийн дизайны хувьд хүлээх үүрэг: ФИДИК-ийн нөхцөлд – гэрээний хавсралтад зааснаар, ажил гүйцэтгэгч нь тодорхойлсон хүрээнд дизайны ажлыг хийж гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэгч бэлтгэсэн бүх дизайнаа захиалагчид нэн даруй танилцуулна. Захиалагч хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гэрээтэй зөрчилдөх зүйл байгаа эсэхийг хянаж, дээрх шалтгаанаар дизайнаас татгалзаж болно. Ажил гүйцэтгэгч 14 хоногийн дотор тухайн дизайны ямар нэг элементийг хийхгүй байж, захиалагчийн зөвшөөрлийг хүлээнэ. Татгалзсан дизайныг нэн даруй засч, нэмэлт өөрчлөлт оруулж, дахин танилцуулна. Шаардлагатай бол ажил гүйцэтгэгч бүх дизайны тооцоог гаргаж өгнө. Энд ажил гүйцэтгэгч төсөв гаргахад голлох үүрэгтэйг харуулж байна. Харин манай хуулиар төсвийг талууд харилцан тохиролцон тогтоох бөгөөд захиалагч тал голлох үүрэгтэй оролцдог¹ юм.

АНУ-ын эх сурвалжид: Ажил гүйцэтгэгч нь инженерийн өгсөн зааврыг хатуу дагах ёстой. Ажлын чанарын талаар талууд тохиролцох бөгөөд хуулиар нарийн тогтоосон нэгдмэл ойлголт үгүй байна.

ФИДИК-ийн нөхцөлд – төлбөр төлөх хугац, журамд ажил гүйцэтгэгч, захиалагч талын аль аль нь оролцох бөгөөд төлбөрийг эхний хагасын, хоёр дахь хагасын, сүүлийн төлбөр гэж ангилдаг байна.

Эхний хагасын төлбөр: захиалагч ажлыг хүлээн авч тэмдэглэл хийсний дараа 14 хоногийн дотор захиалагч ажил гүйцэтгэгчид эхний хагасын төлбөрийг төлнө.

Хоёр дахь хагасын төлбөр: Үлдсэн төлбөрийг хавсралтад заасан хугацааг өнгөрсний дараа эсвэл дутагдлыг зассаны дараа, ажлыг бүрэн гүйцэтгэснээс хойш 14 хоногийн дотор дутагдлыг зассанаар захиалагч ажил гүйцэтгэгчид төлнө.

Сүүлийн төлбөр: хамгийн сүүлийн үйл явдал болсноос хойш 42 хоногийн дотор ажил гүйцэтгэгч нь захиалагчид гэрээний эцсийн үнэлгээтэй холбоотой шаардлагатай бичиг баримтын хамт сүүлийн тооцоог танилцуулна.

Сүүлийн тооцоог танилцуулснаас хойш 28 хоногийн дотор захиалагч ажил гүйцэтгэгчид холбогдох төлбөрийг төлнө. Хэрэв захиалагч ажил гүйцэтгэгчийн эцсийн төлбөрийн талаар тооцооны нэг хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй бол тооцоо хийх үед зөвшөөрөхгүй байгаа шалтгаанаа бичнэ. Иймд төлбөр хийх журамд хоёр тал оролцож, тооцоог ажил гүйцэтгэгч гаргаж, захиалагч хянан зөвшөөрснөөр төлбөрийг төлдөг байна.

Ажил гүйцэтгэгч үүргээ үл биелүүлэх: ажил гүйцэтгэгч ажлыг орхин явсан бол захиалагчийн заавраас татгалзах, эсвэл хойшлуулалгүйгээр, түргэн хугацаанд ажиллаагүй бол гэрээний зөрчлийн талаар бичгээр гомдол гаргасныг үл харгалзан захиалагч энэхүү зүйлд заасан үл биелүүсэнтэй нь холбоотой тэмдэглэл өгч болно.

Ажил гүйцэтгэгч захиалагчийн тэмдэглэлийг авснаас хойш 14 хоногийн дотор доголдлыг засах бүхий л боломжит алхмыг авч хэрэгжүүлээгүй бол захиалагч дараагийн 21 хоногийн дотор хоёр дахь тэмдэглэлийг өгөөд, гэрээг цуцалж болно. Үүгээр ажил гүйцэтгэгч тухайн байрлал, тоног төхөөрмжөөс чөлөөлөгдөх бөгөөд хоёр дахь тэмдэглэлд заасан ажил гүйцэтгэгчийн тоног төхөөрмжийг уг ажил дуусах хүртэл хэрэглэнэ.

Захиалагч үүргээ үл биелүүлэх: захиалагч гэрээнд заасан төлбөрөө

төлөөгүй бол гэрээний зөрчлийн талаар гаргасан бичгэн гомдлыг үл харгалзан ажил гүйцэтгэгч үүргээ үл биелүүлсэн талаарх энэ зүйлтэй холбоотой тэмдэглэлийг өгч болно. Захиалагч энэхүү тэмдэглэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор доголдлоо засаагүй бол ажил гүйцэтгэгч ажлын бүхий л гүйцэтгэлээс татгалзаж болно.

Ажил гүйцэтгэгчийн тэмдэглэлийг хүлээн авснаас хойш доголдлоо 28 хоногийн дотор засаагүй бол ажил гүйцэтгэгч дараагийн 21 хоногийн дотор хоёр дахь тэмдэглэлийг өгч, гэрээг цуцалж болно. Үүгээр ажил гүйцэтгэгч тухайн байрлалаас чөлөөлөгдөнө. Энд тодорхой хугацаа заасан нь маргаан үүсэх, хохирлыг тодорхой хэмжээнд барих боломжийг олгож байгаа зохицуулалт юм.

Гэрээг цуцлахтай холбоотой төлбөр: гэрээг цуцалсны дараа ажил гүйцэтгэгч тухайн ажлын байрлалд бодитоор шилжүүлсэн материал, тоног төхөөрмж, гүйцэтгэсэн ажлын төлөгдөөгүй төлбөрийг авах эрхтэй.

Хэрэв захиалагч ажил гүйцэтгэгчийн үүргээ биелүүлээгүйгээс болж гэрээг цуцалсан бол захиалагч гэрээг цуцлах өдөр гүйцэтгээгүй байсан үнийн дүнийн 20 хувийн дүнгээр төлбөр авах эрхтэй.

Хэрэв ажил гүйцэтгэгч захиалагчийн үүргээ биелүүлээгүйгээс болж гэрээг цуцалсан бол ажил гүйцэтгэгч татгалзсан үнэ болон гэрээг цуцлах өдөр гүйцэтгээгүй байсан ажлын үнэлгээний 10 хувийг авч байрлалыг орхих эрхтэй.

Энэхүү төлбөрийн үүрэг нь талуудыг шүүх, арбитрад хандан, хохирлыг дотоод итгэлээр шийдэх асуудлаас зайлсхийхэд тусалсан ФИДИК-ийн заалт байдгийг гэрээ байгуулагч талууд анхаарч болох юм.

Ажил гүйцэтгэх гэрээний загварт хийсэн дүн шинжилгээ

Нэг. ХБНГУ-ын гэрээний загварыг Монгол Улсын ажил гүйцэтгэх гэрээний загвартай² харьцуулан үзвэл, дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

1. Германы хууль тогтоомжид захиалагч төлбөр төлөх аргыг нарийвчлан зааж өгдөг байна. Харин Монгол Улсын ажил гүйцэтгэх гэрээнд ажлын

¹ Sweet E Maxwell, Chitty on Contracts, Volume 2, Specific contracts, 37-095.

² С.Будрагчаа "Гэрээ" үлгэрчилсэн загварт орсон ажил гүйцэтгэх гэрээ хэмээх бүлгийн гэрээний үйлдлийг тоймлон харьцуулав.

гүйцэтгэлийг хүлээн авсны дараа санхүүжилтийг банкиар дамжуулан төлөхөөр заасан байна.

2. Германы загварт хариуцлагын талаарх гомдлын шаардлага гаргахад үл хамаарах нөхцөлийг заасан байна. Монгол Улсын хувьд ийм нөхцөлийг гэрээнд тусгах тохиолдол тун ховор байна. Энэ нь Иргэний хуулийн үүргийн эрх зүйгээр зохицуулагдах бөгөөд гэрээний нэг талын санаатай үйлдлээс үүссэн хохирлыг тодорхой зааж¹, бусад нөхцөлийг иргэний хуулийн нийтлэг зохицуулалтаас харах хэрэгтэй болж байна.

3. Германы гэрээний загвар нь улс хоорондын эрх зүйн зөрчилдөөний хэм хэмжээнээс урьдчилан сэргийлж, гадаад элемент бүхий харилцаанд хууль хэрэглэх болон хууль үйлчлэх газрыг ХБНГУ-ын хууль, ХБНГУ-ын тухайн хот хэмээн заах нь элбэг ажээ. Харин Монгол Улсын гэрээнд ийм заалтууд оруулах тохиолдол нь ховор хэмээн дүгнэж болно. Энд Иргэний хуулийн 549 дүгээр зүйлийн 549.5 дахь хэсгээр шийдэгдэх боломжтой. Нэмж хэлэхэд гэрээнд үүсэх аливаа маргааныг шийдвэрлэх арбитрыг эсвэл шүүхийг тодорхой заах хэрэгтэй. Монгол Улсын зарим гэрээнд маргаан гарвал шүүх, арбитраар шийдвэрлэнэ гэж байна. Энэ нь буруу бөгөөд аль нэгийг нь тодорхой заах хэрэгтэй юм.

Хоёр. ФИДИК-ийн Барилгын дизайны ажлын гэрээний нөхцлүүд. Монгол Улсын Иргэний хуулийн хувьд шинэлэг байж болох зохицуулалтыг судлан үзье.

Нууц, итгэмжт деталь ажиллагаа нь ажил гүйцэтгэлийн технологийг хамгаалсан зохицуулалт юм. Үүнтэй төстэй байдлаар олон улсын хэмжээнд заншлын шинжтэй үйлчилдэг, талууд гэрээндээ тохиролцоо болох УИНДРОУ-ийн олон улсын арилжааны гэрээний зарчмын 2.1.16 дугаар заалтад "Аль нэг тал хэлэлцээний үед нууц мэдээлэл

өгсөн бол гэрээ байгуулсан эсэхээс үл хамаарч нөгөө тал түүнийг задруулахгүй, хувийн зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй. Хэрэв энэ үүргээ зөрчсөн бол бусад талд учирсан хохирлыг төлнө"² гэжээ.

Ажил гүйцэтгэгч гүйцэтгэлийн аюулгүй байдлыг хангахад голлох үүрэгтэй бөгөөд туслан гүйцэтгэгч хариуцлага хүлээж, үүргийг хуваарилан авдагаар захиалагчийн өмнө хариуцлага хүлээх гол субъект болдог онцлогтой. Байгаль орчныг хамгаалах асуудал ажил гүйцэтгэгчийн үүрэг болж заавал ордог байна.

Барилгын дизайны ажил хийх гэрээний хувьд барилгын бүтцийн бичиг баримтууд, техникийн стандарт, зохицуулалтууд, загварууд, барилгын зураг, гар арга, патентын эрх зэрэг ойлголтууд гарч ирж, гэрээнд тусгадаг нь нарийн зохицуулалт байгааг харуулж байна.

Мөн хуулийн өөрчлөлт, мөнгөний ханшны өөрчлөлт гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцох, мөн гэрээний аль нэг нөхцөлийг өөрчлөх эрх талуудад байдаг зэрэг онцлог зохицуулалттай байна.

Гурав. ОХУ-ын хувьд ажил гүйцэтгэх гэрээ, барилгын ажил гүйцэтгэх гэрээний загвар нь дотроо хэд хэдэн хувилбартайгаар гэрээ байгуулагч талуудад санал болгодог нь сайшаалтай юм.

Дүгнэлт

Хамгийн өргөн хүрээнд практик шаардлагаа харуулсан гэрээ бол ажил гүйцэтгэх гэрээ мөн гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Монгол Улсын гадаад элемент бүхий хувийн эрх зүйн харилцаанд дахь ажил гүйцэтгэх гэрээний онцлог, хэрэглээг харгалзан, үүний дээр гадаад улсуудын жишиг, олон улсын практикт хүлээн зөвшөөрөгдөж, тогтсон зөвлөмж, загварыг харуулан дүгнэлт хийхийг зорьсон болно.

Монгол Улсын Иргэний хуулийн 31 дүгээр бүлэг Ажил гүйцэтгэх гэрээ, мөн II хэсэг Үүрэг хэмээх бүлэг хэсгээр холбогдох зохицуулалтыг императив болон

диспозитив хэм хэмжээний түвшинд гаргасан байна. Монгол Улсын Барилгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл илүү боловсронгуй болж байна. Барилгын тухай хууль 1998 оны 8 дугаар сарын 7-ны өдөр батлагдан 2000, 2001, 2003, онд нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдүүлснээр манай улсад барилга барих ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах эдийн засаг, хууль эрх зүйн үндэс бий болсон юм. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн үйлчлэлийг сайжруулах зорилгоор зарим зохицуулалтгүй орхигдсон зайлшгүй хуульчлах шаардлагатай харилцааг хуульчлах, барилгын салбарт үйлчилж байгаа олон дүрэм, журам, заавраас хуулийн хүрээнд шийдэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх, зарим тодорхой бус, ойлгомжгүй бүрхэг заалтууд, нэр томъёог тодруулан нарийвчлан томъёолох, түүнчлэн бусад хуультай уялдуулах чиглэлээр зарим өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

ОХУ-ын хувьд их барилгын ажил гүйцэтгэх гэрээ гэж нэрлэгдэж буй гэрээ нь АНУ, ХБНГУ-ын Construction contract гэсэн нэршилтэй дүйх бөгөөд энэ нь барилгын ажил гүйцэтгэх гэрээг бодвол илүү өргөн цогц шинжтэй гэрээ болж байна.

Иймд олон улсын хувийн эрх зүй дэх ажил гүйцэтгэх гэрээний бусад төсөөтэй гэрээнээс ялгагдах шинжийг улам бүр тодорхой болгох, талуудын дунд маргаан үүсэхээс сэргийлэх, сул талыг бий болгохгүй байх зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжид хийсэн дүгнэлт, саналуудыг дараах байдлаар гаргасан болно.

Нэг. Гэрээ байгуулагч талуудад өгөх зөвлөмж

ЗӨВЛӨМЖ 1: Барилгын АГТ нь өөрийн гэсэн онцлог гүйцэтгэлтэй болохыг судлагааны ажлаас харж болохоор байгаа учир боловсронгуй болгох шаардлагатай. Тухайлбал, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, тэр дундаа инженерийн, дизайны гэрээг нийтлэг байдлаар хийх нь тохиромжгүй бөгөөд тус бүрийн онцлогийг агуулсан заалтыг ФИДИК-ийн гэрээний ерөнхий нөхцлөөс авч тусгах нь ач холбогдолтой байна. Манай барилгын компаниуд мөн

¹ Монгол Улсын Иргэний хуулийн 219 дүгээр зүйл.

² Олон Улсын хувийн эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2004 он. УИНДРОУ-ийн олон улсын арилжааны гэрээний зарчим. 366 дахь тал.

өөрсдийн гэрээний загвартай байх боловч эрсдлийг хуваарилах асуудал дээр ажил гүйцэтгэгч талд ихээхэн хариуцлага хүлээлгэж байна. Талууд тохиролцоо олон хувилбарыг гаргаж болно. Үүнд:

Хувилбар 1: Ажлын үр дүнг хүлээлгэн өгөхөөс өмнө форс мажорын тохиолдол, байгалийн гэнэтийн үзэгдэл зэрэг саадын үед эрсдлийг захиалагч тал бүрэн хариуцах буюу 50 хувиар хуваан хариуцаж болно.

Хувилбар 2: мөн ажлын үр дүнг хүлээлгэн өгөхөөс өмнө материал уствал үг материалыг гаргасан тал эрсдлийг хүлээж болно.

Хувилбар 3: ажлын үр дүнг хүлээлгэн өгөхөөс өмнө талуудын буруутай үйлдлээс үл шалтгаалан ажлын үр дүнд доголдолд хүрвэл гэрээнээс татгалзах эрх талуудад бүрэн байх бөгөөд урьдчилан сэргийлж, талууд тохиролцон даатгалд хамруулах боломжтой.

ЗӨВЛӨМЖ 2: Өнөөгийн практикт гэрээний загварыг бэлэн хуулбарлаж, гэрээ байгуулж буй иргэдийн сэтгэхүйг харгалзан, гэрээний загварт өөрчлөлт оруулж, хамгаалгаа гадаадын иргэдтэй байгуулж буй гэрээнд хэрэглэх эрх зүй, шүүх буюу арбитрын харьяаллыг тогтоох нь ач холбогдолтой. Үүнд байгаль орчныг хамгаалах, даатгал, патент, үйлдвэрийн өмчийн эрх, өөрчлөх эрх зэргийг тусгах нь талуудад төдийгүй гуравдагч этгээдэд ач холбогдолтой заалт болох аж. Өөрөөр хэлбэл, гэрээний диспозитив заалтыг гэрээнд альтернатив эрх байдлаар оруулах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ 3: Барилгын ажил гүйцэтгэх гэрээний эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгааг харгалзан ОХУ-ын эрх зүйн зохицуулалтаас онолын тайлбар, ойлголтыг авч үзэж гэрээний харилцаанд анализ хийхэд Монгол Улсын хувьд тохиромжтой байна. Үүнээс тохиромжтой арга бол талууд гэрээг байгуулахад хамгийн тохиромжтой, заалтуудыг оруулдаг байх хэрэгтэй. Үүнд: Ажил гүйцэтгэгч, захиалагчид бий болсон зах зээлийн байрлалын онцлогийг бичиг баримтдаа тусгах, олон жишиг хэрэгт тохирсон заалтуудыг оруулах, заалт хоорондын сөрөгөлцсөн тайлбар, ишлэлийг хамгийн бага түвшинд

байлгах, шаардлагуудыг давтахгаас зайлсхийх гэх мэт.

ЗӨВЛӨМЖ 4: Хамгийн гол нь томоохон гэрээний хувьд нийтлэг нөхцөл, онцгой нөхцөл, хавсралт, арбитрын хэлэлцээр зэргийг давхар байгуулах нь маргаан үүсхэн тохиолдолд ч хугацаа алдалгүй шийдвэрлэхэд дөхөмтэй байх болно.

Хоёр. Иргэний хуулийг боловсронгуй болгох чиглэлээрх санал

САНАЛ 1: Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой бүх харилцааг хуульчилж өгөх шаардлагагүй учир АНУ-ын зохицуулалттай ижил гэрээний чөлөөт байдлыг эрхэмлэх нь зүйтэй. Ажил гүйцэтгэх гэрээг байгуулахад тулгарч буй гол бэрхшээл нь ажил гүйцэтгэх гэрээний талаарх заалтад гэрээний зүйлийн талаарх ойлголтыг тодорхой болгох хэрэгтэй байна. Үүнд 343 дугаар зүйлийн 343.2 дахь хэсэгт гүйцэтгэсэн ажлын үр дүн байна хэмээсэн боловч энэ зүйл нь төрлийн шинжээр тодорхойлогдохгүй, тооны хувьд цөөн байдаг онцлогийг хуульчилж өгөх нь маргаан гарах явдлыг багасгана. Энэ нь худалдах, худалдан авах гэрээнээс ялгах сайн талтай юм.

САНАЛ 2: ХБНГУ-ын зохицуулалтад тусгагдсан нэг давуу тал болох ажил гүйцэтгэгч нууцлалын хариуцлага хүлээх үүрэгтэй болгох нь ашигтай. ХБНГУ-ын хувьд 5 жил өнгөрсний дараа нууцлалын хүчинтэй байх хугацааг дуусгавар болгодогийг дээр дурдсан. Мөн БНХАУ-ын хувьд ч гэрээний төслийн загвар зэргийг хуулбарлахгүй, дуурайхгүй байх үүрэг хүлээлгэдэг нь аливаа зөрчлөөс шууд хамгаалж өгч байна. Мөн ФИДИК-т нууц, итгэмжит деталь ажиллагааг оруулсан байдгийг анхаарах нь зүйтэй.

САНАЛ 3: Иргэний хуулийн 356 дугаар зүйлийн 356.1 дэх хэсэгт эрсдлийг ажил гүйцэтгэгч хүлээх императив заалт байгааг диспозитив заалт болгох. Өөрөөр хэлбэл, гэрээнд өөрөөр заагаагүй бол хэмээх хэсгийг энэхүү заалтын эхэнд оруулах нь зүйтэй. Учир нь ажил гүйцэтгэх гэрээний сул тал нь ажил гүйцэтгэгч байна. Энэ талд эрсдлийг

бүрэн оноох нь учир дутагдалтай. Талуудын чөлөөт сонголт хийх боломжийг олгох хэрэгтэй.

САНАЛ 4: Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт "Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацааг 1 жил байна" гэж заасан нь Монгол Улсын Иргэний хуулийн 349 дүгээр зүйлд ажил гүйцэтгэгчийн хариуцлагын талаар гомдлын шаардлага гаргах хугацааг 3 жил байхаар заасантай нийцэхгүй байгаа юм. Иймд Иргэний хуультай нийцүүлэн 3 жил хэмээн заах нь барилгын ажлын хувьд илүү нийцнэ.

Эцэст нь тэмдэглэхэд гэрээний ерөнхий нөхцөлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байдалтай нийцүүлж, эрхээ хамгаалах нь Монгол Улсыг бусад улсын хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчтэй харилцахад ихээхэн үр дүнтэй, маргаанаас зайлсхийх аргыг олоход туслах учиртай.



ГҮТГЭЛЭГ ТОЙРСОН МАРГААНТАЙ АСУУДАЛУУД

БНЭУ-ын Дэлигийн их сургуулийн Хуулийн сургуулийн
магистрант П.Өнөрмаа

1. Ерөнхий ойлголт, төрөл

Бусдыг гүтгэх үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх алхам анх XVI зуунд хийгджээ¹. Хүн төрсөн цагаасаа эхлэн нэр төрөө хамгаалах, хамгаалуулах эрхтэй. Цэвэр ариун нэр төр ямар ч эд баялгаас үнэтэй² тул ихэнх эрх зүйн системүүд үүнийг нэр төр, хувийн нууцад хамруулан үздэг. Хэдийгээр хүний нэр хүнд хуулиар хамгаалагдсан байдаг ч түүнд халдаж чадах эрх гэж бий. Тэр нь үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх юм. Энэ хоёр эрх хоёулаа Үндсэн хуулиар хамгаалагдсан байдаг. "Миний нэр төрд халдах эрх хэнбугайд ч байхгүй боловч миний талаар санал бодлоо илэрхийлэх бусдын эрхэнд би хориг тавьж яагаад ч чадахгүй. Гэгцхүү энэ хоёрын тэнцвэрт байдлыг бодит үнэн л хангана."³

Гүтгэлийн агуулга нь тухайн хүний ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагаа, бусад эрх ашигт хохирол учруулах мэдээлэл бүхий, нийгмийн зүгээс тухайн хүнийг үнэлэх үнэлэмжийг эрс бууруулахад чиглэсэн байдаг.⁴ Гүтгэлийн хоёр үндсэн төрөл бий. Үүнд:

- амаар;
- бичгээр.

Бусдыг бичгээр гүтгэнэ гэдэгт хууль ёсны баримт нотолгоогүйгээр тухайн хүн, байгууллагын талаар худал мэдээллийг зориуд, санаатайгаар хэвлэх, зурах, үзүүлэн баримал, чихмэл хийх үйлдлүүдийг тооцдог бол амаар гүтгэх хэлбэрт гүтгэсэн ариа, дийлэн зангаа буюу биеэр дүрслэх үйлдэл ордог.

Энэ хоёр хэлбэрийн аль нь илүү хор уршигтай болох талаар судлаачид маргалдсан хэвээр бөгөөд нэгдмэл зөвшилд хүрч чадаагүй байна.

Энэтхэгийн Эрүүгийн Хуульд гүтгэх гэмт хэргийн төрлийн ялгааг тусгайлан салган зүйлчлээгүй байдаг.⁵ Уг хуулийг бүтээгчид хүнийг

амаар, бичгээр гүтгэх нь адилхан хор уршигтай гэж үзсэн төдийгүй Английн Эрүүгийн хууль дахь гүтгэлгийн төрөл тус бүрд ялгамжтай ял оноох гэсэн санааг алдаатай хэмээн шүүмжилдэг.

2. Гүтүүлэгч буюу хохирогч хэн байх вэ?

А. Нас барсан хүнийг гүтгэх. Нас барсан хүний талаар худал мэдээлэл тараасан тохиолдолд нас барсан хүний өмнөөс шүүхэд хандах боломжгүй. Харин тухайн нас барсан хүний тухайн мэдээлэл нь өөр хэн нэгэн амьд хүний /ихэвчлэн төрөл садан г.м/ нэр төрд хохирол учруулсан бол тэр хүн шүүхэд хандаж учирсан хохиролоо арилгуулах, нэр төрөө сэргээлгэх эрхтэй. Харин манай зарим судлаачид нас барсан хүнийг гүтгэх нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гэж үздэг.⁶

Б. Хэсэг бүлэг хүмүүсийг гүтгэх. Жишээлбэл "Бүх шүүгчид хахууль авдаг" гэж хэлсний төлөө аль нэг шүүгч дангаараа өөрийг нь гүтгэсэн гэж үзэж шүүхэд хандах боломжгүй. Харин тухайн мэдээлэлд өөрийг нь илт онцгойлон нэрлэсэн бол сая шүүхэд хандах эрхтэй.

Харин уг гүтгэлгийн материал нь яригдаж буй хэсэг хүмүүсийн тухай үгүйлсэн хэдий ч түүнийг уншсан хэн бүхэнд гишүүн бүрийн үйлдэл хэмээн ойлгогдох илэрхий шинжтэй бол гүтгэлэгт хамрагдсан этгээд дангаараа зарга үүсгэх эрхтэй байдаг.

В. Компани болон Корпорацийг гүтгэх. Гүтгэлгийн улмаас компанийн эд хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаанд бодит хохирол учирсан бол хохиролоо нөхөн төлүүлэхээр шаардлага гаргах эрхтэй ба заавал ноцтой хохирол учирсан байх албагүй.

Г. Төрийн албан хаагч ба улс төрийн намыг гүтгэх. Аль ч ардчилсан гэгдэх нийгэмд төрд алба хашигч

шүүмжлэлээс ангид байх ёсгүй. Иймээс тэд "эмзэг арьстай" байх боломжгүй. Ихэнх тохиолдолд тэдний үйл ажиллагааны талаархи мэдээлэл нь шүүмжилсэн эсвэл гүтгэсэн мэт харагдах боловч үнэн хэрэгтээ бага ч атугай үнэний хувьтай байдаг. Харамсалтай нь мэдээлэл бүрийг тодорхой фактаар нотлох боломж хомс байдаг. Ард түмэнд үнэнийг хүргэх гэсэн оролдлого эцэстээ гүтгэлэг нэр зүүх нь олонтаа. Энэ үүднээс АНУ, Англи, Өмнөд Африк, Энэтхэг зэрэг оронд төрийн байгууллага, нутгийн удирдах байгууллага, бусад төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагууд өөрсдийнх нь үйл ажиллагааг гүтгэсэн хэмээн шүүхэд заргалдах эрхгүй байдаг байна.

Д. Албан хаагчийг гүтгэх. Гүтгэлэг гэгдэх мэдээлэл нь зохих баримтаар буюу бодит байдлаар үнэн болох нь тогтоогдвол хариуцагч тал нотлох үүрэг хүлээхгүй.

Ангилд аливаа нийгмийн тулгамдсан асуудлыг хөндсөн хэвлэл мэдээллийн чөлөөт дуу хоолойг хүндэтгэн үздэг ба энэ ч утгаараа тухайн мэдээллийг гүтгэлэг мөн эсэхийг нягтлан үзэхдээ 1. Тухайн мэдээлэл нь нийгмийн эрх ашгийг хэр хөндөж буй? 2. Мэдээллийн эх сурвалж юу болох? 3. Асуудлын нийгмийн ач холбогдол, 4. Тухайн асуудалд гүтгүүлэгч буюу хохирогчийн хийсэн тайлбар 5. Мэдээлэл хэвлэгдсэн цаг хугацаа, нөхцөл байдал, өгүүллийн өнгө зэргийг сайтар шинжлэн үздэг.

Ер нь сүүлийн үед гүтгэлгийн шинж чанартай гэгдэх мэдээллийг шинжлэн үзэхдээ ард түмэн бодит үнэнийг мэдэх эрхтэй байх зарчмыг шалгуур болгон үзэх хандлага өргөн дэлгэрч байна. Үнэнийг ил гаргах нь нийгмийн эрх ашигт нийцэх тохиолдолд уг үйлдэл нь гүтгэлэг болохгүй. Харин үүнийг хувь хүний нууцийг бүдүүлгээр дэлгэн харуулахад ашиглах нь эндүүрэл болох ба гагцхүү олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудалд авч үзэх нь зөв юм.



¹ W. Keeton, et, al, *Prosser and Keeton on the Law of Torts*, 1984, pp.773-78

² W. V. H. Rogers Winfield & Jolowicz on Tort, 15th edition, Sweet & Maxwell 1998

³ NoorMohd v. Mohd. Jiauddin, AIR 1992 MP244, p 249

⁴ Манай хуулинд мөн адил

⁵ С.Нарангэрэл "Монгол Улсын Эрүүгийн Эрх Зүй: Тусгай анги", 106 дахь тал

Монгол Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах зарим асуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1-ийн 4-т зааснаар Монгол Улсын Дээд Шүүх "Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах" эрхтэй юм. Энэ нь уг шүүх нь зөвхөн гарсан маргаанд тулгуурлаж шийдвэрээ гаргах ёстой ба гаргасан тайлбар нь зөвхөн тухайн маргаандаа (шаардлагатай бол төсөөтэй тохиолдолд) албан ёсны байх ёстой гэсэн үг юм. Гэтэл Улсын Их Хурал Шүүхийн тухай хуулийн 15.6.5-д "Үндсэн хуулиас бусад хуулийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг Улсын Дээд шүүх гаргана" гэж Үндсэн хуулийн заалтыг тодотгохдоо Улсын Дээд шүүхэд хэтэрхий их эрх мэдэл олгосон байна. Уг ёсондоо шүүх бол зөвхөн маргалдагч хоёр талын хэргийг шүүх байгууллага бөгөөд шүүх нь маргаанд тулгуурлаж шийдвэр, тайлбараа гаргах ёстой юм. Мөн Дээд шүүх л зөвхөн хуулийн тайлбар гаргах эрхтэй гэдэг нь бусад шатны шүүх тайлбар хийх эрхгүй. Дээд шүүхийн тайлбар байхгүй бол хэргийг шийдэж чадахгүй, энэ нь улмаар Дээд шүүхийн шат хүртэл давж заалдаж байж л тухайн хэрэг шийдвэрлэгдэхээс өөр гарцгүй болгож байна. Дээд шүүхийн гаргасан тайлбар хуулийн нэгэн адил хүчинтэй байдаг энэ үзэгдэл манай оронд 1990 оноос өмнө тогтсон ойлголт ба "одоогоор хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан цөөн тооны оронд үйлчилдэг". Тухайлбал, ОХУ энэ зохицуулалтаас татгалзсан байна. ХБНГУ-д Дээд шүүхийн тайлбар тус улсын бүх нутаг дэвсгэрт хуулийн нэгэн адил хүчинтэй гэдэг нь бусад шүүхийн чиг үүргийг үгүйсгэсэн, шүүгчийн хараат бус байдалд халдсан, хүний эрхийг зөрчсөн зохицуулалт гэж үздэг. Мөн нөгөө талаас нийгмийн харилцаа байнга хөгжиж байдаг учраас шүүх түүнийг



ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
Б.Гүнбилэг

тухайн тохиолдолд нь тайлбарлахаас бус байнга, бүх нийтээр заавал дагаж мөрдөх хүчинтэйгээр тайлбарлах ёсгүй юм. Жишээ нь: Компьютер гэдэг үгийг Дээд шүүхээр тайлбарлуулж, бүх нийтээр дагаж мөрдөх ямар ч боломжгүй. Гэтэл хуульд заасан эрх бүхий этгээд энэ үгийг тайлбарлуулахаар Дээд шүүхэд хандвал Дээд шүүх тайлбарлаж чадахгүй гэх эрх байхгүй, эрх байхгүй учраас хийдэлтэй тайлбар гаргах болж байгаа юм. Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2-т зааснаар "Иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаа Улсын дээд шүүхэд ирүүлнэ" гээд уг зүйлийн 7-д "Хуулийн тайлбарыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө" гэж заасан нь иргэд ямар нэгэн хэрэг үүсгэлгүйгээр Дээд шүүхээс чөлөөтэйгээр хуулийн зүйл, заалтыг хэрхэн ойлгох талаар тайлбар гаргуулахаар хүсэлт гаргах эрхтэй,

Дээд шүүхийн тайлбар хуулийн нэгэн адил хүчинтэй болж байгаа юм. Мөн Дээд шүүхийн тайлбар хуулийн нэг хэсэг болж, цаашилбал хуулийн нэгэн адил Монгол Улсын хууль үйлчилж буй орон зайд заавал дагаж мөрдөх хүчин чадалтай болж байна. Дээд шүүхийн тайлбар хуулийн нэгэн салшгүй хэсэг болж, Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт хуулийн нэгэн адил хүчин чадалтайгаар үйлчилж байгаа энэ тохиолдолд Дээд шүүх хууль тогтоогчийн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэсэн заалттай шууд зөрчилдөж байгаа юм. Энд ГАГЦХҮҮ гэдэг үгийг анхаарна уу. Нөгөө талаас иргэд хуульч, өмгөөлөгч, хуулийн зөвлөхийн шаардлагагүйгээр, цаашилбал шүүхэд нэхэмжлэл гаргалгүйгээр өөрийнхөө хэргийг хэрхэн шийдвэрлэж болохыг доод шатны шүүхүүдэд хандалгүйгээр шууд Дээд шүүхийн шийдвэрийг гаргуулж, урьдчилан харж болж байгаа юм шиг төсөөлөл төрнө. Тухайлбал, иргэн хуулийн зүйл заалтыг ойлгохгүй бол Дээд шүүхэд хандаад түүнээс тайлбар гаргуулж болно гэсэн нь хуулийн зүйл, заалтыг хэрхэн ойлгох талаарх мэдлэгийг Дээд Шүүхийн шүүгчдээс бусад хуульчдаас асуух шаардлагагүйгээр олж авах боломж бүрдэж байна. Учир нь одоогийн хуулиар Дээд шүүх хуулийг тайлбарлах үүрэгтэй болж байгаа юм. Энэ нь Дээд Шүүхийн ачааллыг маш ихээр нэмэгдүүлэх томоохон хүчин зүйл мөн.

Мөн уг тайлбар нь хуулийн нэгэн адил хүчин чадалтай учраас иргэн хууль санаачлагчийн эрхийг эдэлж болох нь гэсэн буруу төсөөлөл өөрийн эрхгүй бий болгож байна. Харин тайлбар хуульд харшилбал Шүүхийн тухай хуулийн 23.8 дахь хэсэгт заасны дагуу

¹ LADO CHANTURIA, RECHTSFORTBILDUNG DURCH RICHTERRECHT, (Rechtsfortbildung durch Richterrecht und Zugang zu Recht, Tagungsband der II. Internationalen Richterkonferenz 2003, Tbilisi 2004.) p. 15.

"Улсын Дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж мөрдөнө". Харин Дээд шүүхийн тайлбар буруу бол зөвхөн Дээд шүүх өөрөө засч залруулах эрхтэй. Учир нь Үндсэн хуулийн Цэцийн хэргийн харьяалалд Дээд шүүхийн шийдвэрийг хянан шийдвэрлэх тухай хэрэг багтдаггүй. Тэгэхээр нэгэнт гарсан тайлбар ямар ч хяналтгүй болж байгаа юм. Бүр хуулиас илүү хүчин чадалтай болж байна. Дээд шүүхийн тайлбар нь албан ёсных байж болох боловч, зөвхөн тухайн хэргийн хүрээнд, эсвэл төсөвтэй хэргүүдийн хүрээнд албан ёсных байх ёстой. Аливаа улсын хуулийн үйлчлэх хүрээнд бүх нийтээр дагаж мөрдөх албан ёсны тайлбар хийх эрх нь гагцхүү Үндсэн хуулийн шүүхэд хадгалагддаг олон улсын жишиг бий гэдгийг энд анхаарах нь зүйтэй.

Дээд шүүх тайлбар гаргаж, доод шатны шүүхүүд түүнийг хууль мэт хэрэглэж байгаа нь Үндсэн хуулийн 49.1-ийг шууд зөрчиж байна. Учир нь аль ч шатны шүүхийн шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагддаг. Тухайн шийдвэрлэж байгаа хэрэгтэй нь холбогдуулж ямар ч албан тушаалтан, дээд шатны шүүхийн шүүгчид хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгчид зааварчилгаа өгөх эрхгүй юм. Харин бусад орны (Япон гэх мэт) практикийг харахад ихэнх тохиолдолд доод шатны шүүгчид дээд шатны шүүхийн шийдвэрүүдийг харгалзан үзэж, шийдвэрээ гаргадаг ба ингэхдээ заавал дагаж мөрдөх албагүй байдаг. Аливаа Үндсэн хуулийн зүйл, заалтууд хоорондоо зөрчилдөхгүй байх ёстой. Хэрэв зөрчилдөн батлагдсан бол тухайн улсын боловсон хүчний мэдлэг, боловсрол хомс гэдгийг шууд илэрхийлдэг. Өнгөц харахад Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, 50.1.4 заалтууд хоорондоо зөрчилдөж байгаа мэт боловч, эдгээр зүйлийг зөв тайлбарлаж, алдааг засах эрх, боломж нь Үндсэн хуулийн цэцэд хадгалагдаж байна.

Нөгөө талаас Дээд шүүх нийтээр дагаж мөрдөх хууль зүйн тайлбар гаргаж байхгүй юм бол хэн тайлбар хийх ёстой вэ гэсэн асуулт урган гарч ирнэ. Манай өнөөгийн хуульчид, тэр дундаа шүүгчид, бүр

тэр дундаа Дээд шүүхийн шүүгчдээс бусад шүүхийн шүүгчид Дээд шүүхийн тайлбаргүйгээр ажлаа явуулж чадах уу? Нийгэмд тун нэр хүнд муутай манай шүүгчид тус бүрдээ өөр өөрийн тайлбарыг хийгээд хэрэг хянан шийдвэрлэж, бодит үнэнийг илэрхийлсэн, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн шийдвэр буюу хууль зүйн тайлбар гаргаж чадах уу? гэдэг асуултууд ар араасаа хөврөн гарч ирнэ.


Энэ асуултад "чадна", эс бөгөөс "чадахгүй" гэсэн хариулт уралдан гарч ирнэ. Гэвч "чадахгүй" гэсэн нь давах болов уу. Учир нь манай нийгмийн уур амьсгал шүүхэд ерөөс итгэхээ байсанд оршино. Хэн нэг хүн ямар нэг хэрэг шийдүүлэхдээ "шүүгчийн гарыг хүндрүүлэхгүй бол болохгүй. Би хүндрүүлэхгүй бол нөгөө тал маань хүндрүүлж миний талд шийдвэр ашиггүйгээр гарах болно" хэмээн айдаг. Мөн өмгөөлөгчид аливаа хэргийг өмгөөлөхөөр болоод шүүх дээр очиход "ямар шүүгчид энэ хэрэг хуваарилагдах бол миний талдаа хүн болов уу, хэн бол?" гэсэн өдөр тутмын хэвшил болсон аймшигт автана. Энэ мэтчилэн олон сөрөг үр дагавар байдаг, байж болох боловч эцсийн дүндээ тэрхүү олон сөрөг үр дагаврыг эргээд Дээд шүүх арилгаж, зөв шийдвэр гаргавал олон нийтэд үр өгөөжтэй. Үндсэн хуульд нийцсэн хэвт ёсыг төлөвшүүлэх нь ойлгомжтой.

Хуульчид, өмгөөлөгчдийн хамгийн гол хүндрэл бол шүүгч аливаа асуудлыг шийдвэрлэхдээ Дээд шүүхийн тайлбарыг урьтал болгодог. Гэтэл Дээд шүүхийн хийсэн тайлбар үргэлж үнэн зөв, нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаггүй. Ингээд хэрэг шийднэ. Хэрэг шийдэхдээ Дээд шүүх тухайн асуудлын талаар тайлбар гаргаагүй бол тухайн хэрэгт хэрэглэгдэх хуулийг шүүгч маань нэг бол тайлбарлах, эс бөгөөс тайлбар байхгүй буюу зохихуулагдаагүй харилцаа мэтээр орших болдог. Дээд шүүх тайлбар хийгээгүй хуулийн зүйл заалт байхад, эрх зүйч эрдэмтдийн бүтээл, онолын тайлбарыг авч ашиглах шаардлага гарна. Гэвч тэрхүү онолын тайлбарыг олж мэдэх, судлах бололцоо, цаг завар манай шүүгчид тун хомс байна. Учир нь тэд

маш их ачаалалтай ажилладаг. Нөгөө талаас тэр бүр монгол хэл дээр ном, судалгааны бүтээл гараагүй, олж уншиж чаддаггүй, гадаадын эрдэмтдийн бүтээл, номыг олж чадвал хэлний бэрхшээлээс болоод уншиж, тэр дундаа зөв ойлгож чадахгүй байх тохиолдол бий. Зарим нэг "үл бүтэх" шүүгчид тухайн хуулийн тодорхой зүйл заалтыг тайлбарласан Дээд шүүхийн тайлбар байхгүй бол "энэ асуудлыг Дээд шүүх тайлбарлаагүй. Тиймээс би мэдэхгүй. Чиний гаргаж байгаа үндэслэл хүчингүй" гэх мэтээр өмгөөлөгч, хуульчдыг тавлаж, ойворгон загнаж буйг бас энд дурдууштай. Тэгэхээр энэ хэв байдлыг үгүй хийж, Дээд шүүх ч бай, доод шатны шүүх ч бай бүх шүүх албан ёсны тайлбар хийдэг гэдгийг хатуу чанд баримталж, хэргийг шүүж буй аль ч шатны шүүгчид ажиллах, судлах боломж гаргах хэрэгтэй байна. Энд хэрэглэж буй албан ёсны хэмээх нэр томъёо нь хуулийн нэгэн адил бүх нийтээр дагаж мөрдөх бус тухайн маргаж буй хоёр талын хувьд буюу тэдний шийдвэрлүүлж буй хэрэгтэй төсөөтэй хожмын үйл явдалд албан ёсны байх тухай ойлголтыг дурдаж байгаа болно.

Дараах хэсэгт энэ мэт асуудлуудын талаар гадаадын иргэд, хуульчдад танилцуулах зорилгоор англи хэл дээр бэлдлээ.

Мөн "хууль", "хууль зүй", "эрх зүй" гэх мэт нэр томъёоны гаргалгааг англи хэл дээр хэрхэн зөв буулгах, ойлгох, буруу ойлгосноос хэрхэн төөрөгдөлд хүрч байгаа болон монголын эрх зүйн хөгжлийн талаар залуу судлаачийн байр суурьнаас товч дурдахыг зорив.



LEGAL SYSTEM OF MONGOLIA:

1. THE TERMINOLOGY "KHUULI" (STATUTE), "KHUULI ZUI" (RULE OF STATUTE) AND HOW THEY INFLUENCE MODERN MONGOLIAN LAW

2. THE INTERPRETATION OF SUPREME COURT OF MONGOLIA

by Gunbileg Boldbaatar*

Once professor John Woronoff said that although no longer burdened by the adjective 'outer' Mongolia still seems terribly remote to most of us (the world). This is not just a matter of distance, for we hear much more about other places far away. The problem is more a lack of interest and lack of knowledge. The lack of interest should decrease now that Mongolia is truly independent and can tighten its relations with other parts of the world.¹ By this work, I welcome you, all foreign colleagues, to do research in Mongolian law and hope Mongolian legal system will be part of your research in the near future.

Brief introduction to Mongolian law

Seeing from historical sources have come down to us from ancient time, Mongolians established their state form first time in 209 B.C., in the period of Khunnu State. It was the first state which built state rules and its traditions, not only for Mongolians but also for Central Asian nomadic tribes.² Afterwards, states such as Sumbe (745-840), Kidan (907-1125) and Great Nirun (A.D. II-IV century), Great Nirun (A.D. III-VI century), Tureg (552-745), Uigur (745-840), Kidan (907-1125) and Great Mongol Empire (1206-1755) existed in the Mongolian territory. As a consequence of occupation by Manchurian Empire in the West Mongol since 1755, Mongolia had been under Manchurian governance until 1911's Revolution for Independence. Even when Mongolia declared its independence in 1911, its neighboring countries, Russia and China, had not acknowledged it and made agreement that Mongolia is the

autonomy of China in 1913. Therefore, Mongolians had fought for their Independence until Mongolia had gained its Independence with help from Russian military in 1921 and adopted its first Constitution after three years. Many can not define it as real Independence. During the time of 1921-1990, Mongolia was under direct influence of the communist regime of Soviet Union and its ruling.

In the 1990, the Mongolian democratic movement overthrew the old communist leadership in a peaceful revolution.³ Acknowledging democracy in 1990, the first Mongolian democratic Parliament was established and adopted the first democratic Constitution of Mongolia in 1992.

Mongolian law is based upon codified laws. Codes such as the Civil Code, Commercial Code, Criminal Code and Procedural Codes form the basis of the system. Principle of respect for statute became the supreme principle of the activities of the State. Statutes or codified laws are the main sources of law in Mongolia. As of today, more than 370 laws exist.

From the first establishment of Khunnu state up to the present period there is rich legacy of history of progress and prosperity of history in politics, economy and social history during this process.⁴

Russian influence in Mongolian law. It is obvious that Mongolian lawyers had mostly copied Russian laws since 1921 until the Democratic Movement in 1990. Even today this habit continues in some ways for the following reasons:

1. Mongolia was under communist regime and Soviet Union ideology of law was directly placed in all kinds of Mongolian State affairs during the 70 years of socialist time. Therefore, we are so used to it.

2. One of the unavoidable reasons is that almost all Mongolian lawyers were educated from the Soviet Union Countries or had taught by Russian influenced Mongolian professors in the country and they currently have most vital positions, legislators and judges, in which in turn affect the progress of Mongolian legal system.

3. Mostly, middle aged and over Mongolians second language is Russian. Therefore, first of all, they see how and what Russian lawyers do and then again try to receive Russian view about law into Mongolian law. It shows that the lack of language knowledge of other languages affects in the legal system.

4. Russia and Mongolia had same legal systems during Communist period. Therefore, it is obvious that after 1990s, Russian law is the first object of Mongolian Comparative law.

1. THE TERMINOLOGY "KHUULI" (STATUTE), "KHUULI ZUI" (RULE OF STATUTE) AND HOW THEY INFLUENCE MODERN MONGOLIAN LAW

The purpose of this part of work is to illustrate the terminology "khuuli"

* Researcher, National Legal Center of Mongolia; Member, Council of Scholars and Professionals of the President of Mongolia. BA., 2003, MA., 2004, National University of Mongolia, School of Law; LL.M., 2005, Saint Thomas University, Law School.

¹ ALAN J.K. SANDERS, HISTORICAL DICTIONARY OF MONGOLIA, Asian Historical Dictionaries, No. 19. ix, (Editor's foreword by John Woronoff, Series Editor of the book).

² J. BOLDBAATAR & D. LUNDJEJANTAN, HISTORICAL OVERVIEW OF MONGOLIA'S STATE AND LEGAL TRADITION 14, (MONGOL ULSIN TOR, ERH ZUIIN TUUHEN ULAMJALAL) Ulaanbaatar 1997

³ ALAN J.K. SANDERS, HISTORICAL DICTIONARY OF MONGOLIA, Asian Historical Dictionaries., No. 19. at 1.

⁴ J. BOLDBAATAR, THE ROLE OF MONGOLS IN THE WORLD AND REGIONAL HISTORY 3, Ulaanbaatar 2003.

(statute) and "*khuuli zu*"¹ (rule of statute), to evaluate how they influence modern Mongolian law and to further prevent from misunderstandings driven from wrong usage of words.

Confucius once remarked that if language is incorrect then what is said does not concord with what was meant; and if what is said does not concord with what was meant, what is to be done cannot be affected.²

The idea of a special and separate legal language remote from common speech is the product of a society in which only a very limited class of "legally competent" people can read the texts of that language.³ We, Mongolian lawyers, used to interpret, understand and use the term "respect for statute" as same meaning as term "respect for law" practically. In other words, it could be a proof of one of the Mongolian modern phrases which says "Mongolians talk wrong, understand right" (in Mongolian, *Mongolchuud buruu yarji, zuv oilgodog*). For example: *khuulich* (translating into English, direct word is *profession of statute*, but meaning is *lawyer*), *Khuuli zuin surguuli* (translating into English, direct word is *School of Study of Statute*, but meaning is *Law School*), *Khuuli zuin Shinjleh Ukhaan* (translating into English, direct word is *Science of Study of Statute*, but meaning is *Legal Science or Jurisprudence*). If we use them correctly, they are *erkh zuichid* which means *lawyer*, *Erkh zuin surguuli* which means *Law School*, and *Erkh zuin Shinjlekh Ukhaan* which means *Legal Science or Jurisprudence*. Therefore, today, all

terminologies with word "of law" or "*legal*" are used by word "of statute" or "*statutory*". Perhaps driven from that, law and statute are understood in same meaning which causes confusion.

Law students can get knowledge of difference between the words law and statute in the classes of theory of law or legal philosophy only. Word "statute" or *khuuli* is very strong in Mongolia.

Law (from the late Old English *lagu* of probable North Germanic origin) in *politics* and *jurisprudence*, is a set of rules or *norms* of conduct which mandate, proscribe or permit specified *relationships* among *people* and *organizations*, intended to provide methods for ensuring the *impartial* treatment of such people, and provide punishments *off* for those who do not follow the established rules of conduct.⁴ Nevertheless, today's Mongolian translators used to translate both words *erkh zui-law* and *statute-khuuli* by word *law* into English. Due to it, when reading about Mongolian legal system and sources of law in English, readers can not understand which word *law* means real *law* or *erkh zui* and which one is *statute* or *khuuli*. Other translations, such as into Russian and German, except into English could be read clearly, in reason that Mongolian translators used to translate these words by correct words. For example, *khuuli* in Russian *zakon*, in German *gesetz*, *erkh zui* in Russian *pravo*, in German *recht*. All translations into English of 1 article, paragraph 2 of the Constitution are used by word "...for the law", not by word "...respect for statute". Therefore, its English translations have no

confusion. Readers can think that "*respect for the law is fundamental principle of the state activities*". Indeed, instead of "*respect for the law*", "*respect for statute*" is correct use. The form of expression of law is its sources. It is very obvious and has no doubt. As we know, sources of law consist of statute, precedent, international treaty, custom, doctrine and etc. We can see from here that statute is not only form of source of law. Statute is an act, which can be evaluated by people and distinguished as bad law or good law, adopted by a legislature, Parliament, and it regulates certain relations of society in appropriate level.

In present, either these good statutes or bad statutes in the matter of use and power are excessively too strong and their practical use takes too much area comparing with other types of source of law in Mongolia. As a matter of fact, there are no other useful types of law, except statute, which regulate and affect people behavior and their relations in the country. The idea or use of other types of sources of law, except statute, such as judicial precedent⁵, legal doctrine⁶ and customary law are not well recognized by Mongolian lawyers.

Although Parliament of Mongolia has ratified many international treaties⁷, they still seem have no self executive power in the country practice, especially in courts due to lack of practical and theoretical knowledge of lawyers. Indeed, only source of law which is well known and used is a statute, its interpretation⁸ and some legal norms which made in conformity with them having real power

¹ According to professor Charles Bawden Mongolian word *zui* means rule, regularity, conformity with the rule, or as final element -ology means like methodology, criminology etc. CHARLES BAWDEN, MONGOLIAN-ENGLISH DICTIONARY 184, Kegan Paul International 1997.

² THE ANALECTS OF CONFUCIUS 171-172, trans. A. Waley (London: G. Allen and Unwin, 1938).

³ THE ROLE OF LINGUISTICS IN LEGAL ANALYSIS 534 (1984) 47 Modern L. Rev. 523.

⁴ BLACKSTONE, WILLIAM, SIR., AN ANALYSIS OF THE LAWS OF ENGLAND: TO WHICH IS PREFIXED AN INTRODUCTORY DISCOURSE ON THE STUDY OF THE LAW 189. 3rd ed. Buffalo, N.Y.: W.S. Hein & Co., 1997. (originally published: Oxford: Clarendon Press, 1758). Also definition of word "law" available at: <http://en.wikipedia.org/wiki/Law>. (last visited in March 10, 2006)

⁵ As precedent is not considered to be a source of law, the courts in the modern Mongolian legal system play no formal role as a source of law. In Mongolia, judges are supposed to only apply law, not to create it.

⁶ OGGEREL TSEVEN AND BATTSETSEG GANBOLD, THE MONGOLIAN LEGAL SYSTEM AND LAWS: A BRIEF OVERVIEW, available at: <http://www.nyulawglobal.org/globalalex/Mongolia.htm> (last visited in March 8, 2006)

⁷ Legal doctrines are not considered as a source of law. Therefore, Mongolian and foreign academic opinions are not taken into account when a court makes a decision. It is not the practice of Mongolian courts to cite the published works of jurists when issuing a judgment. In many ways, jurisprudence is still in its infancy stage. *Supra* note 9.

⁸ The status of international law in the Mongolian legal system was dramatically transformed by the 1992 Constitution of Mongolia. The 1992 Constitution of Mongolia provides that "the international treaties to which Mongolia is a party, shall become effective as domestic legislation upon the entry into force of the laws or on their ratification or accession. *Supra* note 9.

⁹ Pursuant to Article 50.1.4 of the Constitution of Mongolia, the Supreme Court provides official interpretations related to the correct application of all laws other than the Constitution. The formal interpretations of the Supreme Court takes the form of a resolution and once issued is to be considered a part of the laws. At present, there is no specific law which requires the promulgation of explanations according to a standardized system. *Supra* note 9.

of law such as legal norms of the Government¹.

Example. Article 1, paragraph 2 of the current 1992's Constitution of Mongolia reads "The fundamental principles of the activities of the State shall be ensurance of democracy, justice, freedom, equality and national unity and respect for statute".

Seeing the history of Medieval Period (XIII-XX century), the terminology *khuuli tsaaз*² were applicable to all types of source of law generally. The terminology was appropriate terminology for feudal society state affairs during this time. Nonetheless, after Mongolia declared its Independence, Mongolian legal system has started being a part of continental legal system and Mongolian legal science has started to be built on the Russian communist theory of law since 1924. In particular, the Constitution of Mongolia of 1960 declared in its purpose that all types of private property shall be eliminated and only socialist or public property is acceptable in the society. Consequently, it was proof of that both public law and private law of Mongolia were under communist ideology completely. In this time, word *law* or *erkh zui* and *statute* or *khuuli* were not distinguished and used with same meaning for reason that there was no need to teach people about the difference between words *law* and *statute*. Otherwise, people would receive knowledge of democracy and talk about freedom, human rights, demonstrate or move against Communist party and its leaders. Therefore, Communist party or the state leaders prohibited to teach real meaning of law and publicized that law is statute or act and orders of the Communist party. For this reason, Mongolia had Constitution and only 25 statute books to regulate all relations in the society in the time.

Nevertheless, this misinterpretation was concluded in 1990 and Mongolian first democratic Constitution was adopted in 1992, but the dilemma of terminologies still continues and the terminology *khuuli* (*statute*) still exists in the Constitution. Thus, word *tsaaз* was taken off for the reason that its verbal form means to punish by death penalty, and politicians decided since it is the remaining of feudal society, it should be taken off. It should be noted that the word *law-erkh zui* is not used in the Constitution of Mongolia. In this way, the word *statute* plays main role in Mongolian legal system as a source of law.

Members of Parliament who adopted 1992's Constitution had might seek to express common law idea of *Rule of Law* and continental law idea of *Rechtsstaat* (in Russian *pravovoe gosudarstvo*, in French *etat de droit*) by terminology "respect for statute".

On the other hand, it might be that they chose terminology "respect for statute" in the Constitution in order to put Mongolian legal system into continental legal system. To be honest about most of Mongolian lawyers, when they speak about idea of continental law, they only think about power of act adopted by legislator, legislation, which is supreme in the system and ignore other types of source of law.

As professor B. Chimid, who drafted present Constitution of Mongolia, wrote, article 1 paragraph 2 of the Constitution does not mean "legal despotism", but rather a respect and adherence to universally recognized laws, abiding by a new legal awareness and legal protection of the interest of the individual.³ But the truth is even scholars try to focus on intentionist approach of interpretation, in practice, it is still used by textualists, who are the most of Mongolian today's lawyers.

It is obvious that recognizing supreme power of statute in the legal

system is one of the explanations of the characteristics of continental law only. As we know, beyond that there are many other ideas of culture, principle, historical progress, theory, opinion of scholars and mutual effect between types of sources of law.

Instead of using terminology "respect to the law", of terminology "respect for statute", and terminologies of statute and law as one same thing makes delusion and harm to legal development in Mongolia. Particularly, it negates role of other types of law and their significance.

German Constitution, article 20 paragraph 3, reads "Legislation is subject to the constitutional order; the executive and the judiciary are bound by law and statute", says not only about statute (*Gesets*) which makes sources of law into narrow sense but also cited word *law* (*Recht*) which puts the regulation into broad sense. Both words *Law* and *Statute* are used here. In other words, it does not limit state activity by word *Statute*. According to the interpretation by prof. Dr. Hans D. Jarass and prof. Dr. Bodo Pieroth, "judicial precedent is not binding directly in Germany. Nonetheless, other universally recognized types of source of law, for example customary law, could be considered as sources of law in Germany"⁴. In other words, even Germany, one of the vital examples of continental law countries, uses judicial precedents of International Courts such as the decision of the European Court of Human Rights at present.

The Federal Constitutional Court of Germany made an order to the effect that the binding effect of a decision of the European Court of Human Rights extends to all state bodies and in principle obliges them, where this is within their jurisdiction and does not violate the principle of the binding force of law and justice (Article 20.3 of the Basic Law).⁵

Article 1 of the Russian Constitution reads "The Russian

¹ In Mongolia, legal acts in the broad sense of the word, can take any number of forms including parliamentary resolutions, presidential decrees, cabinet ministry resolutions, and ministry rules and orders. Moreover, as declared by the Constitution, legal acts may be issued by the Governors of the Aimags, Capital city, Soms, Duuregs, Bags, and Horoos. These legal acts are to be called "ordinances" and must conform to the laws of the nation.

² *Khuuli tsaaз* means statute and penalty. Word *tsaaз* also could be explained as word "prohibition". G.B.

³ B. CHIMID. ESTIMATING APPROPRIATE SYSTEM IS THE BASE OF EFFECTIVE DOING OF LEGAL REFORM (ZOHISTOI TOGTOЛTSOOG BARINJAALAH NI ERKH ZUIN SHINETGELIG UR NULUUTEI HIH UNDES BOLON NI) 24, Ulaanbaatar

⁴ Dr. HANS D. JARASS & DR. BODO PIEROTH, GRUNDESETZ FÜR DIE BUNDESREPUBLIK DEUTSCHLAND (KOMMENTAR) 475, Muenchen 2000.

⁵ See Order of the First Chamber of the First Senate of 5 April 2005 – 1 BvR 1664/04, available at: http://www.bundverfassungsgericht.de/entscheidungen/frsames:rk20050405_1bvr166404e. (last visited in March 10, 2006)

Federation-Russia shall be a democratic federal-rule of law state with the republican form of government" and article 15, paragraph 2 of the Constitution reads "Organs of state power and local self-government, officials, citizens and their associations must comply with the statutes and the Constitution of the Russian Federation". Readers can see that word *rule of law state* is used in Russian Constitution with broad sense.

Also, critics may say I am very focused on textualist approach of the interpretation and suggest that if we see by intentionist approach the idea of "respect for statute" could be explained in correct. But, this is not true in the present case. Although intentionalists can say the correction will be found by intentionalism in the interpretation, text of the statute must fit with idea of used word. Otherwise, we can call a tiger as a cat or we can say a tiger is a cat.

Once Justice Scalia, judge of US Supreme Court, said that "allow the judge to rely only on statutory language; she cannot confirm her reading of the text by an examination of legislative history or other nonstatutory materials".¹⁸ Like his words, Mongolian judges rely only on statutory language, including Supreme Courts interpretation, in present which it causes negation of other sources of law because of wrong usage of terminology in the Constitution "respect for statute".

Perhaps critics may say that this work is extremely focused on the terminology "respect for statute" and suggest that the idea of "respect for law" could be covered by other terminologies in the Constitution of Mongolia. For instance, they would say terminologies such as *ensurance of democracy, justice, freedom, equality and national unity* may fill up word "respect for law".

Surely in some way, they can fill up it in reason that the purpose of law is *ensurance of democracy, justice, freedom, equality and national unity*. Regrettably, they can not replace word law in full sense. Merely, they are some parts of the purpose of law.

Therefore, it is essential to make amendment in the present Constitution of Mongolia and place the word law in the article. Then, it must be read as "The fundamental principles of the activities of the State shall be ensurance of democracy, justice, freedom, equality and national unity and respect for law and statute".

Although concerning rule of law state is similar with such states declaring that their principle of state activity is rule of law, certain state can have its own specific elements, which means these elements must fit with general scope of the theory of rule of law state.¹⁹

2. THE INTERPRETATION OF SUPREME COURT OF MONGOLIA

Interpretation of legal terminologies is one of the most interesting questions in Mongolia. According to article 50, paragraph 1, subparagraph 4 of the Constitution of Mongolia, **Supreme Court exercises the power to provide official interpretations for correct application of all other laws except the Constitution.**

Also, article 23 paragraph 2 of the Court Act states "Citizen, official, legal entity and organization have a right to request Supreme Court to make interpretation on certain article of statutes which causes ambiguity and doubt during their understanding, obeying, implementing and using the law". This article shows that citizen, official, legal entity and organization can get interpretation of Supreme Court directly, not through litigation. And, paragraph 7 of the article states "The interpretation is binding for citizens, officials, legal entities and organizations in the territory of Mongolia" which means:

1. interpretation of Supreme Court has same legal power as statute;
2. or Supreme Court has a right of legislature;
3. without the interpretation, statutes can not be implemented;

4. and the interpretation is inseparable part of statutes of Mongolia.

It is obvious that "courts must interpret law as the result of the clash of interests between litigants".²⁰ In my opinion, these articles are not in conformity with article 20 of the Constitution of Mongolia stating "The Parliament (State Great Khural) is the highest organ of state power, and the legislative power is vested only in the Parliament" for reason that legislative power shall be vested only in the Parliament not in the Supreme Court. As I mentioned above, the interpretation of Supreme Court is binding for all as statute.

On the other hand, it is understood that people can find answers by requesting interpretation from Supreme Court, not by hiring lawyers, advocates or going through lower courts. They can sit and wait at home what Supreme Court will say about their questions because it makes official and binding interpretation for any cases in Mongolian territory. Therefore, without litigation people can find final decision for any case. It could be one of the main factors of Supreme Court's extremely overloaded works.

Furthermore, if the interpretation of Supreme Court is binding for all in the territory of Mongolia, then, it means citizen and the others have a right of initiator of law.

Now, other question- What if the interpretation of Supreme Court is illegal? According to article 23 paragraph 8 of Court Act states that "If the interpretation of Supreme Court is contrary to statute, statute will be complied". But, who can decide is it contrary to statute? Only Supreme Court can decide whether it is illegal or not for reason that Constitutional Court of Mongolia has no jurisdiction over the decision of Supreme Court.

As we know, the interpretation of Supreme Court is binding only for individual cases and if it is binding, it is only in common law countries, but Mongolia is not considered as a part of it.

As it is mentioned above, article 20 of the Constitution states that "The Parliament is the highest organ of state power, and the supreme legislative power is vested only in the Parliament".

Like some other countries which were under communist regime, the official interpretation by Supreme

¹⁸ ROBERT K. RASMUSSEN, A STUDY OF THE COSTS AND BENEFITS OF TEXTUALISM: THE SUPREME COURT'S BANKRUPTCY CASES, 71 WASH. U. L.Q. 535, at 540 (1993)

¹⁹ T. SENGODURU, THE BASE OF STATE AND LAW OF MONGOLIA 26, Ulaanbaatar 2000.

²⁰ WILLIAM B. BARKER, STATUTORY INTERPRETATION, COMPARATIVE LAW, AND ECONOMIC THEORY: DISCOVERING THE GRUND OF INCOME TAXATION., San Diego Law Review., vol. 40: 821, 2003. p. 826

Court of Mongolia is to be bound for all persons within its jurisdiction. This appearance of binding power of the interpretation of Supreme Court in the state's territory is a remaining of the Communist regime and "some parts of post Soviet Union States have such regulation nowadays!". Likely, today's Mongolian courts conclude that statutory interpretation must be made only by Supreme Court and without it statutes can not be explained by judges of lower instant courts. For this reason, procedures of many cases were ended with uncertainty and parties' agitation. For example, as an attorney at law, I was asked to assist one businessman who is called Mr. T² in August 2005 in Ulaanbaatar, Mongolia. He was a representative of foreign citizen Ms. S. plaintiff in the civil case, who could not take part on the judicial session in judicial day because of unavoidable reason to be in her country. Judge S. judge of District Court, who was appointed to decide the case, refused me to represent my client in the court for reason that my letter of power of attorney is invalid without first plaintiff's signature. It was obvious that Mr. T, who is not lawyer, needed lawyer's assistance in the court and also the case had been in rush to be decided for reason that judgement had already been pending for five years. In his letter of authorisation written by first plaintiff were written sentence "*This letter grants Mr. T. full power and authority (including the right of disposal of the object) to do all and any acts that relate or may relate to the object on behalf of me. All and any documents and information that relate or may relate to the object can be signed by Mr. T*" which means he can sign in the letter of power of attorney or hire attorneys freely. Furthermore, according to the article 62 paragraph 5 of the Civil Code of Mongolia, "if an authorization indicates the possibilities for carrying out such acts through the other person or it is necessary to do so for the interests of the principal, then such an authorization may be transferred" which means if he can not hire attorneys, as what judge S. thinks, in

my opinion, there is another way that he also able to transfer some parts of his authorization to the attorney in order to express his arguments through lawyers in the court. And as you see from above mentioned sentence in the letter of power of attorney is also argument that Mr. T. was granted the right of disposal of the object which means he can make any decision even to sell it. Since Mr. T. is granted by full power and authority, and the Constitution of Mongolia says that everyone has a right to have legal assistance, it is obvious that Mr. T. can hire lawyer in order to protect his and his principal's rights in court.

Unfortunately, judge S. could not recognize my power of attorney for reason that as she explained, according to article 62 paragraph 7 of the Civil Code, "A proxy is obliged to notify the principal about the transfer of its rights to the other as well as about the transferee of authorization. A proxy which has not performed its obligation shall be liable for consequences arising out of the acts of transferee like its own acts" which means, as the judge said, the court needs to receive a document showing that the transfer of authorization or signing in the letter of power of attorney are allowed by the first plaintiff (the principal). Then, we argued that the text of the article does not say about, if any, letter of authorization could not be transferred or letter of power of attorney written by the proxy must be shown or written in the court or to other parties. On the contrary, she asked us to show official interpretation of the article 62 of the Code by Supreme Court of Mongolia. We and also she knew there was no official interpretation in this article. Yet the Supreme Court has not managed to do it and judges of lower courts think that they have no authority to interpret statute. This is a fact and we were baffled. Hearing from other lawyers of Mongolia, I found out that many similar cases relating to lack of either official interpretation or knowledge and passive acts of judges happen.

However judges of lower courts of Mongolia know that they need to interpret statutes, if necessary in the case deciding or lack of official

interpretation, and use interpretation of legal scholars, they are still reluctant to do it because of article 15 paragraph 6 subparagraph 6 of Court Act, adopted in 2002, which says "Only Supreme court can make official interpretation of laws other than the Constitution", and principle of "Court shall use only statute or provisions written in statute in judgment". In addition, article 1 paragraph 2 of the Constitution, which states about respect to statute, also causes inactiveness of judges, and makes deviations.

In this way, judges of lower courts do not know their function, on the other hand, the attitude that they think they do not have an authority to interpret law or the understanding that only Supreme Court of Mongolia has a right of interpreting law become causes for making incorrect decisions, which encourage parties of case to appeal to upper courts especially until the last level which is Supreme Court. Proof of this argument is shameful result which shows that "572 cases were revised by Criminal Chamber of the Supreme Court in 2004. Lower courts decisions of 321 of them were approved and the rests were changed by the Chamber. It means only 56.1 percent of decisions appealed to the Court were approved" which shows almost half of the appealed criminal cases' decisions were wrong.

CONCLUSION

It will be correct if we replace the terminology *Khuuli Zuin Shinjleh Ukhaan* (Science of Study of Statute) by terminology *Erkh Zuin Shinjleh Ukhaan* (Science of Law) and other wrong use of terminologies. Otherwise, word *Khuuli Zui* makes ambiguity and harms legal development in Mongolia as a start.

Furthermore, relations in society are changed almost everyday and courts need to interpret regulations in individual cases. Therefore, article 50, paragraph 1, subparagraph 4 of the Constitution of Mongolia should be interpreted by the Constitutional Court of Mongolia clearly, which means the Constitutional Court need to interpret that Supreme Court has a power of official interpreting only on individual cases and article 23 paragraph 2 of the Court Act should be overruled.

¹ LADO CHANTORIA, RECHTSFÖRBITILDUNG DURCH RICHTERRECHT, (Rechtsfortbildung durch Richterrecht und Zugang zu Recht, Tagungsband der II. Internationalen Richterkonferenz 2003, Tbilissi 2004.) p. 15.

² In order to protect private interest of the client, names are abbreviated in this text.

³ "B. DORJGOTOV, JUDGE OF THE SUPREME COURT: SOME ARTICLES OF CRIMINAL CODE ARE IMPOSSIBLE TO IMPLEMENT", Daily "Century news", 2005.12.05.

Багш, оюутны "Эврика - 2006" эрдэм шинжилгээний бага хурлын эрх зүйн салбарын тэргүүн байрт шалгарсан илтгэлүүдийг Та бүхэнд хүргэж байна.

Эрх зүйт ёс ба хуульчийн ёс зүй (Шүүгчийн ёс зүйн жишээн дээр)

"Хуульчид бол Америкийн
ардчилсан язгууртнууд юм"
А.Токвилль



Шилдэг багш - илтгэгч,
МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн багш, докторант
М.Батсуурь

Ардчилал, эрх чөлөө, эрх зүйт ёсны талаар ам нээдэг болоод багагүй хугацааг ардаа хийсэн боловч хөндөж хэлэлцэгдэх ёстой олон асуудлууд өөрийн дарааллаа хүлээсээр байгаа билээ. Эдгээр асуудлын нэг нь хуульчийн ёс зүйн асуудал юм.

Социалист эрх зүйн тогтолцооны үед хуульчид энэ асуудалд анхаарлаа хандуулж байсан боловч энэ нь хамтач үзлийн байр суурийг хадгалж байсан учраас өнөөдөр агуулга нь хоцрогдож, огт өөр буюу хүний эрх, эрх чөлөөний өнцгөөс уг асуудлыг дахин нягталж үзэхийг шаардаж байна. Түүгээр ч үл барам хуульчийн ёс зүйн доголдлоос болж өнөөдөр манайд ардчилсан эрх зүйт ёсны үнэт зүйлсийг бүхэлд нь үгүйсгэх, хууль шүүхийн тогтолцоонд үл итгэх байдал газар авсаар байгаа нь сэтгэл эмзэглүүлэм зүйл болжээ. Сүүлийн үед идэвхжиж буй иргэний хөдөлгөөнүүд нь нэг талаас иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, жагсаал цуглаан хийх эрхээр хамгаалагдсан улс төрийн зүйт ёсны тэмцэл мөн боловч нөгөө талаас асуудлыг шүүх эрх мэдлээр дамжуулан шийдвэрлүүлэх бус, харин шаардлага, хүчирхийллийн замаар шударга ёсыг тогтоохыг оролдож буй нь иргэдийн шүүх эрх мэдэлд хэр зэрэг итгэл алдарсныг илтгэж буй нэг жишээ мөн. Тиймээс миний энэ илтгэл орчин үеийн ардчилсан эрх зүйт ёсны өнцгөөс хуульчийн ёс зүй, тэр дундаа

шүүгчийн ёс зүйн асуудлыг байх ёстой хийгээд байгаа байдлын арга зүйн хүрээнд хөндөж, төгсгөлд нь өөрийн санал, дүгнэлтийг илэрхийлэх болно.

Сэдвийн томъёолол

1. Ардчилсан эрх зүйт ёс ба хуульчийн ёс зүй
2. Хуульчийн ёс зүйн орчин үеийн шаардлага
3. Хуульчийн ёс зүй ба тулгамдсан асуудлууд
4. Дүгнэлт

1. Ардчилал, эрх чөлөөг хамсуулан ярихдаа бид ардчиллыг хамгийн товчоор хуульчлагдсан эрх чөлөө гэдэг бол эрх чөлөө нь ардчиллын үндсэн шалгуур хэмээн дүгнэцгээдэг. Гэхдээ ардчилал, эрх чөлөө нь бид нарт хар аяндаа ирдэг заяа төөрөг биш ээ. Ардчиллыг нийгэмд бодит институт болгон төлөвшүүлэхэд нэг талаас олон нийтийн мэдэх эрх дээр суурилсан бие даасан хэвлэл мэдээллийн

институт, нөгөө талаас хараат бус шүүх эрх мэдлээр хамгаалуулсан жинхэнэ бат бэх хуулийн тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэдэг.¹ Ийм хуулийн тогтолцоо байж гэмээж нь улс төрийн босоо ба хэвтээ хариуцлагын тогтолцоо илүү үр нөлөөтэй ажиллах болж, төрийн эрх мэдлүүд бие биендээ хутгалдахгүй хуваарилагдан тэнцвэржиж, үүний үр дүнд хамгийн бага засагладаг төр, иргэний эрхэмсэг оршихуй, эрх чөлөө баталгааждаг билээ. Тиймээс эрх зүйт ёс нь ардчилал, эрх чөлөөний үзэлд суурилсан хуулийн тогтолцоо хийгээд түүний баталгаа болох хараат бус, бие даасан шүүх эрх мэдэл хоёрын хөг нийлүүлсэн хослол мөн билээ.²

Шүүх нь хуулийг хэрэглэхдээ гагцхүү хүний эрх чөлөөг хамгаалсан үзэл баримтлалаар тайлбарлах замаар хуулийн тогтолцооны үндсэн зорилгыг амилуулж, иргэдийн хуульд итгэх итгэлийг сэргээн ардчилалд өөрийн хувь нэмрээ оруулдаг.³ Энэ утгаараа шүүх нь нэг талаас нийгэмд шударга ёсыг тогтоогч төрийн эрх мэдлийн нэг институт мөн бөгөөд эрх зүйн үр нөлөө бүхий хамгаалал шаарддаг. Энэ эрх зүйн хамгаалал нь шүүх, шүүгчийн хараат бус байх, бие даасан байх гэсэн эрх зүйн зарчмаар баталгааждаг. Харин нөгөө талаас шүүх нь энэ эрх мэдлийг хэрэгжүүлэгч хувь хүмүүсийн бодитой үйл ажиллагаа байдаг. Тиймээс хүний эрх чөлөөний баталгаа болсон шүүн таслах ажиллагааг зүгээр л түүнд ажиллаж буй хувь хүмүүсийн дур зоргод найдаад орхих бус, харин ухаалаг боловсруулсан ёс зүйн хэм хэмжээгээр баглан нь чухал. Учир нь "Хэн дор эрх мэдэл байна, түүн дор хилэнц байна" гэсэн эртний

¹ Ж.Маршалл "Цөөн хүний эрх мэдэл: Хуульчийн ёс зүй ба эрх чөлөөг сахин хамгаалахад түүний гүйцэтгэх үүрэг" Муж улсуудын шүүхийн үндэсний төвийн Монгол дахь төсөлд зориулж Про-Этикийн бэлтгэсэн зарим материалаас...

² Г.О.Доннел. Ардчиллын чанар хуулийг дээдлэх ёс яагаад хэрэгтэй вэ? "Ардчиллын чанар" судалгааны өгүүллийн эмхтгэл. УБ, 2005. 77 дахь тал

³ Ромын Дигестэд "Шүүх бол ярьдаг хууль, хууль бол ярьдаггүй шүүх" хэмээсэн байдаг.

⁴ Мөн Ромын хуульч Ульпианы хэлснээр "Шүүгч бол иргэнд эрх чөлөөг нь эдлүүлэх гэсэн хувируулж, байнгын дур зорго мөн" гэсэнтэй санаа нэг юм. Л.Блэзийсайхан "Дээж бичиг". 87 дахь тал.

мэргэдийн онч цэцэн үг хуульчдыг ч мөн тойрохгүй ээ.

Хуульчийн ёс зүйг орхигдуулсан нийгмийн ирээдүйн талаар Францын зохиолч, улс төрийн онолч Алексис де Токвилль /1805-1859/ бичихдээ: "Ардчилсан бүгд найрамдах засаглалтай улсад хүмүүс хуулийг хэрэглэх замаар үр шимийг нь хүртэж, түүгээр хамгаалуулахыг эрмэлзэх цорын ганц зам бол шүүгчид ийм боломжийг хангаж, хэрэгжүүлэхэд оршино.

Хэрэв хууль, шүүхийн тогтолцоо нь хүмүүсийн эрх ашгийн эсрэг ажиллах буюу ийнхүү ажиллаж байгаа мэт ойлгогдвол, хууль тогтоомж хүмүүсийн эрх чөлөөг хамгаалах арга хэрэгсэл байхаа больж, ардчилсан бүгд найрамдах засаглал нуран унана" хэмээн нэгэнтээ тэмдэглэсэн удаатай. Тэгэхлээр дээрхээс үндэслэн хуульчийн ёс зүй хүний эрх, ардчилал, эрх зүйт ёсыг хамгаалах чухал хэрэгслүүр гэж хэлж болно.

2. Хуульчид ямар ч хамаагүй үнээр хуулийг улс төрийн явуулгыг зорилгод гуйвуулахаас хамгаалах ёстой. Энэ бол нийгмийн бусад гишүүдийн өмнө хүлээсэн тэдний зүй ёсны үүрэг хэмээн эрх зүйн онолын эрдэмтэн Х.Келзен хэлжээ. Чухамхүү хууль, шүүх эрх мэдлийн тогтолцоо нь өөрөө улс төржөөрөө л иргэний эрх чөлөөнд учрах хамгийн том аюул үүний цаана нуугдаж байдаг. Ардчиллыг хуульчилж болно, харин хуулийг, ялангуяа шүүхийг ардчилж болохгүй гэсэн зарчим үүнтэй холбоотой үүссэн болов уу. Тиймээс энэ үг өнөөдөр ч гэсэн хуульчдын дунд үнэ цэнээ алдаагүй бөгөөд хуульчийн ёс зүйн үндэс болж байна.

Хэдийгээр хуульчид нэг талаас өөрсдийн үйл ажиллагааны үндсэн

үүргийг ухаарч, ёс зүйн үнэт зүйлсээ итгэл үнэмшил болгон баримтлах нь тэдний соёлын асуудал боловч нөгөө талаас энэ эрх мэдлээ ашиглан өөрсдөө давуу байдал бий болгож, үүнийгээ зүй бусаар ашиглахаас хамгаалж хянах нь нийгмийн бусад гишүүдээс тавьж буй шаардлага байдаг. Энэ дотоод хийгээд гадаад ёс зүйн хэм хэмжээнээс хуульчийн ёс зүйн шаардлага урган гардаг.

Өдгөө хуульчийн ёс зүйн шаардлагыг мэргэжлийн төрлөөс үл хамааран үзвэл харилцагчаас тавигдах ёс зүйн хэм хэмжээ (харилцагчдаа үнэнч байх, түүний ашиг сонирхлыг хамгаалах, итгэл даахтай холбоотой асуудлууд), мэргэжлийн хуульчдын дунд тавигдах ёс зүйн хэм хэмжээ (шүүхийн ерөнхий чиг үүрэг-тогтолцооноос оролцогч талуудад тавих шаардлага), мэргэжлийн нэр хүнд, хуулийн байгууллагаас тавигдах ёс зүйн хэм хэмжээ¹ хэмээн багцлан харж болохоор байна.

А. Харилцагчаас тавигдах ёс зүйн хэм хэмжээ гэдэг нь шүүх эрх мэдлийн байгууллагуудаар дамжуулан эрх зүйн маргаанаа шийдвэрлүүлж буй иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас хуульчдад тавьж буй ёс зүйн шаардлагууд багтдаг. Энэ ёс зүйн хэм хэмжээ нь мөн дотроо хоёр үндсэн шаардлагад хуваагддаг. Тухайлбал:

- Өөрөө өөрөөсөө чөлөөлөгдөх; Маргааныг таслан шийдвэрлэж буй шүүгч нь өөрийн хувийн зан чанарууд болох айх, ичи, нэрэлэх, өсөрхөх, дургүйцэх зэргээс бүрэн ангижирч, шүүн таслах ажиллагааг зөв шударгаар явуулах ёстой байдаг. Үүнийг тодорхой болгохын тулд нэгэн жишээ татъя. Еврейчүүд

ба бусад үндэстний цөөнхийг ялгагварлан харгис хэргийг хандаж байсан 3 дугаар Рэйхийн хавчлагын үед хамгийн ихээр тэднийг үзэн ядаж байсан хүмүүсийн дунд Нюрнбергийн хуулийг гаргасан Герман шүүгчид байсан гэдэг. Гэтэл эдгээр шүүгчид бид зүгээр л хуулийг хэрэглэсэн гэж өөрсдийгөө зөвтгөж байсан.² Тэд шударга бус хуулийг таслан зогсоохын төлөө эрх мэдлээ ашиглах боломж байсан. Гэтэл тэд хэсээгүй бөгөөд үүнд еврейчүүдийг үзэн ядах хувийн байдал нь нөлөөлсөн юм. Тиймээс өнөөдөр шүүгчийн ёс зүйд зайлшгүй байх ёстой хэм хэмжээ бол шүүх эрх мэдэлд орж болох шүүгчийн хувийн сэдлийг хаахтай холбоотой хэм хэмжээнүүд юм. Тухайлбал, манай шүүгчийн ёс зүйн дүрмийн 7.2.2-д заасан "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай хуулийн заалтыг хэлбэрлэлтийг мөрдөхийн зэрэгцээ урьд нь ойр дотно харилцаатай байсан хүмүүс, эсхүл өмнө нь ажиллаж байсан буюу эрх ашгийг нь ямар нэг хэлбэрээр хамгаалж байсан байгууллага, хуулийн этгээдийн хооронд үүссэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд оролцохгүй байх", мөн 7.2.3-д "Хэрэг маргаан нь шүүхээр хянан шийдвэрлэгдэх гэж байгаа хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, найз нөхөд, садан төрлийн хүмүүстэй хувийн харьцаанд орохгүй байх" зэрэг хязгаарлалтууд нь үүний нэг тод илрэл мөн.

-Мэдлэггүй, чадваргүй байдлаас чөлөөлөгдөх. Маргалдагч талуудаас тавих нэг шаардлага бол тухайн шүүгч нь маргааныг таслах туршлага мэдлэгтэй, үр чадвартай байх явдал.⁴ Шүүгч хуулийн хэм хэмжээ, түүний цаана агуулагдах

¹ Ж.Маршалл "Цөөн хүний эрх мэдэл: Хуульчийн ёс зүй ба эрх чөлөөг сахин хамгаалахад түүний гүйцэтгэх үүрэг". Муж улсуудын хуульшарил үндэстний төвшин Монгол дахь төсөлд зориулж Про-Этикийн бэлтгэсэн зарим материалдаас...

² Х.Тэмүүжин "Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур, үндэслэл. Хуульчийн ёс зүй гарын авлага". УБ., 2004. 9 дэх тал

³ See, e.g., United States v. Altschuler, 3 trials of war criminals before the NUREMBERG MILITARY TRIBUNALS under CONTROL COUNCIL LAW No. 10, at 1, 1014 (1951) (quoting defendant Rothenberger: "The judge is on principle bound by the law. The laws are the orders of the Fuehrer.").

⁴ Гэхдээ шүүгчийн мэдлэггүй, чадваргүй байдал нь хэрэг маргаанаас шийдвэрлүүлэхээр хандаж буй иргэдийн итгэлийг бууруулах магадлалтай учир шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл мөн ч энэ нь бусад шүүгчээс тухайн шүүгчийн хараат бус байдлыг нөлөөлөх үндэслэл биш хэмээн шийдсэн сонирхолтой шийдвэрийг ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх гаргажээ. Нийгмийн халамжийн шүүхэд мэргэжлийн хувьд нэгэн сүл шүүх ажиллаж байж. Тиймээс үг шүүх ажил үүргийн хуваарьтаа нэгэн жижиг танхим буюу камер бий болгосон бөгөөд ажилдаа тааруу шүүгчээс бусад шүүгчийг өөр танхимд нэгэн зэрэг харьяалагдахаар хуваарилсан байна. Эцсийн дүнд гурван жилийн дотор тухайн шүүгч нэг л хэрэгт итгэгч шүүгчээр ажиллаж, 35 хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгчээр орсон байна. Гэхдээ үг 35 хэргийн 25 тохиолдолд нь ямарваа нэгэн шийдвэр гаргаагүй байна. Тэр шүүгч ерөнхийдөө ажиггүй болсон байна. Холбооны Үндсэн хуулийн шүүх дээрхи ажил үүргийн хуваарилалтыг шүүгч хүйн хувьд хараат бус байх зарчмыг зөрчиж, шүүгчийг албан тушаалаас нь огцруулсантай адил болжээ хэмээн дүгнэсэн. Шүүгч хүн ажилдаа хичнээн муу байсан ч гэсэн хамт олны зүгээс түүнийг "тэвчх" ёстой хэмээн шийджээ. Bundesverfassungsgerichtliche Scheidung BVerfGE 17, 252, 259 ff. A. von B. Ардчилсан эрх зүйт төр дэх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Үндсэн хуулийн зохицуулалт. Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр. УБ., 2004. 49-50 дахь тал

үзэл баримтлал, үнэт зүйлсийг нээн илрүүлэх онолын мэдлэгтэй байж, түүнийгээ тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх чадвартай байх нь шүүгчийн шийдвэр үндэслэлтэй байж, маргалдагч талуудад хүлээн зөвшөөрөгдөх урьдчилсан нөхцөл болж өгдөг. Тиймээс амьдралын туршлага, хууль зүйн мэдлэгээ байнга хөгжүүлэх нь тухайн хуульчийн соёл төдийгүй нэг чухал үүрэг байдаг. Энэ талаар шүүгчийн ёс зүйн дүрэмд хэм хэмжээчилсэн байна. Тухайлбал, дүрмийн 9.1-д "Шүүгч нь хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, шинжээч, яллагдагч, шүүгдэгч болон нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч зэрэг хэргийн аль ч оролцогчтой харилцахдаа ялгавартай байдал гаргалгүйгээр тэгш, хүндэтгэлтэй хандаж, шүүгчийн зүгээс хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг өөрийн үйл ажиллагаа, үг яриагаар төрүүлж чадахуйц мэдлэг, харьцааны соёлыг эзэмшсэн байх үүрэгтэй бөгөөд шүүхэд ажиллаж байгаа хэн бүхнээс ийнхүү харьцахыг шаардаг эрхтэй" хэмээн заажээ.

Б. Мэргэжлийн хуульчдын дунд тавигдаж ёс зүйн хэм хэмжээ гэдэгт шүүн таслах ажиллагаанд оролцохдоо баримтлах ёс зүйн хэм хэмжээний шаардлагууд ордог. Хуульчийн ажлын үндсэн талбар нь шүүн таслах ажиллагаа байдаг. Энд өмгөөлөгч хувийн ашиг сонирхлыг, прокурор нийтлэг ашиг сонирхлыг тус тус хамгаалан тэмцэлдэж, шүүгч хөндлөнгийн байр сууринаас эрх зүйд тулгуурлан маргааныг шийдвэрлэдэг. Чухамхүү энгийн юм шиг атлаа нарийн төвөгтэй энэ процедураас эрх зүй амилж, нийгэмд шударга ёс бий болж байдаг. Тиймээс хуульчийн ёс зүйг түүний ажил үүргийн амин сүнс нь болсон шүүн таслах ажиллагаанаас гадну үнэлэх нь утгагүй. Энэ талаархи үзэл санаа нь шүүгчийн ёс зүйн дүрмийн 8.1-д "Шүүн таслах үйл ажиллагаа нь шүүгчийн өөр бусад бүх ажлаас ямагт илүү чухал байна", 8.2-д "Шүүгч шүүн таслах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, хуульд заасан журмын дагуу явуулах үүрэгтэй", 9 дүгээр зүйлд "Шүүгч нь хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч,

өмгөөлөгч, прокурор, шинжээч, яллагдагч, шүүгдэгч, нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч зэрэг хэргийн аль ч оролцогчтой харилцахдаа алагчлалгүйгээр тэгш, хүндэтгэлтэй хандах...", "Хэргийн оролцогчид болон бусад хүмүүстэй албаны хувьд харилцахдаа хүнийг доромжлох, үндэслэлгүй хүлээлгэх, чирэгдүүлэх, хувийн сонирхолтойгоо ойлгуулахыг эрмэлзэх, сэтгэл зүйн тавгий байдлал оруулах, ашигилж зандрах, айлгаж сүрдүүлэх, дарамтлах, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бусаар авирлахыг хориглоно" гэх зэргээр энэ шаардлагыг тусгасан байдаг.

В. Мэргэжлийн нэр хүнд, хуулийн байгууллагаас тавигдах ёс зүйн хэм хэмжээ гэдэгт тухайн хуульчийн ажиллаж буй байгууллагаас өөрийн байгууллагын нэр хүнд, түүнд хандах нийгмийн гишүүдийн итгэлийг хамгаалах зорилгоор тавигдаж буй ёс зүйн шаардлагуудыг багтааж ойлгодог. Үүнийг тодруулах үүднээс нэгэн жишээ авъя, АНУ-д 1970-аад оныг хүртэл хуульчийн ёс зүй нь олон нийт, хуульчдын анхаарлыг төдийлөн сайн татдаггүй байсан. Харин 1972 онд "Уотергейт"-ийн хэрэг гарч, энэ талаар Конгресс дээр хэлэлцэх үеэр Р.Никсоны засаг захиргааны үед олон хуульч буруу үйл ажиллагаанд оролцож байсан нь тодорхой болсон. Үүний үр дүнд олон нийтийн дунд эрх зүйн салбарын нэр хүнд уналтад орсон байна. Тиймээс хуульчдын нэр хүндийг сэргээх зорилгоор хуульчийн ёс зүйн асуудлыг урьд урьдынхаас илүү анхаарах болж, түүнийг хамгаалах институтийг бий болгосон байна.¹

Хуульчийн мэргэжлийн нэр хүндийг хамгаалах ёс зүйн

шаардлага нь шүүгчдийн ёс зүйн дүрэмд мөн тусгагджээ. Энэ шаардлагууд нь шүүгчийн дүрэмд "Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ямар нотлох баримтыг үндэслэх, ямар хууль хэрэглэх эрхийг гагцхүү шүүгч эдэлдгийн хувьд энэхүү өндөр хариуцлага бүхий албан тушаалдаа хүндэтгэлтэй хандаж, өөрийн үйл ажиллагаагаараа шүүх эрх мэдлийн нэр төрийг хадгалж, олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байх үүрэгтэй" хэмээн бататгагджээ.

Эдгээр ёс зүйн шаардлагыг зөрчөөл сануулах, зэрэг дэвирг 6-12 сар хүртэл хугацаагаар бууруулах, ажлаас чөлөөлөх, огцруулах зэрэг арга хэмжээ авахаар дүрэмд тусгагдсан байна. Мөн сахилгын шийтгэлийг ногдуулах эрх мэдлийг 15 гишүүдээс бүрдэх Шүүхийн сахилгын хороонд хадгалуулжээ.

3. Ёс зүйгүй хуульч бол араатан гэж, эсхүл ёс зүйгүй хүнд шүүх эрх мэдлийг шилжүүлнэ гэдэг нь галзуу солиотой хүнд зэвсэг өгсөнтэй адил хэмээх эртний сэтгэгчдийн мэргэн үг бий. Өнөөдөр энэ үг зарим хуульчдын хувьд их сургуулийн байшинд л байдаг зүйл болон хувирсан нь нууц биш болжээ. Тэд өөрсдийн нийгмийн өмнө хүлээсэн үүргээ умартан ёс зүйн алдаа дутагдлыг давтсаар байна. Энэ нь эргэдэг шүүх эрх мэдэлд эргэлзээ төрүүлэх аюулыг нийгэмд бий болгож байгаа бөгөөд дараах судалгаанаас тохын бүх дүүрэг, Тухайлбал, Сант марал сангаас 2001 оны 10-11 дүгээр сард Улаанбаатар хотын бүх дүүрэг, Өмнөговь, Дундговь, Архангай, Увс болон Сүхбаатар аймгуудаас тохиолдлын журмаар сонгон авч ярилцсан 2203 хүний дунд хийсэн судалгаагаар² дараах дүр зураг харагдаж байна.

Шүүхэд хэр зэрэг итгэдэг вэ? (хувь)

	Байгууллага	Бүрэн итгэдэг	Заримдаа итгэдэг	Бага зэрэг	Итгэдэггүй	Хариулаагүй	Бүгд
1	Улсын дээд шүүх	30	33	25	8	4	100
2	Орон нутгийн шүүх	16	27	40	16	2	100

¹ АНУ-ын Дээд шүүхийн шүүгч асан Т.Кларк-аар толгойлуулсан Америкийн Өмгөөлөгчдийн холбоо байгууллагдсан. Винсент Р.Жонсон. АНУ-ын өмгөөлөгчдийн ёс зүйн шинэтгэл. Америкийн өмгөөлөгчдийн холбооны Азийн эрх зүйн санаачилга төсөл. УБ., 2004 он, 5 сар

² Сант марал төвөөс хийсэн судалгаа. УБ., 2001 он

Шүүхээр маргаан шийдвэрлүүлэх тохиолдолд шүүхийг хэрхэн төсөөлж байна вэ? (хувь)

		Бүрэн нийцэж байна	Бага зэрэг нийцэж байна	Бараг нийцэхгүй байна	Огт нийцэхгүй байна	Хариулаагүй буюу мэдэхгүй	Бүгд
1	Шүүхийн үйл ажиллагааг ойлгоход бэрхшээлтэй	36	34	19	7	5	100
2	Шүүхийн шийдвэр гартал маш их хугацаа шардагдах болно	56	23	12	5	5	100
3	Орон нутгийн шүүх	28	30	22	13	7	100
3	Шүүхийн шийдвэр хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэхгүй						

Таны бодлоор доорхи хүмүүст шүүх хэрхэн хандах вэ? (хувь)

		Хамраагүй илүү	Илүү	Адил	Доогуур	Хамраагүй доогуур	Бүгд
1	Хөрөнгө мөнгөтэй хүмүүст	45	44	11	0	0	100
2	Нөлөө бүхий албан тушаалтай хүмүүст	61	30	9	0	0	100
3	Хамаатан садан, найз нартга	14	39	44	3	1	100

Доорхи дүгнэлтүүдээс санал нийцэж байгааг тэмдэглэнэ үү. (хувь)

		Бүрэн нийцэж байна	Бага зэрэг нийцэж байна	Бараг нийцэхгүй байна	Огт нийцэхгүй байна	Хариулаагүй буюу мэдэхгүй	Бүгд
1	Компаний сонирхлыг хувь хүнийхээс илүү авч үздэг	50	32	11	4	4	100
2	Шүүгчийн шийдвэрт улс төрийн нөлөө их байдаг	27	38	23	8	4	100
3	Шүүгчийн шийдвэрт хувийн сонирхол их байдаг	37	39	15	5	4	100
4	Хэрэг цаг хугацаандаа шийдвэрлэгддэггүй	55	27	10	4	4	100
5	Шүүхийн ажилтнууд тусархуу, зөлдэг	8	32	34	22	4	100

	Судалгааны асуулт	Шүүгч	Хуульч	Иргэд
1	Хүнд суртал, чирэгдүүлэлт	66,8%	36,9%	43,9%
2	Гар хардаг, дайллага урилгаас татгалздаггүй	13,5%	16,0%	29,3%
3	Тал тохой татдаг	11,1%	15,7%	0,6%
4	Харилцааны соёл муу	88,5%	31,5%	26,2%

Дээрх хандлагын судалгаа нь олон нийтийн дунд шүүхийн нэр хүнд доод цэгтээ хүртэл унасны томоохон нотолгоо болж байна. Мөн 2002 онд явуулсан "Авилгын талаарх олон нийтийн санал бодол, байр суурь" сэдэвт социологийн судалгаанд оролцогсод цагдаагийн байгууллага 64.6 хувь нь, шүүх 65.7 хувь нь, прокурор 54.5 хувь нь авилгад автсан гэж хариулсан байхад Шүүхээр хэрэг маргаан шийдвэрлүүлж байсан иргэдийн дунд явуулсан социологийн судалгаанд оролцогчдын 23.4 % нь шүүгч хатуу ширүүн харьцаатай байсан, 17.2 % нь тэднийг буруутгаж гэмт хэрэгтэн адил үзсэн, 31.3 % нь үл тоомсорлож хайхрамжгүй хандсан гэсэн дүгнэлтэд хүрсэн бол зөвхөн 0.7 хувь нь ёс журмын дагуу зөв харьцсан гэж хариулжээ. 2004 оны 4-5 сард Хууль зүйн үндэсний төвөөс шүүгчийн ёс зүйн байдлыг судлах төслийн хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд Өдрийн сонин, Өнөөдөр, Монголын мэдээ, Зууны мэдээ, Үнэн сонин зэрэг өдөр тутмын сонинд шүүгчдийн ёс зүй, шүүхийн ажил байдлын талаар гарсан бүх нийтлэл, мэдээ баримтыг түгвэрлэж, дүн шинжилгээ хийхэд шүүгчид харилцааны соёл хэт доогуур, маргагч талууд болон шүүх хуралдаанд оролцогчидтой хувийн харьцаа тогтоодог, эд материалын болон хувийн нөлөөнд автамтгай, хүнд сурталтай, шүүх хуралдаанд хайхрамжгүй ханддаг, архинд дуртай зэрэг зөрчил хамгийн нийтлэг болох нь харагдсан байна.¹

Түүнчлэн, Хууль зүйн үндэсний төв, ШУА, МУИС, Нийслэлийн шүүхийн хамтран 2004 оны 4, 5 сард хэрэгжүүлсэн шүүгчийн ёс зүйн байдлыг судалсан социологийн судалгааг авч үзвэл:²

¹ Б.Батцэрэн "Шүүгчийн ёс зүйн үндсэн асуудал, Шүүгчийн гаргаж буй ёс зүйн нийтлэг зөрчил. Хуульчийн ёс зүй гарын авлага". УБ., 2004. 42 дахь тал

² Д.Золзаяа "Шүүгчийн ёс зүйн байдлын судалгаа. Хуульчийн ёс зүй гарын авлага". УБ., 2004. 56 дахь тал

Эдгээр судалгааны үр дүнгүүд нь шүүхийн сахилгын хорооны судалгаа, шүүгчдийн дунд хийсэн судалгаагаар нотлогдсон юм. Тухайлбал, 2003 оноос хойш мөрдөгдөж байгаа ёс зүйн дүрмийн дагуу шүүгч нарт хэрэг үүсгэсэн үндэслэлээр нь авч үзвэл: Хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэх 25.8%, биеэ авч явах байдал 25.8%, хэргийн оролцогчидтой харилцах 16.1%, шүүн таслах ажиллагаанд тавигдах шаардлага 16.1%, зохисгүй байдал гаргасан 3.2%, холбогдох хууль зөрчсөн нь 12.9%¹ байгаа нь дээрх хандлага хий хоосон зүйл биш гэдгийг илтгэж байна. Түүгээр ч үл барам шүүгчид өөрсдөө ч энэ байдлаа хүлээн зөвшөөрч байна. 270 гаруй шүүгчээс "шүүгчид өдгөө дутагдаж байгаа чанарын талаар асуулга явуулахад (1) мэргэшсэн чанар дутдаг – 65.7%, (2) хууль зүйн онолын мэдлэг дутдаг – 75.0%, (3) мэргэшлийн ёс зүй дутдаг – 46.6%"² гэсэн хариулт өгсөн байна.

Дээрхээс дүгнэж үзвэл шүүгчийн ёс зүйн хүрээнд хэрэг маргааныг шийдвэрлэх мэдлэг, үр

чадвар дутмаг, сонирхлын зөрчилд автамтгай буюу хувийн сонирхлоос чөлөөлөгдөөгүй, бие авч явах болон харилцааны соёл муу зэрэг нийтлэг зөрчил харагдаж байна.

5. Хуульчийн ёс зүйн шаардлагуудыг нэлээд сайтар хэм хэмжээчлэсэн боловч бодит байдал дээр ёс зүйн асуудал орхигдож байгаа шалтгаан нь юу вэ? гэсэн асуулт тавигдах нь мэдээж. Энд өгөх хамгийн товч хариу бол ёс зүйн хяналтыг хэрэгжүүлэх институтийг зөв бүрдүүлээгүйн зэрэгцээ иргэний зүгээс тавих ёс зүйн хяналт суларсан. Өнөөдрийн шүүгчийн ёс зүйн хяналтын тогтолцоог Улсын Дээд шүүхэд байрлах Шүүхийн сахилгын хороо хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь бие даан хараат бус ажиллаж чадахгүй байна. Үүнтэй холбоотойгоор мэргэжлийн ёс зүйн хяналт суларлаа. Нөгөө талаар шүүн таслах ажиллагаанаас ангид байгууллага хэрэгжүүлж байгаа нь шүүн таслах ажиллагаанд гарч буй алдаа дутагдлыг сайн илрүүлж чадахгүй байна. Шүүгчийн ёс зүйн хяналт нь үнэн чанартаа АНУ-ын

шүүгч Алекс Козинскийн шоглоом болгон зүйрлэсэн нэгэн согтуу эрийн онигоог санагдуулам болжээ.³ Өөрөөр хэлбэл, хөндлөнгийн этгээд хамгийн амархан олж хардаг энгийн зүйл дээр хяналт нь ажилладаг атлаа түүний цаана буй нарийн асуудлуудыг төдийлөн анзаарч хянахгүй байна.

Тиймээс хуульчийн ёс зүйг шүүн таслах ажиллагаатай уялдуулах, түүний хараат бус, бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс тухайлбал, шүүгчийн ёс зүйг шүүх эрх мэдлийн нэг оролцогч болох өмгөөлөгчийн байгууллагын дэргэд ажиллах байгууллагад шилжүүлж болох эсэхийг хөндөх цаг нь болжээ. Нөгөө талаас олон нийтийн хэвлэлээр зэвсэглэсэн иргэний нийгмийн байгууллагууд хуульчдын ёс зүйн хяналтыг өмнөхөөс илүү хүчтэйгээр хэрэгжүүлэх ёстой болж байна. Ингэж хуульчийн ёс зүйн хяналтыг сайжруулснаас бид шударга ёсыг тогтоох эрх мэдэл бүхий хуульчдыг шударга бус авир гаргахаас сэргийлж чадна гэдэгт эргэлзэхгүй байна.



¹ Б.Батцэрэн "Шүүгчийн ёс зүйн үндсэн асуудал, Шүүгчийн гаргаж буй ёс зүйн нийтлэг зөрчил. Хуульчийн ёс зүй гарын авлага", УБ., 2004. 42 дахь тал

² Н.Лүндэндорж "Шүүх эрх мэдлийн хямрал". Өдрийн сонин, УБ., 2006.04.11

³ Шөнө дэнгийн гэрэлд 4 хөллөн нэгэн согтуу эр мөлхөж байв. Цагдаа уг согтуу хүн дээр очин юу хийж байгааг асуухад согтуу хүн гэсэн 25 центээ хайж байна гэж түүнд тайлбарладаг. Цагдаа түүнд туслахаар болж, удалгүй тэд хоёулаа зоосыг хайн мөлхдөг. Хагас цаг хайсны эцэст цагдаа залхаж түүнээс "Та 25 центээ яг энэ хавьд хаясан гэдэгтээ итгэлтэй байна уу?" гэж асуухад согтуу хүн "Өө, үгүй л дээ, энүүхэн гудамжинд унагаасан юм, гэхдээ тэнд хайхад хэтэрхий харанхуй байна" гэдэг. A.Kozinski "Ethics for Judges", Hofstra Law Review. № 33, 2004

Торгох ялын биелэлт, түүнийг үр нөлөөг дэвшилцлээ нь

Шилдэг оюутан-илтгэгч, МУИС-ийн
Хууль зүйн сургуулийн оюутан Р.Мөнхзүл

Ял нь хатуу чангадаа бус харин
гарцаагүй байх ёстой ба
ингэснээр бусад хүмүүст ч
этгээдэл төрүүлж тэднийг
гэмт хэрэг үйлдэхээс нь
сэргийлж чадна.
Чезаре Беккариа (1738-1794)

үг ял халдахгүй учир нийгэм хамт олны дунд байж хүмүүжих боломжийг
олгодог;

2. Торгох ялыг нэг удаа л хэрэгжүүлнэ;
3. Уг ялыг тэнсэн хянан харгалзаж болохгүй;
4. Хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулна.

Торгох ялын зорилго: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эдийн засгийн
механизмаар цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан
сэргийлэхэд оршино.

Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээд учруулсан хохирлоо
барагдуулахын зэрэгцээ торгох ялаар шийтгэгддэг. Ийнхүү гэмт замаар
алдагдалтай амьдрах уу? аль эсхүл хууль ёсны замаар аж төрөх үү гэдгийг
эрэгцүүлэн бодоход уг ял гэм буруутай этгээдэд тодорхой нөлөөлөл үзүүлнэ³.

2. Монгол Улсад торгох ялын биелэлт тулгамдсан асуудал болох нь

Торгох ялын биелэлт

Энэхүү хэсгийг судлахын өмнө торгох ялын биелэлт ямар үзүүлэлттэй
байгааг он дараалсан статистик судалгаанд тулгуурлан үзүүлбэл:⁴

Ялын төрөл	Он/дү	Биелүүлбэл зохих		Бодитой биелүүлсэн		Үлдэгдэл		Хувь
		г/х	мөнгө	г/х	мөнгө	г/х	мөнгө	
Торгуулийн ял	2002 он	2281	215434.1	1423	117724.9	42%	858	97709.2
	2003 он	726	266498.5	572	224552.8	75%	154	41945.7
	2004 он	503	409658.4	360	323915.4	20.1%	143	85743
	2005 он	567	694285.9	388	710732	20.5%	159	183553.9
	2006 оны 3 сарын 6- ний байдал					13%	2179681.2	87%

Үндсэн ойлголт: Эрүүгийн хуулийн
тусгай ангид заасан тохиолдолд
шүүхээс мөнгөн төлөөс ногдуулахыг
торгох ял гэнэ.¹

Торгох ялыг дэлхийн нийтийн
хэмжээнд үндсэн ял болгон /зарим
улс орон тухайлбал, ХБНГУ-д хорих
ялтай зэрэгцүүлэн нэмэгдэл ялын
шинжтэйгээр хэрэглэдэг/ түгээмэл
хэрэглэдэг.

Монгол Улсын хувьд дундад
зууны үеийн хуулиудад торгох ялыг
хэрэглэхээр заасан байдаг ч
зорилго, мөн чанарын хувьд
өнөөгийн үзэл баримтлалаас
ялгаатай юм. Торгох ялыг биет
зүйлийн хэлбэрээр өөрөөр хэлбэл,
малаар тооцож гаргуулдаг байсныг
есөөр торгох гэж нэрлэдэг байсан.²
Харин өнөөгийн хуулиар зөвхөн
мөнгөн хэлбэр хэмээн онцгойлон
зааж өгсөн бөгөөд Монгол Улс нь
торгох ялыг түгээмэл хэрэглэдэг
орнуудын тоонд орж байна.

**Монгол Улсын Эрүүгийн хуульд
заасан торгох ялын үндсэн
шинжүүдийг тодорхойлох нь:**

1. Торгуулсан этгээдийн
эдийн засгийн эрхээс өөр эрхэд

Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасан торгуулийн ялаар
шийтгүүлж, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш нэг жил өнгөрсөн
273 гүйцэтгэх баримт бичиг, үүнээс төлбөрийн чадваргүй /хөрөнгө,
орлогогүй/ гэсэн шалтгаанаар 200 ялтанд холбогдох 949.2 сая төгрөгийн,
оршин суугаа тодорхойгүй хаяггүй, эрэн сурвалжлагдаж буй 73 ялтанд
холбогдох 136.5 сая төгрөгийн торгуулийн ял биелэгдээгүй байна.

Торгох ялын биелэлтийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас
үзнэ үү.

**2002-2004 он хүртлэх торгох ялын биелэлт дөнгөж
22.1 хувьтай байна.**

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2002 он.

² Г.Совд нар "Монгол хуулиуд", УБ., 1997 он. 10 дахь тал

³ С.Нарангзэрэл "Монгол улсын эрүүгийн эрх зүйн ерөнхий анги", УБ., 2000 он. 277
дахь тал.

⁴ ШШГЕГ-ын мэдээллийн алба.

Энэхүү тоо баримтаас торгох ялын биелэлт хангалтгүй, үлдэгдэл нь тогтмол өндөр хувьтай, жил дараалан өсөх хандлагатай, цаашид зайлшгүй анхаарах шаардлагатай тулгамдсан асуудал мөн болох нь харагдаж байна.

Торгох ялын биелэлтийн тухай үзүүлэлтээс үүдэн гарч буй тулгамдсан асуудлууд

Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шүүхийн шийтгэх тогтоол гарсан бол заавал биелэгдэх зарчим, торгох ялын зорилго, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх гэх мэт зарчмууд алдагдаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 9 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 1-д гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэнэ хэмээн заасан байдаг.

Хариуцлага гарцаагүй байх зарчим бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлж хүмүүжүүлэхээс гадна бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх санааж өгөх ач холбогдолтой байдаг¹. Өөрөөр хэлбэл, энэ нь гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээд заавал ял шийтгэл эдлэх ёстой бөгөөд үүгээрээ Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан ялын зорилго хангагдаж байх ёстой юм. Ийнхүү ялын зорилго хангагдахдаа шийтгүүлж буй этгээдийг эд хөрөнгө бусад байдлаар нь ялгаварлалгүйгээр адил тэгш байх ёстой байдаг билээ.

Эдгээр зарчмууд хэрхэн алдагдаж буйг дараах жишээгээр авч үзье:

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч 1 жил өнгөрсөн бол ялыг эдлүүлж болохгүй;

2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-д торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл үү ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг

баривчлах, 3 жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно.

Нэгдүгээр тохиолдол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д холбогдуулан авч үзвэл:

Шүүгдэгч "А" Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145.3-д заасан гэмт хэрэг үйлдсэн байна. 145.3-д "Энэ хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл **таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ**" гэжээ.

Шүүх "А"-г хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөн зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгожээ. Мөнгөн дүнгээр энэ нь одоогийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцвол 16800000 төгрөг юм.

Өгөгдөл: "А" нь сар бүр зуун мянган төгрөг торгуулийн дансанд байршуулсаар байв. Гэтэл эрүүгийн хуулийн 76.1.1 дэх заалтын дагуу нэг жил өнгөрсөн тул торгох ялыг цаашид эдлүүлэх боломжгүй болов. Энэ тохиолдолд "А"-н хувьд бодож үзвэл (100000 х 12 сар буюу нэг жил = 1200000). Нэг жилийн хугацаанд сая гаруй төгрөг төлсөн бөгөөд үлдсэн 15600000 төгрөгийн торгууль нь төлөгдөх боломжгүй хаагдаж ял биелэгдэхгүй үлдэж байна.

Хоёрдугаар тохиолдол: Тохиолдол адилхан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-д холбогдуулан авч үзвэл:

Өгөгдөл: "А" эхэндээ мөнгөө бага багаар дансанд хийж байгаад

хэсэг хугацааны дараа зогсжээ. Иймд ШШГТХ-ын 93.1 дэх хэсэг "Ялан эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс, цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэргээр ял эдлэхээс санаатайгаар зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж, торгох ялыг хорих ялаар солих тухай саналыг прокурорт гаргана" гэж заасны дагуу хорих ялаар сольсон байна.

Уг хорих ялын хугацаа нь **1 жил 1 онгоор** байхаар тогтоолд заажээ. Энэ тохиолдолд **5-8 хүртэл жил хорих ял** эдлэх альтернатив санхцтай байтал ердөө 1 жил хорих ял эдлээд л хариуцлагаас чөлөөлөгдөж байгаа юм. Гэтэл ЭХ-ийн 74 дүгээр зүйлд хүнд гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын 3/2-оос доошгүй хувийг эдэлсэн бол хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн харгалзан суллана гэжээ. Эндээс аваад үзвэл анх эдлэх ёстой байсан 8 жилээс дөнгөж 8 сарыг нь эдлээд чөлөөлөгдөх боломжтой байна.

Мөн түүнчлэн насанд хүрээгүй этгээд торгох ялаар шийтгэгдсэн нөхцөлд түүний торгуулийг хэн төлөх вэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Насанд хүрээгүй этгээдүүд нь ямар нэг орлогын эх үүсвэр байхгүй бөгөөд түүний торгуулийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар нь төлөхөөс өөр аргагүй. Гэтэл ял шийтгэлийг бусдад халдааж болохгүй гэмт хэрэгтэн өөрөө биечлэн эдэлнэ гэсэн Үндсэн хуулийн зарчим энд зөрчигдөж байгаа юм.

Монгол Улсад торгох ялын биелэлт ийнхүү хангалтгүй, мөн зохицуулалт алдаатай байдаг. Гэтэл торгох ял хэрэглэж буй байдал, түүний хэмжээ² тогтмол өндөр хувьтай өссөн үзүүлэлтэй байна.

Торгуулийн ял хамгийн өргөн хэрэглэгддэг ялын төрөл юм. Нийт шийтгүүлэгчдийн ихэнх хувь нь торгуулийн ялд хамаарагддаг. Энэ нь **нэгдүгээрт**, авто замын осол зөрчилтэй холбогдсон гэмт хэрэг сүүлийн жилүүдэд их гарч байгаа, **хоёрдугаарт**, хорих ялыг аль болох цөөн ногдуулах ялын бодлогоо хамааралтай юм.³

¹ Г.Совд "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар". УБ., 2002 он. 15 дахь тал

² Хавсралтад дурдсан тоо баримтаас үзнэ үү.

³ Т.Батболд "Ишидээр гүйцэтгэх газрын дарга, улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, хурандааг" "Хорихоос өөр төрлийн ял эдлэлтийн байдал, цаашид чиг хандлага" илтгэл. УБ., 2006 он.

Торгох ялын талаар практик ажилтнуудын санаа бодол

Илтгэлийн хүрээнд торгох ялын талаар шүүгч, прокурор, шийдвэр гүйцэтгэгч нарын дунд явуулсан судалгааны зарим дүнгээс:

Торгох ял биелэх боломж хэр зэрэг байна вэ? гэсэн асуултад 30 шүүгч, прокурорын 19 нь дунд, 11-муу, 20 шийдвэр гүйцэтгэгчийн 2 нь дунд, 18 нь муу гэжээ. Эрүүгийн хуульд олон жилийн хорих ялтай гэмт хэрэгт торгох ял ногдуулж болохоор байгаа нь хэр оновчтой зохицуулалт вэ? гэхэд шүүгч, прокурорын 8-онончтой, 22-алдаатай, торгох ялаас зайлсхийх явдал нийтлэг байна гэдэгтэй санал нийлэх үү? Шүүгч, прокурорын 24-санал нийлж байна, 6-санал нийлэхгүй байна, шийдвэр гүйцэтгэгч нарын 17-санал нийлж байна, 3-гүйг гэсэн байна. Эндээс харахад шүүгч, прокурор торгох ялыг ихэвчлэн хэрэглэх хандлагатай байгаа боловч биелэх боломж багатай гэж үзсэн байна.

Хэдийгээр торгох ял хэрэглэж буй байдал нь их байгаа боловч хөдөө, орон нутагт уг ялын оронд албадан ажил хийлгэх ялыг түлхүү хэрэглэж байна. Учир нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгждийн хувьд бага учраас бие биенийхээ амьдрал ахуйг тодорхой хэмжээгээр мэддэг байна. Иймд торгууль төлөх чадваргүй гэж үзвэл албадан ажил хийлгэх ял ногдуулдаг байна.¹

3. Шалтгаан нөхцөл

Дээр дурдсан тулгамдсан асуудлууд юунаас, ямар шалтгаан нөхцөлөөс болж буйг тогтоохын тулд дараах асуудлуудын хүрээнд судалгаа хийлээ.

- Онолын үзэл баримтлал
- Харьцуулсан эрх зүй судлалын үр дүнг Монгол Улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалт, практикт ай харьцуулан авч үзэх

Онолын үзэл баримтлал:

XVIII зуунаас эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд анхны сургаал, чиглэл, арга зүй үүссэнээс эрүүгийн эрх зүйн ялын бодлого, зорилгын тухай хоёр үндсэн онол хөгжиж ирсэн байна.

Үүнд:

1. retributive justice /цээр-лүүлэх онол/²
2. resorative justice /нөхөн сэргээх онол/

retributive justice /цээрлүүлэх онол-н үзэл баримтлал

Уг онолын гол төлөөлөгч Чезаре Беккариа³ нийгмийн сайн сайхны эсрэг чиглэсэн, хор уршиг учруулсан үйлдэл л гэмт хэрэг болно. Үйлдсэн гэмт хэрэг ба ногдуулсан ял хоёр нь хоорондоо нийцж байх ёстой. Өөрөөр хэлбэл, ял ногдуулах хамгийн гол шударга хэмжүүр бол учруулсан хор уршиг юм. Ялын зорилт нь зовоон тарчилгахад бус харин учруулсан хохирлыг арилгах, уг этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхэд оршино.

Ял нь хатуу чанга бус харин гарцаагүй байх ёстой ба ингэснээр бусад хүмүүст ч сэтгэгдэл төрүүлж тэднийг гэмт хэрэг үйлдэхээс нь сэргийлж чадна. Тэрээр анх гэмт хэргийн шалтгаал буюу гэмт хэргийг ангилж тухай санааг гаргасан. Уг онолын гол ололт нь Талионы /нүдийг нүдээр, шүдийг шүдээр/ зарчмыг үгүйсгэж гэмт үйлдэлд тохирсон ял ногдуулах ёстой хэмээн ялын тухай үзэл баримтлалыг гаргаж ирсэн. Уг онолыг ХБНГУ, ОХУ, Франц гэх мэт улс орнууд баримталж байна.

Уг онолын торгох ялын талаарх үзэл баримтлал:

1. Торгох ялын зорилго: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эдийн засгийн механизмаар цээрлүүлэх, урьдчилан сэргийлэх;

2. Торгох ялыг төлбөрийн чадвартай хүнд л оногдуулах ёстой;

3. Торгуулийн хэмжээ өндөр байхдаа гол бус харин ял шийтгэгдэх явдал хамгийн чухал;

4. Уг онолын дагуу шунахайн сэдэлтэй гэмт хэрэгт торгох ял ногдуулж болохгүй.

resorative justice /нөхөн сэргээх онол-н үзэл баримтлал

Уг онолын гол төлөөлөгч нь Иммануил Кант юм. Тэрээр эрүүгийн хариуцлага, түүний үндэслэлийн тухай асуудлыг зан суртахууны сургаальд үндэслэн авч үзсэн. Хүмүүсийн эрх чөлөө нь бусад хүмүүсийн эрх чөлөөг хязгаарлах ёсгүй. Хууль зөрчигчийн үзэл санааны эрх чөлөө нь мөн л үзэл бодлын эрх чөлөө юм. Тэрээр эрүүгийн хариуцлагын талаар Талионы зарчим буюу адил гэмт хэрэгт нь адилхан л ял шийтгэх ёстой гэжээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн л бол хариуг нь л өгөх ёстой. Уг онолыг АНУ, Канад зэрэг улс орнууд баримталж байна.

Уг онолын торгох ялын талаарх үзэл баримтлал:

1. Торгох ялын гол зорилго хохирлыг нөхөн төлүүлэх,
2. Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон хохирогчийг эвлэрүүлэх,
3. Торгох ял нь хорих ялаас чухал.

Тэгвэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн ялын зорилгыг авч үзвэл: 45.3 дахь хэсэг "Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас эерчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино".

Эндээс дүгнэвэл манай Эрүүгийн хуулийн ялын зорилго нь дээрх хоёр онолын аль алины шинжийг агуулсан байгаа нь харагдаж байна. Гэтэл торгох ялын эрх зүйн зохицуулалт нь ялын зорилготойгоо нийцээгүй чухам аль

¹ Б.Билэгсайхан, Б.Уранцэцэг "Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн" УБ, 2004 он.

² Robert M. Bohm, Keith N. Haley "Criminal justice", 517 дахь тал.

³ Чезаре Беккариа "О преступлениях и наказаниях", 105 дахь тал.

онолоор нь уг зохицуулалт хийгдсэн нь харагддаггүй. Үүний жишээг доорх хэсэгт харьцуулан судаллаа.

Харьцуулсан эрх зүй судлалын үр дүнг Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн зохицуулалт, практикт харьцуулан авч үзвэл

Retributive justice /цээрлүүлэх онол/-н үзэл баримтлалыг баримтлагч орнуудын нэг нь ХБНГУ юм. Тийм ч учраас ХБНГУ-н торгох ялын эрх зүйн зохицуулалт нь цээрлүүлэх онолын үзэл баримтлал дээр суурилагдсан нь шууд харагддаг. Монгол Улс нь эрх зүйн тогтолцооны хувьд Роман-Германы бүлд хамаарагддаг билээ. Иймд уг орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзье. Үүнд:

- Торгох ял ногдуулах үндэслэл шалгуур;
- Торгууль төлөх нөхцөл, боломж, ялын биелэлтийг хангах арга зүй;
- Торгох ялыг хэрэглэж буй гэмт хэрэг гэсэн багц сэдвүүдийн хүрээнд харьцууллаа.

Торгох ял ногдуулах үндэслэл, шалгуур

ХБНГУ¹: Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зааснаар шүүгдэгчид торгох ял ногдуулахдаа түүний эд хөрөнгийн байдал, орлого, мөнгөн хүримтлэл, хувийн байдал, бий болох хөрөнгийг харгалзан ногдуулахыг шүүгчид үүрэг болгосон байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд уг зохицуулалт байхгүй.

Төлөх нөхцөл боломж, ялын биелэлтийг хангах арга зүй

- ХБНГУ²: Торгуулийн хэмжээг шүүгч тогтооно. Торгуулийг нэг өдрийн дундаж орлогыг харгалзан ногдуулна. Торгох ялыг биелүүлээгүй бол хорих ялаар солино. Ийнхүү солихдоо орлогын нэг өдрийг нэг өдрийн хорих ялаар тэнцүүлэн сольдог.

Монгол Улс: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-500 дахин нэмэгдүүлсэн мөнгөн торгууль ногдуулна. Ялаас зайлсхийсэн тохиолдолд 3 хүртэл жил хорих, баривчлах ялаар солино.

Торгох ялыг хэрэглэж буй гэмт хэрэг

- ХБНГУ³: Залилан, хулгай, булаалт, дээрэм гэх мэт шунахайн сэдэлтэй гэмт хэрэгт торгох ял оногдуулдаггүй. Учир нь дээрх гэмт хэргийг үйлдэж буй этгээд нь эдийн засгийн хувьд ямар нэг бэрхшээлтэйн улмаас бусдын эд хөрөнгөд халдаж байгаа юм. Иймд эдгээр хүмүүст торгох ял ногдуулж буй нь хэрэг дээрээ дахин хулгай хийгээд торгуулиа төл гэсэн агуулгатай дүйж байгаа юм.

Монгол Улс: Дээрх гэмт хэргүүдэд торгох ялыг ихээр хэрэглэж болохоор зохицуулсан байдаг.

- ХБНГУ⁴: Хорих ял өндөр гэмт хэрэгт торгох ялыг альтернатив байдлаар хэрэглэдэггүй. ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 278 дугаар зүйлээс 161-д нь торгох ялыг хорих ялтай альтернатив байдлаар хэрэглэхээр заасан байдаг. Онцлог зүйл нь 6 сар, 1, 2, 3, 5 жил хүртэл хорих ялтай гэмт хэрэгт ногдуулахаар заажээ. Учир нь цээрлүүлэх онол нь учруулсан хор уршигт нь тохирсон ял ногдуулахыг номолж, анхлан ялыг ялгавартайгаар эрэмбэлж тогтоосон байдаг. Эрэмбэ ёсоор торгох ял нь хамгийн хөнгөн ял. Харин хорих ялын хэмжээ өндөр байгаа гэмт хэрэгт хөнгөн ял ногдуулах нь дээрх онолоос гажсан тохиолдол болдог.

Монгол Улс: 5 ба түүнээс дээш жилийн хорих ялтай гэмт хэрэгт хэрэглэхээр заасан байдаг. Тухайлбал, ЭХ-ийн тусгай ангийн 145.3 /хулгай/, 146.3 /бусдын эд хөрөнгийг булаах/, 147 /бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 148 /бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах/, 148.3, 156.3 /банкны тухай хууль тогтоомж зөрчих/, 157.2 дахь хэсэг зэрэг гэх мэт.

- ХБНГУ: Торгох ялтай альтернатив байдлаар олон төрлийн ял хэрэглэдэггүй. Хорих, торгох гэсэн хоёр сонголттой. Учир нь хүн төрөлхтөн хүнийг 21 аргаар цаазалдаг байв. Энэ байдлаасаа татгалзаж аль болох ганц аргыг хэрэглэхийг эрмэлзэж байна. Үүнтэй адилаар эцсийн дүндээ тухайн этгээд хоригдох явдал гол тул заавал олон арга замаар эрхийг хязгаарлах нь илүүц хэмээн үздэг бөгөөд энэ нь хүмүүнлэг ёсны зарчимтай уялдаатай юм.

Монгол Улс: ЭХ-д зааснаар хорих, торгох, баривчлах хэмээн олон сонголттой заасан байдаг. Эндээс баривчлах ял нь илүүц юм. Учир нь манай хуульд баривчлах ялыг үндсэн агуулгаас нь буруу байдлаар оруулж ирсэн. Баривчлах ял гэдгийг нэгэн жишээгээр тайлбарлая. "А" цалингаа буухаар хажуу талын үйлчилгээний газар орж ливо уудаг. Ийнхүү уухдаа олон түмний тайван байдлыг алдагдуулж агсам, согтуу тавьдаг байна. Харин бусад үед хэзээ ч ийм зан гаргадаггүй бөгөөд маш даруу нэгэн. Энэ байдал нь цалин буух үед л давтагддаг тул түүний цалин буух орой нь ганцааранг нь хорьдог түр хугацааны арга хэмжээ юм.

Resorative justice /нөхөн сэргээх онол/-н гол төлөөлөгч орон бол АНУ.

Иймд АНУ эрхийг нөхөн сэргээх тал дээр ямар онцлогтой байна вэ гэдгийг авч үзвэл: Уг ялыг шүүгдэгч торгууль төлөх боломжтой нөхцөлд хэрэглэнэ. Хэрэв төлбөрийн чадваргүй бол хорих ял

¹ Jurgens Baumann. Strafrecht Allgemeiner Teil. Lehrbuch. 1995 j. s. 97

² Мөн тэнд

³ Мөн тэнд

⁴ Strafgesetzbuch. Besonderer Teil. Einen Besonderen Teil §§ 80-358.

ногдуулна. Торгох ялыг 10 жил хүртэл хугацаатай хорих ялтай хослуулан хэрэглэх тохиолдол байдаг. Гэмт хэргийн субъект нь иргэн бол хүнд, онц хүнд гэмт хэрэгт торгуулийн хэмжээ 250000\$, хуулийн этгээд бол 500000\$, бусад гэмт хэрэгт 10000\$ хүртэл хэмжээтэй байна.

Хэрэв тухайн этгээд бусдад 100000\$-н хохирол учруулсан гэж шүүгч түүнийг 200000\$-оор торгожээ гэж үзье. Тэгвэл нэг зууг нь хохиролыг барагдуулж харин үлдсэнийг нь торгуулийн дансанд байршуулдаг байна. Хэн нэгэн этгээд бусдын хохирлыг барагдуулж чадаагүй нөхцөлд уг данснаас төлбөр гаргуулж хохирлыг барагдуулдаг байна.

Өөр бусад улс орны эрх зүйн зохицуулалт, практик

Их Британи: Хорихоос бусад ялд нэмж буюу өөр ялтай хамаатан хэрэглэнэ. Торгуулийн хэмжээ нь тогтсон хязгаарлалтгүй, торгуулиа төлөөгүй бол 12 сараас хэтрэхгүйгээр хорих ялаар солино.

Франц: Торгох ялын хэмжээг тогтоохдоо I зэргийн зөрчилд 250 франк, II зэргийн зөрчилд 1000 франк, III зэргийн зөрчилд 3000 франк, IV зэргийн зөрчилд 5000 франк, V зэргийн зөрчлийг давтан үйлдсэн бол 20000 франк байна.

Япон улс: Хүндэвтэр гэмт хэрэгт ногдуулна. 20000 иен түүнээс дээш хэмжээтэй, бага хэмжээний торгуулийг хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулна. 10000-20000 иен хүртэл байна¹.

Дүгнэлт

Монгол Улсын хэмжээнд торгох ялын биелэлт тун хангалтгүй байгаа бөгөөд энэ нь нэн яаралтай шийдвэрлэвэл зохих тугламдсан асуудал болох нь харагдаж байна. Энэ байдал нь ял гарцаагүй байх эрүүгийн эрх зүйн зарчим, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гарсан л бол заавал биелэгдэх ёстой гэсэн салбар дундын зарчим, торгох ялын зорилго тус тус алдагдаж гэмт этгээдүүд торгох ялын цээрлэл амсалгүйгээр ял завшиж байгаа нь нийтлэг үзэгдэл боллоо. Үүний

шалтгаан, нөхцөлийг торгох ялын тухай зохицуулалт нь эрүүгийн эрх зүйн онолын үзэл баримтлал, тэдгээр онолыг удирдлага болгодог бусад орны практик туршлагаас ялгаатай, зөрүүтэй байгаагай холбон тайлбарлаж байна. Тухайлбал, манай улсын Эрүүгийн хуульд заасан ялын зорилго нь дээрх хоёр онолын аль алинийх нь шинжийг агуулсан байдаг. Гэсэн хэдий боловч торгох ялын хувьд зөвхөн цээрлүүлэх онолын үзэл баримтлалтай нийцэж байгаа боловч бүрэн утгаар нь хуульдаа зохицуулж өгөөгүй байна. Торгох ялын эрх зүйн зохицуулалтыг онолын үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулахгүй энэ байдлаараа хэрэгжвэл торгох ял нь ял биш болох, зөвхөн баян хүнд ногдуулдаг, харин хорих, баривчлах нь ядуу хүний ял болчих вий гэсэн хандлага ажиглагдаж байна.

Санал

Иймд дараах саналыг дэвшүүлж байна.

Торгох ял өндөр байхдаа гол биш харин гарцаагүй байх, ялыг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, ялын зорилготойгоо нийцэж байх гэсэн үзэл баримтлалын үүднээс торгох ялын зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай байна. Үүнд:

1. Ялыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бус харин өдөрт олж буй орлогын хэмжээгээр ногдуулах;

2. ЭБШХ-д тухайн этгээдийн эдийн засгийн байдлын тухай мэдээллийг хавтаст хэрэгт дэлгэрэнгүй байдлаар тусгаж оруулах, шаардлагатай тохиолдолд байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэгтэй гэсэн агуулга бүхий нэмэлт оруулах, эсхүл аргачилсан зааварчилгааг боловсруулан гаргах;

3. Олон жилийн хорих ялтай гэмт хэрэгт торгох ялыг сонгож хэрэглэх боломжтой зохицуулалтыг өөрчлөн найруулах;

4. Торгох ялтай баривчлах ялыг сонгож хэрэглэх боломжтой зохицуулалтыг өөрчлөн найруулах;

5. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан ялын зорилго нь

бидний өмнө дурдсан хоёр онолын аль алины шинжийг агуулсан байдаг. Тиймээс ялын зорилгыг бүрэн дүүрэн хангахын тулд эдгээр онолыг баримталдаг улс орнуудын практик туршлага, зохицуулалтыг боломжтой хүрээнд өөрийн тогтолцоонд нэвтрүүлэх. Үүнд нөхөн сэргээх онолыг баримтлагч АНУ-ын хувьд тухайн этгээд 2000 \$-н хохирол бусдад учруулжээ. Энэ тохиолдолд шүүх түүнийг 5000\$-оор торгосон гэвэл үлдсэн 3000\$ нь торгуулийн санд төвлөрдөг байна. Өөр хэн нэгэн этгээд бусдад учруулсан хохирлоо барагдуулаагүй тохиолдолд торгуулийн сангаас гаргуулж зөрчигдсөн эрхийг сэргээх гэсэн зорилгыг хангах бүрэн боломжтой байна. Иймд торгуулийн сан байгуулах хэрэгтэй юм;

6. ШШГТХ-ийн 91.1 дэх хэсэг "Торгох, эд хөрөнгө хураах ял ногдуулсан шүүхийн шийтгэл тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа нь энэ хуулийн II хэсэгт заасан иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны дагуу гүйцэтгэгдэнэ" гэж заасан байдаг. Уг заалтыг хүчингүй болгох. Учир нь уг заалт нь ЭХ-ийн 3 дугаар зүйлийн 3.2-д заасан эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно гэсэн зарчмыг зөрчиж байгаа юм. Нөгөө талаар иргэний хэргийн шийдвэр биелүүлэх, эрүүгийн хэргийн тогтоол биелүүлэх явдал бол агуулга мөн чанар, зорилгын хувьд эрс ялгаатай юм;

7. Торгох ялыг хорих ялаар солихдоо 3 хүртэл жилээр биш харин 1 өдрийн орлогыг нэг өдрийн хорих ялаар солих;

8. Торгох ялыг нэг жил өнгөрсөний дараагаар ялаас чөлөөлөх гэсэн зохицуулалтыг өөрчлөн найруулж цааш сунгах боломжтой байхаар зохицуулалт оруулах.



¹ Д.Бадам, Б.Цэрэнчимэд "Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй". УБ., 2003 он.170 дахь тал

Захиргааны хэргийн шүүхээ Засгийн газрын шийдвэрийн хянаж нь

Шилдэг оюутан-илтгэгч, МУИС-ийн
Хууль зүйн сургуулийн оюутан Д.Энхчимэг

"Захиргааны шүүхгүйгээр эрх зүйт төрийн тухайд сэтгэн бодох огтхон ч боломжгүй"
Ю.Н.Старилов

Оршил

Өнөө үед ардчилсан эрх зүйт ёс (rule of law) төлөвшсөн улс, оронд хүний эрх, эрх чөлөөг хангах, эрх мэдэл хуваарилах, удирдах үйл ажиллагаа нь хууль ёсны байх, хараат бус шүүгчдийн хэрэгжүүлдэг шүүхийн хамгаалалт тогтоон засаг төрийн зүгээс хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдлаас сэргийлэх нь нэгэнт зарчим болон тогтжээ. Үүнтэй уялдан удирдах үйл ажиллагаа, хууль дээдлэх зарчмаас¹ хараат бус байх санаа үүсэн гарсан байна. Өөрөөр хэлбэл, аливаа захиргааны байгууллага нь зөвхөн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллах бөгөөд эрх хэмжээгээ хэтрүүлэн хүний эрх, эрх чөлөөнд халдахыг хориглох тухайд юм.

Ийнхүү төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу удирдах байгууллагаас хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга, механизм улс орнуудад онцлог шинжтэйгээр бүрэлдэн тогтсон байна. Үүнд:

- Шүүхтэй төстэй байгууллага буюу хараат бус трибунал-ердийн шүүхийн хяналт доор нийтийн эрх зүйтэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэдэг шүүхтэй төстэй байгууллага;

- Ердийн шүүхийн арга-энэ арга нь захиргааны

тусгайлан шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэхгүй бөгөөд ердийн шүүхээс захиргааны байгууллага, албан тушаалтантай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг;

- Захиргааны арга-тухайн захиргааны актыг батлан гаргаж буй захиргааны байгууллагын дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас хянан шалгаж, шийдвэрлэх;

- Захиргааны төрөлжсөн шүүх буюу төрөлжсөн арга- энэ арга нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх төрөлжсөн шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа байна.²

Шүүх эрх мэдлийн утга агуулга нь хүний эрх, эрх чөлөөг хангахад болон хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа, шийдвэр нь хуульд нийцсэн эсэхэд хяналт тавихад оршино.³ Монгол Улсад байгуулагдаад удаагүй ЗХШ ч мөн адил иргэний эсрэг, түүнийг шүүх бус харин хуулиар давуу эрх олгогддог захиргааны шийдвэрийг хууль ёсны эсэхийг хянах, үүнтэй уялдан эрх нь зөрчигдөж буй этгээдийн эрх ашгийг сэргээдэг. Тэгвэл иргэнийхээ эрхийг эрх мэдлэтнүүдийн зүгээс хамгаалах үүрэг бүхий ЗХШ маань үнэхээр энэхүү үүргээ практик дээр төгс утгаар нь биелүүлж, хамгаалж чадаж буй эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байна. Тэр дундаа ЗХШ-ийн хяналтад хамаарах эсэх нь судлаачдын хувьд маргаантай

байгаа, доод шатныхаа байгууллагад ямар ч даалгавар өгч болзошгүй Засгийн газарт уг асуудал илүүтэйгээр хамаарна.

Иймд захиргааны материаллаг эрх зүйд хамаарах энэхүү асуудлаар өнөөгийн байдлаар онолын түвшинд судалсан бүтээл үгүйн дээр судлаач, эрдэмтдийн дунд ихээхэн маргаантай байгаа, практик дээр Засгийн газраас гаргасан шийдвэртэй холбогдон хүний эрхийг зөрчсөн асуудал үүсэх болсон нь уг сэдвийг сонгон авч судлах үндэслэл боллоо. Илтэгчийн зүгээс судалгааныхаа зорилгод хүрэхийн тулд харьцуулсан болон бусад судалгааны аргыг ашиглаж өөрийн орны захиргааны эрх зүйн онцлогыг харгалзан эдүгээ практикт тулгамдаж буй асуудлууд дээр судалгааг эрхлэн үүнээс үүдэн гаргалгаа хийхийг зориллоо.

НЭГ. Судлагдахуун болон судалгааны объектоо тодорхойлохуй*

Хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ЗХХШТХ)-д нийтийн захиргааны байгууллага гэсэн ойлголтын доор гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах байгууллага, албан тушаалтанг тодорхойлж өгсөн. Тэгвэл **Үндсэн хуулийн цэц (ҮХЦ) 2005 оны 3 дугаар сарын 31-ний дүгнэлтээрээ ЗХХШТХ-ийн 4.1.1-т заасан захиргааны шүүхийн хяналтад багтах Засгийн газар... гэсэн заалтыг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж, УИХ-аас цэцийн дүгнэлтийг**

¹ Захиргааны аливаа байгууллага зөвхөн хуулиар олгогдсон бүрэн эрхийн дотор шийдвэр гаргах бөгөөд хүний эрхийн хүрээнд хөндлөнгөөс оролцож, хуулийг хүчингүй болгож ч, өөрчилж ч болохгүй юм. Б.Чимид "Захиргааны хэргийн шүүхийн үндсэн ойлголт, ач холбогдол. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг". УБ., 2004. 15 дахь тал.

² Гдаад орнуудын захиргааны хэргийн шүүх. Захиргааны хэргийн шүүх. Цуврал гарын авлага. УБ., 2005.

³ Ю. И. Стецовский. "Судебная власть". Изд. "Дело" Москва., 1999. с. 54.

⁴ Шинжлэн судлах ажил, яг мэрэгн буудахын адил "байгаа" олж харж голд нь онохыг шаардана. Сумаа тусах цэгийг бай гэдэг бол судлаачийн ухаан тусах газрыг объект, тулж судлах зүйлийг судлагдахуун гэдэг. Түүнийгээ эхлээд тодорхойлж товлохгүй бол нүдээ аниад гох дарахын адил буюу. Б.Чимид "Үндсэн хуулийн үзэл баримтлал I". УБ., 2002. 94 дэх тал.

хүлээн зөвшөөрч хассан.

Үндэслэлдээ: Монгол Улсын Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынхоо хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон байна. Засгийн газар Үндсэн хуульд заасан эрхээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлэх боломж нь нээлттэй байна¹ хэмээн заасан. **Дээрхээс үүдэн төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс Үндсэн хуулийн цэцэд үл хамаарах асуудал буюу ердийн хуулийн хүрээнд иргэний эрхийг Засгийн газраас зөрчсөн тохиолдолд шүүхэд үүрэхэд хамгаалуулах боломжгүй болсон юм.**

Учир нь онолын хувь ЗХШ болон ҮХЦ-ийн эрх хэмжээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагааг хянах хүрээнд огтлолцох явдал тэгээмэл боловч энэ нь давхцана гэсэн үг биш юм. Иймд ЗХШ-ээс хэргийг шийдвэрлэхдээ ердийн хууль хэрэглэдэг бол ҮХЦ гагцхүү Үндсэн хуульд захирагдан, түүний утга, агуулга, зүйл, заалтыг хэрэглэн Үндсэн хуулийн хэмжээний маргааныг шийдвэрлэдэг.²

Иймд манай өнөөгийн түвшинд ЗХШ-ийн харьяалан шийдвэрлэх маргаанд ЗГ-ын шийдвэр хамаарах эсэхийг "онолын" болон "практик"-ийн үүднээс олж тогтоох нь судлаач миний судалгааны объект, үндсэн гол судлагдэхүүн нь ЗХШ-ийн хяналтын объектод хамаарах

гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын шийдвэр болно.

Судлаач судалгаа эрхлэн явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээ болон онол, практикийг харьцуулан судалсны үндсэн дээр ЗХШ-ийн хянах объектын онцлогийг төвийлгөн гаргахыг эрмэлзлээ.

ХОЁР. Эрх зүйн хэм хэмжээний түвшинд.

ЗХШ-ийн хяналтын объектод хамаарах гүйцэтгэх эрх мэдлийг хэрхэн тодорхойлохоос хамааран Засгийн газрын шийдвэрийг хянах эрхтэй эсэх нь тодорхойлогдоно. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу "нийтийн захиргаа" (public administration) гэсэн ойлголт нь ерөнхий утга санааг илэрхийлэх үү, эсхүл зөвхөн тодорхой нийтлэг шинж бүхий хэсгийг илэрхийлэх үү? гэдгийг судлаач, эрдэмтэд янз бүрээр тодорхойлж ирсэн. Жишээ нь: эерэг (positive), сөрөг (negative) гэх мэт.

Өнөө үед нийтийн захиргаа гэсэн ойлголт хууль зүйн шинжлэх ухаанд өргөн ба явцуу гэсэн хоёр утгаар ойлгогддог.³ Үүнд нь:

• Нийтийн захиргаа

өрөөн утгаараа— Гүйцэтгэх эрх мэдлийг бүхэлд нь харамсан ойлголт. Энэ нь Вальтер Еллиникийн нийтийн захиргааг тодорхойлсон сонгодог ойлголттой дүйцэнэ хэмээн үзсэн байна. Түүний үзсэнээр төр болон нийтийн захиргааг хэрэгжүүлэгч бусад этгээдийн хууль тогтоох болон шүүн таслахаас бусад чиглэлд

хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь нийтийн захиргаа юм.

• Нийтийн захиргаа

явцуу утгаараа— ЗГ-ыг өөртөө хамааруулдаггүй, харин түүнд харьяалагдах захиргааны байгууллагын нийтийг захирамжилсан шинжтэй үйл ажиллагаа буюу зөвхөн хууль биелүүлэх явдлыг нийтийн захиргаа гэж үздэг.⁴ Өөрөөр хэлбэл, дээрх ойлголтын хүрээнд нийтийн захиргааг Засгийн газар, захиргаа гэж ялгах үндэслэл нь улс төр захиргааны мэргэшсэн аппаратыг ангид байх ёстой гэж үздэг оршино.

Гэхдээ нийтийн захиргаа гэсэн ойлголтыг илэрхийлсэн хуульд тусгагдсан албан ёсны нэг мөр тодорхойлолт байхгүй юм.⁵ **Улс орнуудын хувьд Засгийн газрын акт шүүхийн хяналтад орох эсэх, Засгийн газрын үйл ажиллагаанд дааж заалдах эсэх, Засгийн газраас захиргааны акт гаргадаг эсэх нь маргаантай ойлголт байдаг.** Зарим нэг онол сургаалиар Засгийн газар нь эрх зүйн тусгай акт гаргадаг гэж үзэж татгалздаг. Учир нь гаргаж буй шийдвэр нь эрх зүйн шууд нөлөөлөлгүй, тиймээс ч захиргааны актын үндсэн шинжийг агуулдаггүй гэж үздэг. Тусгай тохиолдолд Засгийн газрын шийдвэр нь захиргааны акт болдог (өршөөл үзүүлэх шийдвэр). **Орчин үед Засгийн газрын шийдвэрийг шүүхээс хянуулах байдлыг үгүйсгэсэн байдал нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдаж байна.**⁶ ХБНГУ-ын хувьд Захиргааны шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд: **Холбооны шүүхээр өөр шүүхэд харьяалахаар заагаагүй, Үндсэн хуулийн бус чанартай бүх төрлийн нийтийн эрх зүйн маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэнэ** гэж заажээ. Энэ нь өөрөө маргааны харьяаллыг тогтооходоо субъектээр бус харин маргааны агуулгыг шалгуур болгож байна. Тэгвэл Монгол Улсын хувьд ЗХШТ төрөлжсөн хуулиндаа захиргааны байгууллага, албан тушаалтан гэсэн ойлголтыг тодорхойлохдоо⁷ субъектыг нь шалгуур болгон тогтоожээ. Харин өмнөх тогтолцооны үед дээрх

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт. УБ., 2005 оны 03 дугаар сарын 31.

² Ц.Сарантуяа "Үндсэн хуулийн шүүх ба Захиргааны хэргийн шүүх. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг". УБ., 2004. 75-76 дахь тал.

³ Hermann Averarius. Kleines Rechtswörterbuch, 7. Auflage, Bonn, 1992, S. 596. дам шилэв.

⁴ Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. УБ., 2004.75 дахь тал.

⁵ П.Одгэрэл "Захиргааны эрх зүйн ерөнхий анги, УБ., 2004. 12 дахь тал.


⁶ Rechtsstaatlicher linnerlei. Muenchen., 2001, Auflage 948.

⁷ ЗХХШТХ-ийн 3.1.1-д "Захиргааны байгууллага" гэж нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төр, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бүх байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн хүрээнд захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёоны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллагын ЗХХШТХ-ийн 3.1.2-д "Захиргааны байгууллага, албан тушаалтан" гэж энэ хуулийн 3.1.1-д заасан байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг жинхэнэ албан хаагч, түүнчлэн нийтийн эрх зүйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжлан шийдвэр гаргадаг төрийн бус албан тушаалтныг хэлнэ. 4.1.4. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг.

ойлголтыг харилцан адилгүй ойлгож, тайлбарлаж байсан¹ байна. ЗХХШТХ-д тодорхойлсоноос үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтан гэж үзэхийн тулд доорх шаардлагыг хангасан байхаар байна. Үүнд:

- захиргааны байгууллага нь тодорхой бүтэц, зохион байгуулалттай;
- өөрт нь хууль тогтоомжоор олгогдсон захиргааны чиг үүрэгтэй;
- чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн нэрийн өмнөөс, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн үйл ажиллагаа явуулдаг;
- чиг үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр гадагш чиглэсэн захирамжилсан шийдвэр гаргадаг байх зэрэг шинжүүдийг тусгасан байна.

ЗШ-ИЙН МАРГААНЫ ХАРЬАЛЛЫГ ТОГТООХДОО



Хуулийн зохицуулалтын хүрээнд захиргааны байгууллага гэсэн ойлголтонд дурдсан шинж Засгийн газарт хамаарах эсэхийг шалгавал:

а) Бүтэц, зохион байгуулалт: Засгийн газар нь Үндсэн хуулийн III бүлэг болон салбар хууль Засгийн газрын тухай хуулийн III бүлэгт зааснаар Засгийн газар нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс бүрдэж, үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ. Засгийн газар үйл ажиллагааны зохих хүрээ, салбарыг дагнан эрхлэсэн ерөнхий болон чиглэлийн яам, хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагтай байна.

б) Захиргааны чиг үүрэг: Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага² бөгөөд улсын хэмжээнд хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёл, захиргаа улс төрийн байгуулалтыг төрөөс удирдах ажлыг өдөр тутам зохион байгуулж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нийтлэг эрх хэмжээтэй байгууллага юм. Ямар чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулахыг Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуульд заасан байна. Тухайлбал: 1/ Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангах, 2/ салбарын болон салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсуулж хэрэгжүүлэх, 3/хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах, 4/хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэх мэт. Дээрх бүрэн эрхээс дараах зохицуулалтууд байна. Үүнд:

1. Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангана (гадагш чиглэсэн бүрэн эрх);
2. Захиргааны хяналт, удирдлагын хүрээн дэх хяналт шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулна;
3. Хууль тогтоомж, ерөнхийлөгчийн зарлиг, засгийн газрын шийдвэрийн биелэлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны

¹ Төрийн гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагааг дагнан эрхлэж хэрэгжүүлдэг байгууллагыг захиргааны байгууллага гэнэ. Б.Чимид "БНМАУ-ын захиргааны эрх зүй. Ерөнхий анги", УБ., 1988. 106 дахь тал. 4.1. Захиргааны хэргийн шүүх нь энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасны дагуу дараах байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актд холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ: 4.1.1. монгол улсын засгийн газар; /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцгийн 2005 оны 3 дугаар сарын 31-ны едийн дүгнэлтээр хүчингүй болсон./; 4.1.2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн /ерөнхий сайд, сайд/; 4.1.3. Монгол Улсын яам;

² Монгол Улсын Үндсэн хууль. 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. "Төрийн мэдээлэл" сэтгүүл, УБ 1992., №1.

байгууллага, улсын үйлдвэрийн газар, байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид хянан шалгаж, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын илтгэл, мэдээллийг хэлэлцэнэ;

4. Нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгж хууль хэрхэн биелүүлж байгаад хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина (гадагш чиглэсэн бүрэн эрх);
5. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тогтоон, тэдгээрийн орон тооны болон зардлын төсвийн хязгаарыг баталж, зохих шатны удирдах ажилтныг томилж, чөлөөлнө (гадагш чиглэсэн бүрэн эрх);
6. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавина (гадагш чиглэсэн бүрэн эрх). Үндсэн хууль болон нарийвчилсан хуулийн хүрээнд Засгийн газарт олгогдсон бүрэн эрхэд дүн шинжилгээ хийж үзвэл ЗГ нь гадагш чиглэсэн захиргааны акт гаргаж болох нь тогтоогдож байна.

Манай улсын нэг онцлог бол Засгийн газар нь иргэн, хуулийн этгээдийн эрх зөрчигдсөн тухай гомдлыг захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд кабинетараа хянан шийдвэрлэх эрхтэй байхаар хуульчилсан. Өөрөөр хэлбэл, Засгийн газар нь өөрийн шууд харьяалах доод шатны байгууллага болох яам, агентлагийн шийдвэрийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааныхаа журмаар хянах эрхтэй байхаар заасан байна.

Харин цэцийн дүгнэлт гарснаар тогтоолд хамрагдсан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг Засгийн газраас хянасан тохиолдолд энэ талаарх

нэхэмжлэлийг ЗХШ хүлээн авах боломжгүй болж байна.¹

в) Шийдвэр гаргах процесс, шийдвэр: Засгийн газар нь аливаа асуудлыг хамтран хэлэлцэж олонхийн санаа бодолд түшиглэн цөөнхийн санааг хүндэтгэн үзэж шийдвэрлэх, гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг дангаар болон хамтран хариуцах, үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын өмнө хамтын хариуцлага хүлээх хамтын удирдлага бүхий байгууллага. Засгийн газрын үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан бөгөөд эрх зүйн хэм хэмжээний шинжтэй бол Засгийн газрын тогтоол, харин шуурхай хэрэгжүүлэх болон өдөр тутмын асуудлаар хэм хэмжээний бус шинжтэй акт болон захирамж гаргана.² Тогтоол болон захирамжид Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна.

Дээрхээс үзвэл Засгийн газар нь өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахдаа хуулийг хэрэглэх үндсэн дээр төрөл бүрийн салбарыг хамарсан эрх зүйн актыг гаргаж, засаглах эрх эдлэж, тухайн шийдвэр нь хуулийг биелүүлэхэд чиглэгдэж заавал биелэгдэх шинжийг агуулж байдаг. Энэ тухайд гавьяат хуульч Б.Чимид: Засгийн газар нь долоо хоногт дор хаяж нэг удаа хуралдаж эрх зүйн бүх салбарт хамаатай, **захирамжилсан болон хэм хэмжээ тогтоосон олон зүүн шийдвэр гаргадаг** хэмээсэн байна. Ийм өргөн эрх хэмжээг хуулиар олгосонтой холбоотойгоор Засгийн газар аливаа асуудлыг албадлагаар хүчээр шийдвэрлэх эрмэлзэлтэй, түүнийгээ хэрэгжүүлэх материаллаг хүч боломжтой байдаг. Тиймээс ч гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаа нь хуульд захирагдмал тэдгээр нь өөрийн үйл ажиллагааг Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцүүлсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, иргэний хувьд хуулиар хориглоогүй бүхэн зөвшөөрөгдөнө, төрийн захиргааны байгууллагын хувьд хуулиар зөвшөөрөгдөөгүй бүхэн хориглогдох үзэл санаа энд үйлчлэх ёстой.

Засгийн газраас гаргаж буй олон салбар эрх зүйг хамарсан шийдвэр нь үнэхээр хүний болон тэдгээрийн хамтлагийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хөндөхөөр үр дагавартай байж чадах эсэх нь улс орнуудын онолын хувьд эргэлзээтэй байдаг талаар дээрх бүлгүүдэд

дурдсан билээ. Тэгвэл Монголын өнөөгийн түвшинд Засгийн газраас гаргаж буй шийдвэрүүд нь дотогш чиглэсэн, улс төрийн шийдвэр байна уу? Эсхүл иргэн, тэдгээрийн нэгдлийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөр үр дагавартай байна уу? гэдгийг тогтоохын тулд дорх судалгааг явууллаа.


ГУРАВ: Судалгаа

Монгол Улсын Засгийн газраас гаргаж буй шийдвэрүүд нь ЗХХШТХ-д тогтоосончлон гадагш үйлчлэл бүхий захиргааны акт гаргадаг эсэхийг тогтоохын тулд Монгол Улсын Засгийн газраас 1992–2005 он хүртэлх хугацаанд гаргасан 2968 тогтоолд дүн шинжилгээ хийж үзлээ. ЗХХШТХ-ийн 3.1.4-д тодорхойлсноор захиргааны актад нэг бүрчилсэн актаас³ гадна **хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, зарлиг**⁴ нь захиргааны актад хамааруулахаар заасан нь манай улсын хувьд онцлог юм. Судалгааны үр дүнд:

• **Нэг бүрчилсэн захиргааны акт 96** (байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай, хамгаалалтын бүс тогтоох тухай, түүх соёлын хосгүй үнэт зүйлсийн жагсаалт);

• **Хэм хэмжээ тогтоосон акт 253** (агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих, зөвшөөрлийн хураамжийн хувь, хэмжээ, захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам, дотоодын их сургууль, коллежид суралцаж байгаа зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам).

Засгийн газрын шийдвэрт нэг бүрчилсэн, хэм хэмжээ тогтоосон актын эзлэх хувийг графикаар үзүүлв.



Дээрх судалгааны үр дүнгээс үзвэл Засгийн газар нь зөвхөн дотогш чиглэсэн, улс төрийн шийдвэрийг гаргаад зогсох бус, харин хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа гадагш чиглэсэн (нэг бүрчилсэн, хэм хэмжээ тогтоосон байдлаар) **захиргааны акт гаргадаг болох нь тогтоогдож байна**. Түүнчлэн гаргаж буй шийдвэрийнх нь **12%-ийг нь захиргааны акт** эзэлж буй нь актын үйлчлэл нь иргэн, хуулийн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхолд **"шууд"** чиглэх боломжтойг харуулж буй хэрэг.

Практикт Монгол Улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэр хуульд нийцэж буй эсэх тухай нэхэмжлэл ЗХШ байгуулагдсанаас хойш 3 удаа УДШ-ийн захиргааны хэргийн танхимд ирсэн байна⁵. Дээрх нэхэмжлэлүүдийг

¹ Ц.Сантуяа "Засгийн газар, сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг анхан шатны шүүх хянахгүй". Өнөөдөр сонин 2005 оны 9 дүгээр сарын 13, №215

² Д.Дашцэдэн "Монгол улсын захиргааны эрх зүй". УБ., 2002. 114 дэх тал.

³ ЗХХШТХ-ийн 3.1.4-д "Захиргааны акт гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ /үйлдэл, эс үйлдэхгүй/-г . . .

⁴ ЗХХШТХ-ийн 3.1.4-д захиргааны акт гэж . . . энэ хуулиар захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр /зарлиг, тогтоол, дүрэм, журам/-ийг захиргааны актад хамааруулна.

⁵ Баримтгүй УДШ-ийн бүртгэлээс иш татав. 1/ Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 18 дугаар тэмдэглэлийг хүчингүй болгуулах тухай. Агуулга нь: хүчин ЗХУ-ын Монгол Улсад байрласан цэргийн өмчийн хөрөнгийг хуваарилж талаар. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан. 2/ Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 6 дугаар тэмдэглэлийг хүчингүй болгуулах тухай. Агуулга нь засгийн газрын 2 гишүүнийг огцруулах эсэх талаар. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан. 3/ Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 28 дугаар тогтоогүй хүчингүй болгуулах тухай. Агуулга нь Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж байгууллага, хувь этгээдээс хураан төлөх журмын талаар. Нэхэмжлэлийг нийслэлийн захиргааны хэргийн шүүх хэрэгсэхгүй болгосон.

захиргааны хэргийн тэнхимийн шүүх хуралдаанаар хэлэлцээгүй боловч, энэ нь Засгийн газрын шийдвэр нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй гэсэн дүгнэлтэд хүргэхгүй юм. Учир нь ЗХШ байгуулагдаад удаагүй, үүнээс үндэслэн ЗХШ-ийн талаарх мэдлэг иргэдийн дунд хомс байгаатай холбоотой бизээ. Гэвч сүүлийн үед Засгийн газрын тогтоол, шийдвэр иргэдийн эрх ашгийг зөрчсөн талаар маргаан гарах болсон. Үүний илрэл нь:

Жишээ 1: Засгийн газрын 2001 оны 233 дугаар тогтоол. Уг тогтоолын гол агуулга нь төрийн албан хаагчдын гэр бүлээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуульд сурсан нэг хүүхдийг төрөөс төлбөрийг нь хариуцах талаарх хэм хэмжээ агуулсан байна. Уг тогтоолын холбогдох заалтад үйлчилгээний албан хаагчид хамааралгүй хэмээн заасан нь илт хууль бус захиргааны актад хамааруулж болохоор байна. Үндэслэлийг тайлбарлавал:

Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн албан хаагчийн ангилалд үйлчилгээний албан хаагчийг хамааруулан үздэг бөгөөд уг хуулийн 27 дугаар зүйлд төрийн албан хаагчийн гэр бүлээс их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн 1 хүүхдийнх¹ нь сургалтын зардлыг тодоодын их, дээд, сургууль, коллеж, мэргэжлийн сургуулийн тус тусын жишгээр тооцож төр хариуцна хэмээн заасан байна. Харин Засгийн газрын тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн хүүхдийн сургалтын зардлыг төр хариуцахгүй байхаар заасан нь хууль дахь заалттай харшилдаг байна. Эрх зүйт ёс төлөвшсөн улс оронд аливаа салбарлан гарсан ердийн хууль нь Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд, бусад эрхийн акт нь Үндсэн хууль, бусад хуульд нийцж байх ёстой. Тэгвэл Засгийн газрын 233 дугаар тогтоол гарсантай холбогдож төрийн сангаас төлбөрийг нь даан суралцаж байсан

нийт 633 оюутан хасагдсан² талаарх тоо баримт ч байна. Энэ тохиолдолд иргэн хүн (төрийн сангаас хасагдсан оюутнууд) эрхээ зөрчигдсөн гэж үзэж буй тохиолдолд хаана хандаж эрхээ сэргээлгэх вэ? Манай өнөөгийн түвшинд дээрх төрийн маргаан буюу ердийн хуулиар эрх нь зөрчигдсөн тохиолдолд иргэн хүн шүүхэд мэдүүлэх эрх нь цэцийн дүгнэлт гарсантай холбогдуулан хэрэгжих боломжгүй болсон.

Жишээ 2: Засгийн газрын 2000 оны 238 дугаар тогтоол. Уг тогтоолд зааснаар нийтийн зориулалт-тайгаар тавьж буй засмал замын тодорхой хэсэг нь иргэн Б-ийн өмчлөлийн газар болох 0,35 га газрыг дайран өнгөрч буйтай холбогдуулан улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор авах талаар зохицуулсан байна. Энэ тохиолдолд хэрэв иргэн Б өөрийн өмчлөлийн газрыг нийтийн ашиг сонирхлын үүднээс гэсэн нэрийдлээр хууль бусаар авсан гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар мэргэшсэн шүүхэд хандах боломжгүй болж байна.

Тэгвэл энэ мэт захиргааны актууд одоогоор ямар нэг хяналтгүй болчихсон байна.

ДӨРӨВ. Судалгааны үр дүн

Судалгааг эрхлэн явуулснаар дараах үр дүнгүүд харагдаж байна. Үүнд:

- ЗХШ-д хянагдах гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтан гэсэн ойлголтыг тодорхойлсон нэг мөр ойлголтгүй юм;
- ЗХШ-ийн хянан шийдвэрлэх маргааныг тогтоохдоо маргааны шинжээр нь бус гагцхүү хариуцагч субъектээр нь тогтоож өгсөн байна;
- Манай өнөөгийн түвшинд гүйцэтгэх эрх мэдэлд хамаарагдах байгууллага, албан тушаалтанг явцуу утгаар тодорхойлж байна;
- Засгийн газар нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн дээр тодорхой салбаруудыг хамааруулан, түүнчлэн

доод шатны захиргааны байгууллагын шийдвэрийг хянаад гаргасан шийдвэр нь гадагш чиглэсэн захиргааны акт болдог;

- Гүйцэтгэх эрх мэдлийн бүрэлдэхүүн болон Засгийн газар нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн дээр гадагш чиглэсэн захиргааны акт гаргадаг болох нь тогтоогдлоо;

- Манай өнөөгийн практик Засгийн газрын шийдвэртэй холбогдон маргаан гарч, шийдвэрлэгдэх боломж нь хязгаарлагдмал байна;

- Засгийн газрын шийдвэрийн үндсэн дээр иргэн, хуулийн этгээд зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах боломжгүй болсон нь тогтоогдлоо.

Дүгнэлт

Илтгэлийг бичих явцад өнөөгийн түвшинд нийтийн захиргааны байгууллага түүн дотроо гүйцэтгэх эрх мэдлийн бүрэлдэхүүн болох Засгийн газар, түүний шийдвэрүүд түүнтэй холбоотой онолын ойлголтууд өөртөө маш баялаг мэдлэгийг агуулсан цаашид энэ талаар судалгаа, шинжилгээний ажил бичих бүрэн боломжтой нь тодорхой болсон юм.

Иймд илтгэчийн зүгээс "Захиргааны хэргийн шүүхээс Засгийн газрын шийдвэрийг хянах нь" гэсэн сэдвийн хүрээнд харьцуулсан болон хэм хэмжээний, харилцааны түвшинд судалгаа иргэдийн үндсэн дээр эдүгээ практикт тулгамдаж буй асуудалд зүй зохистой, үр нөлөөтэй шийдлийг хайхын хамт өөрийн судалгаанаас гаргалгаа хийн дараах саналуудыг дэвшүүлж байна:

1. ЗХХШТХ-д Үндсэн хуулийн цэцэд хамаарагдахаас бусад нийтийн эрх зүйн хүрээнд гарсан ЗГ-ын шийдвэрийг хянахаар зохицуулах;
2. ЗХХШТХ-ийн 4.1.1-д заасан "Засгийн газар" гэсэн заалтыг сэргээж, Засгийн газрын шийдвэрийг гадагш чиглэх шинжээр нь оруулах;
3. Засгийн газрын гаргасан иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны актууд хяналттай болох.



¹ Гэр бүлээс нь их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн нэг хүүхэд гэдэгт төрийн улс төрийн, захиргааны, тусгай болон үйлчилгээний албан тушаал эрхлэж байгаа иргэний гэр бүлийн гишүүн болох төрсөн болон үрчилж авсан хүүхдүүдээс боловсролын асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан өмчийн аль ч хэлбэрийн их, дээд болон мэргэжлийн сургуульд элсэн суралцаж эрхийг тогтоосон журмын дагуу олж авсан зөвхөн нэг хүүхэд хамаарна. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай. УБ, 1995 оны 8 дугаар сарын 31.

² Монголын оюутны холбооноос гаргасан тоо баримтаас иш татав.

Эрх зүйт ёс

(Эрх зүйг бүтээх ажиллагаа)

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
магистрант О.Мөнхсайхан

"Өөр хүнд биш, хуульд захирагддаг хүн л эрх чөлөөтэй."

"Хууль үгүй бол эрх чөлөө байхгүй."

"Ямар нэг хувь хүний засаглалаас хуулийн засаглал илүү дээр."

Имануэл Кант

Жон Локк

Аристотель

I. Оршил

Эрх зүйт ёс (Rule of Law) нь хууль дээдлэх зарчим (Rule by Law)-аас ялгаатай ойлголт. Заримдаа бид хууль дээдлэх зарчмыг эрх зүйт ёстой адил утгаар тайлбарладаг. Хуулийг дээдлэх нь ямар нэгэн хуульгүй байснаас, хэн нэгний дур зорго ноёрхож байснаас хамаагүй дээр л дээ. Хэдий хууль дээдлэх зарчим нь ийм дэвшилттэй боловч Үндсэн хуульт ардчилалд төдийлөн хангалттай биш. Учир нь Засгийн газарт хязгааргүй эрх мэдэл олгосноор ямар ч дэглэмийг хууль ёсных болгож болно.¹ Тэгвэл хуулийг юу хязгаарлах вэ (манаачийг хэн манах вэ), хууль нь өөрөө юунд захирагдах ёстой вэ?

Эрх зүй нь бүрэн эрхт нэгний хэлсэн зүйл үү? Хааны зарлиг, даргын тушаал, эрхтэн дархтаны бодож олсон тэр зүйл үү? Эрх мэдлийг дангаараа барьж байгаа тэр этгээд эрх зүйг тогтоодог уу? Хятадын удирдагч асан Маогийн хэлсэнчлэн эрх зүй гэдэг бууны гохоос гарч байгаа тэр зүйл мөн үү? Эсвэл эрх зүй өөрийг нь бүтээж байдаг үндсэн хэм хэмжээ (basic norm)-нд захирагдах, түүгээр зохицуулагдаж, хязгаарлагдаж байдаг уу?

Парламентаас баталсан хууль тогтоомж хууль бус байж болох уу? Эрх зүйт ёсны үүднээс авч үзвэл, Үндсэн хууль бүтээх үндсэн (нийтлэг) хэм хэмжээг зөрсөн Үндсэн хуулийн заалт Үндсэн хуулийн бус болж болох уу? Дэлхийн II дайны дараа явагдсан Нюрнбергийн шүүх ажиллагаанаас хойш энэ асуултын

хариу тодорхой болсон билээ. "Тийм байж болно." Зарим хуулиуд хууль бус байдаг бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх нь гэмт хэрэг болдог.

Гитлерийн үед Германы Rechtsstaat (эрх зүйт төр) нь Gesetzstaat (хууль төр) байсан. Өөрөөр хэлбэл, хуулийг дээдэлсэн төр гэсэн агуулгыг илэрхийлж байв. Харамсалтай нь үүнээс үүдэн аймшигтай үр дагаварт хүрсэн билээ. Тиймээс нацизмын үеэс хойш Германы эрх зүй судлал "Rechtsstaat" ойлголтөө өөрөөр тодорхойлжээ. Тодруулбал, тэд "Rechtsstaat" гэдэгтээ хуульд үндэслэсэн төрийн тухай ойлгох болсон бөгөөд тэрхүү хууль нь хэн нэгэн, ямар нэгэн зүйл (тухайлбал, парламент, Үндсэн хууль) зөрчиж өөрчлөх ёсгүй зарчмуудад тулгуурласан байх ёстой.

Сталин, Гитлер, Чойбалсан нараас өмнө удирдагчийн хэлсэн зүйл болгон хууль гэж үздэг онол маш хүчтэй, дэлхийн нийтийн шинжтэй байв. Энэ онолыг хууль зүйн позитивизм гэдэг. Дэлхийн II дайны дараагаар дэлхий нийт энэ онолоос татгалзсан.

Хууль зүйн позитивизмыг дайны дараа хүчтэй шүүмжилж байсан, мөн энэ зууны хамгийн гарамгай эрх зүйн философичдын нэг бол Харвардын их сургуулийн профессор Лон Л.Фуллер юм. Тэрээр Эрх зүйн ёс суртахуун гэсэн номондоо Эрх зүйт ёсыг тодорхойлогч үл өөрчлөгдөх гол үндэслэлүүдийг гаргаж тавьсан. Миний энэ өгүүлэл Л.Фуллерийн үг бүтээлд тулгуулах болно.

Эрх зүйт ёсыг агуулгын болоод хэлбэрийн талаас нь тодорхойлсон байдаг. Энэхүү

өгүүлэлдээ би зөвхөн эрх зүйт ёсны хэлбэрийн шаардлагуудыг буюу эрх зүй нь хэлбэрийнхээ хувьд ямар зарчмуудад захирагдсан байх ёстой тухай авч үзнэ. Өөрөөр хэлбэл, миний анхаарлаа хандуулах зүйл бол эрх зүйн идеал агуулга (объект) бус, харин идеал хэлбэр юм. Эрх зүйт ёс бол зүй ёсны олон элементүүдийн зөвхөн нэг нь бөгөөд зүй ёсны агуулгын шаардлагуудын (нийгмийн зүй ёсны) тухайд ялгаатай үзэл бодлууд байдаг боловч эрх зүйт ёсны идеал хэлбэрийн тухайд санал зөрөөд байдаггүй.²

Нийтлэг байх, тогтвортой байх, нийтэд мэдэгдсэн байх, буцаан хэрэглэхгүй байх гэсэн дөрвөн зарчмыг Английн эрх зүйд хөгжлүүлэхэд Локк чухал хувь нэмэр оруулсан гэдэг. Энэ дөрвөн дээр Проф. Фуллер тодорхой (хоёрдмол утгагүй) байх, зөрчилгүй байх, боломжгүй зүйлийг шаардахгүй байх, нийтсэн байх гэсэн зарчмуудыг нэмсэн.³ Филлерийн эдгээр зарчмууд нь урьдах зарчмуудаа илүү тодруулсан, нарийвчилсан шинжтэй гэж хэлж болно.

II. Эрх зүйт ёсны хэлбэрийн шаардлагууд

1. Эрх зүйн эх сурвалжууд бие биенээ шатлан захирах

Эрх зүй олон улсын гэрээ, Үндсэн хууль, парламентаас тогтоосон хууль (статус), зарлиг, захиргааны дүрэм, заавар, тогтоол зэрэг бичмэл (позитив) текстээс өргөн агуулгатай. Шүүхийн шийдвэр ч эрх зүйн эх сурвалж мөн. Гэвч эрх зүйн мөн чанар эдгээсээ цаана ордаг.

Эрх зүй я л газрын зураг шиг. Газрын зураг тодорхой нутаг

¹ Ф.А.Хакс, 2004, 73 дэх тал.

² D. Neil MacCormick, 1997, p. 72.

³ Fuller L., 1964, p. 657.

дэвсгэрийг харуулдаг. Газрын зургийг бүтээх, зохион байгуулах, тайлбарлахад баримтлах ёстой үндсэн дүрмүүд гэж бий. Үүнтэй нэгэн адил, эрх зүйн эх сурвалжууд бие биенээ шатлан захирдаг байх, эрх зүйг хэрэгжүүлэх, тайлбарлахдаа зохих аргуудыг хэрэглэдэг байх нь эрх зүйт ёс. Үндсэн хуульт ардчилалд амин чухал.

Хууль тогтоох тэргэнд захиргааны дүрэм, заавар, зарлиг, тогтоол, зохицуулалт зэргийг ачихаасаа өмнө Үндсэн хуулийн сайн морийг хөллөх хэрэгтэй. Гэхдээ сайн морийг бий болгож байгаа "генетик код"-д гол анхаарлаа төвлөрүүлбэл зохино.¹ Үндсэн хуулийн эрх зүйг яаж бий болгож байгаа нь зохих үр дүнд хүрэх үү үгүй юу, тэр нь хууль ёсны байх уу үгүй юу гэдгийг харуулна. Процесс, үр дүн хоёр хоорондоо нягт холбоотой. Чиний хаана очих чинь яаж явахаас чинь шалтгаална. Өөрөөр хэлбэл, зөв аргыг хэрэглэж зөв зорилгод хүрнэ.

Биологичид генетик кодын үр нөлөө хувьсал өөрчлөлтийнхөөс бага байдаг гэж хэлдэг. Мөн нэр үгнээс үйл үг нь илүү хүчтэй гэдэг. Үндсэн хуулийн хувьд ч энэ үнэн.

Үндсэн хуулийн тухай бодож эргэцүүлэх, маргаж мэтгэлцэх, хэрэглэх үйл ажиллагаа Үндсэн хуулийн бичиг баримтаас өөрцгийг чухал юм.² Үндсэн хуульд нийцсэн үү үгүй юу гэдгийг шийдвэрлэх стандартууд, Үндсэн хуулийг хэрэглэх аргууд нь эрх зүйн шатлан захирах тогтолцоонд хамгийн өндөр байр суурь эзэлдэг. Эдгээр стантартууд Үндсэн хууль гэж юу вэ гэсэн гол асуулттай холбогддог.

Энд нэгэн хийсвэр туршилт хийе. Бид хайрцаг хийсэн бөгөөд түүнд тагтаанууд орох боломжтой нүх гаргасан. Энэ нүхний гадна талд хар товч, дотор талд нь хэд хэдэн өнгийн өөр өөр товчууд байрлуулав. Энэ туршилтыг бид дараах байдлаар явагдахаар зохиосон. Хэрвээ тагтаа хайрцагт нэвтрээд ногоон өнгийн товчийг товшвол хоёр өдрийн хоолыг идүүр лүү нь хийх бөгөөд үүний

дараа тэр тагтаанд нэг долоо хоног хоол өгөхгүй. Хэрвээ тагтаа хайрцагны доторх өөр нэг товчийг товшвол бага зэрэг эсвэл огт хоол авахгүй. Хэрвээ тагтаа хайрцаг руу нэвтрэхээсээ өмнө гадна талын хар товчийг товшвол түүнд бага зэргийн маш гоё хоол байнга өгнө. Тэгээд тагтаа хайрцагны дотор талын аль ч өнгийн товчийг дарсан гоё хоолоо авсаар байх болно. Энэ тохиолдолд хар товчийг эхлээд тоншихгүйгээр ногоон товчийг тоншсоных нь төлөө оногдуулдаг долоон өдрийн шийтгэлийг түүнд оногдуулахгүй. Тагтаанууд хайрцаг руу нэвтрэхээсээ өмнө хар өнгийн товчийг тонших хэрэгтэй гэсэн үнэт зүйлд суралцах болов уу? Тэд өөрсдийн амьдралыг сайжруулахын тулд дүрмүүдийн шатлан захирах ёсын дагуу өөрсдийгөө "хязгаарлах" уу?

Энэ хийсвэр туршилтыг Проф. Лавренс Трайб зөвлөсөн байдаг. Энэ нь "өөрийгөө хязгаарлах" гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн түлхүүр санааг ойлгоход бидэнд тусладаг. Аливаа Үндсэн хууль бүх хууль тогтоомжийг хязгаарладаг шигээ өөрийгөө хязгаарлах, журамлах ёстой.

Үндсэн хуультай адилтгах баримт бичгийг тайлбарладаг дүрмүүд нь Үндсэн хуулиас илүүдэд түвшнийх гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль гэж нэрлэгдсэн баримт бичиг сайн Үндсэн хуулийн гол хэсгийг хэзээ ч агуулдаггүй.

Мэдээж, хүмүүс бол тагтаанууд биш. Гэхдээ тавигдаах асуулт хэвээр. Дүрмүүдийн шатлан захирах ёсны дагуу хүмүүс өөрсдийгөө хязгаарлаж сурах уу? Үүний үр дүнд хүмүүс өөрсдийн амьдралаа дээшлүүлээд зогсохгүй оюун ухаан, туршлагад суурилсан илүү дэвшилтэт иргэншилд хүрэх боломжтой.

2. Ерөнхий байх

Энэ нь эрх зүйд тавигддаг хамгийн чухал зарчмуудын нэг юм. Эрх зүйн хэм хэмжээг нийтлэг нөхцөлөөр илрэх ёстой. Энэ санаа Германы эрх зүйн философийн

уламжлалд Кантын нэртэй холбогддог бол Английн эрх зүйн философийн уламжлалд Локкын нэртэй холбогддог.³ Локк "хууль тогтоох буюу хамгийн дээд байгууллага нь өөрийн эрх мэдлийг дур зоргоороо хэрэгжүүлж болохгүй бөгөөд шударга ёсонд захирагдах ёстой. Харин эрх олгогдсон шүүгчид иргэдийн эрхтэй холбоотой асуудлыг нийтэд зарлагдсан хуулиар шийдвэрлэнэ" гэсэн байдаг.

Эрх зүй нь төстэй нөхцөл байдалд байгаа бүх хүмүүст, бүх институтад адилхан (тэгш) хэрэгжих ёстой.⁴ Хууль нь ерөнхий байх ёстой бөгөөд тодорхой хувь хүнд зориулагдах ёсгүй.⁵ Эрх зүй төмөр нүүртэй байх ёстой, зохицуулж байгаа субъект рүүгээ хараад инээж, уурлаж болохгүй. Эрх чөлөөг хүртэх тэгш боломж нь тэгш хариуцлага хүлээх шаардлагыг бий болгодог. Эрх чөлөө байгаа цагт хариуцлага ямагт байдаг.

Энэ зарчим нь эрх зүйн тэгш хамгаалалт гэсэн Үндсэн хуулийн хамгийн ерөнхий шаардлагыг илэрхийлдэг. Энэ ойлголтын талаар өчнөөн өгүүлэл бичиж, ном зохиол туурвиж ирсэн нь түүнийг эрх зүй судлалд нэн чухал болохыг харуулж байдаг.

Эрх зүй ерөнхий байх ёстой гэсэн энэ зарчмын агуулга хоёр талтай. Нэг талаас эрх зүйн зохицуулалтад хамрагдаж байгаа субъектүүд рүү хандааг, нөгөө талаас тэдгээр эрх зүйн субъектүүдээс шаардаж эсвэл хориглож байдаг зүйлүүд рүү хандааг. Ерөнхий байх зарчмыг эхний агуулгаар нь зөрсөн жишээ бол тодорхой этгээдийг хоёрдмол утгагүйгээр заасан хууль юм. Харин тухайн орон зай, цаг хугацаанд тодорхой үйлдлийг хориглосон, эсвэл шаардсан хууль нь энэ зарчмыг хоёрдах агуулгаар нь зөрчдөг.⁶ Ф.А.Хаекийн хэлснээр хуулийг "ерөнхий байдлаар томъёолсон байх бөгөөд тодорхой цаг хугацаа, газар, тодорхой хүмүүсийг заагаагүй гагцхүү хүн бүрт тохиолдож болох нөхцөл байдлыг тодорхойлон өгөхлсөн байна."⁷ Эндээс үзэхэд ерөнхий байх зарчим аливаа тусгайлан хуулийн эсрэг чиглэдэг байна.

3. Нийтэд мэдэгдсэн байх

Эрх зүйг нийтэд мэдээлдэг, хэвлэдэг байх ёстой. Холбогдох хүмүүс түүнийг мэдэх боломжтой

¹ Barnabas D.Johnson, 1998, p. 2.

² "Үндсэн хууль бол шүүгчийн хэлсэн зүйл" (Judge Frankfurter), Ulrich Karpen, 1998, p. 174.

³ D. Neil MacCormick, 1997, p. 72.

⁴ Barnabas D.Johnson, 1998, p. 3.

⁵ Lawrence B.Solum, 1994, p. 122.

⁶ Richard Flathman, 1994, p. 304-305.

⁷ Ф.А.Хаек, 2004, 67 дахь тал.

байх хэрэгтэй. Ингэснээр хүмүүс ямар эрх эдэлж, үүрэг хүлээх вэ гэдгээ мэдэж авна. Аливаа зан үйлийн стандарт, хэм хэмжээг олон нийтэд мэдээлээгүй, мэдэх боломж олгоогүй бол хэрэгжүүлж болохгүй. Мэдэх боломжгүй "эрх зүй" нь ойлгомжгүй, ямар ч утга учиргүй зүйл юм. Тиймээс хууль бус. Мэдэх боломжгүй хууль байхгүйтэй адил. Харин хууль байхгүй байна гэдэг эрх чөлөө байхгүй байна гэсэн үг (Локк).

Хууль ёс бол Засгийн газрын бололцоог хязгаарлаж, түүнд бие хүний ажил хэрэгт дур зоргоороо хөндлөнгөөс оролцох хүчин чармайлтыг нь үгүй хийх боломж олгохгүй байдаг. Бие хүн тоглоомын дүрмийг мэдсэнээр өөрийн зорилгыг хэрэгжүүлэх эрх чөлөөтэй байх бөгөөд үүнд нь засгийн эрх баригчид саад хийхгүй гэсэн итгэлтэй байна.¹ Хэрвээ тэрхүү тоглоомын дүрмийг хувь хүмүүс мэдэж чадахгүй бол өөрийн зорилго, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь тэр дүрэм саад болно. Хамгийн гол нь эрх зүй өөрөөс нь юуг шаардаж байгааг мэдсэннээх үндсэн дээр хувь хүн өөрийн зорилгоо тодорхойлж төлөвлөгөөгөө боловсруулж чадна.

Нийтэд мэдэгдсэн байх зарчим нь шийдвэрлэх ач холбогдолтой хэдий ч ихэнхдээ орхигддог. Энэ нь шүүгчээс шийдвэрлэх гаргахаас өмнө жинхэнэ үндэслэлээ гаргадаг байхыг шаарддаг. Түүний үндэслэл нь хэлбэрийн төдий бус, харин холбогдох факт болон эрх зүйн зарчмуудаас урган гарах шүүгчийн сонголтыг харуулсан оюуны бодит үйл ажиллагаа байх шаардлагатай.² Түүнийг уншсан ердийн хүн шүүгчийм учраас энэ шийдвэрийг гаргасан юм байна шүү дээ гэж ойлгохуйц байх ёстой.

Хуулийн сургуулийн оюутнууд, хуульчид, шүүгчид, олон нийт шүүхээс урьд өмнө нь гаргасан бүх шийдвэрүүдийг хянаж үзэх, тэдгээрийн талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, шүүгч тухайн шийдвэрийг гаргахад хүргэсэн үндэслэл дэвшүүлэх процессийг шүүмжлэх боломжтой байх шаардлагатай. Үндэслэл дэвшүүлэх процесс гэдэгт фактуудыг цуглуулах, ангилах, зохион байгуулах, мөн тэдгээр фактуудад зохих эрх зүйн зарчмуудыг хэрэглэх, эрх зүйн үнэлгээ өгөх ажиллагааг ойлгодог.³

4. Тодорхой байх

Нийтэд мэдэгдсэн байх зарчимтай нягт уялдаатай зарчим бол тодорхой байх зарчим юм. Эрх зүй нь хоёрдмол утгагүй мэдээлэгдсэн байх ёстой. Зан үйлийн стандарт, дүрмүүдийг олж мэдэх боломжтой байх төдийгүй тэдгээр нь ойлгогдохуйц байх ёстой.

Жолооны үнэмлэх хурааж авахад баримтлах ёстой шударга процесс (үндсэн шударга ёс)⁴ нь хувь хүний эрх чөлөөг хязгаарлахад баримтлах шударга процессоос өөр нөхцөл байдлыг шаарддаг. Гэвч шударга процессийг судлаж байгаа судлаачдад "шударга процесс" гэдэг энэ хэллэг өөрөө тухайн тохиолдол бүрт тохирох зан үйлийн тодорхой стандартыг зааж өгдөг.⁵

Эрх зүйн хөгжлийн үр дүнд бий болсон түүхэн үнэт зүйлсийг үл тоомсорлож болохгүй. Олон зууны туршид шударга процессийг тодорхойлохыг оролдож ирсэн эрх зүйн тогтолцоонуудыг судалж ололт амжилтаас нь эзэлдэггүйгээр тухайн тохиолдол бүрт баримтлах шударга процессийг хэзээ ч "тодорхойлж" чадахгүй.

Шударга процесс (үндсэн

шударга ёс)-ийг эрж хайсан түүх Сократ, Платон, Аристотель нарын санаануудтай адил эртнийх. Шударга процесс гэсэн нэр томьёо анх III Эдвард 28-ын эртний статутагд илэрч байсан бөгөөд адл түмний төрийг хязгаарласан анхны хууль болох Магна Хартаг дурдагдаж байжээ. Магна Хартаг 1215 оны Анлийн Хаанд зориулан тогтоосон бөгөөд түүнд Грек, Ром, Жүд, Христ, Исламын эрх зүй судлахаас үүдэлтэй эрх зүйн зарчмуудыг хөгжүүлэн тусгасан гэдэг. Харин улс тэдгээр зарчмуудыг эзэлдэн авахдаа ичээгүй. Бид ч гэсэн гаднаас эрх зүй судлалын ололтыг эзэлдэн авахдаа ичих хэрэггүй гэж бодож байна.

Тухайн тохиолдол бүрт шударга процесс юуг шаардаж байгааг мэдэхийн тулд эртний шударга процесс судлал руу харах хэрэгтэй. Мэдээж хэрэг, тодорхой байх гэсэн зарчмыг төрүүлсэн түүхэн эх сурвалжуудтай танилцахгүйгээр, урьд өмнө нь гарч байсан олон мянган хэргүүдийг судлахгүйгээр үүнийг хийх боломжгүй юм.

Түүхэн ойлголтыг түүхтэй нь холбохгүйгээр тодорхойлж болохгүй гэдэг. Шударга процессийн тухай санаа хэдэн зуун жилийн тэртээд шийдэгдсэн мянга мянган хэргүүдэд агуулагдаж байдаг. Энэ мэргэн ухаан нь хүн бүхэнд хамаатай.

Зарим судлаачид тодорхой байх зарчмыг зөрчилгүй байх, боломжгүй зүйлийг шаардахгүй байх, хоёрдмол утгагүй байх гэсэн зарчмууд тодруулж байдаг гэж үздэг.⁶ Густав Радбрух "эрх зүйн дүрмүүд тодорхой байснаараа хувь хүмүүсийг төрийн дур зоргоос хамгаалж байдаг учраас эрх зүйн тодорхой байдал нь хамгийн дээд императив болдог" гэж тодорхой байх зарчмын ач холбогдлыг үнэлсэн. Эрх зүйн тодорхой байдлыг хангана гэдэг бол шударга бус хуулиас хамгаалж байгаа явдал огт биш, харин урьдчилан таамаглаж болохуйц байдлыг баталгаажуулж өгдөг.⁷ Энэ урьдчилан таамаглаж болохуйц байдал нь өөрсдийн ирээдүйг бие даан төлөвлөх, уг төлөвлөгөөндөө эрх зүйн шаардаж байгаа зүйлсийг тооцоолж оруулах боломжийг хүмүүст олгодог.⁸ Үүндээ энэ нь хүний нэр төрийг хүндэтгэж байгаа явдал юм. Эрх зүйн дэг журам нь хүмүүсийг хэнээс хараат бус бие даасан оюун ухаантай⁹ гэж хүлээн

¹ Ф.А.Хаек, 2004, 67 дахь тал.

² Barnabas D.Johnson, 1998, p. 4.

³ Barnabas D.Johnson, 1998, p. 4.

⁴ Англи – Америкийн эрх зүйд байдаг "Due Process of Law" гэсэн нэр томьёог шударга процесс гэж орчууллаа.

⁵ Barnabas D.Johnson, 1998, p. 4.

⁶ D. Neil MacCormick, 1997, p. 73

⁷ D. Neil MacCormick, 1997, p. 73.

⁸ "...эрх чөлөөт орны засгийн газрын үйл ажиллагаа урьдаас тогтоосон ил тод дүрэм журмаар хязгаарлагдсан байдаг, энэ нь ямар нэг нөхцөл байдалд засгийн төлөөлөгчид албадлагын ямар арга хэмжээ хэрэглэх вэ гэдгийг ихээхэн нарийн тодорхой утган мэдэх бололцоог олгодог гэсэн үг юм. Үүнээс үндэслэн бие хүн өөрийн үйл ажлыг бат итгэлтэй төлөвлөж болно. Хаек, 2004, 65 дахь тал.

⁹ Үүнийг Жозеф Рэз "хүмүүс өөрсдийн бие даасан харилцагатай шийдвэрүүд дээрээ үндэслэж үйл ажиллагаагаа явуулдаг" гэж хэлсэн байдаг.

зөвшөөрч хүндэтгэж байгааг тодорхой байх зарчим илэрхийлдэг. Хүний тухай энэ үзэл баримтлалыг ХБНГУ-ийн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд "Хүний нэр төрд халдаж болохгүй. Төрийн бүх эрх мэдэл хүний нэр төрийг хүндлэх, хамгаалах үүрэгтэй" гэж заасан. Харин Монгол Улсын Үндсэн хуульд "Хүн бүр эрх зүйн этгээд байна," "Монгол Улсын иргэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ" гэж заасан. Хүний нэр төрийг хүндлэх үүргийг Монголын төр нэгэн адил хүлээнэ.

5. Буцаан хэрэглэхгүй байх

Өөрсдөөс нь эрх зүй ямар зүйл шаардаж байгааг, ямар зан үйлийг хориглосон, тэрхүү зан үйлийг үйлдвэл ямар хариуцлага хүлээлгэх тухай хүмүүс урьдчилан мэдэх эрхтэй. Тиймээс эрх зүй ч өчигдөр хууль ёсны байсан ч өнөөдөр хууль буст тооцож байгаа зан үйл үйлдсэнийх нь төлөө хэнд ч хариуцлага тооцож болохгүй. Хуулийг буцаан хэрэглэж болохгүй. Буцаан хэрэглэж байгаа хууль нь хэзээ ч өөрчлөгдөж магадгүй гэсэн ачуулгыг бий болгох замаар ирээдүйн эрх зүйн үйлчлэлийг сулруулдаг, мөн хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулж чаддаггүй.¹ Энэ нь эрүүгийн эрх зүйн стандарт юм. Энэ зарчмыг эрх зүйн бусад салбарт хэрэглэх нь илүү төвөгтэй байдаг.

Эрх зүйн аливаа тогтолцоонд хариуцлага хүлээх тухай ойлголт гол байр суурь эзэлдэг. Хуулийг буцаан хэрэглэснээр (зарим онцгой тохиолдлоос бусад үед) тэрхүү үндсэн ойлголтын мөн чанарт эргэж засагдахааргүй хохирол учруулдаг. Хүмүүс юу буруу, юу зөв болохыг мэдэхгүй болдог.

Энд нэгд зүйлийг онцолж хэлэх ёстой. Эдгээр зарчмуудад туйлын утга байхгүй. Тэднийг хад чулуун дээр сийлээгүй. Энгийн ухамсраар ойлгогдох тэр хүрэнээс цааш чиглэсэн үнэт зүйлсийг эдгээр зарчмууд тусгаж байдаг. Эдгээр зарчмуудын дундаас буцаан

хэрэглэхгүй байх зарчмыг ойлгоход төвөгтэй. Заримдаа түүний хүчийг сулруулах, бүр үл хэрэглэх тохиолдол бий. Дээр дурдсанчлан эрүүгийн эрх зүйд энэ зарчмыг тууштай баримтлах ёстой. Харин эрх зүйн бусад салбарт хэрэглэхгүй байхыг заримдаа хүлээн зөвшөөрдөг.²

Буцаан хэрэглэхгүй байх зарчмыг шинээр хэрэгжүүлэхийг зорьж буй улс орнууд эрт дээр үеэс хөгжиж ирсэн эрх зүй судлалд анхаарлаа хандуулж, түүний ололтуудыг ашиглаж хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Дэлхийн эрх зүй судлалын баялаг ололтоос татгалзах нь нэгэнт бий болгосон мэргэн ухааныг дахин бий болгохтой адил ухаалаг бус алхам. Дэлхийн худалдааны сүлжээ, банкны систем, аюулгүй байдлын ашиг сонирхол, эзэл тооцооны тогтолцоо зэргийг дахин нээх, бий болгохтой адил тэнэг хэрэг.

Аливаа улс бусад орны эрх зүйг зээлдэн авч байдаг. Хуулийг зээлдэн авах нь шинжлэх ухааны ололтыг зээлдэн авахаас ч илүү байж мэднэ. Хэлэхийг хүсч байгаа зүйлээ бид хэлж болно гэхдээ дэлхийн эрх зүй судлалаас татгалзах хэрэггүй л болов уу. Хамгийн холыг хардаг хүмүүс аугаа суутнуудын мөрөн дээр гишгэж явдаг.

6. Өөрчлөмтгий бас тогтвортой байх

Эрх зүй нь байнга өсөж дэвшиж байдаг, түүний хэл ч хөгждөг. Аливаа эрх зүйн тогтолцоо тэрхүү хөгжлийн процессийнхоо хүрээнд орших ёстой. Тиймээс эрх зүй нь өөрчлөмтгий хэрнээ тогтвортой байх, өөрөөр хэлбэл, эрх зүйн хувьслын явцад үл өөрчлөгдөх үндсэн зарчмуудын дагуу л өөрчлөгдөх ёстой.³ Тэдгээр нь шүүгчид шийдвэрийнхээ жинхэнэ үндэслэл болодог зарчмууд юм.

Халуунаар үлээж байснаа гэнэт хүйтнээр үлээх мэт огцом өөрчлөгддөг эрх зүй нь хүмүүст алсыг харж үйл ажиллагаагаа зохицуулах боломж олгодоггүй, урьдчилан таамаглахад бэрх байдлыг үүсгэдэг. Энэ нь эрүүл ухааны шаардлагыг хангаж чадахгүй, ямар ч утга учиргүй (абсурд) зүйл бөгөөд ерөөс эрх зүй биш.

Эрх зүйн дүрмүүд нь хүмүүсийн хувийн зорилгодоо хүрэх багаж хэрэгсэл болж байдаг. Тиймээс

эдгээр дүрэм нь зарим хүн түүнийг өөртөө бусдаас илүү ашигтайгаар ашиглаж чадахгүй гэсэн итгэл төрүүлэхгүй байхын тулд урт удаан хугацааных байх учиртай.⁴

7. Ухаалаг (рационал) байх

Бүх эрх зүй болоод эрх зүйг бүтээх ажиллагаа ухаалаг (рационал) байх ёстой. Энэ зарчим маш өргөн хүрээнд хэрэгждэг. Ухаалаг байдлаа гэсэн эрх зүйд ямар ч үнэ цэнэ байхгүй, ердөө л "эрх зүй" гэсэн нэр зүүснээс цаашгүй.

Ухаалаг эрх зүй өнгөрсний туршлагад үндэслэн одоогийн мэргэн ухааныг ирээдүйн үйл ажиллагаа руу хөрвүүлэхийг хичээдэг. Тэрхүү мэргэн ухаан нь логик (тодорхой бодол санаа, илэрхийллийн дүрмүүд)-оор журамлагдаж, шинжлэх ухаан (үнэ цэнэ бүхий туршлага, туршилт, ажиглалтыг бүгдийг нь багтаасан бүх таамаглалын нийлбэр)-аар боловсрогдож, хүн байна гэдэг нь чөлөөт хүсэл зоригоо хэрэгжүүлэх, ухаалаг сайн сонголт (олон янзын хувилбарууд дундаас хийсэн ухаалаг, тэнцвэртэй, төгс сонголт) хийх, зан үйлээ сайн үйлдэл, үнэт зүйлээр баяжуулахын нэр гэсэн итгэл найдваараар хөглөгддөг.⁵

8. Боломжгүй зүйлийг шаардахгүй байх

Эрх зүй боломжгүй зүйлийг шаардах ёсгүй. Эрх зүй нь биелүүлж чадахааргүй зан үйлийг хүмүүсээс шаардаж болохгүй.⁶ Дээр тэмдэглэсэнчлэн, эрх зүй нь хүний амьдралын ухаалаг байдлыг судалж ирсэн философи, эрх зүй судлалын ололтууд дээр тулгуурлах хэрэгтэй. Ухаалаг бус эрх зүйд итгэх ямар ч боломж байхгүй. Хүнээс боломжгүй зүйл шаардаж байгаа эрх зүй зөвхөн ухаалаг бус төдий биш бас абсурд (энгийн ухамсраар үл ойлгогдох, утгагүй), тиймээс хууль бус.

Хүн төрөлхтөн шударга бус хуулийг биелүүлэхээс татгалзах нь боломжгүй биш гэж үзсэн. Жишээлбэл, хүмүүсийг төрлөөр устахыг тушаасан даргын тушаалыг биелүүлэх ёсгүй. Гэвч үндсэн шударга ёсны үүднээс хүн төрөлхтөн тушаал өгсөн даргд нь шүүх ажиллагаа явуулна. Дарангуйлал үйлдэж байсан дээд албан тушаалтан бол хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд.

¹ Ulrich Karpen (ed.), 1988, p. 227.

² M.D.A. Freeman, 2001, p. 160.

³ Barnabas D.Johnson, 1998, p. 6.

⁴ Barnabas D.Johnson, 1998, p. 5.

⁵ Ф.А.Хаек, 2004, 66 дахь тал.

⁶ Barnabas D.Johnson, 1998, p. 3.

⁷ M.D.A. Freeman, 2001, p. 160.

9. Зөрчилгүй байх

Эрх зүй нь логик уялдаа бүхий тогтолцоо байх учиртай. Хэдийгээ дээр дурдсанчлан сайн шийдвэр гаргахын тулд өрсөлдөгч үнэт зүйлүүдийг жигнэж үзэхийг шаардаж боловч амны зүүн талын шаардаж байгаа зүйлийг баруун тал хоригож болохгүй.

Хүний ертөнц төгс биш учраас янз янзын эрх зүйн эх сурвалжууд хоорондоо зөрчилтэй зан үйлийн стандартуудыг шаардаж байдаг. Тиймээс эрх зүйн эх сурвалжууд бие биенээ шатлан захирдаг байх шаардлагатай. Захиргааны акт нь хуульд, хууль нь Үндсэн хуульд, Үндсэн хууль нь нийтлэг үндсэн хуульд захирагдаж байх ёстой. Эдгээр эх сурвалжууд нь хамтдаа логик уялдаа бүхий тогтолцоог бий болгодог.

Эцэст нь бид жин банг нь тааруулсан мэргэн ухаан буюу ухаалаг байдалд үндэслэсэн шатлан захирах ёс бүхий эрх зүйн тухай ойлголт дээр эргэж ирлээ.

10. Нийцсэн байх

Эрх зүй албаны харилцааг хувийн болон бизнесийн харилцаанаас дутуугүй зохицуулдаг байх ёстой. Төрийн аливаа үйл ажиллагаа хуулийн дагуу байх ёстой. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа хуульд нийцэх ёстой.¹ Төрийн үйл ажиллагааг үнэлж болохуйц байх ёстой. Эрх зүйг бүтээж байдаг дүрмүүд нь төрийн хөндлөнгийн оролцоог хааж, дүр зоргыг нь хязгаарладаг байх ёстой.²

Албаны үйл ажиллагаа эрх зүйд нийцэх ёстой гэсэн шаардлага чухал ач холбогдолтой. Эрх зүй гэж зөвхөн удирдагчаас удирдуулж байгаа субъектүүдэд удирдахын тулд тогтоосон тэр зүйл биш. Төр ард түмэнд зориулж эрх зүйг зохиодоггүй. Үнэн хэрэгтээ хууль нь ямар нэг хууль тогтоох байгууллагаас хамаагүй өмнө байсан зүйл юм.³ Үндсэн хуульд ардчилалд эрх зүйг ард түмэн тогтоох бөгөөд тэрхүү эрх зүйд ард түмэн өөрсдөө төдийгүй төр

захирагдах ёстой. Тиймээс төрийн хууль гэж байх ёсгүй.

Үндсэн хуулийн эрх зүй төрийг зохицуулж, хязгаарлахад гол анхаарлаа хандуулдаг. Тиймээс төрөөс үндсэн хуулийн эрх зүйг тогтооно гэж ярих нь ухаалаг (рационал) бус. Нэгэн удаа Иракийн удирдагч асан Садам Хуссейн "Би Иракт шинэ Үндсэн хууль тогтооно" гэж зарласан гэдэг. Бидний өмнө өгүүлж байсанчлан, ийм Үндсэн хууль нь ухаалаг байх зарчмыг зөрчсөн утгагүй, зөрчилтэй зүйл.

III. Дүгнэлт

Германы "Rechtsstaat," Англи-Америкийн "Rule of Law" гэсэн ойлголтуудын агуулгыг эн тэргүүнд нэгтгэдэг зүйл нь дээр дурдсан формаль зарчмууд юм. Учир нь эдгээр зарчмууд хүн төрөлхтний нийтлэг ёс суртахууны үнэт зүйлд үндэслэдэг. Тиймээс "Rule of Law"-ын талаархи хамгийн сайн ойлголт бол "Rechtsstaat"-ийн ойлголт гэж хэлэгдэх болсон.⁴ Тэд адилхан зарчмууд дээр тулгуурладаг.

Хууль бүтээх ажиллагаанд эдгээр зарчмуудыг баримтлах нь хүний нэр төрийг хамгаалах зайлшгүй нөхцөл юм бол бид зөвхөн эрх зүйт ёсыг төгөвшүүлэх замаар л хүний нэр төр, эрх, эрх чөлөөг хамгаалж хангаж чадна. Хууль тогтоох засгийн бүрэн эрхийг хязгаарладаг эдгээр зарчим ямар хүлбэртэй байлаа ч гэсэн хувь хүний салшгүй эрх, хүний эрхийг зөвшөөрөн хүлээхээр бодсон байдаг юм.⁵ Тийм ч учраас 1948 оны Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын оршилд "хүмүүс эзэрхэг засаг, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг эрх зүйт ёсоор хамгаалах нь зайлшгүй чухал"⁶ гэж заасан.

Эх сурвалж

Монгол хэлээр:


1. Дэвид Боаз, *Либертарианизм (Хувь хүний эрх чөлөөний философи)*, Орч. Б.Батчулуун, Монсудар, 2005.
2. Ф.А.Хаек, *Боолчлогдох зам*, Орч. П.Чойжил, Монсудар, 2004.
3. *Эрдэм шинжилгээний бага хурлуудын Илтгэлийн*

эмхтгэл (Бүгд найрамдах улс тунхагласны болон Анхдугаар Үндсэн хууль батлагдсан 80 жил, Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 13 жилийн ойд зориулсан). Ханнс Зайделийн Сан, 2005.

4. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.

Англи хэлээр:

5. *Universal Declaration of Human Rights*, 1948.
6. Barnabas D. Johnson, *Rule of Law (Governing Law and Law-Making)*, 1998.
7. M.D.A. Freeman, *Lloyd's Introduction to Jurisprudence*, Seventh Edition, London, Sweet & Maxwell LTD, 2001.
8. D. Neil MacCormick, 'Rechtsstaat' and Rule of Law, *The Rule of Law*, Edited by Josef Thesing, Konrad-Adenauer-Stiftung, 1997.
9. Ulrich Karpen, *Rule of Law, The Constitution of the Federal Republic of Germany*, Edited by Ulrich Karpen, Baden – Baden: Nomos Verl.-Ges, 1988.
10. Lawrence B. Solum, *Rule of Law: Nomos XXXVI*, Edited by Ian Shapiro, New York University Press, 1994.
11. Richard Flathman, *Liberalism and the Suspect Enterprise of Political Institutionalization: the Case of the Rule of Law*, *Rule of Law: Nomos XXXVI*, Edited by Ian Shapiro, New York University Press, 1994.
12. Ronald Dworkin, *Law's Empire*, The Belknap Press of Harvard University Press, 1986, Fuller L., *The Morality of law*, New Heaven, Yale University press, 1964.



¹ Lawrence B. Solum, 1994, p. 122.

² D. Neil MacCormick, 1997, p. 74.

³ Дэвид Боаз, 2005, 152 дахь тал.

⁴ D. Neil MacCormick, 1997, p. 77.

⁵ Ф.А.Хаек, 2004, 74 дэх тал.

⁶ Preamble, *Universal Declaration of Human Rights*, 1948.

Монголын цагдаагийн байгууллагын түүхэн замналаас

ЦЕГ-ын ажилтан, цагдаагийн дэд хурандаа З.Батсүх

1921 оны Ардын хувьсгалын ялалтын дараахнаар ардчилсан төр, засгийн тогтолцоог шинээр зохион байгуулах ажлын эхэн үед Цэргийн яамны харьяанд "Сэргийлэх цэргийн салаа" байгуулж, ард түмний амь бие, эд хөрөнгөд халдагсадтай тэмцэх, хэв журам, энх амгаланг сахиулах, улс орны дотоод байдал, хувьсгалын ололтыг хамгаалах үйл хэрэгт үйл ажиллагааг чиглүүлж байсан юм. Энэ нь Монгол Улсын шинэ үеийн Цагдан сэргийлэх байгууллагын үүсэл байсан бөгөөд бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх, шинэчлэн сайжруулах талаар хувьсгалын эхний жилүүдээс эхлэн шат дараалсан арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байлаа. Намын төв хороо, Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 18 дугаар хурлаар "Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм" батлан мөрдүүлсэн байх ба 1924 онд хуралдсан Улсын анхдугаар их хурлаар Цагдан сэргийлэхийг Цэргийн яамны харьяаллаас Дотоод явдлын яамны харьяанд шилжүүлжээ.

Ийнхүү Цагдаагийн байгууллагын эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгохын зэрэгцээ үндсэн үүрэг зорилтыг нарийвчлан тодотгож, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах, гал түймэртэй тэмцэх, автозамын хөдөлгөөнийг зохицуулан хянах үүргүүдийг гүйцэтгэж байсан юм.

Цагдаагийн байгууллагын энэхүү үүрэг нь хувьсгалын ололтыг бататгах эздрээ түвэгтэй үе, түүнээс хойш дайн самууны болон бүтээн байгуулалтын жилүүдэд ч боловсронгуй болон шинэчлэгдэж ирсэн юм. Зах зээлийн харилцаанд шилжсэн сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллага бие даан

ажиллаж, бүтэц зохион байгуулалт, мэргэжлийн боловсон хүчний хангалт, холбоо, техник, зэвсэглэмжийн хувьд шинэчлэгдэн бэхжсээр байна. Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх үндсэн зарчмыг удирдлага болгон ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага гүйцэтгэж байгаа үүрэг, өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Хууль зүйн албадтай байнга ажлаа уялдуулан зохицуулж нягт хамтран ажиллаж ирсэн түүхэн уламжлалтай юм.

Цагдаагийн ерөнхий газар нь 1996 оноос Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 1993 онд УИХ-аар хэлэлцэн баталсан "Цагдаагийн байгууллагын тухай хууль" нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс суурь болж байгаа бөгөөд цагдаагийн үйл ажиллагаагаар заалт нь хэрэгждэг олон хуулиуд шинэчлэгдсэний зэрэгцээ дээрх хуульд нийцүүлэн дотооддоо олон арван журам, заавар батлан мөрдсөнөөр эрх зүйн таатай орчин бүрдэж шинэчлэгдсээр байна.

Гэвч сүүлийн жилүүдэд улсын хэмжээгээр эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн нь хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах шаардлагыг бий болгож байна.

Урьд өмнө манай улсад гарч байгаагүй шинэ төрлийн гэмт хэргүүд ч янз бүрийн хэлбэрээр илрэх болов.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай илрүүлэх, албадын ажлын уялдааг сайжруулах, мэргэжлийн удирдлагаар хангах, албаны шуурхай бэлэн байдлыг дээшлүүлэх, машин техник, харилцаа холбооны хүч чадлыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх талаар тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх талаар тодорхой зорилт дэвшүүлэн тусгай төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Монголын цагдаагийн байгууллагын түүхт 85 жилийн ойг угтсан ажлын хүрээнд олон талт ажил зохиож, ойгоо амжилт бүтээлээр угтлаа.

2006 оны эхний хагас жилд улсын хэмжээнд 8969 гэмт хэрэг гарч бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал гэмт хэргийн тоо 93-аар буюу 1.0 хувь буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 91.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.4 хувиар ахисан үзүүлэлт юм.

Ажлын ахиц ололт нь манай алба хаагчдын уйгагүй хөдөлмөр зүтгэлийн үр дүн юм. Цаашид гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд ард иргэд, засаг захиргааны хүч туслалцааг аль болох өргөнөөр авч хамтран ажиллахын зэрэгцээ иргэдээс ирүүлсэн гэмт хэргийн холбогдолтой өргөдөл мэдээллийг бүрэн гүйцэд шуурхай шалган шийдвэрлэхэд цагдаагийн бүх шатны удирдлага онцгой анхаарах байна.

Өнөөдрийн болон ирээдүйн цагдаагийн байгууллагын өөрчлөлт шинэчлэлтэд дэлхийн олон улсын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тодорхой төсөл боловсруулж хэрэгжүүлэх, алба хаагчдаа сургаж, дадлага сургууль хийлгэх, туршлага судалж нэвтрүүлэх, мөн дотооддоо ч боловсон хүчнийг сургах, давтан сургах ажлыг шинэлэг арга хэлбэрээр явуулж, чанар үр дүнд дээшлүүлэх шаардлагатай байгаа юм.

Цагдаагийн түүхэнд холбогдох лавлагаа

1921 он:

✓ 7 дугаар сарын 19-ний өдрийн Засгийн газрын 6 дугаар хуралдаанаар Цагдан сэргийлэх байгууллагыг Цэргийн яамны бүрэлдэхүүнд байгуулж "Сэргийлэх цэргэ" гэж нэрлэхээр тогтжээ.

1922 он:

✓ 3 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн цагдаа нарыг хугацаат цэргийн албан хаагчийн адил хуаранд байрлуулахгүй, гэр орноор нь суулган ажиллуулж, сар бүр 9 лангийн цалин олгож байх болжээ.

✓ Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хороо 134 орон тоотой, анхны даргаар нь Жанжидын Гүрсэд томилогдов.

1923 он:

✓ 2 дугаар сарын 15-аас цагдаа нарын цалинг 27 лан болгон нэмжээ.

✓ Цагдан сэргийлэх байгууллагыг цэргийн яамны захиргаанаас гаргаж Дотоод явдлын яамны бүрэлдэхүүнд шилжүүлэн улсын цагдан сэргийлэх газар болгон зохион байгуулсан.

✓ Хөдөө, орон нутагт цагдаагийн байгууллагын эхлэл бий болов.

✓ 7 дугаар сард Улиастай хотод бага дарга 1, цагдаа 4 орон тоотой салбар байгуулсан нь хамгийн анхных нь ажээ.

1925 он:

✓ Нийслэл хүрээнд гадаадынхны мэдэлд байсан усан хөөрөгний газрыг улсын мэдэлд худалдан авч, анх удаа, Улсын галын аюулаас хамгаалах албыг байгуулжээ.

✓ Энэ оны эхээр Магсар хурцын Дугаржав Цагдан сэргийлэх байгууллага (ЦСБ)-ын даргаар ажиллаж байжээ.

1926 он:

✓ ЦСГ-ын шинэ дүрэм батлагдсан ба газрын даргаар их зохиолч Д.Нацагдоржийн эцэг Ц.Дашдорж томилогджээ.

1927 он:

✓ Бүрэн бус мэдээгээр энэ онд эрүүгийн том, жижиг 2 мянга шахам гэмт хэргийг илрүүлэн шийдвэрлэжээ.

1928 он:

✓ Үйлдвэр, аж ахуй, хоршооллын зарим чухал газрыг хамгаалах цагдаагийн гэрээт харуул анх бий болжээ.

✓ Энэ онд ЦСБ-ын даргаар Г.Бумцэнд ажиллаж байв.

1929 он:

✓ ЦСБ-ын эрхэлж байсан эрүү, иргэний хэргийг хотын шүүн таслах газарт харьяалуулж, ЦСБ-ыг дан ганц сэргийлэн хамгаалах ажил эрхлүүлэхээр шийдвэрлэж байжээ.

1930 он:

✓ Гадаад худалдааны пүүс, хар, шар феодалын хөрөнгө хураах ажил хүчтэй байсан учир өмчийн гэмт хэрэг эрс өссөн бөгөөд энэ бүхэнтэй тэмцэхэд ЦСБ онцгой үүрэг гүйцэтгэж байв.

1932 он:

✓ ЦСБ зөвхөн Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяанд ажиллаж байсныг өөрчилж, Дотоодыг хамгаалах газрын бүрэлдэхүүнд шилжүүлэн үйл ажиллагааг нь өргөтгөн зохион байгуулжээ.

1934 он:

✓ Сэлэнгэ аймгийн цагдан сэргийлэх ангийг байгуулж, даргаар нь М.Чойдогийг томилжээ.

✓ Хөвсгөл аймгийн цагдан сэргийлэх ангийг байгуулж, даргаар нь Төгсийн Ёндонг томилжээ.

1936 он:

✓ 1936 оны 2 дугаар сард ДХГ-ыг ДЯЯ болгон өргөтгөхөд УЦСБ-ыг түүний бүрэлдэхүүнд байхаар зохион байгуулсан байна.

✓ Улс төрийн аппарат, шуурхай эрэн сурвалжлах, сэргийлэн хамгаалах, хот хамгаалах, гэрээт харуулын, аж ахуй, санхүүгийн тасаг байгуулж мөн эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, эрэн сурвалжлах тасгийг гүйцэтгэх албаны хэлтэс болгон өргөтгөжээ.

✓ Сайд нарын зөвлөлийн 1936 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолоор Уурын тэргэний хэлтэс байгуулав.

1937 он:

✓ ЦСБ-ын улс төрийн аппаратын харьяа нам, эвлэлийн товчоодыг байгуулсан бөгөөд цагдан сэргийлэхийн ажилтнуудыг цэргийн албаны ээлжийн татлагаас чөлөөлөх журам гарчээ.

1938 он:

✓ Хэнтий, Булган, Архангай, Завхан, Өвөрхангай, Дорноговь, Ховд аймгуудад цагдан сэргийлэх анги байгуулжээ.

✓ ЦСБ-ын гүйцэтгэх ажилтны нэг жилийн сургуулийг анх удаа 28 сурлагчтайгаар нээж хичээллүүлжээ.

1940 он:

✓ УЦСЕГ-ын бүрэлдэхүүнд паспортын хэлтэс шинээр байгуулж даргаар нь Бат-Очирын Лувсаншаравыг томилжээ.

✓ Увс, Говь-Алтай, Баян-Өлгий аймагт цагдан сэргийлэх анги байгуулжээ.

✓ 5 дугаар сарын 25-аас ЦС-ийн нийт ажилтнуудад хууль ёсны ээлжийн амралтыг жил бүр олгож байх журам гарчээ. Үүнээс урьд нь ээлжийн амралт авч байгаагүй, зөвхөн өвчин, гачигдалтай хүнд чөлөө олгодог байжээ.

✓ Энэ үед Дотоод явдлын яам, цагдан сэргийлэхийн ажилтнуудын өдөрт ажиллах цагийн хуваарь нь өглөө 10-16, орой 20 цагаас 01 цаг хүртэл үргэлжилдэг байжээ.

1941 он:

✓ Ардын цагдан сэргийлэхэд туслах сайн дурын бригадыг анх байгуулжээ.

✓ Зөвлөлтийн улаан армид туслах ажил эхэлж, цагдан сэргийлэхийн ажилтнууд 2 сарын хугацаанд 55 мянган төгрөг хуримтлуулж хандивлажээ.

1942 он:

✓ Сүхбаатар, Дундговь, Баянхонгор аймагт цагдан сэргийлэх анги байгуулжээ.

1943 он:

✓ Төв аймгийн цагдан сэргийлэх анги байгуулагджээ.

✓ Энэ онд хүн амины хэрэг 12 гарсны 8-ыг онд нь багтаан илрүүлж байжээ.

1944 он:

✓ УЦСГ-ын гүйцэтгэх хэлтсийн бүрэлдэхүүнд нэг тасаг шинээр нэмэн байгуулж, түүнд эрэлч нохойн алба, тоо бүртгэлийн групп, хээ шинжилгээ, гэрэл зургийн ажил хариуцуулжээ.

1945 он:

✓ Энэ оны 9 дүгээр сард гүйцэтгэх хэлтсийн 2 дугаар тасгийг улс, олон нийт, хоршооллын өмчид халдагчид ба дамын наймаачидтай тэмцэх үүрэг бүхий хэлтэс болгон өргөтгөжээ.

✓ Улаанбаатар хотын цагдан сэргийлэх ангийг дахин шинээр байгуулж, даргаар нь ахмад Н.Маналжав, орлогчоор Г.Чойдон нарыг томилжээ.

1946 он:

✓ 1946 оны 9 дүгээр сарын 12-нд ДЯА-ны сайдын 504 тоот тушаалаар ЦСГ-ын дэргэдэх мөрдөн байцаах тусгай групп байгуулсан нь одоогийн мөрдөн байцаах газрын эх суурь юм.

1947 он:

✓ Мөрдөн байцаах групп мөрдөн байцаах хэлтэс болон өргөжиж, уурын тэрэгний хэлтсийн дэргэд мөрдөн байцаах тасаг байгуулагджээ.

1949 он:

✓ 1949 оны байдлаар улсын цагдан сэргийлэх газрын төв аппаратад ажиллаж байсан 135 офицерын дотор дээд боловсролтой 4, дунд боловсролтой 17, хөдөөгийн 118 офицeroос дээд боловсролтой 1, дунд боловсролтой хүн 20 ажиллаж байжээ.

1957 он:

✓ 1957 оны 7 дугаар сард онц сэргийлэгчдийн анхдугаар зөвлөгөөн Улаанбаатар хотод болж, тэргүүний 200 гаруй офицер, сэргийлэгч шалгаран оролцжээ.

1958 он:

✓ 1958 оны 5 дугаар сарын 24-нд МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны 166 тоот тогтоолоор УЦСГ-ыг ерөнхий газар болгосон байна. Энэ үед УЦСГ-ын даргаар хошууч генерал

Ц.Нансалжав, орлогч бөгөөд гүйцэтгэх албаны хэлтсийн даргаар хурандаа С.Рэнцэнхорлоо нар ажиллаж байв.

1960 он:

✓ УЦСГ-т 1960 онд Шинжлэх ухааны техникийн тусгай тасгийг байгуулсан нь гэмт хэрэгтэй тэмцэхэд шинжлэх ухааны техникийн ололтыг ашиглаж, хурууны хээ, авто ба ердийн хөсөг, хүний ул мөр, эвдрэл, багаж хэрэгслийн мөр, бичгийн шинжилгээг бие даан хийдэг болжээ.

1961 он:

✓ 1961 оны 7 дугаар сард онц сэргийлэгч, тэргүүний гал сөнөөгчдийн 2 дугаар зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо хийж, 324 төлөөлөгч оролцжээ.

1962 он:

✓ 1962 оны 6 дугаар сарын 3-нд МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны 212 дугаар тогтоолоор УЦСГ-ын даргыг НАХЯ-ны 1 дүгээр орлогч байхаар тогтоож, хэлтсийн дарга, орлогчдоос доош албан тушаалын ажилтныг томилох, халах, төсөвт арга хэмжээ, санхүү аж ахуйгаа бие дааж шийдэх болгож эрхийг өргөтгөж байжээ.

✓ 1962 онд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар ЦСБ-ын ажилтан, олон нийтийн бригадын гиүүшдийн нэр хүнд, эрүүл мэнд, амь биед халдагсдад эрүүгийн хариуцлага хүлээлгэж байх болов.

1963 он:

✓ 1963 оны 10 дугаар сарын 25-нд Засгийн газрын 499 дүгээр тогтоолоор Улсын цагдан сэргийлэхийн дүрмийг шинэчлэн баталж сэргийлэгч нар тангараг өргөдөг журмыг анх удаа бий болгожээ.

1964 он:

✓ 1964 оны 8 дугаар сард МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны тогтоолоор /218 дугаар/ мөрдөн байцаах ажлыг ЦСБ-д төвлөрүүлэхээр шийдвэрлэж, НАХЯ-ны сайдын 1964 оны 8 дугаар сарын 24-ний 511 тоот тушаалаар мөрдөн байцаах газрыг 3 хэлтэстэйгээр байгуулжээ.

1965 он:

✓ БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1965 оны 2 дугаар сарын 9-ний 26 дугаар зарлигаар УЦСБ-ыг улаан тугтай болгож баярын өдрийг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдөр хийж байхаар тогтоожээ.

1966 он:

✓ 1966 оны 7 дугаар сард Цагдан сэргийлэх байгууллагын 45 жилийн ойг тэмдэглэж, УЦСБ-ыг Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ. Шагналыг БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу гардуулав.

1967 он:

✓ МАХН-ын Төв хорооны 305 дугаар тогтоолын заалтын дагуу 1967 онд УЦСГ-т эрүүгийн нэгдсэн тоо бүртгэл ба шалтгаан нөхцөлийг судлах, тусгай тасгийг байгуулан ажилд нь 1967 оны 8 дугаар сарын 1-ээс оруулжээ.

1968 он:

✓ УЦСБ-д туслах хүчний тэргүүний гишүүдийн улсын анхдугаар зөвлөгөөнийг Улаанбаатар хотод цагдан сэргийлэх байгууллага удирдан зохион байгуулж хийжээ.

✓ 1968 онд Москва хотод болсон социалист орнуудын цагдан сэргийлэх байгууллагын V симпозиумд анх удаа Монголын ЦСБ-ын төлөөлөгчид оролцож, түүнээс хойш тасралтгүй 15 дугаар симпозиум хүртэл оролцжээ.

✓ 1968 онд насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх хэлтсийг УЦСГ-т байгуулжээ.

1969 он:

✓ 1969 оны сүүлчээс эхлэн Криминалистикийн кабинетег өөрчлөн байгуулж Сургалтын төв болгож эхэлсэн байна.

✓ 1969 оны эхээр УЦСБ-ын төв, хөдөөгийн өмчийн төлөөлөгч нарын зөвлөгөөн семинар хийж туршлага солилцуулан албаны мэдлэгийг ахиулж байжээ.

✓ С.Будрагчаа 1969 оны 2 дугаар сард НАХЯ-ын нэгдүгээр орлогч сайд, УЦСГ-ын даргаар томилогджээ.

1970 он:

✓ МАХН-ын Төв хорооны улс төрийн товчоо 1970 оноос эхлэн нэгдсэн арга хэмжээ /операция/ зохиож эхэлсэн байна.

✓ 1970 оны Сайд нарын Зөвлөлийн 398 дугаар тогтоолоор УЦСЕГ-ын гүйцэтгэх албаны хэлтсийг татан буулгаж, оронд нь ЭХЭС, сэргийлэн хамгаалах хэлтсүүд байгуулжээ.

1971 он:

✓ 1971 оны 7 дугаар сарын 16-нд онц сэргийлэгч, гал сөнөөгчдийн улсын IY зөвлөгөөн болжээ. ЭХЭС албаныхан 1970 оны 8 сард улсын төв музейгээс алдагдсан 260 мянган төгрөгийн үнэ бүхий алт, мөнгөний хулгайчийг олж илрүүлжээ.

✓ ЦСБ-ын 50 жилийн ойг тэмдэглэж, хурандаа С.Рэнцэнхорлоо, дэд хурандаа Y.Жамбадагва, ахлах дэслэгч Р.Өлзийбуян нар гавьяат хуульч цол шагнаулжээ.

1972 он:

✓ 1972 онд ЭХЭС албаны шугамаар ЗХУ-д туршлага судлах групп явж ажиллажээ.

✓ ЗХУ болон социалист орны ЦСБ-ын туршлагаас суралцах зорилгоор хэвлэл мэдээллийн групп анх байгуулагджээ.

1973 он:

✓ БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1973 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод хэв журам сахиулах эргүүлийн албанд ГАЗ-24 машин 4, ГАЗ-69 машин 1, УАЗ машин 4, мотоцикл 60-г тус тус олгож эргүүл жижүүрийн албанд үйлчлэх болжээ.

1974 он:

✓ БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1974 оны 216 дугаар зарлиг, түүнийг биелүүлэх зааврын дагуу ЗХХБ-аас суллагдсан зарим хүмүүст захиргааны хяналт тогтоон ажилладаг болов. 1974-1980 онд 2897 хүнийг хүлээн авч бүртгэсний дотроос 644 хүнд хяналт тогтоожээ.

✓ 1974 онд ЦСБ-ын тусгай дунд сургууль Сайд нарын Зөвлөлийн тогтоолын үндсэн дээр байгуулав.

1975 он:

✓ 1975 онд урьдчилан мөрдөн байцаалт явуулсан хэрэг 1971 оноос 17.9 хувь, шийдсэн хэрэг 4.2 хувь анхны хугацаанд шийдсэн хэрэг 18.1 хувь төлүүлсэн хохирол 28.7 хувь, бичсэн мэдэгдэл 30.8 хувиар тус тус нэмэгдэж шүүхээс буцсан хэрэг 9.1 хувиар буурчээ. Мөрдсөн хэргийнхээ 88.9 хувийг хуулийн анхны хугацаанд барагдуулжээ.

1976 он:

✓ 1976 онд МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны 116 дугаар тогтоолоор УЦСЕГ-т Улс төрийн хэлтэс байгуулжээ.

1977 он:

✓ 1977 онд НАХЯ-ны сайдын 46 тоот тушаал гарч УЦСЕГ-ын социалист өмч хамгаалах алба ашиглан шамшигдуулсан гэмт хэрэгтэй тэмцэхээс гадна албан тушаалыг урвуулан ашиглах, аж ахуйн эсрэг зарим гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй болон ажиллажээ.

✓ Мөрдөн байцаагчдын улсын зөвлөгөөн болж МБГ-ын ажилтан ц.Содов БНМАУ-ын гавьяат хуульч цол хүртжээ.

1978 он:

✓ БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор УЦСЕГ-т эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх албыг /сэргийлэн хамгаалах хэлтэс/ хэлтэс, тасаг, байцаагч, хэсгийн байцаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

1979 он:

✓ БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор нийслэл хотын дотор эргүүл постын үүрэг гүйцэтгэж хэв журам сахиулах үүрэгтэй цэргийн тусгай батальоныг хугацаат цэргийн албан хаагчаар зохион байгуулжээ.

✓ 1979 онд УЦСЕГ-т зохион зааварлах, нэгдсэн тоо бүртгэл, дүн шинжилгээ мэдээллийн тасаг, бичиг хэрэг бүхий штабыг НАХЯ-ны сайдын 718 тоот тушалаар байгуулжээ.

1980 он:

✓ МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны 51 дүгээр тогтоол гарч ЦСБ-ын албадын ажлыг төрөлжүүлэн мэргэжлээх заалт чиглэл өгч байв. Бие

бүрэлдэхүүний 60-аас дээш орон тоотой анги салбарт улс төрийн орлогчтой болгохоор шийдвэрлэж байжээ.

✓ 1980 онд ЭХЭС албаны шугамаар төв, хөдөөд "эрэл", "лонх", "мэх", "таван эрдэнэ" зэрэг 20 гаруй нэгдсэн арга хэмжээ зохиож 463.5 мянган төгрөгийн хохиролтой 208 хэрэг илрүүлж байв.

✓ 1980 онд ЦСБ-ын мөрдөн байцаах аппарат 4397 хэрэгт урьдчилсан мөрдөн байцаалт явуулж 3778 хэргийг шийдвэрлэж, улс, нийгэм, ард иргэдэд учирсан 6 сая төгрөгийн буюу 81.9 хувийг нөхөн төлүүлж байв.

1981 он:

✓ ЦСБ-ын 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж Галын аюулаас хамгаалах газрын төв команд, Завхан аймаг дахь цагдан сэргийлэх анги хоёрыг БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлигаар Алтангадас одонгоор шагнажээ.

1982 он:

✓ ЦСБ-ын тусгай дунд сургуулийг өргөтгөж Цагдаагийн дээд сургуулийг байгуулжээ.

1983 он:

✓ Москва хотод болсон социалист орнуудын ЦСБ-ын 15 дугаар симпозиумд төлөөлөгчөө оролцуулав.

✓ 1983 оны 12 дугаар сарын 16-нд хуулийн байгууллагуудын ажлын тухай 316 дугаар тогтоол гарав.

1984 он:

✓ 1984 оны эхээр хуулийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн болов.

✓ Мөрдөн байцаагч нарын ээлжит зөвлөгөөн болов.

1985 он:

✓ БНМАУ-ын ЦСБ-ын дүрэм шинээр батлагдан гарав.

1986 он:

✓ ЦСБ-ын шуурхай эрэн сурвалжлах албаны шинэ зааврыг боловсруулж гарав.

1989 он:

✓ ЦСБ-ын хэмжээгээр энэ онд байгууллага, ард иргэдээс 35414 санал өргөдөл, гомдол

хүлээн авсны дотор гэмт хэргийн тухай өргөдөл мэдээлэл 12204 байв. Нийт 6173 гэмт хэрэг бүртгэж, оны эцэст эзэнгүй хэрэг 2315 байжээ.

1990 он:

√ НАХЯ татан буугдаж, БНМАУ-ын Цагдаагийн ерөнхий газар бие даасан байгууллага болов.

√ Цагдаагийн байгууллагыг бэхжүүлэх тухай БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 396 дугаар тогтоол гарав.

√ Цагдан сэргийлэх, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэх баталгааны тухай БНМАУ-ын хууль батлагдан гарав.

√ Цагдаагийн байгууллага шинээр "Нүгэл буян" нэртэй сонинг нийтэд эрхлэн гаргав.

1991 он:

√ Цагдаагийн ерөнхий газар, Улаанбаатар хотын цагдаагийн газрын удирдлагын аппаратыг нэгтгэн, эрүү, өмч, сэргийлэн хамгаалах, шуурхай алба, улс төрийн хэлтэс зэрэг зохион байгуулалтад оров.

√ БНМАУ, БНХАУ-ын цагдаагийн байгууллагын төлөөлөгчид харилцан айлчилж, хамтын ажиллагааг сэргээн тогтоов.

√ 1991 оны 7 дугаар сард Монголын цагдаагийн байгууллагын 70 жилийн ойг өргөн тэмдэглэв. Ойн баяраар Мөрдөн байцаах газрын орлогч дарга С.Дамдин, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч Р.Доржпалам нар БНМАУ-ын "Гавьяат хуульч" цол шагнагджээ.

√ 1991 онд анх удаа Монголын цагдаагийн байгууллагын эрүүгийн алба эрхэлсэн дэд дарга хурандаа Ц.Жамьяансэнгэ АНУ-ын холбооны мөрдөх товчоо болон цагдаагийн байгууллагын ажил байдалтай танилцах ажлаар сар орчим хугацаанд аваад ирэв.

√ Монгол Улс 1991 онд

Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполд гишүүнээр элсэн орж, Цагдаагийн ерөнхий газрын дэргэд Интерполын үндэсний товчоо байгуулагдав.

√ 1993 онд анх удаа "Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль" УИХ-аар хэлэлцэгдэн батлагдаж, 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхлэв.

√ 1997 онд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хууль батлагдан гарав.

√ 1997 онд Цагдаагийн байгууллагын дарга нарын олон улсын холбоонд Монгол Улсын цагдаагийн ерөнхий газар /дарга, хошууч генерал Ч.Амарболд/ гишүүнээр элсэн оров.

√ Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг "ЖАЙКА"-гийн шугамаар 1995 оноос Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг техник тоног төхөөрөмжөөр хангах төсөл хэрэгжүүлж эхэлжээ. Энэ төслийн хүрээнд 2004 онд 45 мянга 950 ам.долларын үнэ бүхий "Өнгөт гэрэл зураг, дүрс бичлэгийн лаборатори байгуулав. 2005 оны байдлаар нийт 279 мянган ам.долларын үнэ бүхий аппарат багаж хэргэсэл нийлүүлжээ.

√ Бүгд найрамдах Турк улсын Дотоод явдлын яам, Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын хооронд хамтын ажиллагааны хэлэлцээр 1997 оны 4 дүгээр сарын 7-нд байгуулжээ.

√ Монгол Улсын цагдаагийн ерөнхий газар, БНХАУ-ын НАХЯ-ны хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр 1998 оны 6 дугаар сарын 15-нд байгуулжээ.

√ Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг зохицуулх багц хуулийг УИХ-аас батлан гаргаж, эрх зүйн шинэ орчин бий болсонтой уялдуулж ЦЕГ-ын бүтэц, орон тоог Засгийн газрын 2002 оны 189 дүгээр тогтоолоор шинэчлэн батлав. Уг тогтоолоор ЦЕГ-ын бүтцийг Тамгын газар,

Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх, Хэв журам хамгаалах, Замын цагдаагийн алба, Цагдаагийн академи, Шинжилгээний хүрээлэн, Санхүү, аж ахуйн газар, Холбооны хэлтэс, Мэдээлэл судалгааны төвтэй байхаар шийдвэрлэв.

√ Засгийн газрын 2002 оны 179 дүгээр тогтоолоор УЕП-ын дэргэд Мөрдөн байцаах тусгай хэлтэс байгуулагдав.

√ Дээрх хуулийн өөрчлөлтийн дагуу төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн цагдан хорих 24, албадан саатуулах байр 2-ыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжүүлэв.

√ Хэрэг бүртгэх албадыг цагдаагийн байгууллагад төвлөрүүлж, Зэвсэгт хүчний жанжин штабаас 25, Хил хамгаалах ерөнхий газраас 5, Гал түймэртэй тэмцэх газраас 26, Үндэсний татварын ерөнхий газраас 13, Гаалийн ерөнхий газраас 14, нийт 83 орон тоог цалингийн сангийн хамт шилжүүлэн авав.

√ 2002 оны хичээлийн жилд ОХУ-д 33, Бүгд найрамдах Турк улсын Цагдаагийн академид 22, бүгд 55 албан хаагч суралцаж байв.

√ 2003 онд Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор гэмт хэргэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах үүрэг бүхий алба хаагчид ажилласан 2 жил тутамд 3 өдрийн, бусад хаагчид 5 жил тутамд 3 өдрийн нэмэгдэл амралт эдлэхээр болов.

√ 2003 онд ЦЕГ-ын Хэв журам хамгаалах газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг Олон нийтийн харилцааны хэлтэс болгон өргөтгөв.

√ Ажлын шаардлага, тухайн нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан 2005 онд Замын-Үүд, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, Ховд, Хөвсгөл аймгийн цагдаагийн хэлтсийг газар болгон өргөтгөв.



НОТАРИАТЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛД

Монгол Улс ардчилсан нийгмийг төлөвшүүлж, хөгжүүлэх өнгөрсөн цаг хугацаанд хууль хамгаалах байгууллагуудыг бэхжүүлэх, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааг нь боловсронгуй болгох тал дээр нилээд анхаарч ажилласан бөгөөд харин одоо энэ цаг үед дээрх асуудлаас илүү бидний бүтээж байгуулсан системд ажиллаж буй боловсон хүчнийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, өөрийн мэргэжлийн чиг үүргээ хэлбэрэлтгүй дагаж биелүүлэх асуудал нь ихэд анхаарал татах болжээ.

Хуулийн байгууллагын ажлын онцлог нь хүний эрх, эрх чөлөө, амь нас, ажил, амьдралтай холбоотой асуудлыг шийдвэрлэж байдаг учраас мэргэшлийн нарийн ур чадвар шаарддаг, ажил хэргээ зөвхөн хууль эрхийн ухамсрыг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр, хэний ч нөлөөнд үл автан зөвхөн хуульд нийцүүлэн хийх ёстой байдаг.

Ингэж ажиллахад дээрхи хуульд заасан ажил үүргээ хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь тухайн субьектын ажилдаа хандах хандлага, ёс зүйгээ эхлэн мөрдөж ажиллах асуудал юм.

Иргэд өөрсдөө сайн дураараа эрх ашгаа хамгаалах зорилгоор хандаж, эрх зүйн үйлчилгээг авдаг /аливаа үйлдэл, үйл явдал, бичиг баримтаа гэрчлүүлэх/ бөгөөд түүнийг нь хууль ёсны болгох үндсэн чиг үүргийг нотариатч хэрэгжүүлж байна.

Иймд нотариатын бүрэн эрхийг хэрэгжүүлж буй нотариатчийн мэргэжил мэдлэг, ур чадварын асуудлаас гадна ажилдаа хандах хандлага, нотариатчийн ёс зүйн асуудал чухлаар тавигдаж байна.



Хууль зүйн магистр,
нотариатч Ч.Баянжаргал

Мэргэжлийн ёс зүй гэж бусдын нэрийн өмнөөс түүний эрх ашгийг хангах үйл ажиллагаа явуулахаар эрх олж авсан этгээд эрх олгосон бүтцийн сонирхлыг өөрийн болон хөндлөнгийн сонирхлоос дээгүүр тавьж эл зан суртлаа албан үйл ажиллагаанд мөрдлөг болгох явдлыг хэлдэг байна¹.

Хуульчийн ёс зүй нь төрөлжин мэргэшлийн ёс зүй болж нарийвчлагддаг.

Мэргэшлийн ёс зүйд хуульчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ баримтлагдахын сацуу, түүний шаардлагууд нь нарийвчлагдан тухайн мэргэшлийн онцлогтой уялдан ажил хэргийн шинжийг нь илэрхийлсэн байдаг.

Нотариатчийн ёс зүй гэдэг нь нотариатч мэргэшлийн үүргээ гүйцэтгэхдээ баримталвал зохих ёс зүйн зарчим, шаардлагыг хэлнэ.

Нотариатч нь нийгэмд үнэн бодит байдлын баталгаа, үлгэр дууриал болсон байх шаардлагыг ханган нотариатчийн нийгмийн өмнө хүлээх үүргийг сахин хангах нь нотариатчийн зорилго, ёс зүйн шаардлагын үндэс болно.

Нотариатчийн мэргэшлийн онцлог:

- Тусгай зөвшөөрлийн үндсэн үйл ажиллагаа явуулдагтай уялдан ёс зүйн хариуцлагууд нь түүнтэй шууд холбоотойгоор тогтоогдсон байдаг; Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно;
- Үйлчлүүлэгч нотариатчид асуудлаа шийдвэрлүүлэхээр сайн дураараа хандаж, үйлчлүүлдэг;
- Төрөөс тогтоосон жишгийн дагуу нотариатын үйл ажиллагааны орлогоор санхүүжин ажилладаг;
- Хувийн статустай;
- Албан тушаалын шатлан захирагдах ёс үйлчилдэггүй.

Нотариатчийн ёс зүйн дүрмийг Нотариатчдын танхимын бүх гишүүдийн хурлаар батлан мөрдүүлж байна². Энэхүү дүрэм нь нотариатчийн ёс зүйн эх сурвалж бөгөөд, нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоосон байдаг.

Нотариатчийн ёс зүйн дүрэмд нотариатчийн ёс зүй гэж юу болох, ёс зүйн зөрчлийн ойлголтыг тогтоогоогүй байна. Нотариатчдын үйл ажиллагааны үндсэн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нотариатын үйлчилгээг үзүүлж, гарч болох аливаа маргаанаас урьдчилан сэргийлэх, тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Нотариатчийн ёс зүй нь мэргэжлийн үүргээ гүйцэтгэхтэйгээр нягт уялдан илэрч хэрэгждэг.

Нотариатчийн хууль зүйн үүрэг:

- Нотариатын үйлдлийг мэргэжлийн өндөр түвшинд, бие даан, хууль тогтоомжид нийцүүлэн хийх;
- Нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

¹ Х.Тэмүүжин "Хуульчийн ёс зүй түүнийг тодорхойлох шалгуур үндэслэл". ХЗУТ. Хуульчийн ёс зүй /гарын авлага/, УБ., 2004 он

² Нотариатчийн ёс зүйн дүрэм. 2004 он.

³ Нотариатын тухай хууль. 1997 он. 19 дүгээр зүйл.

- Иргэн хуулийн этгээдээс эрхээ хэрэгжүүлэх, хууль ёсны эрх ашиг сонирхлоо хамгаалахад нь үйлчлэх, тэдний эрх үүргийг нь тайлбарлан өгч, нотариатын үйлдэд хийснээс үүдэн гарах үр дагаврыг урьдчилан сануулж, зөвлөгөө өгөх;
- Нотариатчаар гэрчлүүлэх бичиг баримтын үнэн зөв эсэхийг хянах;
- Нотариатын үйлдэл хийсэн бичиг баримт, мэдээллийг шүүх прокурорын газар, хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллагын шаардсаны дагуу гаргаж өгөх;
- Нотариатын үйлдэл хийх эрхээ гагцхүү өөрөө хэрэгжүүлэх.

Нотариатчийн хуулиар тогтоосон үүргээ биелүүлэхдээ хандах хандлага, түүнийг хэрхэн зүй зохиистойгоор хэрэгжүүлж байгаа нь нотариатчийн ёс зүйн үндсэн асуудал юм.

Нотариатчийн мэргэжлийн ур чадвар:

- **Бичиг баримт боловсруулах чадвар:** Нотариатч гэрээ, хэлцэл, итгэмжлэл зэрэг хууль зүйн бичиг баримтын боловсруулалтыг өдөр тутам хийх шаардлагатай болдог.
- **Бичиг баримттай ажиллах чадвар:** Нотариатын үйлдлийн бүртгэл хийх, үйлчлүүлэгчийн бичиг баримттай танилцах, албан хэргийг хөтлөх, бичиг баримтыг архивлах ажиллагаа нь нотариатын ажлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм.
- **Нотлох баримтыг үнэлэх чадвар:** Үйлчлүүлэгчийн бичиг баримтыг хянан шалгах, үнэн зөвийг магадлах, шаардлагатай бол шинжилгээний байгууллагаар шинжлүүлэх, эрх бүхий байгууллагаас лавлах зэргээр гэрчлүүлж буй бичиг баримт болон

бусад байдлыг шалган, гэрчилж болох эсэхийг нотлох баримтыг үнэлэх замаар тогтоодог.

- **Зөвлөгөө өгөх чадвар:** Нотариатч үйлчлүүлэгчийг хүлээж авахаас эхлээд, гэрчлэх, тухайн үйлдлийг хийж дуусгах бүхий л ажиллагаанд үйлчлүүлэгчид шаардлагатай зөвлөгөөг өгч чаддаг байх хэрэгтэй. Иргэн, хуулийн этгээдээс эрхээ хэрэгжүүлэх, хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалахад нь үйлчлэх, тэдний эрх, үүргийг нь тайлбарлан өгч, нотариатын үйлдэл хийснээс үүдэн гарах үр дагаврыг урьдчилан сануулж зөвлөгөө өгөх явдал түүний хууль зүйн үүрэг мөн.
- **Харилцааны чадвар:** Нотариатч үйлчлүүлэгчтэй зөв боловсон харьцаж, асуудлыг нь тодруулан бүрэн ойлгох, үйлчилгээний журмыг ойлгомжтой тайлбарлах, зэргээр үйлчлүүлэгчтэй чадварлаг харилцаж чаддаг байх ёстой.

Нотариатчийн ёс зүйн үндсэн зарчим: Ёс зүйн дүрэмд зааснаар ёс зүйн үндсэн зарчмыг дараах байдлаар тогтоосон байна:

Нотариатчийн ёс зүйн зарчим нь нотариатчийн ёс зүйг үнэлэх үнэлэмжүүд юм.

- хууль дээдлэх
 - шударга ёсыг үйл ажиллагаандаа баримтлах
 - үйлчлүүлэгчийн итгэл хүндэтгэлийг хүлээх
 - мэргэжлийн өндөр түвшинд албан үүргээ гүйцэтгэх
 - үйл ажиллагаа явуулахдаа хараат бус байх
- Нотариатч нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх, ашиг сонирхлыг хамгаалахдаа шударга бус үйлдэл гарахаас ямагт зайлсхийж, нотариатын аливаа үйлдлийг зөвхөн хууль тогтоомжид нийцүүлэн, хуурамч нотариатын

гэрчлэл хийхээс татгалзах ёс зүйн зарчимтай. Иргэд нь нотариатч дуудсаны дагуу ирдэг бус, харин өөрийн эрх ашгаа хамгаалуулахын тулд хууль зүйн туслалцаа авахаар сайн дураар их итгэл өвөрлөн ирдэг. Иймээс үйлчлүүлэхээр ирж буй хэнийг боловч үл ялган, өндөр итгэл хүндэтгэлийг хүлээж, мэргэшлийн үүргээ нэр төртэй, хууль ёсоор гүйцэтгэх нь ёс суртахууны үүрэг мөн.

Үйлчлүүлэгч нь нотариатчаар эрх ашгаа хамгаалуулж байгаа учир үйлчлүүлэгчийн найдвар хүндэтгэлийг хөсөрдүүлэхгүй, ямар ч нөхцөлд тэдний нэр төрийг гутаан, басамжлан дорд үзсэн байдал гаргахгүй, хариу хүндэтгэл үзүүлж харилцах нь зүйтэй.¹

Нотариатчийн үйлдэл нь хууль зүйн нарийн мэргэжлийн үйл ажиллагаа гэдгийг ухамсарлан, мэргэжлийн үүргээ хуулийн шаардлагын дагуу гүйцэтгэх ёстой.

Үүний тулд нотариатч нь мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж, хууль тогтоомж, эрдэм шинжилгээний ном зохиолыг судалж, нотариатын практикт дүн шинжилгээ хийж ажиллавал зохино.

Латин нотариатын холбооноос тус Латин нотариатын номлолыг боловсруулсан байна. Эдгээр нь:

- өөрийн төр засгаа хүндэл;
- хийх гэж буй үйлдэлдээ эргэлзвэл бүү хий;
- үнэнийг эрхэмлэ;
- болгоомжтой ажилла;
- нэр төрөө бод;
- шударга ёсыг удирдлага болго;
- чанар чансаатай ажилла;
- чиний үүрэг бол хүмүүсийн хөөрөнд маргаан гаргахгүй байх гэдгийг санаж яв зэрэг болно.

Нотариатчийн ёс зүйн үндсэн хэм хэмжээг нотариатчийн ёс зүйн дүрэмд тогтоож өгснөөр нотариатч бүр ёс зүйн шаардлага, хэм хэмжээг баримтлан ажиллах, түүнд үйл ажиллагаагаа нийцүүлэх, зохисгүй зан үйлээс татгалзах учиртай.²

Нотариатчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг тодорхой тохиолдолд зөрчил гаргасан нөхцөлд хэрэглэх учир норматив шинжтэй бөгөөд цаашид тодорхой чиглэлээр боловсронгуй болгож байх нь зайлшгүй.

¹ Д.Цогт-Очир "Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал", УБ., 107 дахь тал.

² Нотариатчийн ёс зүйн дүрэм. 2004 он

Нотариатчийн ёс зүйн хэм хэмжээ нь нотариатчаас албан үүргээ хэрхэн зүй зохистой гүйцэтгэх, зан үйлийн хэмжээ хязгаарыг тогтоож өгсөн байна.

1. Нотариатын үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн үйлчлүүлэх боломжийг хангасан /ая тухыг хангасан/ ажлын байртай байна.

2. Нотариатч бүр тогтоосон цагийн хуваариар ажиллана.

3. Нотариатч албан үүргээ гүйцэтгэхдээ бусдаас шан харамж авах, ашиг олох зорилгоор өөрийн үүрэгт ажлаа ашиглаж болохгүй.

4. Өөрийн танил тал, хувийн харилцаагаа ашиглан хууль зөрчиж, аливаа үйлдлийг хуурамчаар гэрчлэх, үйлчлүүлэгчтэй санаатай хуйвалдан хууль бус үйл ажиллагаа явуулах, тийм оролдлого хийхийг хориглоно.

5. Нотариатч үйлчлүүлж байгаа хүнийхээ хууль ёсны ашиг сонирхлыг хангана.

6. Нотариатч бүр бусад нотариатчийн нэр хүндийг хүндэлж, тэдний нэр төрийг гутаан доромжлох, үйлчлүүлэгчдэд нь буруу ойлголт өгөх эрхгүй.

7. Нотариатчийн үйлчилгээний хөлснөөс гадна ямар нэгэн урамшуулал, бэлэг сэлт авах бусад хөнгөлөлт олж авахыг оролдох эрхгүй.

8. Нотариатч нь мэдсээр байж хуурамч бичиг баримт ашиглан нотариатын үйлчилгээ явуулж болохгүй.

9. Нотариатч нь хуулиас гадуур тусалцаа үзүүлэх, хуулийг зориуд буруу хэрэглэхийг хориглоно.

10. Үйлчлүүлэгчийн хууль бус шаардлагыг хүлээн авахгүй байх эрхтэй.

11. Нотариатч нь Монголын Нотариатчдын танхим, аймаг, нийслэлийн салбараас өгсөн үүрэг даалгавар, томилолтыг биелүүлэх үүрэгтэй.

12. Нотариатч бүр үйлчлүүлэгчтэй хүндэтгэлтэй хандан, соёлч боловсон харьцаж, тэдний нэр төрийг гутаах, доромжлох эрхгүй. Үйлчлүүлэгчээс ч ийнхүү харилцахыг шаардах эрхтэй.

13. Албан үүрэгтэйгээ холбогдсон төрийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээдийн нууцыг чанд хадгална.

14. Нотариатч нь тамга, баталгааны тэмдгээ бусдад шилжүүлэх, ажлын байрандаа согтууруулах ундаа хэрэглэх, тойргоо дур мэдэн солих, татвараас зайлсхийх зорилгоор үйлчилгээ үзүүлсэний орлого, мэдээ тайлангаа хуурамчаар гаргахыг хатуу хориглоно.

15. Нотариатч нь Нотариатчдын танхимын гишүүний элсэлтийн татвар, гишүүний татвар, нотариатчийн хариуцлагын даатгалын хураамжийг цаг хугацаанд нь төлөх үүрэгтэй.

Нотариатч нь үйлчлүүлэгчтэй харилцахдаа ажил хэрэгчээр хандаж, хууль бус үйлдэл хийхээс татгалзан, хурдан шуурхай үйлчилж, хүнд суртал гаргахгүй ажиллах нь зүйтэй.

Үйлчлүүлэгч бүхэн тогтоосон хууль зүй, горим журмыг бүрэн мэдсэн байдаггүй тул зөв харилцаж, учрыг мэдүүлж ойлголцсоноороо үйлчлүүлэгчийг хууль зөрчихөөс урьдчилан сэргийлж, тэдний эрхийн ухамсрыг дээшлүүлэхэд нотариатч тусалцаа үзүүлж байдаг.¹

Нотариатын үйлдэл хийхээс татгалзаж буй үндэслэлээ үнэн зөв, тодорхой, ойлгомжтой тайлбарлах үүрэгтэй. Гэхдээ нотариатын хууль тогтоомжид заасан үндэслэлээр нотариатын үйлдэл хийхээс татгалзах бүрэн эрхтэй.

Нотариатчийн ёс зүйн хэрэгжилтэд тавих хяналт

Нотариатчийн ёс зүйн хэм хэмжээ нотариатчийн үйл ажиллагаанд баримтлагдаж хэвшил болсон байх учиртай.

Нотариатчийн ёс зүйн хэрэгжилтэд өөрийн эрх зүйн ухамсар, соёл, нэр төрөө эрхэмлэх болон үйлчлүүлэгчийн хүсэлт шаардлага чухал ач холбогдолтой.

Нотариатчийн ёс зүйн хэмжээний хэрэгжилтэд Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөл хяналт тавина.

Сахилгын зөвлөл дараах үндсэн үүргийг гүйцэтгэнэ:

1. Нотариатчын сахилгын хэргийг хянан шийдвэрлэх;

2. Зөрчил дутагдлаас сэргийлэх талаар нотариатчдын дунд мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулах;

3. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэнэтийн үзлэг шалгалт хийх;

4. Нотариатчид зөрчил, дутагдлаа арилгах, ажлаа сайжруулах хугацаатай үүрэг өгөх.

Нотариатчид сахилгын хэрэг үүсгэх үндэслэл нь дор дурдсан этгээдийн гаргасан гомдол, мэдээлэл, шүүмжлэл байна:

1. Иргэний гомдол;
2. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтны гомдол, мэдээлэл;

3. Хэвлэлд нийтлэгдсэн үндэслэл бүхий мэдээлэл, шүүмжлэл.

Нотариатчийн ёс зүйн хэм хэмжээ, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага зөрчсөн бол зөрчлийн шинж байдлыг харгалзан нотариатчид дараах сахилгын шийтгэлийг ногдуулна:

1. Сануулах;
2. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох.

Ёс зүйн дүрэмд зааснаар сахилгын шийтгэл ногдуулахгүйгээр тусгайлан зөвлөж, анхааруулж болно.

Нотариатчийн ёс зүйн асуудлыг боловсронгуй болгох үндсэн чиглэлүүд:

- нотариатын байгууллага, хамт олныхоо нэр хүндийг эрхэмлэн дээдлэх, биеэ авч явах байдал нь албан харилцаанд нийцсэн байвал зохино.
- нотариатч мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлэх талаар заалт оруулах
- нотариатын үйлдлийг албан бичиг хэргийн шаардлагад нийцүүлэн туйлын нямбай хөтөлж байх
- нотариатч үйлдэл хийхээс татгалзах тохиолдолд түүнийхээ үндэслэлээ үнэн бодитой, тодорхой тайлбарлаж өгөх үүргийг тогтоох



¹ Д. Цогт-Очир "Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал", 1999 он, 107 дахь тал

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын
29-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Эрчим хүчний тухай хуулийн зарим зүйл, заалтыг дор дурдснаар тайлбарласугай.

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын "эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээ" гэдэгт хоёр буюу түүнээс дээш аймгийн төвийг хамрах цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа, хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг ойлгохоос гадна эх үүсвэргүй дамжуулах, түгээх сүлжээ нэгэн адил хамаарах бөгөөд эдгээр нь мөн нэгдсэн сүлжээнд орно.

2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын "үйлдвэрлэгчийн үнэ, диспетчерийн зохицуулалтын болон дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний төлбөр, импортын цахилгааны үнэ" зэргийг Эрчим хүчний зохицуулах газраас тус тусад нь буюу эдгээрийн аль нэгийг багтаан баталж, эрчим хүчний хэрэглэгчдэд мөрдүүлэхээр нийтэлж, нийтийн хүртээл болгосон бол "тариф" гэсэн ойлголтоор тус тус хэрэглэгдэнэ.

3. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын "тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлш болон тоног төхөөрөмж, сэлбэгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх журам батлах" гэдгийг зөвхөн энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2-т заасан цахилгаан, дулаан үйлдвэрлэх ажиллагаанд хамааруулна. Хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бусад асуудалд, тухайлбал, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх цахилгаан дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, цахилгаан дулаан түгээх, эрчим хүчээр зохицуулалттай болон зохицуулалтгүй хангах, цахилгаан импортлох, экспортлох, эрчим хүчний барилга байгууламж барих үйл ажиллагаанд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт хамаарахгүй.

4. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3-т "эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан цахилгаан, дулааны тоолуураар хэрэглэгчийг хангах, тоолуурыг холболтын цэгт суурилуулах" гэсний "эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан" гэдгийг Стандартчилал, Хэмжил зүйн байгууллагаар албан ёсоор баталгаажуулсныг хэлнэ.

Мөн заалтын "холболтын цэг" гэдэг нь дамжуулагч, түгээгч, хангагч болон хэрэглэгчийн цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээ, шугам, тоног төхөөрөмжийн өмчлөлийн буюу эзэмшлийн харьяалал, заагаар тодорхойлогдоно.

5. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "зохицуулалттай хангалтаар цахилгаан импортлох" гэдэг нь цахилгаан импортлох, импортлосон цахилгаанаа Эрчим хүчний зохицуулах газраас хянаж баталсан үнээр хэрэглэгчдэд худалдахыг хэлнэ. Хэрэглэгчдэд цахилгаан худалдах эрх нь цахилгаан импортлох тусгай зөвшөөрөлтэй хамт олгогдсон байвал зохино.

6. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т заасан "тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хүлээн авснаас хойш 60 хоногийн" хугацааг сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан баримт бичгийн хамт Эрчим хүчний зохицуулах газар буюу аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлд хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн тооцно.

7. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан "тусгай зөвшөөрөл олгосон нөхцөл өөрчлөгдсөн" гэдэгт тусгай зөвшөөрөл авах үед энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан баримт бичгээр тогтоогдсон үндэслэл, нөхцөл, үзүүлэлтүүд өөрчлөгдсөнөөс шалтгаалан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг шинэчлэх, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий болсныг хамааруулан ойлгоно.

8. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасан "бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэдэгт хүчингүй болсон тухайн тусгай зөвшөөрөлд заасантай ижил төрлийн ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий этгээдийг ойлгоно.

9. Хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3-т заасан үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтлөх" гэдэг нь эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хуулийн этгээдийн эрхэлж байгаа үйл ажиллагааны төрөл тус бүрээр, үндсэн тайлан бүртгэлээс тусад нь санхүүгийн тайлан, бүртгэл хөтлөхийг хэлнэ. Харин эдгээр нь санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дансны жагсаалтын дагуу бүртгэгдсэн байна.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

А.ДОРЖГОТОВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын
29-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 24 ДҮГЭЭР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд нэг мөр ойлгож, эвэ хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 4 дэх заагт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5 дахь хэсгийг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирох, бие махбодид нь хүндэвтрэх, хүнд гэмтэл, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үлэмж, их, онц их хэмжээний эд хөрөнгийн хохирол зэрэг хүнд хор уршиг учирдаг тул хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг нэг бүрчлэн тогтоож, түүнийг арилгуулах талаар хуульд заасан арга хэмжээ авч байвал зохино.

2. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгчдэд шүүхээс үндсэн болон нэмэгдэл ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 55, 56 дугаар зүйлүүдэд заасан ял хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлаас гадна гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан эд хөрөнгийн буюу эд хөрөнгийн бус хохирлын хэр хэмжээ, шинж чанар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын талаарх хууль тогтоомжийн зөрчлийн шинж чанар, гэмт этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй.

3. Хуулийн 215, 217-222 дугаар зүйлүүдэд заасан хүний бие махбодид учирсан гэмтлийн зэргийг шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлтээр заавал тогтоосон байвал зохино.

4. Хуулийн 215 дугаар зүйлийн 215.1 дэх хэсэгт заасан "жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчих" гэдэгт Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмээр тогтоосон хэм хэмжээ, журмыг гэм буруутайгаар зөрчсөнийг ойлгоно.

5. Хуулийн 215 дугаар зүйлийн 215.1 дэх хэсэгт заасан "үлэмж хэмжээний хохирол" гэдэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан эд хөрөнгийн шууд хохирол нь мөн хуулийн 29 дүгээр зүйлд заасан мөнгөн илэрхийлэлд оруулснаар гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас дээш нэг зуун хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, 215 дугаар зүйлийн 215.2, 217, 218, 219 дүгээр зүйл, 220 дугаар зүйлийн 220.1, 221 дүгээр 221.1, 222 дугаар зүйлийн 222.1 дэх хэсэгт тус тус заасан "их хэмжээний хохирол" гэдэгт эд хөрөнгийн шууд хохирлыг мөнгөн илэрхийлэлд оруулснаар нэг сарын

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун хорин таваас дээш хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, 215 дугаар зүйлийн 215.3, 220 дугаар зүйлийн 220.2, 221 дүгээр зүйлийн 221.2, 222 дугаар зүйлийн 222.2 дахь хэсэгт тус тус заасан "онц их хэмжээний хохирол" гэдэгт эд хөрөнгийн шууд хохирлыг мөнгөн илэрхийлэлд оруулснаар нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй хохирол тус тус учруулсан байхыг хэлнэ.

6. Тээврийн хэрэгсэлд учирсан эвдрэлийн хэмжээг тодорхойлохдоо түүний эд ангийн элэгдэл хорогдлыг хасч, эвдэрч гэмтсэнийг засаж сэргээхэд шаардагдах эд анги, бусад материалын үнийг оруулан тооцно.

Харин тээврийн хэрэгслийн эвдэрч гэмтсэнийг засаж сэргээхэд гарсан ажлын хөлсийг тухайн этгээдийн гэм буруутай эсэхийг хэлэлцэх хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд үүнтэй холбоотой зардлыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж болно.

Мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэг шалгагдаж байх хугацаанд тухайн тээврийн хэрэгслээр олох байсан орлого, цалин хөлсийг хохирлын хэмжээнд оруулахгүй.

7. Хуулийн 215 дугаар зүйлийн тайлбарын "өөрөө явагч бусад машин" гэдэгт зам, барилга, хөдөө аж ахуйн болон тусгай зориулалт бүхий бүх төрлийн өөрөө явагч машин механизм, тэдгээрийн ажлын тоног төхөөрөмж зэргийг ойлгоно.

8. Тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд замын хөдөлгөөнд оролцохдоо нийтийн хэрэгцээний замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчиж гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн энэ бүлэгт заасан гэмт хэргийн аль тохирох зүйл, хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Хэрэв уг этгээд хэдийгээр тээврийн хэрэгсэл жолоодож явсан боловч уул уурхай, зам, барилга, ажиж буулгах, засвар үйлчилгээ хийх зэрэг тодорхой нэг ажил үйлдвэрлэл явуулах дүрэм, заавар болон хөдөлмөр хамгааллын журам зөрчиж хор уршиг учруулсан байвал энэ нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг болохгүй учир уг үйлдлийг Эрүүгийн хуулийн аль тохирох зүйл, хэсгээр зүйлчилнэ.

9. Тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн хэд хэдэн хэсгүүдэд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг буй болгосон бол тухайн зүйлийн хамгийн хүнд ялтай хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

10. Тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид яаралтай тусламж үзүүлээгүй, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдээгүй, эсхүл хэргийн газраас зугтаасан бол Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлд зааснаар давхар зүйлчилнэ.

Харин жолоочтой цуг явсан этгээд осол болсныг болон хохирогчийн биед гэмтэл учирсныг мэдсээр байж түүнд яаралтай тусламж үзүүлээгүй, эсхүл тусламж үзүүлэх шаардлагатайг зохих байгууллагад мэдэгдээгүй бол Эрүүгийн хуулийн 107 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

11. Хуулийн 216 дугаар зүйлийн 216.1 дэх хэсэгт заасан "хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлээгүй" гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд зам тээврийн осол гаргасны дараа хохирогчид эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай болсныг мэдсэн бөгөөд туслах бололцоо байсан атлаа түүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлээгүй, түргэн тусламж дуудаагүй, осол болсон газарт ойр байгаа эмнэлгийн байгууллагад аль тааралдсан тээврийн хэрэгслээр хүргүүлэх буюу зайлшгүй тохиолдолд өөрийн жолоодож яваа тээврийн хэрэгслээр хүргэх арга хэмжээ аваагүй зэргийг хамааруулан ойлгоно.

Мөн зүйл, хэсгийн "хэргийн газраас зугтаасан" гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд зам тээврийн осол гаргасан үйлдлээ нуух, хариуцлагаас зайлсхийх зорилгоор ослын газрыг тээврийн хэрэгслээр, эсхүл явганаар санаатай орхиж явсан үйлдлийг хэлнэ.

Харин ослын улмаас тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд өөрөө гэмтсэн учраас хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлж чадаагүй, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх боломжгүй байсан бол түүнд Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

12. Хүнийг санаатай алах, бие махбодид нь гэмтэл санаатай учруулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгийг устгах, гэмтээх зорилгоо хэрэгжүүлэхдээ гэмт этгээд тээврийн хэрэгслийг зэвсэг, хэрэгсэл болгон ашигласан бол хор уршгийн байдлыг харгалзан түүний үйлдлийг хүний амь бие, эрүүл мэндийн буюу өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн аль тохирох зүйл, хэсгээр зүйлчилнэ.

13. "Бүрэн бус тээврийн хэрэгсэл" гэдэгт Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс батлан гаргасан "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" болон "Замын хөдөлгөөний дүрэм"-ээр тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлагыг хангаагүй тээврийн хэрэгслийг ойлгоно.

14. “Жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээд” гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх аваагүй, мөн захиргааны шийтгэлийн журмаар болон шийтгэх тогтоолоор тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй боловч тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүмүүс хамаарна.

15. “Согтуурсан буюу мансуурсан этгээд” этгээд гэдэгт Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заан тодорхойлсон согтууруулах ундаа болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэсэн өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох, өөртөө хяналт тавих чадваргүй болсон этгээдийг ойлгоно.

16. “Өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох, өөртөө хяналт тавих чадваргүй болсон байдал” гэдэг нь хүрээлэн байгаа юм үзэгчлүүдийг зөв тусгах ба танин мэдэх сэтгэцийн үйл ажиллагаа алдагдан, тэдгээрийг гэж буруугаар, хий хоосон, хувирч өөрчлөгдсөнөөр тусгах, тэдгээрийн хоорондын харилцаа холбоог саланги, тасархай, авчалдаагүй байдалд хүлээж авах, буруу ойлгох зэрэг хэвийн бус байдлыг хэлнэ.

17. Зам тээврийн ослын улмаас учирсан эрүүл мэндийн болон эд хөрөнгийн хохирлын хэр хэмжээ, шинж чанар нь Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг буй болгоогүй боловч тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд мөн хуулийн 216 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг иргэний нэхэмжлэгчээр заавал тогтоож, хохирлын асуудлыг нь эрүүгийн хэрэгтэй нь нэг мөр шийдвэрлэж байвал зохино.

18. Түүнчлэн ослын улмаас учирсан эрүүл мэндийн болон эд хөрөнгийн хохирлын хэр хэмжээ, шинж чанар нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дангаар бий болгох үндэслэлгүй байвал тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээдтэй холбоотой эрчлийн асуудлыг эрх бүхий албан тушаалтан Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар шийдвэрлэх бөгөөд харин хохирогч өөрт учирсан эд хөрөнгийн хохирлоо иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж болно.

19. Зам тээврийн ослын улмаас хүний бие махбодид хөнгөн гэмтэл, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заан тодорхойлсон үлэмж хэмжээнээс бага хэмжээний эд хөрөнгийн хохирол учирсан нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дангаар бий болгохгүй тул ослын улмаас эдгээрээс өөр хор уршиг учруулсанд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа бол дээр дурдсан хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг иргэний нэхэмжлэгчээр заавал тогтоож, тэдгээрт учирсан эд хөрөнгийн хохирлыг эрүүгийн хэрэгтэй нь нэг мөр шийдвэрлэж байх нь зүйтэй.

Энэ тохиолдолд гэмт хэрэгт тооцохгүй болсон хүний бие махбодид хөнгөн гэмтэл, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үлэмж хэмжээнээс бага хэмжээний эд хөрөнгийн хохирол учруулсныг гэмт этгээдийн гэм буруутай эсэхийг хэлэлцэх хохирлын хэр хэмжээ, шинж чанарт оруулан тооцохгүй.

20. Хуулийн 220, 221 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн субъект нь аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын аюулгүй ажиллагаанд албаны хувьд хяналт тавих үүрэг бүхий ажилтан байна.

21. Хуулийн 223 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь бусдын өмчлөлд байгаа тээврийн хэрэгслийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр авч явсан үйлдэл байх бөгөөд субъектив талын шинж нь гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр илэрнэ. Энэ гэмт хэргийн сэдэлт нь тухайн тээврийн хэрэгслийг өөрийн өмч болгох гэсэн зорилгогүй, түр зуур унах, дүрсгүйтэх, зугатаах, оргох зэрэг хэлбэртэй байдгаараа бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, гэмт хэргээс ялгаатай.

Тээврийн хэрэгслийг хадгалах, хамгаалах, үүрэг бүхий этгээд тээврийн хэрэгслийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр дур мэдэн авч явсан бол Эрүүгийн хуулийн 223 дугаар зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Харин тээврийн хэрэгслийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр авч, түүнийг нь бусдад худалдсан, арилжсан, эд ангиар нь салгаж сэлбэгээр ашигласан бол тухайн тээврийн хэрэгслийг авсан арга, хэлбэрийг нь харгалзан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн аль тохирох зүйл, хэсгээр зүйлчилнэ.

22. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас тээврийн хэрэгсэлд учирсан эвдрэлийн үнэлгээ, хэмжээг хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдээр тогтоолгоно.

23. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.1, 498.2, 498.5 дахь хэсэг, 499 дүгээр зүйл болон мөн хуулийн 52 дугаар бүлгийн бусад зүйл, хэсэгт заасан гэм хорыг арилгах талаар эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргасан бол холбогдох иргэн, хуулийн этгээдийг иргэний хариуцагчаар тогтоон, байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулан уг асуудлыг нэг мөр хянан шийдвэрлэж байвал зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.БАТСАЙХАН

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ**

2006 оны 5 дугаар сарын
29-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 145 ДУГААР ЗҮЙЛИЙН
ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ**

Эрүүгийн хуулийн 7 дугаар хэсэг, 19 дүгээр бүлгийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5 дахь хэсгийг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

1.1. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэдэгт бусдын эд хөрөнгийг нууц, далд аргаар, шунахай сэдэлтээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч, бүр мөсөн, үнэ төлбөргүй өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрдүүлсэн буюу захиран зарцуулсан шууд санаатай үйлдлийг ойлгоно.

1.2. “Хулгайлах” гэмт хэргийн субъект нь 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын харьяат, харьяалалгүй этгээд байж болно.

1.3. Бага буюу өндөр настай, сэтгэцийн болон бусад хүнд өвчтэй, согтуурсан, мансуурсан буюу унтаж байсан, хөгжлийн бэрхшээлтэй /сохор, дулий/ зэрэг бусад байдлаас шалтгаалан тухайн үед болж байгаа үйл явдлыг мэдрэхгүй, ойлгож мэдэхгүй, илчлэх чадваргүй байдлыг далимдуулан тэдний дэргэд эд хөрөнгийг авсан үйлдлийг бусдын эд хөрөнгийг хулгайлсан гэмт хэрэг гэж үзвэл зохино.

1.4. Бусдын эд хөрөнгийг нууц, далд аргаар, шунахай сэдэлтээр авч байх үед дэргэд нь байгаа этгээд тухайн үйлдлийн шинж чанарыг ойлгож мэдээгүй, эсхүл гэмт этгээдтэй холбоотой /найз, танил, төрөл садан гэх мэт/ тул түүний зүгээс хориглох, эсргүүцэх явдлыг гаргахгүй гэж тухайн этгээд тооцон бусдын эд хөрөнгийг хууль бусаар авсан үйлдлийг хулгайн гэмт хэргээр зүйлчлэх нь зүйтэй.

Харин гэмт хэрэг үйлдэх үед дэргэд нь байсан этгээд бусдын эд хөрөнгийг хууль бусаар авах үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авсан бол гэм буруутай этгээдийн үйлдлийг бусдын хөрөнгийг булаах гэмт хэргээр зүйлчилбэл зохино.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах үед өмчлөгч буюу эзэмшигч уг үйлдлийг харсан /мэдсэн/ талаар гэмт этгээд ойлгосон атлаа авсан эд зүйлээ өөрийн эзэмшилд үлдээх зорилгоор уг үйлдлээ үргэлжлүүлсэн бол түүний үйлдлийг бусдын эд хөрөнгийг булаах, харин хохирогчийн амь биед нь аюултайгаар хүч хэрэглэсэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээр тус тус зүйлчилнэ.

1.5. Эрүүгийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “давтан үйлдэх” гэдэгт хулгайн гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн байхыг ойлгоно.

Гэхдээ гэмт хэрэг үйлдэх санаа нь тус тусдаа үүссэн, тус бүрдээ бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй байх бөгөөд уг үйлдэлдээ ял шийтгүүлсэн буюу ял шийтгүүлээгүйн аль аль нь хамаарна.

Харин хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээдийн дахин шинээр үйлдсэн гэмт хэрэг нь давтан үйлдсэн гэмт хэрэгт тооцогдохгүй.

1.6. Мөн зүйлийн 145.2, 145.3, 145.4 дэх хэсэгт заасан “бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн” гэдгийг Улсын Дээд шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоолд тайлбарласнаар ойлгоно.

1.7. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “машин механизм” гэдэгт хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин болон өргөх, буулгах, ухах, малтах, түрэх, цоолох, зүсэх зэрэг зориулалттай машин механизмуд хамаарна.

“Машин механизмыг хэрэглэсэн” гэдгийг бусдын эд хөрөнгийг хулгайлах үйлдлээ хөнгөвчилж түргэтгэх, хамгаалалт, бэхлэлтээг эвдэх, биеэр авч чадахгүй эд хөрөнгөд хүрэх, зөөж тээвэрлэх зорилгоор урьдчилан бэлтгэж

ашигласныг ойлгоно.

Харин хулгайлах үйлдэл төгссөний дараа түүнийг зөөж тээвэрлэх, хэргийн газраас зайлуулах зэрэгт машин механизм ашигласныг энэ ойлголтод хамааруулахгүй.

1.8. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “тусгайлан бэлтгэсэн багаж, хэрэгсэл” гэдэгт хулгайн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу ашигласан бэхэлгээ, хамгаалалтыг эвдэх зориулалт бүхий биеийн хүч нэмэгдүүлэх, үйлдлийг хялбаршуулахад хэрэглэсэн бүх төрлийн багаж хэрэгсэл, тэсэлж, дэлбэлэх болон химийн, үйлдвэрлэлийн, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулан ойлгоно.

1.9. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “орон байр” гэдэг, хүн байнга буюу түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт, сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно. Орон байр нь хөдөлгөөнтэй, түр шинжтэй байж болно.

1.10. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “агуулах сав” гэдэг нь эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байшин, пин, амбаар, илүү гэр, гэрийн болон тээврийн чингэлэг, бүх төрлийн агуулах, зоорь, автомухлаг, хөргөх ба эд бараа зөөх төхөөрөмжтэй автомашин, граж, албан тасалгаа, үйлдвэрлэлийн эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байр, түүнчлэн хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан болон тусгай зориулалтын автомашины кабин, багаж, онгоц, галт тэрэг, далайн хөлгийн ачаа хадгалах сав зэргийг хамааруулан ойлгоно.

Мал, гэрийн тэжээвэр амьтныг бусдын халдлагаас хамгаалж зориулалтын цоож, бэхэлгээ хийсэн хашаа байр, савыг “агуулах сав” гэдэгт хамааруулж болно.

Харин мал болон гэрийн тэжээвэр амьтны зөвхөн өөрийнх нь хөдөлгөөнийг хорих, салхи, жавар, бороо цаснаас нөмөрлөх зориулалтын хашаа, хороо, саравчийг энэ тайлбарын 1.10 дахь заалтын 2 дахь хэсэгт заасан шинжгүй бол “агуулах сав” гэдэг ойлгогтод хамааруулахгүй.

1.11. Мөн зүйлийн 145.2 дахь хэсгийн “орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн” гэдгийг түлхүүр тааруулах, багаж хэрэгсэл ашиглах буюу ашиглахгүйгээр цонх, хаалга, түгжээг эвдэх, цуургыг сугалах, онгорхой байхад нь сэм орох, нуугдах зэрэг бусад аргаар нэвтрэн орохыг ойлгоно. Мөн тодорхой хугацаанд байх эрх бүхий этгээд өөр цаг хугацаанд үйлдвэрлэлийн байр, албан тасалгаа зэрэгт зөвшөөрөлгүйгээр орсон байвал орон байр, агуулах саванд нэвтэрсэн гэж үзнэ.

Харин үйлчилгээний газар /дэлгүүр, музей, үзэсгэлэнгийн танхим гэх мэт/-т хууль ёсоор нэвтэрч орсны дараа хулгайлах гэмт хэрэг үйлдсэнийг орон байр, агуулах саванд нэвтэрсэн гэж үзэхгүй.

1.12. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2, 145.3, 145.4 дэх хэсгүүдэд заасан “үлэмж, их, онц их хэмжээний хохирол” гэдгийг Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар тодорхойлно.

Харин Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хувьд хохирлын хэмжээг харгалзахгүй.

1.13. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “олон тооны мал хулгайлсан” гэдэгт нэг буюу хэд хэдэн удаагийн үйлдлээр 8 бод эсхүл 25 бог, түүнээс дээш тооны мал хулгайлсан байхыг ойлгоно.

1.14. Мөн зүйлийн 145.3 дахь хэсэгт заасан “хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан” гэдэг ойлголт нь хулгайлсан зүйлийн хэмжээ, үнээр бус, хохирогчийн амьдралд уг зүйлийн гүйцэтгэж байсан эдийн засгийн ач холбогдлыг шалган тогтоосон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс өгөх үнэлэмжээр тодорхойлогдоно.

1.15. Мөн зүйлийн 145.3 дахь хэсэгт заасан “нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж” гэдгийг байгалийн болон ослын гамшигт тохиолдсон, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, гоц халдварт өвчин дэлгэрсэн зэрэг онцгой нөхцөл байдлын улмаас нийтийн анхаарал сарнисныг далимдуулж хулгайн гэмт хэрэг үйлдэхийг ойлгоно.

1.16. Мөн зүйлийн 145.4 дэх хэсгийн “хулгайн гэмт хэрэгт хоёр буюу түүнээс дээш удаа, эсхүл булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд” гэдгийг урьд энэ төрлийн гэмт хэрэгт шүүхээр ял шийтгүүлснээс хойш Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа өнгөрөөгүй байхыг ойлгоно.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Дээд шүүхийн “Эрүүгийн хуулийн 123' дүгээр зүйлийг тайлбарлах тухай” 1997 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 74 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН
ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР
Д.БАТСАЙХАН
Ч.ГАНБАТ

Үргэлжлэл. (түрүүч нь 2005 оны №3, №4, 2006 оны №1, №2-т)

Латин нэр томъёо

Celebritas –	баяр ёслол
Celebro –	баярлах
Celer –	хурдан, түргэн
Celo –	нуух
Censeo –	үнэлэх, санал өгөх
Censualis –	газрын
Censor –	ромын магистрат (нийгмийн ёс суртахуун ба улсын мөнгө санхүүтэй холбогдох тооллого, бичиг дансыг хөтөлдөг)
Censuere –	Ромын сенатын зарлиг, шийдвэр
Censura –	шалгалт; шалгагчийн үүрэг
Census –	үнэ, дүн
Centum –	зуу
Centumviri –	шүүх бүрэлдэхүүний гишүүд (Ромын иргэдийн дунд үүссэн энгийн хэргийг шийдвэрлэхээр томилогдсон 105 шүүгч)
Cepi corpus –	би түүнийг барьсан (өртнийг баривчлах тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн талаар мэдэгдэх хэлбэр)
Cepi corpus et est in custodia –	би түүнийг барьсан, тэр харуул хамгаалалтын дор хоригдож байна (этгээдийг баривчлах тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн талаар мэдэгдэх хэлбэр)
Cepi corpus et paratum habeo –	би түүнийг барьсан, тэр миний хажууд байна (этгээдийг баривчлах тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн талаар мэдэгдэх хэлбэр)
Cepit et abduxit –	бариад авч явсан
Cepit et asportavit –	барьж аваачсан
Cerno –	шийдэх; харж үзэх
Certamen –	тэмцэл
Certiorari –	хэргийг шалгах болон шийдвэрийг засаж залруулахын тулд хэргийг дээд шатныхаа шүүхэд явуулах талаар доод шатны болон бусад шүүхүүдээс шаардсан дээд шатны шүүхийн шийдвэр
Certe –	үнэхээр; нээрэн
Certo –	тэмцэлдэх
Certus –	тодорхой; үнэн бодит
Cessa regnare, si non vis judicare –	шүүхэд дуудагдахыг хүсээгүй бол захирахаа боль
Cessante causa cessat effectus –	хэрвээ үндэслэл алдагдвал үр дүн бас үгүй болно
Cessante ratione legis cessat et ipsa lex –	хуулийн үндэслэл алга болохын хамт уг хууль бас оршихоо болих ёстой

Cessante statu primitive, cessat derivatus –	анхны байдал алга болохын хамт уламжилсан (дагалдсан) байдал мөн алга болдог
Cesset executio –	гүйцэтгэхийг түдгэлзүүлэх тухай тушаал
Cesset processus –	хэргийг шүүх ажиллагааг түдгэлзүүлэх тухай тушаал
Cessio –	бууж өгөх; найр тавих; хямдруулах
Cessio bonorum –	төлбөрийн чадваргүй өртөн өөрийн эд хөрөнгөө түрээслэгчид шилжүүлж өгөх замаар шоронд орохоос чөлөөлөгдөх ба нэр төрөө аврах эрх
Cessionarius –	цессионари
Cesso –	зогсох, болих
Ceteris paribus –	ижил тэгш нөхцөлд
Ceterum –	юуны урьд
Ceterus –	гэх мэтчилэн
Charta chyrographata –	хуудасны хоёр талд (хэсэгт) ба дундуураа тусгаарлагдан бичигдсэн гэрээ
Charta communis –	хоёр талаар байгуулагдсан гэрээ
Charta de non ente non valet –	үл орших юмны талаархи гэрээ хүчингүй
Charta partita –	усан тээврийн гэрээ
Chartarum super fidem, mortuis testibus, ad patriam de necessitudine, recurrendum est –	хэрвээ гэрчүүд нас барсан бол бичиг баримтыг магадлахын тулд тангарагтнуудад хандах хэрэгтэй болдог
Chirographum –	өрийн хуудас
Chirographum apud debitorem repertur presumitur solutum –	бичигдсэн үүрэг өртний гарт орох юм бол уг үүрэг гүйцэтгэгдсэн гэж хүлээн зөвшөөрөгддөг
Chirographum non extans presumitur solutum –	бичигдсэн үүрэг эс олдвол уг үүргийг гүйцэтгэсэн гэж хүлээн зөвшөөрөгддөг
Christianitatis curia –	шашны шүүх, сүмийн шүүх
Cibus –	хоол хүнс
Cicatrix –	сорви
Circa –	ойролцоо
Circuitus est evitandus –	хэргийн шаардлагагүй сунжралтаас зайлсхийх хэрэгтэй
Circulus –	тойрог
Circumeo –	тойрох
Circumstantibus –	шүүх танхимд байгаа хөндлөнгийн хүн
Circumsto –	бүслэх, хүрээлэх
Circumvenio –	зайлсхийх; мэхлэх; хохирол учруулах
Citatio ad reassumendam causam –	заргаа хүлээж байх үедээ нас барсан нэхэмжлэгчийн өв залгамжлагчид хаягласан шүүхийн зарлан
Citatio est de jure naturali –	шүүхэд дуудах бол жам ёсны эрх юм
Citatus ad non suum iudicium comparare tenetur –	хэн нэгнийг нөгөөтэй маргахад хүргэж байгаа этгээд шүүхэд дуудагдах ёстой

Citissime –	аль болох түргэн; онц яаралтай
Cito –	яаруулах, хөөх; хурдан, түргэн
Civilis –	иргэний
Civilis ratio naturalia jura corrumpere non potest –	иргэний эрхийн хувьд үндэслэлтэй бол жам ёсны эрхийг хасч чадахгүй
Civiliter –	Цивилитер (иргэний хуулиар)
Civiliter mortuus –	иргэний эрхээ хасуулах нь иргэний үхэлд хүргэнэ
Civis –	иргэн
Civis Romanus sum –	би ромын иргэн
Civitas –	иргэний; улс орон; иргэдийн хурал
Clam –	нууцаар
Clam delinquentes magis puniuntur quam palam –	гэмт хэргийг аль болох нууцаар үйлдэх тусам ил үйлдсэн хүнээс илүү хүнд шийтгэл оногдуулах ёстой
Clamea admittenda in itinere per attornatum –	гадаадад байгаа үйлчлүүлэгчийн эрх ашгийг илэрхийлэх зорилгоор өмгөөлөгч оруулахыг тушаасан шүүхийн шийдвэр
Clamo –	орилох, хашгирах
Clamor –	орилоон
Clarus –	ойлгомжтой; тодорхой
Classis –	дуудлага; анги
Claudo –	түгжих
Clausula –	төгсгөлийн хэсэг
Clausula derogatoria –	гэрээслэлд нөхцлийг гэрээслэгчээр нууцаар тусгах ба урьдаас хэлэлцэж тохирсон гэрээслэл нь энэ нөхцлийг агуулаагүй бол хүчингүй болдог
Clausula generalis non refertur ad expressa –	онцгойлон яригдаж байгаа юманд ерөнхий байдал үл хамаарна
Clausula quae abrogationem excludit ab initio non valet –	татгалзахыг хориглосон тайлбар эхнээсээ л хүчингүй
Clausulae inconsuetae inducunt suspicionem –	заншлын бус эсвэл ердийн бус нөхцөл үргэлж эргэлзээ төрүүлж байдаг
Claves curiae –	шүүх байрны түлхүүр
Clemens –	эрхэм, хүндэт
Clementia –	өршөөл, ивээл
Clericale privilegium –	санваартны тусгай эрх
Clericus –	лам, санваартан
Clericus inercati –	зах зээлийн эмх журмыг сахиулах албан тушаалтан
Cliens –	клиент, үйлчлүүлэгч

/үргэлжлэл дараагийн
дугаарт/

ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ЭРДЭМТДИЙГ АНХААРЛЫГ ТАТАВ

Хууль зүйн үндэсний төв, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, БНСУ-ын Күүкмений их сургууль, МУИС-ийн Хууль зүйн сургуулиас хамтран зохион байгуулсан "Өмнөд Солонгос-Хойд Солонгос-Монгол Улсын иргэний болон газрын хууль тогтоомжийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт олон улсын бага хурал амжилттай болж өнгөрлөө.

Бага хурлын үеэр эрдэмтдийн анхаарлыг газрын хууль тогтоомжид тусгагдсан асуудал ихээхэн татаж байсан юм. Газрын өмчлөгч, эзэмшигч гэсэн ойлголтын талаар илтгэл тавьсан хүмүүсээс гурван улсын эрдэмтэд сонирхон асууж байлаа.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга, доктор



Олон улсын бага хурал оролцогчид



Х.ҮТ-өөс эрхлэн гаргасан бүтээлийг бага хуралд оролцсон тавагцааг тооцогчид академич Ж.Амарсанаа гардуулав.

Ш.Батсүх "Монгол Улсын газрын шинэтгэл ба эрх зүйн зохицуулалтад хамаарах асуудал", Солонгосын хууль тогтоомж судлалын хүрээлэнгийн дарга Жун Ву Ли "Өмнөд Солонгосын газрын хууль тогтоомжийн асуудал ба цаашдын чиг хандлага" сэдвээр илтгэл тавив.

Хурлын төгсгөлийн үеэр Солонгосын хууль тогтоомж судлалын хүрээлэн, Хууль зүйн үндэсний төв судалгаа шинжилгээний бүтээлээсээ харилцан солилцлоо.

Энэхүү бага хурал нь Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойтой тохиохын зэрэгцээ Солонгос, Монголын харилцааг дан ганц соёл урлагийн талд бус эрх зүйн салбарт өргөжүүлснээрээ ач холбогдолтой юм гэж хуралд оролцогчид үзэж байлаа.

Д.Уянга

ШИНЭ НОМ

Иргэний хуулийн тайлбар дахин хэвлэгдлээ



Хууль зүйн үндэсний төв ГТХАН-ээс хэрэгжүүлж буй "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төсөлтэй олон талаар хамтран ажилладаг бөгөөд уг төслөөс 2005 онд цөөн тоогоор хэвлэн гаргасан "Иргэний хуулийн тайлбар /Ерөнхий анги/" номыг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээг хангах зорилгоор дахин хэвлэлээ.

Энэхүү номыг ХЗҮТ-өөс дахин хэвлэн гаргахдаа зохиогчдын хийсэн тайлбарыг ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт оруулаагүй болно.

Тайлбар нь тэргүүн ээлжинд практик дээр ажиллаж байгаа хуульчдад зориулагдсан бөгөөд хууль зүйн шинжлэх ухааны үндсэн ухагдахууныг ч давхар тусгасан юм.

Тайлбарыг зохиогчид хуулийн тодорхой зохицуулалтыг хэрэглэх тал дээр маргаантай байгаа асуудлыг нарийвчлан судалж шийдэл гарган санал болгохыг зорьсон билээ.




Энэхүү тайлбар Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэлийн явцыг хуульчдад ба иргэдэд ил тод болгоход зохих хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.

**Та бүхэн Иргэний хуулийн тайлбар толио өргөнөөр
худалдан авна уу.**

Харицах утас: 315736
317494
319144

Үнэ: 25000

ХУУЛЬГҮЙ ТӨР - ДӨРГҮЙ БУХ



МЭРГЭЖЛИЙН ЦОРЫН ГАНЦ ХЭВЛЭЛ

ХАРИЛЦАХ УТАС: 315736

ФАКС: 315789